



БОЛОВСРОЛ,  
ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ



БОЛОВСРОЛ ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ

ЯПОНЫ ОЛОН УЛСЫН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ БАЙГУУЛЛАГА

Энэхүү модулийг БШУЯ, ЖАЙКА хамтран хэрэгжүүлж буй “Багшлахуйн арга зүйн хөгжлийг түгээн дэлгэрүүлэх тогтолцоог бэхжүүлэх” төслийн хүрээнд боловсруулав.

# **ХИЧЭЭЛИЙН СУДАЛГАА:**

## **БАГШ БЭЛТГЭДЭГ ИХ, ДЭЭД СУРГУУЛИУДЫН СУРГАЛТАД ЗОРИУЛСАН ХИЧЭЭЛИЙН ХӨТӨЛБӨР**

Багш бэлтгэдэг их, дээд сургуулийн бакалаврын сургалтад зориулав.

Улаанбаатар хот

2013

## ГАРЧИГ

|                                                                                                          |     |
|----------------------------------------------------------------------------------------------------------|-----|
| <b>ӨМНӨХ ҮГ</b> .....                                                                                    | 4   |
| <b>“Хичээлийн судалгаа” хичээлийн тодорхойлолт</b> .....                                                 | 6   |
| <b>“Хичээлийн судалгаа” хичээлийн тодорхойлолтын тайлбар</b> .....                                       | 12  |
| <b>Лекц 1. Удиртгал</b> .....                                                                            | 14  |
| <b>Семинар 1. Багш хичээлийн судалгаа хийх эрх зүйн үндэс</b> .....                                      | 25  |
| <b>Лекц 2. Хичээлийн бэлтгэл судалгаа-1</b> .....                                                        | 28  |
| <b>Семинар 2. Судлагдахууны агуулгын судалгаа хийх арга зүй</b> .....                                    | 39  |
| <b>Семинар 3. Хэрэглэгдэхүүний судалгаа хийх арга зүй</b> .....                                          | 41  |
| <b>Лекц 3. Хичээлийн бэлтгэл судалгаа-2</b> .....                                                        | 43  |
| <b>Семинар 4. Мэдлэг эзэмшилтийн судалгаа хийх арга зүй</b> .....                                        | 52  |
| <b>Семинар 5. Багшлахуйн арга барилын судалгаа</b> .....                                                 | 54  |
| <b>Лекц 4. Хичээлийн бэлтгэл судалгаа-3</b> .....                                                        | 56  |
| <b>Семинар 6. Үнэлгээний судалгаа хийх арга зүй</b> .....                                                | 60  |
| <b>Семинар 7. Ээлжит хичээлийн болон нэгж сэдвийн үнэлгээний судалгаа хийх арга зүй</b> .....            | 62  |
| <b>Лекц 5. Хичээлийн бэлтгэл судалгааны үр дүнг хөтөлбөр боловсруулахад тусгах нь</b> .....              | 64  |
| <b>Семинар 8. Сонгосон сэдвийнхээ хүрээнд ээлжит хичээлийн бэлтгэл судалгаа хийх</b> .....               | 72  |
| <b>Семинар 9. Ээлжит хичээлийн хөтөлбөр боловсруулах</b> .....                                           | 73  |
| <b>Лекц 6. Хичээл заах, ажиглах нь</b> .....                                                             | 74  |
| <b>Семинар 10, 11. Хичээлд ажиглалт хийх</b> .....                                                       | 91  |
| <b>Лекц 7. Хичээлийн хэлэлцүүлэг зохион байгуулах нь</b> .....                                           | 92  |
| <b>Семинар 12. Хэлэлцүүлгийн орчин, хэлэлцүүлгийг удирдах</b> .....                                      | 98  |
| <b>Семинар 13. Хэлэлцүүлэгт оролцож судалгаат хичээлийн хуудас бөглөх</b> .....                          | 99  |
| <b>Лекц 8. Хичээлийн судалгааны үр дүнг хичээлийн арга зүйг сайжруулан хөгжүүлэхэд хэрэглэх нь</b> ..... | 101 |
| <b>Семинар 14, 15. Судалгаат хичээлийн хөтөлбөрийг сайжруулах</b> .....                                  | 114 |
| <b>Семинар 16. Хичээлийн судалгааны талаар сурсан зүйлээ нэгтгэн дүгнэх</b> .....                        | 116 |
| <b>ХАВСРАЛТ. Нэр томъёоны хураангуй</b> .....                                                            | 119 |

## БОЛОВСРУУЛСАН БАГ:

### Ахлагч:

Чойжилсүрэнгийн Нямгэрэл

МУИС-ийн Хими, Химийн Инженерчлэлийн  
Сургуулийн багш

### Гишүүд:

Мөнхөөгийн Ганбат

МУИС-ийн Физик Электроникийн Сургуулийн багш

Лхагвасүрэнгийн Мөнхтуяа

МУБИС-ийн Компьютер, Мэдээллийн Технологийн  
Сургуулийн тэнхимийн эрхлэгч

Цэрэндоржийн Наранцэцэг

МУБИС-ийн Багшийн Сургуулийн багш

Цэвэгжавын Пагмасүрэн

МУБИС-ийн Байгалийн Ухааны Сургуулийн багш

Дагвын Энхцэцэг

МУБИС-ийн Багшийн Сургуулийн захирал

Гончигжавын Юмчмаа

МУИС-ийн Газар зүй Геологийн Сургуулийн багш

## ЭКСПЕРТИЙН БАГ:

### Ахлагч:

Алимаагийн Туяа

БШУЯ-ны Суурь, бүрэн дунд боловсролын хэлтсийн  
дарга

### Гишүүд:

Ноокоогийн Оюунцэцэг

МУИС-ийн Хими, Химийн Инженерчлэлийн Сургуулийн  
багш

Чодингийн Ганцэцэг

БШУЯ-ны Сургуулийн өмнөх, бага боловсролын  
хэлтсийн мэргэжилтэн

Жамцийн Нарантуяа

БШУЯ-ны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын  
мэргэжилтэн

Оросоогийн Оюунтунгалаг

Багшийн Мэргэжил Дээшлүүлэх Институтын дэд  
захирал

Бадамжавын Золзаяа

МУБИС-ийн Компьютер, Мэдээллийн Технологийн  
Сургуулийн ахлах багш

## РЕДАКЦИЙН БАГ:

Төмөрбаатарын Ганбаатар

МУБИС-ийн Математик, Статистикийн Сургуулийн  
багш

Шагдарсүрэнгийн Сайнбилэг

МУИС-ийн Хими, Химийн Инженерийн Сургуулийн  
багш

Өлзийдоогийн Мөнхдолгор

Зохиомж Дээд Сургуулийн Монгол хэлний багш

## ЗӨВЛӨХ БАГ:

Иший Тэцүя

Төслийн менежер

Сүзүки Саяака

Сургалт, хяналт үнэлгээ хариуцсан мэргэжилтэн

Бадамсамбуугийн Хишигбаяр

Төслийн мэргэжилтэн

## ӨМНӨХ ҮГ

Та бүхний гар дээр хүргүүлж буй энэхүү багш бэлтгэдэг их, дээд сургуульд зориулсан “Хичээлийн судалгаа” хичээлийн хөтөлбөрийг Монгол Улсын Засгийн газар, Японы Олон Улсын Байгууллага (ЖАЙКА)-ын хооронд 2009 оны 12 дугаар сарын 8-ны өдөр байгуулсан хэлэлцээрийн дагуу хамтран хэрэгжүүлж буй **“Багшлахуйн арга зүйн хөгжлийг түгээн дэлгэрүүлэх тогтолцоог бэхжүүлэх”** төслийн хүрээнд боловсруулсан болно. Энэхүү төслийг хэрэгжүүлснээр ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагаанд хүүхэд төвтэй сургалтын технологи, арга зүйг шинээр нэвтрүүлэх хүний нөөц бэлтгэгдэж, түүнийг түгээн дэлгэрүүлэх үндэсний тогтолцоо бүрдсэн байх зорилт тавин ажиллаж байна.

Өнгөрсөн 2006-2009 онд БШУЯ болон Японы Олон Улсын Хамтын Ажиллагааны Байгууллага (ЖАЙКА)-ын хамтран хэрэгжүүлсэн **“Монгол Улсын хүүхдийн хөгжлийг дэмжих багшлах арга зүйн шинэчлэл”** (“Teaching methods Improvement Project towards Children’s Development in Mongolia”) төслийн хүрээнд 8 мэргэжлийн баг ажиллаж, тус бүр цуврал гурван зөвлөмж боловсруулсан. Сонгосон сэдвийн хүрээнд тодорхой нэрлэсэн арга зүйг хэрэгжүүлэх нэгж хичээлийн хөтөлбөр боловсруулж, түүнийгээ төслийн загвар сургуулиуд дээр туршин сайжруулж, эцэст нь арга зүйгээ сайжруулах гэсэн 3 цикл үе шатаар ажиллан улмаар багшлах арга зүйн зөвлөмж боловсруулан нийтийн хүртээл болгосон билээ. Төслийн загвар сургуулиуд дээр явуулсан туршилт хичээлийг илүү боловсронгуй, хөгжингүй болгохын тулд ашигласан арга барил нь **“Хичээлийн судалгаа”** байсан юм.

Харин БШУЯ болон ЖАЙКА-ийн хамтран хэрэгжүүлж буй төслийн хоёр дахь шат болох **“Багшлахуйн арга зүйн хөгжлийг түгээн дэлгэрүүлэх тогтолцоог бэхжүүлэх”** (“Teaching methods Improvement Project towards Children’s Development in Mongolia”) төслийн загвар аймаг, дүүрэг, загвар бус аймаг дүүргийн сургууль, багш нар хичээлийн судалгааг хийж, нэлээдгүй туршлага хуримтлуулж, багшлах арга зүйг хөгжүүлэх, сургуулийн сургалтын чанарыг дээшлүүлэх, багш нарын бүтээлч хамтын ажиллагаагаар ажлын байран дээрээ мэргэжлээ дээшлүүлэхэд хичээлийн судалгаа чухал ач холбогдолтой болохыг үйл ажиллагааны алхам бүртээ мэдэрч байна.

Хичээлийн судалгаа, түүний менежментийг “арга зүйн хөгжлийг түгээн дэлгэрүүлэх үндэсний хэмжээний тогтолцоо” болтол нь хөгжүүлж, тогтвортой байдлыг хангахад бидний “шинэ багш” гэж нэрлэж ирсэн, багш бэлтгэдэг их, дээд сургуулийг төгсөөд эхний жилдээ багшилж байгаа багш нарын “хичээлийн судалгаа”-ны талаарх ойлголт, мэдлэг, түүнд оролцож ажиллах бодит чадвар маш чухал юм.

Иймд энэхүү хичээлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ төслийн I шатанд боловсруулсан зөвлөмжийг ашиглан “суралцагчдын суралцахуйг дэмжсэн арга зүй”-г хэрэглэн (зөвлөмжийг сайтар судлахын зэрэгцээ бодит туршлага

хуримтлуулж бүтэн 3 жил бүтээлчээр ажилласан сургууль багш нараас суралцах бүх боломжийг эрэлхийлэх) багшлахуйн арга зүйгээ хөгжүүлэх, бүтээлчээр хамтран ажиллах арга, менежментийн хувьд үүрэг оролцоо, хариуцлагаа ойлгож оролцох боломжоор оюутан-багшийг сэдэлжүүлж, удахгүй төгсөөд очиж ажиллах ажлын байрны чиг үүрэгт эрх зүйн хувьд хичээлийн судалгаа нэвт шингэсэн байгаа нийгмийн шаардлагыг мэдрүүлэхэд анхаараарай.

“Хичээлийн судалгаа” нь мэргэжлийн дидактикийн хичээлийг судлаж, хамгийн багадаа нэг удаагийн багшлах дадлага хийсэн ахлах ангийн оюутанд зориулсан 2 багц цагийн багтаамжтай хичээл болно. Хичээлийн тодорхойлолтод лекц болон семинарын хичээлийн сэдэвчилсэн төлөвлөгөөг тусгаж өгсөн бөгөөд хөтөлбөрт тухайн сэдвийн хүрээнд лекц ба семинарын хичээлийн залгамж холбоог тодорхой харуулах үүднээс тухайн сэдвийн лекц, семинарыг хамт оруулсан болно. Мөн хичээлийн судалгааг тодорхой судлагдахууны онцлогтойгоор тайлбарлах зайлшгүй шаардлагын улмаас зарим хичээл (хими, газарзүй, мэдээлэл зүй, хүн байгаль гэх мэт)-ээр харилцан адилгүй жишээ авсан байгаа юм. Иймээс энэхүү хичээлийг заах профессор багшаас тухайн оюутан-багшийн ЕБС-д заах хичээл (тодорхой нэг судлагдахуун)-ээр аль болох иж бүрэн жишээ, тайлбар бэлтгэхийг шаардах болно. Мөн энэ хичээлийг үр дүнтэй, чанартай зохион байгуулах нэг үндэс нь ЕБС дээр практик туршилттайгаар явуулах явдал юм.

Аливаа сургалтын хөтөлбөрийг боловсруулахад багш (сургагч)-ийн дидактик шийдэл чухал хэдий ч тухайн хөтөлбөрийг бүтээлчээр хэрэгжүүлэхэд суралцагч (оюутан-багш)-ийн сэдэл тэмүүлэл, хэрэгцээ, санаачлага ч эн тэнцүү ач холбогдолтой гэдэгтэй Та лав санал нийлэх биз ээ. Энэхүү сургалтын хөтөлбөр нь ягштал дагах “хууль” биш бөгөөд Та бүхэн өөрийн арвин их туршлагадаа үндэслэн оюутан-багшийн хэрэгцээ шаардлага, нөхцөл боломжид тулгуурлан шинэ аргаар улам баяжуулна гэдэгт бид итгэлтэй байна.

*Бидний хамтын үйл ажиллагаа харилцан тустай, үр өгөөжтэй байх болтугай.*

## **“ХИЧЭЭЛИЙН СУДАЛГАА” хичээлийн тодорхойлолт** **/үлгэрчилсэн/**

|                                    |                                                                                    |
|------------------------------------|------------------------------------------------------------------------------------|
| <b>Хичээлийн индекс:</b>           | Тухайн их, дээд сургууль өөрөө шийднэ                                              |
| <b>Хичээлийн багц цаг:</b>         | 2 (1 : 1 : 0 лекц : сем : лаб.)                                                    |
| <b>Судлах улирал:</b>              | Тухайн их, дээд сургуулийн хэрэгжүүлж буй сургалтын төлөвлөгөөгөөр зохицуулагдана. |
| <b>Өмнөх холбоо:</b>               | Тухайн мэргэжлийн багшлах дадлага                                                  |
| <b>Долоо хоногт хичээллэх цаг:</b> | 1 : 2 : 0 : 4 (лекц : сем. : лаб. : бие даалт)                                     |

### **Сургалтын зорилго:**

Хичээлийн судалгааны үндсэн алхам, судлагдахуунд болон сургуульд суурилсан хичээлийн судалгаатай танилцах. Хичээлийн судалгааны багт ажиллах, хичээлийн бэлтгэл судалгааны үндсэн дээр хичээл төлөвлөх, хичээлд ажиглалт хийх, хэлэлцүүлэгт оролцож сайжруулах санал боловсруулах арга барил, чадварт суралцах

### **Сургалтын агуулга:**

1. Хичээлийн судалгаа ба суралцахуйг дэмжсэн багшлах арга зүй, багшийн ажлын байрны тодорхойлолт ба хичээлийн судалгааны уялдаа холбоо, хэрэгцээ шаардлагыг судлана.
2. Хичээлийн бэлтгэл судалгааны төрөл тус бүрийг хийх арга зүйтэй танилцаж тодорхой нэгж хичээлийн жишээн дээр хичээлийн бэлтгэл судалгаа гүйцэтгэнэ.
3. Хичээлийн төлөвлөлт хийх, ажиглах, ажиглалтын тэмдэглэл хөтлөх загвар хуудсууд, ажиглалтын тэмдэглэлээс нотлох баримт цуглуулах арга зүйтэй танилцаж тодорхой нэгж хичээлийн жишээн дээр ажиглалт хийнэ.
4. Хичээлийн судалгааны хэлэлцүүлгийн зохион байгуулалт, баримтлах журам, хэрэгцүүлэгт оролцох, хөтлөх аргатай танилцаж тодорхой нэгж хичээлийн жишээн дээр хичээлийн хэлэлцүүлэгт оролцоно.
5. Хичээлийн судалгааны үр дүнг сургууль, хичээлийн үйл ажиллагаанд хэрэгжүүлэх арга зам, боломжуудтай танилцаж тодорхой нэгж хичээлийн жишээн дээр хэлэлцүүлгийн үр дүнд үндэслэн хичээлийн төлөвлөлтийг сайжруулна.

### **Сургалтын арга зүй:**

Энэхүү хичээлээр оюутан-багш нарыг ганцаарчилсан болон багаар хамтран ажиллах хэлбэрээр суралцахуй үйл ажиллагаанд чиглүүлнэ. Лекцийн хичээлээр өгөгдөх зарим даалгавар ганцаарчлан ажиллах хэлбэртэй байх бол семинарын хичээл болон ихэнх даалгавар багаар ажиллах үйл ажиллагааг голлоно. Лекцийн хичээлээр авсан онолын ерөнхий мэдлэгээ ЕБС-д заах тодорхой, бодит нэгж, ээлжит хичээлийн жишээн дээр буулган турших, түүнээсээ хамтран суралцах арга зүйг хэрэгжүүлнэ.

### **Сургалтаар эзэмших мэдлэг чадвар:**

- Хичээлийн бэлтгэл судалгаа болон хичээлийн судалгааны аргатай танилцаад туршиж үзэх явцад **хичээлийн судалгаа хийх арга барил, ур ухаанд суралцана.**
- Лекцийн хичээлээр танилцсан зүйлээ тодорхой нэгж хичээлийн жишээн дээр туршиж үзэх, гүйцэтгэх явцад **хичээлийн судалгаанд оролцох,**

**хичээлийн судалгааны үр дүнг өөрийн багшлах ажлын чанарыг хөгжүүлэхэд хэрэглэх үндсэн арга барил эзэмшинэ.**

- Сургуулийн бодит практикт хичээлийн судалгаа хийх идэвхтэй үйл ажиллагааны дүнд хичээлийг ажиглах, бусдаас дэвшилтэт арга зүй, дидактик шийдэлд суралцах, бусдын хэрэгжүүлэх арга зүйг мэдэрч ойлгох, сурагчдын хариу үйлдлийг ойлгох, арга зүйг хөгжүүлэх шинэ, шинэлэг санаа гаргах, ойлгомжтой бичиж цэгцлэх, илтгэн мэдээлэх зэрэг **өөрийгөө илтгэх, хөгжүүлэх чадвар, арга, хандлага төлөвшинө.**

#### **Дүгнэх журам:**

Нийт **100** оноо. Улирлын шалгалт **30** оноо, сургалтын явцын үнэлгээ **70** оноо  
Сургалтын явцын үнэлгээ дараах байдлаар хуваарилагдана:

- |                                                       |               |
|-------------------------------------------------------|---------------|
| - Лекцийн даалгаврын гүйцэтгэл                        | 15 оноо       |
| - Семинарын гүйцэтгэл                                 | 25 оноо       |
| - Явцын шалгалтыг 2 удаа бүтээлийн хамгаалалтаар авна | 2x15 =30 оноо |

#### **Хэрэглэх гарын авлага, эх сурвалж:**

**“Монгол Улсын хүүхдийн хөгжлийг дэмжих багшлах арга зүйн шинэчлэл” төслийн хүрээнд боловсруулсан зөвлөмж**

1. Бодит юмсыг загварчлан тооцоолох үйлд хүүхдийг сургах арга зүй, *Боловсролын түвшин: Бага, Хичээл: Математик, Бүлэг сэдэв: Нэмэх, хасах үйлдэл*, Зөвлөмж I, О.Чулуунцэцэг, Д.Энхцэцэг, Ч.Алтантуяа, Г.Норжмоо, 120 хуудас, 2007.
2. Бодит юмсыг загварчлан тооцоолох үйлд хүүхдийг сургах арга зүй, *Боловсролын түвшин: Бага, Хичээл: Математик, Бүлэг сэдэв: Үржих, хуваах үйлдэл*, Зөвлөмж II, О.Чулуунцэцэг, Д.Энхцэцэг, Т.Оюун, Д.Энхтуяа, Г.Норжмоо, 120 хуудас, 2008.
3. Хийж бүтээх, зурах, дүрслэх үйлээр дамжуулан математикийн агуулгыг эзэмшүүлэх арга зүй, *Боловсролын түвшин: Бага, Хичээл: Математик, Бүлэг сэдэв: Хэсэг ба бутархай*, Зөвлөмж III, О.Чулуунцэцэг, Д.Энхцэцэг, Ч.Цогзолмаа, Б.Ганцэцэг, Б.Гэрэлгуа, 128 хуудас, 2009.
4. Хүүхдээр математикийн хялбар мэдлэг бүтээлгэх арга зүй, *Боловсролын түвшин: Суурь, Хичээл: Математик, Бүлэг сэдэв: Рациональ тоо*, Зөвлөмж I, Т.Ганбаатар, Н.Лхагвадорж, Д.Сэргэлэн, М.Энхтуяа, Д.Мөнхбаатар, У.Доёд, Л.Даваажаргал, 112 хуудас, 2007.
5. Сурах үйлийн баримжаагаар суралцахуйг дэмжих арга зүй, *Боловсролын түвшин: Суурь, Хичээл: Математик, Бүлэг сэдэв: Геометр функц*, Зөвлөмж II, Т.Ганбаатар, Ц.Далайжамц, У.Доёд, Э.Чойсүрэн, 126 хуудас, 2008.
6. Хүүхдээр асуудал шийдүүлэх арга зүй, *Боловсролын түвшин: Суурь, Хичээл: Математик, Бүлэг сэдэв: Квадрат функц, Дөрвөн өнцөгт*, Зөвлөмж III, Т.Ганбаатар, Ц.Далайжамц, У.Доёд, М.Итгэл, Э.Чойсүрэн, 128 хуудас, 2009.
7. Амьд биеийн хөгжлийг таниулах арга зүй, *Боловсролын түвшин: Бага, Хичээл: Хүн орчин, Бүлэг сэдэв: Ургамал бидний орчин*, Зөвлөмж I, Г.Нэргүй, Ц.Дашдорж, Э.Мөнгөнтулга, Г.Пунсалпаамуу, А.Бямба, Б.Баярчимэг, 120 хуудас, 2007.
8. Монгол орны бүс нутгийн байгаль ба нийгэм ахуйн шүтэлцээг таниулах арга зүй, *Боловсролын түвшин: Бага, Хичээл: Хүн орчин, Бүлэг сэдэв: Манай орны байгаль*, Зөвлөмж II, Э.Мөнгөнтулга, Г.Нэргүй, Г.Пунсалпаамуу, А.Бямба, Б.Баярчимэг, 120 хуудас, 2008.
9. Хүрээлэн буй орчинг тоглоомын явцад таниулах арга зүй, *Боловсролын түвшин: Бага, Хичээл: Хүн орчин, Бүлэг сэдэв: Ургамал бидний орчин*, Зөвлөмж I, Э.Мөнгөнтулга, Г.Нэргүй, Г.Пунсалпаамуу, А.Бямба, Б.Баярчимэг, Ч.Оюунгэрэл, Б.Нарангэрэл, 128 хуудас, 2009.
10. Сорил туршилтаар мэдлэг бүтээлгэх арга зүй, *Боловсролын түвшин: Суурь, Хичээл: Байгалийн ухаан, Бүлэг сэдэв: Бид ба ус*, Зөвлөмж I, Ц.Даржаа, Б.Бурмаа, А.Дулмаа, Г.Юмчмаа, М.Алтанцэцэг, Б.Батцэцэг, 124 хуудас, 2007.

11. Сорил туршилтаар мэдлэг бүтээлгэх арга зүй, *Боловсролын түвшин: Бага, Хичээл: Хүн байгаль, Бүлэг сэдэв: Би ба агаар*, Зөвлөмж II, Б.Бурмаа, Ц.Даржаа, М.Алтанцэцэг, Г.Юмчмаа, Б.Батцэцэг, Э.Даваахүү, 66 хуудас, 2008.
12. Сорил туршилтаар мэдлэг бүтээлгэх арга зүй, *Боловсролын түвшин: Бага, Хичээл: Хүн байгаль, Бүлэг сэдэв: Агаар*, Зөвлөмж III, Б.Бурмаа, Ц.Даржаа, М.Алтанцэцэг, Г.Юмчмаа, Б.Батцэцэг, Э.Болормаа, М.Баасанхүү, 120 хуудас, 2009.
13. Сорил тооцоогоор мэдлэг бүтээлгэх арга зүй, *Боловсролын түвшин: Суурь, Хичээл: Хими, Бүлэг сэдэв: Ус, уусмал*, Зөвлөмж I, Ч.Нямгэрэл, Н.Оюунцэцэг, З.Урансайхан, Г.Баярмаа, Ш.Сайнбилэг, П.Лхагвасүрэн, Н.Отгонбаяр, Ж.Батбилэг, 144 хуудас, 2007.
14. Мэдээлэл боловсруулж химийн мэдлэг бүтээлгэх арга зүй, *Боловсролын түвшин, Хичээл: Хими, Бүлэг сэдэв: Ус, уусмал*, Зөвлөмж II, Ч.Нямгэрэл, Н.Оюунцэцэг, З.Урансайхан, Г.Баярмаа, Ш.Сайнбилэг, П.Лхагвасүрэн, Ц.Отгонбаяр, Ц.Лхагвасүрэн, 110 хуудас, 2008.
15. Контекстэд суурилан мэдлэг бүтээлгэх арга зүй, *Боловсролын түвшин: Суурь, Хичээл: Хими, Сэдэв: Нүүрстөрөгчийн хэрэглээ-шинж чанар, Контекст: Галын хор ба нүүрсхүчлийн хий, Кокс ба түлшний боловсруулалт, Идэвхжүүлсэн нүүрсний хэрэглээ*, Зөвлөмж III, Ч.Нямгэрэл, Н.Оюунцэцэг, Ш.Сайнбилэг, Г.Баярмаа, З.Урансайхан, П.Лхагвасүрэн, Ц.Отгонбаяр, Ц.Лхамсүрэн, 110 хуудас, 2009.
16. Хялбар туршилтаар мэдлэг бүтээлгэх арга зүй, *Боловсролын түвшин: Суурь, Хичээл: Физик, Бүлэг сэдэв: Цахилгаан хэлхээ*, Зөвлөмж I, М.Ганбат, Б.Ариунбаяр, П.Лхагвасүрэн, Я.Мөнхсайхан, Г.Чулуунбаатар, 128 хуудас, 2007.
17. Сургалтанд сурагчдын өмнөх төсөөллийг тооцох арга зүй, *Боловсролын түвшин: Суурь, Хичээл: Физик, Бүлэг сэдэв: Цахилгаан хэлхээ*, Зөвлөмж II, М.Ганбат, Б.Ариунбаяр, П.Лхагвасүрэн, П.Мөнхбаяр, Я.Мөнхсайхан, Х.Баярцэнгэл, Д.Оюунтунгалаг, 112 хуудас, 2008.
18. Контекст төвтэй сургалтаар мэдээлэл харилцааны цогц чадамж төлөвшүүлэх арга зүй, *Боловсролын түвшин: Суурь, Хичээл: Физик, Бүлэг сэдэв: Цахилгаан энерги*, Зөвлөмж III, М.Ганбат, Б.Ариунбаяр, П.Лхагвасүрэн, П.Мөнхбаяр, Я.Мөнхсайхан, 126 хуудас, 2009.
19. Айн киррикулим боловсруулах арга зүй, *Боловсролын түвшин: Бага, Хичээл: Мэдээлэл зүй, Агуулгын ай: Мэдээлэл*, Зөвлөмж I, Л.Мөнхтуяа, Л.Чойжооваанчиг, 120 хуудас, 2007.
20. Асуудал шийдвэрлэх замаар мэдээллийг мэдлэг болгон хувиргах арга зүй, *Боловсролын түвшин: Суурь, Хичээл: Мэдээлэл зүй, Агуулгын ай: Мэдээлэл*, Зөвлөмж II, Л.Мөнхтуяа, Л.Чойжооваанчиг, Б.Золзаяа, Д.Цэдэвсүрэн, Ч.Долгоржав, 120 хуудас, 2008.
21. Хэрэглээнд суурилсан сургалт зохион байгуулах арга зүй, *Боловсролын түвшин: Суурь, Хичээл: Мэдээлэл зүй, Агуулгын ай: Мэдээлэл*, Зөвлөмж III, Л.Мөнхтуяа, Л.Чойжооваанчиг, Б.Золзаяа, Д.Цэдэвсүрэн, 128 хуудас, 2009.
22. Төсөлт ажлын арга зүй, *Боловсролын түвшин: Бага*, Зөвлөмж I, Ц.Наранцэцэг, Наканиши Рейко, Б.Булган, 92 хуудас, 2007.
23. Төсөлт ажлын арга зүй, *Боловсролын түвшин: Суурь*, Зөвлөмж II, Ц.Наранцэцэг, Ц.Оюун, Наканиши Рейко, Б.Булган, 128 хуудас, 2008.
24. Төсөлт ажлын арга зүй, *Боловсролын түвшин: бага, суурь*, Зөвлөмж III, Ц.Наранцэцэг, Ц.Оюун, Наканиши Рейко, Б.Булган, Б.Гэрэл, 150 хуудас, 2009.
25. Зөвлөмж боловсруулах гарын авлага, Ч.Нямгэрэл, Ж.Нарантуяа, Л.Мөнхтуяа, Н.Оюунгэрэл, 64 хуудас, 2009.
26. Хичээлд мониторинг хийх зөвлөмж, Ш.Сайнбилэг, Н.Оюунгэрэл, Б.Золзаяа, Д.Энхтуяа, Г.Нарангэрэл, Б.Батцэцэг, Э.Чойсүрэн, Б.Баярчимэг, О.Чулуунцэцэг, Ц.Буйданбаатар, П.Лхагвасүрэн, 80 хуудас, 2009.



**Лекцийн сэдэвчилсэн төлөвлөгөө (1кр)**

| Д.х.<br>Судлах<br>цаг | Лекцийн бүлэг<br>сэдэв                                                                | Агуулга                                                                                                                                                                                                                                                                                                                                         |
|-----------------------|---------------------------------------------------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| I<br>2ц               | <b>Лекц 1.</b> Удиртгал                                                               | <ul style="list-style-type: none"> <li>• Боловсролын шинэчлэл</li> <li>• Багшийн хөгжил буюу ажлын байран дээрээ багш мэргэжлээ дээшлүүлэх асуудал</li> <li>• Хичээлийн судалгаа, түүний хөгжил</li> </ul>                                                                                                                                      |
| II<br>2ц              | <b>Лекц 2.</b> Хичээлийн бэлтгэл судалгаа-1                                           | <ul style="list-style-type: none"> <li>• Хичээлийн бэлтгэл судалгааны талаарх ойлголт, мөн чанар</li> <li>• Судлагдахууны агуулгын судалгаа</li> <li>• Хэрэглэгдэхүүний судалгаа</li> </ul>                                                                                                                                                     |
| IV<br>2ц              | <b>Лекц 3.</b> Хичээлийн бэлтгэл судалгаа-2                                           | <ul style="list-style-type: none"> <li>• Мэдлэг эзэмшилтийн судалгаа, Хүүхдийн судалгаа</li> <li>• Багшлахуйн арга барилын судалгаа</li> </ul>                                                                                                                                                                                                  |
| VI<br>2ц              | <b>Лекц 4.</b> Хичээлийн бэлтгэл судалгаа-3                                           | <ul style="list-style-type: none"> <li>• Үнэлгээний судалгаа</li> </ul>                                                                                                                                                                                                                                                                         |
| VIII<br>2ц            | <b>Лекц 5.</b> Хичээлийн бэлтгэл судалгааны үр дүнг хөтөлбөр боловсруулахад тусгах нь | <ul style="list-style-type: none"> <li>• Хичээлийн хөтөлбөрийн элементүүд</li> <li>• Хичээлийн хөтөлбөр боловсруулахад бэлтгэл судалгааны үр дүнг тусгах нь</li> </ul>                                                                                                                                                                          |
| X<br>2ц               | <b>Лекц 6.</b> Хичээл заах, ажиглах нь                                                | <ul style="list-style-type: none"> <li>• Хичээлийн технологи: хичээлийн зорилго, зорилт, агуулга, арга зүй, үнэлгээ, багшийн сурган хүмүүжүүлэх үйл, сурагчийн сурч танин мэдэх үйл</li> <li>• Хичээлд ажиглалт хийх арга зүй: хичээлийн ажиглалтын техник, баримт цуглуулах арга зүй, ажиглалтын тэмдэглэл түүнд боловсруулалт хийх</li> </ul> |
| XII<br>2ц             | <b>Лекц 7.</b> Хичээлийн хэлэлцүүлэг зохион байгуулах нь                              | <ul style="list-style-type: none"> <li>• Судалгаат хичээлийн хэлэлцүүлгийг зохион байгуулах, хэлэлцүүлгийн орчин</li> <li>• Хэлэлцүүлгийг хөтлөн удирдах, чиглүүлэг</li> <li>• Хэлэлцүүлэг-идэвхтэй оролцоо</li> <li>• Судалгаат хичээлийн хуудас</li> </ul>                                                                                    |
| XIV<br>2ц             | <b>Лекц 8.</b> Хичээлийн судалгааны үр дүнг арга зүйн хөгжилд хэрэглэх нь             | <ul style="list-style-type: none"> <li>• Хичээлийн хөтөлбөрийг сайжруулах</li> <li>• Агуулга сайжруулахад хэрэглэх</li> <li>• Арга зүй, дидактик шийдлийг сайжруулахад хэрэглэх</li> <li>• Хэрэглэгдэхүүнийг сайжруулахад хэрэглэх</li> </ul>                                                                                                   |

*Лекцийн даалгавар гүйцэтгэх, шалгах:*

1. Лекц бүрийн дараа ойлгоцоо шалгахад зориулсан сорих асуулт, тэдгээртэй холбоотой мэдээлэл бүхий сурах бичиг, гарын авлагын нэр, уншиж судлах хуудасны дугаарыг өгнө.
2. Лекцийн даалгаврын гүйцэтгэлийг улирлын явцад 2 удаа шалгана. Ихэнх тохиолдолд лекцийн даалгаврын гүйцэтгэл семинарын хичээл дээр хэрэглэгдэнэ.

**7.5 оноо x 2 удаа = 15 оноо**

### Семинарын хичээлийн сэдэвчилсэн төлөвлөгөө (1кр)

| Д.х,<br>Судлах цаг | Семинарын<br>сэдэв                                                          | Агуулга                                                                                                                                                                                        |
|--------------------|-----------------------------------------------------------------------------|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| I (II) 2ц          | <b>Семинар 1.</b> Багш хичээлийн судалгаа хийх эрх зүйн үндэс               | <ul style="list-style-type: none"> <li>Багшийн ажлын байрны тодорхойлолт ба хичээлийн судалгаа</li> <li>Багшийн ажлыг үнэлж дүгнэх журам ба хичээлийн судалгаа</li> </ul>                      |
| III, 2ц            | <b>Семинар 2-7.</b> Хичээлийн бэлтгэл судалгаа                              | <ul style="list-style-type: none"> <li>Судлагдахууны агуулгын судалгаа хийх арга зүй</li> <li>Хэрэглэгдэхүүний судалгаа хийх арга зүй</li> </ul>                                               |
| III (IV) 2ц        |                                                                             | <ul style="list-style-type: none"> <li>Мэдлэг эзэмшилтийн судалгаа хийх арга зүй</li> </ul>                                                                                                    |
| V, 2ц              |                                                                             | <ul style="list-style-type: none"> <li>Багшлахуйн арга барилын судалгаа</li> </ul>                                                                                                             |
| V (VI) 2ц          |                                                                             | <ul style="list-style-type: none"> <li>Үнэлгээний судалгаа хийх арга зүй</li> </ul>                                                                                                            |
| VII, 2ц            |                                                                             | <ul style="list-style-type: none"> <li>Ээлжит хичээлийн болон нэгж сэдвийн үнэлгээний судалгаа хийх арга зүй</li> </ul>                                                                        |
| VII (VIII), 2ц     |                                                                             |                                                                                                                                                                                                |
| IX, 2ц             | <b>Семинар 8.</b> Ээлжит хичээлийн бэлтгэл судалгаа хийх                    | <ul style="list-style-type: none"> <li>Тухайн хичээлийн нэгэн ээлжит хичээлийн сэдэв сонгож түүнийг бэлтгэхэд чиглэсэн хичээлийн бэлтгэл судалгаа хийх</li> </ul>                              |
| IX (X), 2ц         | <b>Семинар 9.</b> Ээлжит хичээлийн хөтөлбөр боловсруулах                    | <ul style="list-style-type: none"> <li>Хийсэн бэлтгэл судалгааныхаа үр дүнг ашиглан хичээлийн хөтөлбөр боловсруулах</li> </ul>                                                                 |
| XI, 2ц             | <b>Семинар 10-11.</b> Хичээлд ажиглалт хийх                                 | <ul style="list-style-type: none"> <li>Хичээл ажиглах, тэмдэглэл хөтлөх, судалгааны баримт цуглуулах дадлага хийх</li> </ul>                                                                   |
| XI (XII), 2ц       |                                                                             |                                                                                                                                                                                                |
| XIII, 2ц           | <b>Семинар 12-13.</b> Судалгаат хичээлийн хэлэлцүүлэг                       | <ul style="list-style-type: none"> <li>Хэлэлцүүлэг хийж буй бодит жишээн дээр анализ хийж орчныг хэрхэн бүрдүүлж, хэрхэн хөтлөх дээр дүгнэлт гаргах</li> </ul>                                 |
| XIII (XIV), 2ц     |                                                                             | <ul style="list-style-type: none"> <li>Судалгаат хичээлийн хуудсыг бөглөсөн жишээтэй танилцах</li> <li>Хэлэлцүүлэгт бодитойгоор оролцох</li> </ul>                                             |
| XV, 2ц             | <b>Семинар 14-15.</b> Судалгаат хичээлийн хөтөлбөрийг сайжруулах            | <ul style="list-style-type: none"> <li>Ажиглалтын тэмдэглэл, хэлэлцүүлгийн дүнг үндэслэн судалгаат хичээлийн хөтөлбөрийг сайжруулах үндэслэлийг тодорхойлох, хөтөлбөрийг сайжруулах</li> </ul> |
| XV (XVI), 2ц       |                                                                             |                                                                                                                                                                                                |
| XVI, 2ц            | <b>Семинар 16.</b> Хичээлийн судалгааны талаар сурсан зүйлээ нэгтгэн дүгнэх | <ul style="list-style-type: none"> <li>Хичээлийн судалгааны үндсэн алхам, хичээлийн судалгаа ба судалгаат хичээл, хичээлийн бэлтгэл судалгаа</li> </ul>                                        |

#### Семинарын хичээлийн үнэлгээ:

Семинарын хичээлийн туршид гүйцэтгэсэн ажлын оролцоо, илтгэсэн байдал, боловсруулсан бүтээл, гаргасан шүүмж тус бүрийн гүйцэтгэлийн нийлбэрээр үнэлнэ.

- |                                                         |                  |
|---------------------------------------------------------|------------------|
| ○ Гүйцэтгэсэн ажлын оролцоо                             | <b>5.0 оноо</b>  |
| ○ Илтгэсэн байдал, боловсруулсан бүтээл, гаргасан шүүмж | <b>9.0 оноо</b>  |
| ○ Семинарын гүйцэтгэл, даалгавар, дэвтэр хөтлөлт        | <b>10.0 оноо</b> |
| ○ Ирц                                                   | <b>1.0 оноо</b>  |
| <b>Нийт:</b>                                            | <b>25 оноо</b>   |

## “ХИЧЭЭЛИЙН СУДАЛГАА” хичээлийн тодорхойлолтын ТАЙЛБАР

Хичээлийн тодорхойлолтод тухайн их, дээд сургууль бүр өөрийн онцлог бүхий бүтэц дизайныг баримталдаг тул энэхүү үлгэрчилсэн тодорхойлолтод зохих өөрчлөлт хийх, нэмэх боломжтой болно. Үлгэрчилсэн тодорхойлолтод зарим нэг тайлбар өгөх нь зүйтэй гэж үзэж байна.

- Дээд боловсролын тухай хууль ёсоор их, дээд сургуулийн хичээлийн багтаамжийг багц цаг (кредит)-аар тодорхойлдог. “Хичээлийн судалгаа” хэмээх 2 багц цагийн багтаамж бүхий хичээлийн агуулгын 1 багц цагийг лекц, 1 багц цагийг семинарын хэлбэрээр судална. Энэ нь долоо хоногт 1 цагийн лекц, 2 цагийн семинар, 4 цагийн бие даалт ноогдоно гэсэн үг юм. Иймээс тус хичээлийн үлгэрчилсэн тодорхойлолтод **“Хичээлийн багц цаг: 2 (1 лекц : 1 сем : 0 лаб)”**, **“Долоо хоногт хичээллэх цаг: 1 лекц : 2 сем : 0 лаб : 4 бие даалт”** гэсэн тусгасан. Үүнийг тухайн сургууль нь хичээлийн тодорхойлолтодоо баримталдаг загварт нийцүүлэн хэрэглэнэ.
- “Хичээлийн судалгаа” хичээлийг хэрэгжүүлэхэд оюутан-багшийн урьдчилан эзэмшсэн байвал зохих мэдлэг, чадварыг мэргэжлийн дидактик болон багшлах дадлагаар эзэмшсэн байдаг. Жишээлбэл, мэдлэг эзэмшилтийн болон алдааны судалгаа хийхэд ЕБС-д тодорхой хэмжээнд хичээл зааж байсан, сурагчтай ажиллаж байсан багшийн бодит туршлага хэрэгтэй болно. Мөн багш бэлтгэгдэг их, дээд сургуулийн хэрэгжүүлж буй хөтөлбөрийн онцлогоос хамаараад мэргэжлийн дидактик хичээл болон багшлах дадлагыг харилцан адилгүй улиралд судалдаг тул үлгэрчилсэн тодорхойлолтод **“Судлах улирал: Тухайн их, дээд сургуулийн хэрэгжүүлж буй сургалтын төлөвлөгөөгөөр зохицуулагдана”**, **“Өмнөх холбоо: Тухайн мэргэжлийн багшлах дадлага”** байна гэсэн болно.
- Энэхүү хичээлийн хувьд “Лекцийн хичээлээр авсан онолын ерөнхий мэдлэгээ ЕБС-д заах тодорхой, бодит нэгж, ээлжит хичээлийн жишээн дээр буулган турших, түүнээсээ хамтран суралцах арга зүй”-г хэрэгжүүлэхийн тулд дараах хүснэгтэд үзүүлсний дагуу лекц, семинарын хичээлийн дарааллыг баримтлахыг зөвлөж байна.

| хичээлийн<br>хэлбэр | цаг | тэгш<br>дх-т4ц | сондгой<br>дх-т4ц | д.х. |     |     |     |     |    |    |    |     |     |      |      |      |      |    |    | нийт цаг |     |     |      |      |      |      |     |     |     |     |    |
|---------------------|-----|----------------|-------------------|------|-----|-----|-----|-----|----|----|----|-----|-----|------|------|------|------|----|----|----------|-----|-----|------|------|------|------|-----|-----|-----|-----|----|
|                     |     |                |                   | I    | I   | II  | III | III | IV | V  | V  | VI  | VII | VII  | VIII | IX   | IX   | X  | XI |          | XI  | XII | XIII | XIII | XIV  | XV   | XV  | XVI |     |     |    |
| Лекц 1              | 2   | I              | I                 | I    | II  | II  | III | III | IV | IV | V  | V   | VI  | VI   | VII  | VII  | VIII | IX | IX | X        | X   | XI  | XI   | XII  | XIII | XIII | XIV | XV  | XV  | XVI | 48 |
| Семинар 1           | 2   | II             | I                 | II   | II  | III | IV  | IV  | V  | V  | VI | VI  | VII | VII  | VIII | VIII | IX   | X  | X  | XI       | XI  | XII | XII  | XIII | XIV  | XIV  | XV  | XVI | XVI |     |    |
| Лекц 2              | 2   | II             | II                | II   | III | III | IV  | IV  | V  | V  | VI | VI  | VII | VII  | VIII | VIII | IX   | X  | X  | XI       | XI  | XII | XII  | XIII | XIV  | XIV  | XV  | XVI | XVI |     |    |
| Семинар 2           | 2   | II             | II                | III  | III | IV  | IV  | V   | V  | VI | VI | VII | VII | VIII | VIII | IX   | X    | X  | XI | XI       | XII | XII | XIII | XIV  | XIV  | XV   | XVI | XVI |     |     |    |
| Семинар 3           | 2   | II             | II                | III  | III | IV  | IV  | V   | V  | VI | VI | VII | VII | VIII | VIII | IX   | X    | X  | XI | XI       | XII | XII | XIII | XIV  | XIV  | XV   | XVI | XVI |     |     |    |
| Лекц 3              | 2   | II             | II                | III  | III | IV  | IV  | V   | V  | VI | VI | VII | VII | VIII | VIII | IX   | X    | X  | XI | XI       | XII | XII | XIII | XIV  | XIV  | XV   | XVI | XVI |     |     |    |
| Семинар 4           | 2   | II             | II                | III  | III | IV  | IV  | V   | V  | VI | VI | VII | VII | VIII | VIII | IX   | X    | X  | XI | XI       | XII | XII | XIII | XIV  | XIV  | XV   | XVI | XVI |     |     |    |
| Семинар 5           | 2   | II             | II                | III  | III | IV  | IV  | V   | V  | VI | VI | VII | VII | VIII | VIII | IX   | X    | X  | XI | XI       | XII | XII | XIII | XIV  | XIV  | XV   | XVI | XVI |     |     |    |
| Лекц 4              | 2   | II             | II                | III  | III | IV  | IV  | V   | V  | VI | VI | VII | VII | VIII | VIII | IX   | X    | X  | XI | XI       | XII | XII | XIII | XIV  | XIV  | XV   | XVI | XVI |     |     |    |
| Семинар 6           | 2   | II             | II                | III  | III | IV  | IV  | V   | V  | VI | VI | VII | VII | VIII | VIII | IX   | X    | X  | XI | XI       | XII | XII | XIII | XIV  | XIV  | XV   | XVI | XVI |     |     |    |
| Семинар 7           | 2   | II             | II                | III  | III | IV  | IV  | V   | V  | VI | VI | VII | VII | VIII | VIII | IX   | X    | X  | XI | XI       | XII | XII | XIII | XIV  | XIV  | XV   | XVI | XVI |     |     |    |
| Лекц 5              | 2   | II             | II                | III  | III | IV  | IV  | V   | V  | VI | VI | VII | VII | VIII | VIII | IX   | X    | X  | XI | XI       | XII | XII | XIII | XIV  | XIV  | XV   | XVI | XVI |     |     |    |
| Семинар 8           | 2   | II             | II                | III  | III | IV  | IV  | V   | V  | VI | VI | VII | VII | VIII | VIII | IX   | X    | X  | XI | XI       | XII | XII | XIII | XIV  | XIV  | XV   | XVI | XVI |     |     |    |
| Семинар 9           | 2   | II             | II                | III  | III | IV  | IV  | V   | V  | VI | VI | VII | VII | VIII | VIII | IX   | X    | X  | XI | XI       | XII | XII | XIII | XIV  | XIV  | XV   | XVI | XVI |     |     |    |
| Лекц 6              | 2   | II             | II                | III  | III | IV  | IV  | V   | V  | VI | VI | VII | VII | VIII | VIII | IX   | X    | X  | XI | XI       | XII | XII | XIII | XIV  | XIV  | XV   | XVI | XVI |     |     |    |
| Семинар 10          | 2   | II             | II                | III  | III | IV  | IV  | V   | V  | VI | VI | VII | VII | VIII | VIII | IX   | X    | X  | XI | XI       | XII | XII | XIII | XIV  | XIV  | XV   | XVI | XVI |     |     |    |
| Семинар 11          | 2   | II             | II                | III  | III | IV  | IV  | V   | V  | VI | VI | VII | VII | VIII | VIII | IX   | X    | X  | XI | XI       | XII | XII | XIII | XIV  | XIV  | XV   | XVI | XVI |     |     |    |
| Лекц 7              | 2   | II             | II                | III  | III | IV  | IV  | V   | V  | VI | VI | VII | VII | VIII | VIII | IX   | X    | X  | XI | XI       | XII | XII | XIII | XIV  | XIV  | XV   | XVI | XVI |     |     |    |
| Семинар 12          | 2   | II             | II                | III  | III | IV  | IV  | V   | V  | VI | VI | VII | VII | VIII | VIII | IX   | X    | X  | XI | XI       | XII | XII | XIII | XIV  | XIV  | XV   | XVI | XVI |     |     |    |
| Семинар 13          | 2   | II             | II                | III  | III | IV  | IV  | V   | V  | VI | VI | VII | VII | VIII | VIII | IX   | X    | X  | XI | XI       | XII | XII | XIII | XIV  | XIV  | XV   | XVI | XVI |     |     |    |
| Лекц 8              | 2   | II             | II                | III  | III | IV  | IV  | V   | V  | VI | VI | VII | VII | VIII | VIII | IX   | X    | X  | XI | XI       | XII | XII | XIII | XIV  | XIV  | XV   | XVI | XVI |     |     |    |
| Семинар 14          | 2   | II             | II                | III  | III | IV  | IV  | V   | V  | VI | VI | VII | VII | VIII | VIII | IX   | X    | X  | XI | XI       | XII | XII | XIII | XIV  | XIV  | XV   | XVI | XVI |     |     |    |
| Семинар 15          | 2   | II             | II                | III  | III | IV  | IV  | V   | V  | VI | VI | VII | VII | VIII | VIII | IX   | X    | X  | XI | XI       | XII | XII | XIII | XIV  | XIV  | XV   | XVI | XVI |     |     |    |
| Семинар 16          | 2   | II             | II                | III  | III | IV  | IV  | V   | V  | VI | VI | VII | VII | VIII | VIII | IX   | X    | X  | XI | XI       | XII | XII | XIII | XIV  | XIV  | XV   | XVI | XVI |     |     |    |

Манай их, дээд сургуулиудийн хичээлийн хуваарь 2 цагаар зохиогддог тул долоо хоногт 1 цаг орох багтаамж бүхий хичээлүүд 2 долоо хоног тутамд нэг удаа ордог уламжлал тогтсон байдаг. Гэтэл “Хичээлийн судалгаа” хичээлийн

хувьд лекцийн хичээлийг улирлын эхэнд дараалан 2 долоо хоног судлах шаардлага гарч байгаа болно.

Мөн хичээлийн бэлтгэл судалгаа хийх, хичээл зааж ажиглах, хэлэлцүүлэг зохион байгуулах зэрэгт ЕБС-ийн бодит орчинд ажиллах боломжтой бол тухайн цаг үед шаардлагатай зохицуулалт хийх нь хичээлийн үр дүнд чухал нөлөөтэй юм.


- Энэхүү хичээлээр оюутан-багшийн үнэлгээг хийхдээ тухайн их, дээд сургуулийн үнэлгээний журамд нийцүүлэн зохицуулах боломж бүрэн нээлттэй болно. “Хичээлийн судалгаа” хичээлийн арга зүйн онцлогтой холбоотойгоор оюутан-багш улирлын туршид нэлээд их бүтээлч ажлыг багаар хамтран гүйцэтгэж байгаа тул явцын үнэлгээ болон улирлын шалгалтын онооны 70 : 30 гэсэн харьцааг санал болгосон болно. Мөн явцын үнэлгээний 70 онооны хуваарилалт, хугацаа зэргийг өөрийн сургуулийн онцлогт нийцүүлэн хэрэглээрэй.
- Энэхүү үлгэрчилсэн тодорхойлолт дахь **“Хэрэглэх гарын авлага, эх сурвалж”**-д БШУЯ болон ЖАЙКА олон улсын байгууллагын хамтарсан 2 шатны төслийн бүтээгдэхүүн болох зөвлөмж, гарын авлага, DVD зэргийг, зарим вэб хуудасны хамтаар өгсөн бөгөөд ЕБС-ийн бага, суурь боловсролын түвшинд 7 төрлийн хичээлээр хязгаарлагдаж байгааг харгалзан үзнэ үү. Иймээс “Хичээлийн судалгаа” хичээлийг заах багш эдгээр эх сурвалжтай сайтар танилцаж, оюутан-багшаар судлуулбал зохимжтой байгаа хэсгүүдээ тодорхойлно уу. Мөн англи болон япон зэрэг бусад гадаад хэл дээрх вэб хуудсуудыг өөрийн мэргэжлийн онцлогтоо нийцүүлэн сонгож хэрэглээрэй.

## Удиртгал

| Хичээлийн хэлбэр, цаг | Агуулга                                                                                                                                                                                              | Хэрэглэг дэхүүн         | Бие даах ажил  |
|-----------------------|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------|----------------|
| Лекц 1 /2 ц/          | <ul style="list-style-type: none"> <li>Боловсролын шинэчлэл</li> <li>Багшийн хөгжил буюу ажлын байран дээрээ багш мэргэжлээ дээшлүүлэх асуудал</li> <li>Хичээлийн судалгаа, түүний хөгжил</li> </ul> | ppt                     | Төсөөлөл бичих |
| Семинар 1 /2 ц/       | <ul style="list-style-type: none"> <li>Багшийн ажлын байрны тодорхойлолт ба хичээлийн судалгаа</li> <li>Багшийн ажлыг үнэлж дүгнэх журам ба хичээлийн судалгаа</li> </ul>                            | Эрх зүйн баримт бичгүүд |                |

### Лекц 1: Удиртгал /2 цаг/

#### 1. Боловсролын шинэчлэл



“Зөв Монгол хүн төлөвшүүлэх” бодлогыг амжилттай хэрэгжүүлэхийн тулд боловсролыг зөв оновчтой шинэчлэх шаардлага бидний өмнө тулгарч байна. Боловсролын шинэчлэлийн нэг хэсэг нь СӨБС, ЕБС, их, дээд сургуулийн багш нарыг чадваржуулах, өөрөөр хэлбэл хандлага, харилцаа, аргазүйг өөрчлөх хэрэгтэй. Өнөөгийн суралцагчдын амьдарч буй нийгмийн хөгжил асар хурдацтай урагшилж буй учир багш нар 10,

20 жилийн өмнөх хуучин арга барилаараа явах боломжгүй болжээ. Сургалтын нэгж хэсэгт судалгаа-дүгнэлт хийдэг **хичээлийн бэлтгэл судалгаа, хичээлийн судалгаа** нь багшийн арга зүйг шинэчлэхэд чухал ач холбогдолтой гэж судлаачид үзэж байна.

#### Боловсролын шинэчлэлийн зорилго

ИРГЭНИЙ АРДЧИЛСАН НИЙГМИЙН ҮНЭТ ЗҮЙЛСИЙГ ЭРХЭМЛЭСЭН ЭХ ОРОНЧ БҮТЭЭЛЧ ӨРСӨЛДӨХ ӨНДӨР ЧАДВАР БҮХИЙ БОЛОВСРОЛТОЙ “ЗӨВ МОНГОЛ” ХҮНИЙГ ТӨЛӨВШҮҮЛЭХ ОЛОН ТАЛТ НӨХЦӨЛ БОЛОМЖИЙГ БҮРДҮҮЛНЭ.

“Зөв Монгол хүн” шинэчлэлийн хөтөлбөрийн зорилтын чиглэлүүд:

- Боловсролын удирдлага, менежмент чанарын шинэчлэл
- Багш хөгжлийн шинэчлэл
- Хувь хүний хүсэл зорилгод суурилсан шинэчлэл
- Боловсролын хүртээмжтэй аюулгүй орчны шинэчлэл

“Зөв Монгол хүн” шинэчлэлийн хөтөлбөрийн зорилтын хүрээнд хийгдэх ажлууд:

- Сургалтын агуулга, арга зүйг шинэчлэх, зохион байгуулалтыг оновчтой болгох

- Багшийг судлаач, хүүхдийн авьяасыг нээх эрэлхийлэгч болгох, багшийн ур чадварыг сурагчийн хөгжлөөр үнэлэх

**Боловсролын шинэчлэлийн бодлого**

- Багшлах боловсон хүчнийг хөгжүүлэх
- Нийгмийн идэвхтэй иргэн болох суралцагчийг хөгжүүлэх

- Сургалтыг өөртөө итгэлтэй, эргэцүүлэн бодох, өөрийгөө илэрхийлэх чадвартай, сурах хүсэл эрмэлзэлтэй, сурах арга барилтай хүүхэд болгох зарчимд тулгуурлан шинэчлэх

- Сургуулийг хүүхдийн хөгжлийн төв болгох, нэг багшид ноогдох хүүхдийн тоог цөөрүүлэх

Боловсролын шинэчлэлээр Монголын бүх шатны боловсролын байгууллагууд:

**Боловсролын тогтолцоо**

- Хүний төлөө тэднийг **дэмжин хөгжүүлэх** хүмүүнлэг үйлчилгээ үзүүлэхэд чиглэсэн насан туршийн тасралтгүй хөгжлийг хангахад чиглэгдэнэ.
- **Хүүхэд бүрийг хөгжүүлэх** бодлого хэрэгжүүлж тогтолцооны шинэчлэл хийнэ.
- Нэг ч хүүхдийг орхигдуулахгүйгээр сургах тогтолцоог бүрдүүлнэ.

- Эрх чөлөө, шударга ёс, тэгш эрх, олон ургальч үзэл гэх мэт иргэний ардчилсан нийгмийн үнэт зүйлсийг эрхэмлэсэн

- зөв төлөвшилтэй
- бүтээлч, өрсөлдөх өндөр чадвар бүхий боловсролтой иргэн төлөвшүүлэхэд чиглэсэн
- олон жилийн судалгаатай бодлогод тулгуурлан тогтвортой хөгжих боломж бүрдэх юм байна.

**1. Багш бүр**

- Хүүхэд бүр сурч чадна гэдэгт итгэх
- Хүүхэд бүр ялгаатай гэдгийг ойлгох
- Хүүхдийн гаргаж буй “алдаа”-ны 80-90% багшийн арга зүйн алдаанаас гарсан гэдгийг хүлээн зөвшөөрөх
- Хүүхэд бүрийг судлан, тэднийг дэмжин хөгжүүлдэг арга барилд суралцах

**Боловсролын шинэчлэлийн үзэл санаа**

- Хүүхэд бүрт хичээл зааж сургах гэдэг ойлголтоос хүүхэд бүрийг өөрийн гэсэн **сонирхолтой** хичээл хийх чадвартай ном унших хүсэлтэй чармайлттай болгоход нь тусалдаг систем эцэг эх сургууль багш нартай хамтран ажиллах үүрэг оролцоог хөгжүүлэхийг зорьж байна.

2. Багшийн ажлын үр дүнг хүүхэд бүрийн хөгжлөөр үнэлэх

3. Хүүхэд нэг бүрийг орхигдуулахгүйгээр сургадаг тогтолцоонд шилжих

4. Нэг багшид ноогдох хүүхдийн тоог цөөлөх

5. Эцэг эх-сургууль-багшийн хамтын ажиллагааг боловсронгуй болгох

6. Хүүхдийн сурч төлөвшихөд эцэг эхийн оролцоог нэмэгдүүлэх, тэдний сурган

хүмүүжүүлэх мэдлэг чадварыг дээшлүүлэхэд онцгой анхаарах

7. Хүүхэд багаасаа номонд дуртай болох компанит ажил улс орон даяар зохион байгуулах

**Суралцахуйн конструктив когнитив онолоор**

Аливаа мэдлэг багшаас суралцагчдад зүгээр нэг дамждаг зүйл биш харин Сурагчид өөрийн идэвхтэй үйл ажиллагаагаар зохиомжлон бүтээдэг юм. Иймд орчин үеийн хичээлийн гол зорилго:


- Багш- хүүхдийн хөгжлийг дэмжигч
- Хүүхэд орчинтойгоо харьцах явцдаа мэдлэг бүтээх, мэдлэг олж авах аргад сургах явдал юм.

- Хүүхэд сонирхолтой хичээл заадаг сургууль уруугаа яардаг болгохын тулд **хичээлийн судалгааг жинхэнэ утгаар нь хийх.**
- Шинэ арга зүйг үзүүлэх, шинэ арга зүйг харж ажиглах нь хичээл заагч болон ажиглагч хоёул **хөгжин** дэвших боломж олгодог.
- Хүүхдийг илүү ойлгож, хүүхэд багш бүрт үр өгөөж өгч чадахаар хичээлийг багш нар **хамтдаа төлөвлөж, боловсруулж** хүргэхийг зорих.

“Зөв Монгол хүн” төлөвшүүлэх хөтөлбөр, боловсролын шинэчлэл, ЕБС-ийн стандарт, хөтөлбөрийн хэрэгжилт нь ээлжит хичээл бүрийн чанараас, цаашилбал хүүхэд нэг бүрийн сурлагын амжилтаас шууд шалтгаална. Иймд оюутан-багш та бүхэн ээлжит хичээл нэг бүрийг чанартай явуулахын тулд хичээлийн бэлтгэл судалгааг хийж түүний үр дүнг хичээлийн хөтөлбөр боловсруулахад оновчтой тусгах арга барилд суралцах хэрэгтэй юм.


Хамтаараа хичээлийн бэлтгэл судалгаа хийх, хичээлийг хамтран төлөвлөх, заах, ажиглах, хэлэлцэх явцдаа арга зүйд суралцах боломжтой юм.

## **2. Багшийн хөгжил буюу ажлын байран дээрээ багш мэргэжлээ дээшлүүлэх асуудал**



Багшийн хөгжлийн асуудлыг “нийгмийн хөгжил-боловсролын шинэчлэл-кирикюлим өөрчлөлт-багшийн хөгжил” гэсэн уялдаа холбоонд авч үзэх нь зүйтэй юм. Нийгмийн хөгжил болон боловсрол нь маш нягт харилцан хамааралтай үйл явц бөгөөд нийгмийн хөгжлийн тодорхой үе болгон боловсролоор дамжуулан дараах үеэ бэлтгэдэг. Орчин үед иргэний боловсролыг чанаржуулан, хүн ардынхаа дотоод нөөцийн

бүтээх чадавхийг тасралтгүй дээшлүүлж байгаа улс бүр бусад улс оронтой өрсөлдөх чадвартай болж, даяарчлалын нөхцөлд зохицож, уламжлалаа хадгалан бие даан хөгждөг болсон. Ийм үед манай улс боловсролын чанарыг эрс сайжруулж, нийт хүн ард, ялангуяа, залуу үеийнхээ бүтээх чадавхийг зохих хэмжээгээр дээшлүүлэх асуудал боловсролын тулгамдсан зорилт болж байна. Бага, дунд боловсролын түвшинд хүүхэд залуучуудаа хариуцлагатай, бүтээлч, ухамсартай иргэн болоход нь бодитой дэмжлэг үзүүлэхийн тулд юуны өмнө шинжлэх ухааны үндэслэлтэй боловсруулсан үндэсний кирикюлим, түүнийг хэрэгжүүлэх мэдлэг, үр чадвартай багштай байх нь зайлшгүй юм.



Ер нь боловсролын үндэсний киррикулим ба багш мэргэжлийн ур чадвар хоёр хоорондоо салшгүй холбоотой ойлголт байдаг. Яагаад гэвэл киррикулим буюу сургалтын хөтөлбөр нь багшаар дамжин сургах, суралцах бодит үйл ажиллагаа болдог учраас шинэ технологи, шинэ хөтөлбөрийг хэрэгжүүлэх гол хариуцлага багшид оногддог. Боловсролын шинэчлэлийн алхам тутамд


улам ил тод болж байгаа нэг асуудал бол багшаа хөгжүүлж өөрчлөхгүйгээр боловсролын шинэчлэл амжилттай болохгүй гэдэг мэдрэмж юм. Шинэ киррикулимийг хэрэгжүүлэгч багш нь тодорхой шинжлэх ухааны салбарт сайн мэргэжилтэн, хүний сэтгэл оюуныг эзэмдэгч сэтгэл зүйч (хүүхдийг оношлох), киррикулимээ байнга хөгжүүлэгч судлаач (хүүхдийн гаргаж буй алдааны дийлэнх хувь нь багшийн арга зүйн алдаанаас үүдэлтэй гэдгийг хүлээн зөвшөөрөх), хүнийг хөгжүүлэх арга техникийг гарамгай эзэмшсэн технологич (хүүхэд бүрийг онцлогт нь нийцүүлэн хөгжүүлэх), сургалтын үйл ажиллагааг чанартай үр ашигтай зохион байгуулагч менежер (хүүхэд нэг бүрийг орхигдуулахгүйгээр сургах) зэрэг олон мэргэшлийн ур ухааныг төгс эзэмшсэн, цаг үеэ дагуулсан “дархан” хүн байх ёстой болж байна. Өөрөөр хэлбэл, багш мэргэшлийн ур чадварын өөрчлөлт нь өргөөшөө ч олон шинэ салбар ухаанаар тэлж, өндрөөшөө ч эрэмбэ ахисан арга зүйгээр гүнзгийрэх үйл явцаар тодорхойлогдож байна.



Багш гэж хэн бэ? гэсэн асуултад хариулахын тулд нийгмийн хөгжлийн хүчин зүйлээс гадна шинжлэх ухааны болон нийгмийн хөгжлийн шаардлагаар энэ ухагдахуун хэрхэн өөрчлөгдөж ирсэн түүхэн үйл явцыг судалсан гол дүгнэлтүүдийг авч үзье. Багш боловсролын философи үндэслэлийг тодорхойлсон судалгаанд багшийг суралцагчийн мэдлэгийг сэргээн хөгжүүлэгч (идеализм), бодит мэдээллийг боловсруулан

дамжуулагч (реализм), суралцагчийн оршин байхад нь туслагч, зөвлөгч (экзистенциализм), суралцагчид мэдлэгээ хүч болгон хувиргахад нь туслагч, дэмжигч (прагматизм), өдөөгч-хариу үйлдлийн диалектик холбоогоор бусдыг дасгалжуулагч, сургагч (бихевиоризм), суралцагч мэдлэгээ өөрөө бүтээх үйл ажиллагааны менежер (конструктивизм) гэж тодорхойлсон байдаг. Харин багш боловсролын агуулга хөгжлийн явцад хэрхэн өөрчлөгдөж ирсэн талаар дурдсан судалгаанд багш бол оюун ухаан болон зан үйлийг дасгалжуулагч → тухайн шинжлэх ухааны мэргэжилтэн судлаач → тодорхой шинжлэх ухааны дидактикч → боловсролын киррикулимч, сургалтын менежер, тухайн салбарын мэргэжилтэн судлаач гэж түүхэн хөгжлийн явцад өөрчлөгдөж ирсэн хэмээн

үзжээ. Түүхийн аль ч цаг үед, философийн аль ч зарчимд тулгуурласан багш ухагдахуун нь олон талт агуулгатай байна.



Багш хүний мөн чанарыг тодорхойлох судалгааны ажлууд хийгдэж “багшийн загвар” боловсруулсны нэг нь БСШУЯ, ЮНЕСКО-ийн бүсийн төвийн дэмжлэгтэйгээр хэрэгжсэн “Математик, байгалийн ухааны багш бэлтгэх кррикулимийн судалгаа” сэдэвт төслийн хүрээнд боловсруулсан “Багш пирамид” загвар юм. Энэхүү загвараар орчин үеийн багш хүний гүйцэтгэх үйл ажиллагаа, түүний агуулгыг дараах байдлаар тодорхойлсон

байна. Үүнд:

- Суралцагчдад тодорхой шинжлэх ухааны мэдлэг, чадвар эзэмшүүлэх үйл ажиллагаа-тухайн шинжлэх ухааны цогц чадамж
- Суралцагчдад мэдлэг, чадвар эзэмшүүлэх үйл ажиллагааг өндөр түвшинд гүйцэтгэх дадал, хэвшил-Тухайн шинжлэх ухааны дидактикийн цогц чадамж
- Суралцахуйн үйл явцыг амьд организм мэт мэдрэх мэдрэмж, түүнийг жолоодох эв дүй-Багш мэргэшлийн цогц чадамж
- Мэдлэг чадвар, дадал хэвшил, эв дүйд илрэх хариуцлага, ёс зүй-Багш хүний төрөлх шинж

*Нийгмийн тасралтгүй хөгжил нь боловсролын тасралтгүй шинэчлэлийг, боловсролын тасралтгүй шинэчлэл нь багшийн байнгын хөгжлийг шаардаж байдаг.* Энэхүү нийгэм түүхийн шаардлагыг хамгийн бага эрсдэлтэйгээр, хамгийн их үр дүнтэйгээр хангаж, багш хөгжих, боловсролын чанарыг баталгаажуулах хүч боломж “хичээлийн судалгаа”-нд байгааг нэгэнт хүлээн зөвшөөрөх болсон байна.

### 3. Хичээлийн судалгаа, түүний хөгжил

Төслийн хүрээнд Япон хэлний жүгё кэнкю гэсэн нэр томъёог хичээлийн судалгаа гэж орчуулсан бөгөөд одоо үндсэндээ энэ нэр томъёог хэрэглэж хэвшиж байна. JUGYO KENKYU буюу ЖЮГЁ-КЭНКЮ нь Япон хэлний жүгё-хичээл, кенкю-судлал, судалгаа, шинжилгээ гэсэн үгний транслитераци бөгөөд одоогоор Америк зэрэг олон оронд орчуулахгүйгээр хэрэглэж байна. Японы

жүгё-кэнкю нь маш эртний түүхтэй бөгөөд орчин үед:

- Багш ажлын байрандаа мэргэжил дээшлүүлэх албан бус тогтолцоо
- Арга зүйн шинэчлэлийг хөгжүүлэх тогтолцоо
- Боловсролын шинэчлэлийг түгээн дэлгэрүүлэх тогтолцоо болтлоо хөгжсөн гэж үздэг байна.

| Хичээлийн судалгаа                                                                                                                                                                                                                                                                  |
|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| <ul style="list-style-type: none"> <li>• Jugyo-lesson</li> <li>• Kenkyu-study or research<br/>Lesson study &gt;&gt; Study of lesson</li> <li>• Jugyokenkyu group &amp; subgroup</li> <li>• Jugyokenkyu is not common in Japanese high schools</li> </ul>                            |
| <ul style="list-style-type: none"> <li>• Багшийн мэргэжил дээшлүүлэх тогтолцоо</li> <li>• Заах арга зүйг хөгжүүлэх тогтолцоо</li> <li>• Боловсролын шинэчлэлийг түгээн дэлгэрүүлэх тогтолцоо</li> <li>• Японы онцлог нь ИДС-ийн профессорын оролцоо өндөр (Fujii sensei)</li> </ul> |


Хичээлийн судалгаанд оролцож хичээл зааж байгаа багшид ч, хичээлд ч оноо өгч, дүн тавьдаггүй бөгөөд оролцогчид бүгдээрээ шинийг эрэлхийлж, суралцаж судалдаг, залуу болон тухайн сэдвийг анх удаа заах багшид чухал эх сурвалж болдог, хүүхэд судлал, хичээл судлалын чухал эх сурвалж болдог зэрэг олон давуу талтай багш нарын сайн дурын үйл ажиллагаа юм.

Хичээлийн судалгааг хийх хэрэгжүүлэх бодит үйл ажиллагааны үр дүнд бидний уламжлалт олон жил хийж байсан “хичээлийн анализ”-ыг одоо Та бүхэнд ухааруулах гээд байгаа “хичээлийн судалгаа”-ны аргатай харьцуулж тайлбарлах нь зүйтэй болохыг бид мэдэрсэн юм. Өнгөц, дутуу ухаарч харвал өнөө бидний хийдэг л ажил (хичээлийн анализ) гэж ойлгогдоно. Хичээлийн судалгааны туршлагатай багш өөрийн биеэр туршиж байж сая хичээлийн анализ, хичээлийн судалгааны мөн чанар, ялгааг, хичээлийн судалгаанд шинээр оролцож байгаа багштай харьцуулж мэдэрч байна. Уламжлалт хичээлийн анализ багшийн заах арга зүйг үнэлэх, хөгжүүлэх гол зорилготой байсан бол хичээлийн судалгаа нь хичээлийн арга зүйг суралцахуйг дэмжих чиглэлээр хэрхэн хөгжүүлэх вэ? гэдэгт гол анхаарал хандуулдаг.

Уламжлалт хичээлийн анализийн арга нь багш төвтэй, багш мэдээллийг хэрхэн дамжуулж байгаа арга зүйд чиглэгддэг бол орчин үеийн хичээлийн судалгааны арга нь хичээлийн дидактик шийдэл, төлөвлөлтийг сурагчид хэрхэн хүлээн авч байгаа тэрхүү байдалд ажиглалт хийж, хичээлийг хүүхдийн танин мэдэхүйд нийцүүлэн шинэчлэн сайжруулах арга зүйг эрхэмлэнэ.

Хичээлийн уламжлалт анализ нь мэдлэг дамжуулах багшийн ур чадвар буюу заах аргыг хөгжүүлэхэд чиглэсэн шалгуураар үнэлгээг явуулдаг. Харин орчин үеийн хичээлийн ажиглалт судалгаа нь суралцахуйн сэтгэл судлалын конструктивизмын “мэдлэг бүтээгддэг” зарчимд тулгуурлан суралцагчдын болон багшийн алдаа, оноо, сурах байдалд дүгнэлт хийх замаар “хичээл”-ийн арга зүйг хөгжүүлэх байдлыг илрүүлэхүйц шалгуураар хичээлийг үнэлнэ.

Хичээлийн анализ нь багшийн заасан тухайн нэг удаагийн хичээлд үндэслэн багшид санал шүүмж өгөх, үнэлгээ дүгнэлт өгөх, зөвлөхөд илүү ач холбогдол өгдөг (багшийн ганцаарчилсан үйл ажиллагаа давамгайлсан) бол хичээлийн судалгаа нь харин багшаар тухайн хичээлийг тодорхой давталттай заалгаж, зааж буй хичээлийн аргазүй суралцагчдын суралцах зүй тогтолд хэрхэн үр өгөөжтэй болж байгаа өөрчлөлтөд үндэслэн үнэлгээ, дүгнэлт өгнө. Өөрөөр



хэлбэл, багш ба мэргэжилтний хамтын үйл ажиллагаа давамгайлсан шинжтэй.

Хичээлийн судалгааг 3, 4, заримдаа 5 үе шаттай хэмээн тайлбарласан байдаг ч үнэндээ хичээлийн бэлтгэл (төлөвлөлт), хичээл зааж ажиглах, хэлэлцүүлэг хийх гэсэн үндсэн гурван алхмаас тогтоно. Тухайн хичээлийн судалгааны зорилго, хамрах хүрээ гэх мэт олон хүчин зүйлээс хамааран дээрх

гурван алхмыг дэлгэрүүлэн задлах гэх мэт байдлаар авч үзэж болно. Жишээлбэл, нэг удаагийн судалгаат хичээлийн хэлэлцүүлэгт үндэслэн тухайн хичээлийн хөтөлбөрийг сайжруулах үйл ажиллагааг зарим тохиолдолд 4-р алхам буюу хичээлийн төлөвлөлтийг сайжруулах гэж нэрлэсэн байдаг. Гэвч энэ нь сайжруулсан хөтөлбөрөөр заах судалгаат хичээлийн хувьд хичээлд бэлтгэх/хичээлийг төлөвлөх алхам байдаг. Дараа дараагийн лекц семинарын хичээлүүд хичээлийн судалгааны үндсэн 3 алхмын дагуу явагдах болно. Иймд алхам тус бүрийн талаар энд дэлгэрэнгүй дурдахгүй.



Хичээлийн судалгаа болон судалгаат хичээлийг нэг зүйл гэж үзэх, ялгааг нарийн гаргахгүй байх тохиолдол нэлээд ажиглагддаг. Хичээлийн судалгаа гэдэг бол багш өөрийн заах арга зүйгээ сайжруулах, ажлын байран дээрээ мэргэжлээ дээшлүүлэх, сургууль сургалтын чанараа дээшлүүлэх гэх мэт олон шатны зорилгыг хангахад чиглэсэн тасралтгүй үйл ажиллагаа

юм. Энэхүү тасралтгүй байх чанарыг нь хангасан хичээлийн судалгааг явуулах үед бид бүхэнд хичээлийн судалгаа ба судалгаат хичээлийн ялгаа, эрэмбэ тодорхой харагдах болно. Судалгаат хичээл бол хичээлийн судалгааны үндсэн нэгж юм. Хичээлийн судалгааны 3 алхмыг нэг удаагийн ээлжит хичээлд буулгаж хэрэгжүүлсэн судалгааны нэгжийг судалгаат хичээл гэж нэрлэж болно. Харин хичээлийн судалгаа бол харьцангуй урт хугацааг хамарсан тасралтгүй үйл ажиллагаа гэж үзвэл судалгаат хичээлүүдийн хооронд багш тухайн хичээлийн судалгааны зорилгод чиглэсэн “багшийн хувийн судалгаат хичээл”-ийг зохион байгуулах ёстой байдаг. Бид ингэж нэрлэдэггүй учраас манай багш нар ажиглагчгүй хичээлдээ хуучин барилаараа хандах нь элбэг байна. Мэдээж “багшийн хувийн судалгаат хичээл”, эсвэл ажиглагчгүй ээлжит хичээлд хэлэлцүүлэг хийгдэхгүй боловч багш ажлын байрны тодорхойлолтод заасны дагуу заасан хичээлийнхээ үр дүнг үнэлэх сайжруулахын тулд “өөрийн үнэлгээ/хэлэлцүүлэг” хийж байж сая “хичээлийн судалгаа” жинхэнэ утгаараа хийгдэх нэг нөхцөл бүрдэнэ. Энэ курс хичээлээр оюутан-багш та тодорхой сэдвийн хичээлээр судалгаат хичээлийн хүрээнд хичээлийн судалгааны ерөнхий арга барилд суралцах бөгөөд жинхэнэ ажлын байран дээрээ очоод 2-3

жилийн хугацаатай “жинхэнэ” хичээлийн судалгааг хийгээрэй. Гэвч лекц, семинарын үеэр тухайн контекстээс хамааран судалгаат хичээл гэхээсээ хичээлийн судалгаа гэсэн нэр томъёог түлхүү хэрэглэсэн болно.

Хичээлийн судалгаа нь сүүлийн арваад жилд олон улсын хэмжээнд боловсрол судлалын нэгэн шинэ судалгааны талбар болон хөгжиж

#### Байгууллага, сэтгүүл

- **The World Association of Lesson Studies (WALS)** /Хичээлийн судалгааны олон улсын холбоо/, Үүсгэн байгуулагч: Australia, China, Japan, Singapore, Sweden, United Kingdom, United States, <http://www.worldals.org/>  
– Жил бүрийн олон улсын хурал: WALS
- **International Journal for Lesson and Learning Studies** Хичээл болон Суралцахуйн судалгааны олон улсын сэтгүүл
- **Lesson Study Alliance**, Chicago Хичээлийн судалгааны нэгдэл  
– The Chicago Lesson Study Group  
– CLSG Meeting, Colloquia, Conference, Public Research Lessons, Lesson Study Summer Institute

байна. Олон улсын хэмжээний томоохон төслүүд хэрэгжихийн зэрэгцээ хичээлийн болон суралцахуйн судалгааны чиглэлээр хийгдсэн судалгааг хэвлэн нийтэлдэг олон улсын бие даасан сэтгүүл хэвлэгдэж байна.

**Судалгааны чиглэл**

- Deepening Student Learning through Lesson Study Хичээлийн судалгаагаар суралцагчийн суралцахуйг гүнзгийрүүлэх нь судалгааг дэмжих түншлэл
- Partnerships to Sustain Lesson Study Хичээлийн судалгааг дэмжих түншлэл
- Learning Communities and School Reform through Lesson Study Хичээлийн судалгаанд суурилсан сургуулийн реформ ба суралцахуйн хамтын нийгэмлэг
- Developing Tools and Arte facts for supporting Lesson Study and Instructional Approaches Хичээлийн судалгаа болон сургалтын хандлагыг дэмжсэн хэрэглэгдэхүүн болон артефактыг боловсруулах
- ....

хичээлийн судалгаа, хичээлийн хандлагыг дэмжсэн хэрэглэгдэхүүнийг боловсруулах зэрэг чиглэлээр сонирхол татсан судалгааны дүнгүүд хэлэлцэгдэх болсон байна.

**Lesson Study in Transnational space**  
**Хичээлийн судалгаа Олон Улсын хэмжээнд**  
John Elliott, International Journal for Lesson and Learning Studies, Volume 1, Issue 2

|                                                                                                                                                                                                                             |                                                                                                                                                                                                                                        |
|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| <p><b>Япон болон Хятад</b></p> <ul style="list-style-type: none"> <li>• Багш нар хамтын хариуцлага хүлээдэг</li> <li>• Хичээлийн судалгааг “судалгаа, шинжилгээ” гэдэг утгаар дүрслэн үзэхэд багахан бэрхшээлтэй</li> </ul> | <p><b>Европ болон АНУ</b></p> <ul style="list-style-type: none"> <li>• Хувь багш ганцаарчилсан хариуцлага хүлээдэг</li> <li>• Багш нар “судлаач” гэсэн үгээр өөрийгөө илэрхийлүүлэх /нэрлүүлэх/-хүсэлгүй байдаг</li> </ul>             |
| <p><u>Багш нар агуулга, арга зүй, хөтөлбөрийн талаарх мэдлэгээ гүнзгийрүүлэх зорилго бүхий мэргэжлийн суралцахуйн хамтын нийгэмлэгт нэгдэж байгаа нь</u> хичээлийн судалгаа гэж үзэх <u>үзэл</u></p>                        | <p>Багш нар хичээлээ бэлтгэхдээ хэрэглэх ёстой <u>хичээлийн идеаль маягт гаргах зорилготой бүтээгдэхүүн боловсруулах нэг хэлбэрт</u> багш нарын зарим бүлэг оролцох /богтлох/ нь хичээлийн судалгаа гэж үзэх <u>эндүү хандлага</u></p> |

Хичээлийн судалгааны чиглэлээр мэргэшсэн, дэлхийд хүлээн зөвшөөрөгдсөн эрдэмтэд энэ чиглэлд хийгдэж байгаа судалгааны ажлуудад мета-анализ хийж хөгжлийн чиг хандлага, судалгаанд гарч байгаа дэвшилтэт ололт болон зарим алдаа буруу хандлагыг шүүн хэлэлцэж байна. Мэдээллийн орон зайд хил хязгаар үгүй болсон өнөө цагт оюутан-багш та бүхэн дэлхийн олон нийттэй хөл нийлүүлэн алхаж бодит боломж байгааг анхаарч үзээрэй.

хичээлийн судалгааг олон улсын



судалгааны зорилгыг авч үзье. Аливаа үйл ажиллагааг хэрэгжүүлэхийн зорилго тодорхой байх нь үйл ажиллагааны үр дүнг үнэлж тодорхойлох үндэс болдог. Үүний нэгэн адил оюутан-багш та хичээлийн судалгааг ямар зорилгоор хийж буйгаа сайтар ойлгох хэрэгтэй. Улс орон бүр, аймаг дүүрэг бүр, сургууль бүр, багш бүр хичээлийн судалгаагаар харилцан адилгүй зорилго тавин ажиллаж болно. Жишээлбэл, Японд голдуу математик, япон хэлний хичээлд, харин АНУ-д математик, байгалийн ухаан, хэл, зургийн хичээлүүдэд судалгаа хийгддэг. Энэ нь эдгээр хичээлийн үүрэг ач холбогдол, заах арга зүйг сайжруулах хэрэгцээ, шаардлагатай уялдан гарч ирдэг байна.

Японд дараах зорилгоор хичээлийн судалгааг хийдэг. Үүнд:

- Суралцагчдын хувьд ойлгоход хэцүү сэдвийн арга зүйг боловсруулах
- Багш нарын хувьд заахад хүнд сэдвүүдийн арга зүйг боловсруулах
- Хүүхдийн буруу, ташаа ойлголтыг засах арга зүйг боловсруулах
- Шинээр судалж буй хичээлийн агуулга, арга зүйг боловсруулах гэсэн байна.

#### Хичээлийн судалгааны зорилго

- Түвшин 1: Тухайн судалгаат хичээлийн тусгай зорилго
- Түвшин 2: Тухайн нэгж хичээлийн тусгай зорилго
- Түвшин 3: Тухайн хичээлийн ерөнхий зорилго
- Түвшин 4: Суралцагчдын хөгжүүлж, төлөвшүүлэх зорилго (long-term goal)

Хичээлийн судалгаа нь нэлээд урт хугацаанд уйгагүй ажилласны дүнд бодит үр дүнгээ өгдөг бөгөөд тиймээс хичээлийн судалгааны зорилгыг хэд хэдэн түвшинд тодорхойлж болно. Үүнд:

Түвшин 1: Тухайн судалгаат хичээлийн тусгай зорилго. Хичээлийн судалгааны тухайн судалгаат хичээлийн хүрээнд шийдэх асуудалд төвлөрнө.

Жишээ нь:

- Дараагийн хичээлд сэдэлжүүлэх зорилгоор Хөшүүргийн зарчмыг ашиглах, асуудлыг таних.
- Тойргийн урт нь түүний диаметрээс гурав дахин их байдгийг судалж тогтоох гэх мэт.

Түвшин 2: Тухайн нэгж хичээлийн тусгай зорилго. Хэд хэдэн ээлжит хичээлээс тогтсон нэгж хичээлээр судалсан агуулга, хэрэгжүүлсэн арга зүйн хүрээнд шийдэх асуудалд төвлөрнө.

Жишээ нь:

- Хөшүүрэг хэрэглэн биеийг өргөхөд хүч хожиж болохыг туршлагаудаар судлах, тодорхойлох
- Тойргийн талбайг тооцоолох, тойргийн болон гурвалжины талбай хоорондоо ямар хамааралтай болохыг тодорхойлох

Түвшин 3: Тухайн хичээлийн ерөнхий зорилго. Тухайн улирал, хичээлийн жилд багшлахуй арга зүйн тодорхой зарчим, шийдэл хэрэгжүүлэх, үр дүнг тогтоох асуудалд төвлөрнө.

Жишээ нь:

- Асуудалд тодорхой баримт нотолгоо, сорил туршлагын дүнд тулгуурлан шинжлэх ухаанч арга барилаар хандах
- Математикийн мэдлэгээ асуудал шийдвэрлэхэд идэвхтэй ашиглах

Түвшин 4: Суралцагчдын хөгжүүлж, төлөвшүүлэх зорилго (long-term goal). Урт хугацаанд сургуулийн хэмжээнд нэгдмэл байдлаар хэрэгжүүлсэн тодорхой багшлахуй арга зүйн зарчмын үр дүнг тогтоох хүрээнд асуудалд төвлөрнө.

Жишээ нь:

- Санаачлагыг гартаа авч сурах
- Хамтран ажиллах чадвартай болох гэх мэт.

Энэхүү “Хичээлийн судалгаа” гэсэн хичээлийн хувьд оюутан-багш та бүхэн Түвшин 1 буюу сонгон авсан нэгж хичээлээс тодорхой нэг ээлжит хичээлийг

ялган авч судалгаат хичээл зохион байгуулж хэлэлцэх хүрээнд хичээлийн судалгааны тодорхой зорилго дэвшүүлж, түүнийхээ хэрэгжилтийг хамтдаа үнэлж, дүгнэх болно.

Хичээлийн судалгааг хэрэгжүүлж буй хүрээ, оролцогч гэх мэт олон хүчин зүйлээс хамааран улс орон бүхэнд хичээлийн судалгааны тодорхой төрөл, ангиллыг нэрлэсэн байдаг. Жишээ нь, Индонезид хичээлийн судалгааг оролцогч гишүүдийн бүрэлдэхүүнийг шалгуур болгон өөр өөр сургуулийн нэг мэргэжлийн багш нарын явуулдаг “Судлагдахуунд суурилсан хичээлийн судалгаа”, нэг сургуулийн өөр өөр мэргэжлийн багш нарын явуулдаг “Сургуульд суурилсан хичээлийн судалгаа” гэж хоёр ангилан үзэж байна.

Макото Ёшида өөрийн “Overview of Lesson Study in Japan” илтгэлдээ Японд зохион байгуулагдаж байгаа хичээлийн судалгааг хэлбэр болон зохион байгуулах газрыг үндэслэн дараах байдлаар ангилж авч үзсэн байна.

- Сургууль дээрх (In-school)
  - Нийлмэл бүлэг (Whole group)
  - Судлагдахууны судалгааны бүлэг (Content-area study groups)
- Сургууль хоорондын (Across schools)
  - Бүсчлэн зохион байгуулсан (Regionally organized)
  - Багшлах эрх олгох сургалтын хэсэг (Part of mandated beginning teacher education)
  - Сайн дурын үндсэн дээр байгуулагдсан клуб, дугуйлан (Voluntarily organized clubs and circles)
  - Боловсролын нийгэмлэг, сургуулиас зохион байгуулсан (Organized by educational associations and institutions)

АНУ, Канад, Мексикийн 38 боловсрол судлаач, багш нар Японд ирж хичээлийн судалгааны туршлага судлах аялалын үед хийсэн илтгэлдээ профессор Dr. Akihiko Takahashi Японд хийгдэж байгаа хичээлийн судалгааны үндсэн хоёр төрлийг танилцуулсан байна. Үүнд:

- Хамгийн түгээмэл төрөл нь сургуульд-суурилсан хичээлийн судалгаа юм. Сургуульд суурилсан хичээлийн судалгаагаар нэг сургуульд ажилладаг багш нар нэгдмэл ерөнхий зорилгыг 5-аас 7 жилд хангах, сургуулийн эрхэм зорилгыг хөгжүүлэхээр ажилладаг.
- Дараагийн хичээлийн судалгааны төрөл нь дүүргийн хэмжээний хичээлийн судалгаа бөгөөд сургуулиудын багш нар хамтран дүүргийн хэмжээнд дэвшүүлсэн зорилгыг хангахын тулд өөр өөр хичээлүүдээр бүлэг болон судалгаат хичээлийг зохион байгуулдаг байна. Энэ төрлийн хичээлийн судалгааны зорилго нь сургуулиудын хооронд туршлага солилцох, хамтын ажиллагааг хөгжүүлэх, дүүргийн хэмжээнд багшлах арга зүйг хөгжүүлэх явдал байдаг.

Японд бодотоор хэрэгжиж байгаа хичээлийн судалгааг “хэн”-ээс “хэн”-д зориулсан байгаагаар нь авч үзээд Гакугей Их Сургуулийн профессор Такахата:

1. Шинээр ажилд орж байгаа багшид зориулсан ахмад багш нараас заах загвар хичээл
2. Ахмад багш нараас удирдамж, заавар авах зорилготой шинэ багшийн хичээл
3. Сургалтын үеэр ахмад багшийн заах загвар хичээл
4. Идэвх санаачлагатай багшаас үзүүлэх тайлан хичээл,
5. Их сургуулиудын түшиц сургуулийн багш нараас заах нээлттэй хичээл
6. Шинэ арга зүйг нэвтрүүлэх хичээл зэрэг төрлүүдийг нэрлэсэн байна.

## Даалгавар.

1. Боловсролын шинэчлэлийн бодлого ба багшийн хөгжилд Хичээлийн судалгааны оролцоог хэрхэн ойлгосноо mind map<sup>1</sup>-аар илэрхийлэх
2. Семинарын хичээлээс өмнө ЕБС-ийн багшийн ажлын байрны тодорхойлолт болон багшийн ажлыг үнэлж дүгнэхтэй холбоотой дараах эрх зүйн баримт бичгүүдийг уншиж танилцах
  - Цэцэрлэг, ЕБС-ийн багшийн ажлын норм тогтоох, багш, зарим албан тушаалтны цалин хөлсийг тооцож, олгох журам **Боловсрол, Соёл, Шинжлэх Ухааны Сайд, Нийгмийн Хамгаалал, Хөдөлмөр, Сангийн Сайдын хамтарсан** 2007 оны 307/91/237-р тушаал (<http://www.mecs.gov.mn/director-content-392-314.mw>)
  - ЕБС-ийн багшийн ажлын байрны үлгэрчилсэн тодорхойлолт БШУ-ны Сайдын 2007 оны 351-р тушаал (<http://www.mecs.gov.mn/director-content-194-318.mw>)
  - Багшийн ажлын төлөвлөх, үнэлэх, дүгнэх аргачлал БШУ-ны Сайдын 2009 оны 561-р тушаал (<http://www.mecs.gov.mn/director-content-265-318.mw>)
  - Улирлын ажлын үр дүнгийн улирлын мөнгөн урамшуулал ЗГ-ын 2008 оны 54-р тогтоол (<http://www.mecs.gov.mn/director-content-292-317.mw>)
  - Улс, аймаг, нийслэлийн “Оны тэргүүний багш” шалгаруулах болзол, түүнийг дүгнэх аргачлал БШУ-ны Сайдын 2007 оны 440-р тушаал (<http://www.mecs.gov.mn/director-content-391-318.mw>)
  - Багшийн мэргэжлийн зэрэг олгох, хасах журам БШУ-ны Сайдын 2008 оны 73-р тушаал (<http://www.mecs.gov.mn/director-content-248-318.mw>)
  - ЕБС, цэцэрлэгийн багш, зарим албан тушаалтанд ур чадварын нэмэгдэл олгох шалгуур үзүүлэлт **Боловсрол, Соёл, Шинжлэх Ухааны Сайд, Нийгмийн Хамгаалал, Хөдөлмөр, Сангийн Сайдын хамтарсан** 2010 оны 362/112/183-р тушаал (<http://www.mecs.gov.mn/director-content-56-314.mw>)
  - Багшлах эрх олгох, хасах журам БШУ-ны Сайдын 2008 оны 74-р тушаал (<http://www.mecs.gov.mn/director-content-185-318.mw>)

<sup>1</sup> “Concept map” нь тодорхой сэдвийн хүрээнд ухагдахуунуудын хоорондын залгамж холбоог илэрхийлдэг бол “mind map” нь тодорхой асуудлын хүрээнд өөрийн ойлголт, бодол санаагаа илэрхийлэхэд хэрэглэгддэг.

## Семинар 1. Багш хичээлийн судалгаа хийх эрх зүйн үндэс

**Зорилго:** Багшийн ажилтай холбоотой эрх зүйн баримт бичгүүдэд задлан шинжилгээ хийж “Хичээлийн судалгаа”-нд суралцах хэрэгцээ шаардлагыг тодорхойлох

**Хугацаа: 2 цаг (90 минут)**

**Хэрэглэгдэхүүн:**

- Багшийн ажлын байрны тодорхойлолт
- Багшийн ажлыг үнэлж дүгнэх журам
- Багшид урамшуулал олгох журам зэрэг Лекц 1-ийн даалгаварт өгөгдсөн эрх зүйн баримт бичгүүд

**Бусад хэрэглэгдэхүүн:** Самбарын цаас, фломастер, скоч, соронз

**Удирдамж:**

Багшийн ажил болон түүнийг үнэлж дүгнэхтэй холбоотой журмуудыг судалж, үр дүнг танилцуулах-90 минут

1. Оюутнуудыг 4 хүнтэй багт зохион байгуулна. 5 минут
2. Багийн гишүүд лекцийн даалгаврын дагуу уншиж танилцсан багшийн ажил болон түүнийг үнэлж дүгнэхтэй холбоотой журмуудыг **ТӨМ 1.1**-ийн дагуу судалж, харилцан зөвшилцөж, ойлголтоо нэгтгэнэ. 20 минут
3. Багшийн ажил болон түүнийг үнэлж дүгнэхтэй холбоотой журмуудын талаар нэгтгэсэн зүйлээ бусдадаа танилцуулахад бэлтгэнэ. 20 минут
4. Баг тус бүр багийн ажлаа танилцуулна. 5 x 5 минут = 25 минут
5. Танилцуулгад үндэслэн багууд харилцан асуулт тавьж, хариулна. 10 минут
6. Багууд ажлын үр дүнгээ харьцуулан, “Хичээлийн судалгаа ба багшийн ажил” гэсэн сэдвээр дүгнэж ярилцах 10 минут

**Даалгавар:**

1. Семинарын хичээлийн үр дүнд үндэслэн “Хичээлийн судалгаа ба багшийн ажил” сэдвээр 40-60 үгтэй эргэцүүлэл бичих

**ТӨМ 1.1. Багшийн ажил болон түүнийг үнэлж дүгнэхтэй холбоотой журмууд дахь хичээлийн судалгааг хэрэгжүүлэхтэй холбогдох боломжит заалтуудыг шинжлэх хүснэгт**

| № | Эрх зүйн баримт бичгийн нэр, дугаар | Хичээлийн судалгааг хэрэгжүүлэхтэй холбогдох боломжит заалт |                                                                  |                      |                       |
|---|-------------------------------------|-------------------------------------------------------------|------------------------------------------------------------------|----------------------|-----------------------|
|   |                                     | Дугаар                                                      | Агуулга (Хичээлийн судалгааны үндсэн үе шатанд харгалзуулсан нь) |                      |                       |
|   |                                     |                                                             | Бэлтгэл, төлөвлөлт (+сайжруулах)                                 | Хичээл заах, ажиглах | Хичээлийн хэлэлцүүлэг |
| 1 |                                     |                                                             |                                                                  |                      |                       |
| 2 |                                     |                                                             |                                                                  |                      |                       |
| 3 |                                     |                                                             |                                                                  |                      |                       |
| 4 |                                     |                                                             |                                                                  |                      |                       |
| 5 |                                     |                                                             |                                                                  |                      |                       |
| 6 |                                     |                                                             |                                                                  |                      |                       |
| 7 |                                     |                                                             |                                                                  |                      |                       |
| 8 |                                     |                                                             |                                                                  |                      |                       |

## БИЕ ДААХ АЖИЛ

1. “Хичээлийн судалгаа ба эхэн үеийн миний төсөөлөл” бичих

- “Хичээлийн судалгаа ба эхэн үеийн миний төсөөлөл” нь “... миний ойлгосноор”, “... миний эзэмших хөгжүүлэх мэдлэг, чадвар” гэсэн үндсэн хоёр хэсэгтэй. “Удиртгал” лекц, “Багш хичээлийн судалгаа хийх эрх зүйн үндэс” семинар, мөн багшлах дадлагын үед хуримтлуулсан туршлагадаа үндэслэн эхэн үеийн төсөөллөө гараар бичиж (өөртөө хуулбар авч үлдэхгүй) багшид хураалгана.
- “Хичээлийн судалгаа” хичээлийн төгсгөлд бие даах даалгавраар оюутан-багш та өөрийнхөө “эхэн үеийн төсөөлөл”-ийг эргэж үзээд өөрийн ахиц дэвшилдээ үнэлгээ өгч дүгнэж үзнэ.

“Хичээлийн судалгаа” - одоо миний ойлгосноор:

[illegible]

*“Хичээлийн судалгаа” - миний эзэмших хөгжүүлэх мэдлэг, чадвар*

This image shows a single sheet of white paper with horizontal blue ruling lines. The lines are evenly spaced and run across the width of the page. There are no margins or other markings on the paper.

## Хичээлийн бэлтгэл судалгаа-1

| Хичээлийн хэлбэр, цаг | Агуулга                                                                                                                                                                               | Хэрэглэг дэхүүн | Бие даалт                                                  |
|-----------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------------|------------------------------------------------------------|
| Лекц 2 /2ц/           | <ul style="list-style-type: none"> <li>Хичээлийн бэлтгэл судалгааны талаарх ойлголт, мөн чанар</li> <li>Судлагдахууны агуулгын судалгаа</li> <li>Хэрэглэгдэхүүний судалгаа</li> </ul> | ppt             | “Хичээлийн бэлтгэл судалгааны мөн чанар” сэдэвт Эсээ бичих |
| Семинар 2 /2ц/        | <ul style="list-style-type: none"> <li>Судлагдахууны агуулгын судалгаа хийх арга зүй</li> </ul>                                                                                       | ТӨМ-үүд         |                                                            |
| Семинар 3 /2ц/        | <ul style="list-style-type: none"> <li>Хэрэглэгдэхүүний судалгаа хийх арга зүй</li> </ul>                                                                                             | ТӨМ-үүд         |                                                            |

### Хичээлийн бэлтгэл судалгаа-1

#### 1. Хичээлийн бэлтгэл судалгаа (Кёзай кэнкю)-ны талаарх ойлголт, мөн чанар

Хичээлийн судалгааны талаар эргэн саная.

Хичээлийн судалгаа нь зөвхөн хамтарч хичээлийн төлөвлөлтөө хийхээс гадна энэ хичээлээ ажиглах нээлттэй хичээл явуулж, ажиглалтын үр дүнгээ дараа нь хэлэлцэх үйл ажиллагааг хамардаг байна.

#### Хичээлийн бэлтгэл судалгаа:

- Тухайн хичээлд тавьсан зорилгодоо хүрэхийн тулд хийдэг үйл ажиллагаа юм.

Багш нар хичээл дээр дэвшүүлсэн зорилгоо хэрэгжүүлэхийн тулд ямар үйл хийвэл үр дүнтэй байх вэ? гэдгийг бодож, хичээлийн бэлтгэл хийхдээ тооцож үздэг билээ.

Хичээлийн бэлтгэл судалгаа бол тухайн хичээлд тавьсан зорилгодоо хүрэхийн тулд хийдэг үйл ажиллагаа юм. Бид бүхэн дэвшүүлсэн зорилгоо хэрэгжүүлэхийн тулд ямар үйл хийвэл үр дүнтэй байх вэ? гэдгийг бодож, хичээлийн бэлтгэл хийхдээ тооцож үздэг билээ. Тухайлбал, Хүүхэд хэрхэн суралцдаг вэ? Сэдвийн агуулгаа хэрхэн сонгох вэ? Ямар хэрэглэгдэхүүн ашиглах вэ? Ямар асуулт асуух вэ? Ээлжит хичээлд

тухайн ухагдахууныг таниулахын тулд мэдээлэл харилцааны технологи /МХТ/-ийг хэрхэн хэрэглэх вэ? гэх мэт хичээлийн зорилгод хүрэх, түүнийг биелүүлэхийн тулд хийгддэг багшлах арга зүйн дидактик шийдлүүд нь хичээлийн бэлтгэл судалгааны салшгүй элемент болдог. Хичээлийн бэлтгэл судалгааны талаар олон тайлбарууд байдаг ба эдгээрийн заримаас дурдъя.

Хичээлийн бэлтгэл судалгааг:

- Хичээлийн бүтэн жилийн, улирлын, бүлэг сэдвийн, нэгж хичээлийн зорилго зорилтыг нэгтгэж эрэмбэлэн төлөвлөдөг тодорхой үе шат бүхий үйл
- Киррикулимийн үндсэн бүрэлдэхүүн хэсэг болох агуулга, зорилго, арга зүй, хэрэглэгдэхүүн, үнэлгээг хамардаг цогц үйл

- Тухайн хичээлийн бэлтгэлд өмнөх хичээлийн явц, үр дүнгээ бүтээлчээр хэрэглэдэг, өнөөдрийн хичээлээс дараагийн хичээлийнхээ бэлтгэлд хэрэглэх арга зүйн санааг олж авч байдаг тасралтгүй үйл
- Тодорхой үе шат бүхий цогц судалгаа – киррикулим
- Хичээлд шинжилгээ хийж арга зүйгээ хөгжүүлж байдаг тасралтгүй үйл гэх зэргээр тайлбарласан байгаа юм.

Эдгээрээс дүгнээд хэлбэл:

- Хичээлийн бэлтгэл судалгаа нь хичээлд бэлтгэх төлөвлөлтийн хүрээнд тасралтгүй хийгдэх тодорхой үе шат бүхий цогц (киррикулим) судалгаа болох нь харагдаж байгаа юм.

Хичээлийн бэлтгэл судалгаа нь:

- Хичээлийг үр дүнтэй болгох
- Суралцагчид – мэдлэг бүтээх, сурах арга барилд суралцах
- Багшид – заах арга зүйн хувьд тасралтгүй хөгжих, судалгааны арга зүйд суралцах дидактик зорилгуудыг агуулж байдаг.

Хичээлийн бэлтгэл судалгаа хийх үйл нь дараах алхмуудаас бүрдэнэ.

Хичээлийн бэлтгэл судалгаа хийх үйлийн алхмууд

- А. Хичээлийн сэдэв
- Б. Хичээлийн бэлтгэл судалгаа хийх
  - Судлагдахууны агуулгын судалгаа
  - Хэрэглэгдэхүүний судалгаа
  - Мэдлэг эзэмших явцын судалгаа
  - Багшлахуйн арга барилын судалгаа
  - Үнэлгээний судалгаа
- В. Дидактик шийдэл гарган авах
- Г. Ээлжит хичээлийн хөтөлбөр боловсруулах

А. *Хичээлийн сэдэв сонгох* – Судалгаат хичээл зохион байгуулах нэгж болон ээлжит хичээлийн сэдвийг сонгох. Тухайн сургуулийн хичээлийн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд хичээлийн судалгаа хийх хугацааг нарийвчлан тогтоож, хичээлийн судалгаа хийх баг (хамтлаг)-ийг бүрдүүлсэн байх нь чухал юм. Хичээлийн сэдвийг сонгохдоо сэдэв-сэдвийн, сэдэв-хичээлийн уялдаа холбоог харгалзах

хэрэгтэй.

Б. *Хичээлийн бэлтгэл судалгаа хийх* – Тухайн сэдэвт буюу сонгогдсон ээлжит хичээлийг хэрхэн зааж байсан туршлага, арга зүйн нөхцөл байдлыг тодруулах. Хичээлийн бэлтгэлийг ээлжит хичээлийн хөтөлбөр боловсруулснаар хязгаарлах боломжгүй юм. Хичээлийн бэлтгэл судалгааг:

1. Судлагдахууны агуулгын судалгаа
2. Мэдлэг эзэмших явцын судалгаа
3. Багшлахуйн арга барилын судалгаа
4. Үнэлгээний судалгаа
5. Хэрэглэгдэхүүний судалгаа гэсэн бүрэлдэхүүн хэсгүүдийн хүрээнд хийнэ.

В. *Дидактик шийдэл гарган авах* – Ээлжит хичээлийн зорилго, зорилтод тохирохуйц хичээлийн төлөвлөлтийг хийх. Уг сэдвийн хүрээнд суралцагчдын өмнөх төсөөлөл, мэдлэг чадвар ямар байгааг харгалзан, тэдний нас сэтгэхүйн онцлогт нийцсэн арга зүйг бий болгох хэрэгтэй.

**Г. Ээлжит хичээлийн хөтөлбөр боловсруулах** – Судалгаат хичээлийн хөтөлбөр боловсруулах. Та бүхэн “Сурган хүмүүжүүлэх зүй”, “Мэргэжлийн дидактик” хичээлийн хүрээнд хичээлийн хөтөлбөр боловсруулах арга зүйг судалж, сурган хүмүүжүүлэх дадлага хийх явцдаа хэрэгжүүлсэн билээ.

Хичээлийн бэлтгэл судалгааг хийхдээ багш өөрийн арга зүйн туршлагад тулгуурлах, тухайн судлагдахуунтай холбоотой шинжлэх ухааны болон арга зүйн ном, сурах бичиг, гарын авлага судлах, ижил мэргэжлийн багш нартай туршлага хуваалцах, хамтран ажиллах, суралцах, цахим эх үүсвэр (вэб сайт, цахим сурах бичиг, сургалтын програм хангамж, сургалтын тоглоом гэх мэт нөөцүүд)-ийг хослуулан ашиглах хэрэгтэй.

### Дүгнэлт

Хичээлийн бэлтгэл судалгаа гэдгийн дор дараах санааг ойлгож байна. Үүнд:

- Хичээлд бэлтгэх, төлөвлөх, хөтөлбөрөө боловсруулахдаа, сурагчдын сурах үйл ажиллагааны алхам бүрийг хэрхэн дэмжих шийдлүүдийг тунгаан бодож боловсруулаад, түүнийгээ хичээлийн явцад хэрхэн хэрэгжүүлэхээ төлөвлөөд, хэрэглэгдэх материалуудыг бэлтгэсэн цогц үйл ажиллагаа явуулж хичээлийн хөтөлбөрийг бэлтгэдэг. Багшийн шийдэл бүр судалгаа.
- Багш өөрийн сурагчдадаа зориулан бэлтгэсэн, өмнөхөөсөө давуу төгөлдөржсөн арга зүйг боловсруулж байгаа нь тухайн багшийн оюуны бүтээл, тухайн багшийн судалгаанд суурилсан хөтөлбөр юм.
- Энд хөтөлбөрийг бэлэн болгосон үр дүнгээс илүүтэй энэ хөтөлбөрийг сурагчийн сурах арга зүй, багшийн багшлахуйн арга зүйг хөгжүүлэх алхмуудтайгаар боловсруулсан үйл явц нь чухал.

## **2. Судлагдахууны агуулгын судалгаа.**

### **1. АГУУЛГЫН СУДАЛГАА**

- Тухайн хичээлийн зорилгод хүрэхээр гүйцэтгэж буй суралцагчдын мэдлэг бүтээх үйл ажиллагаа, тэрхүү үйл ажиллагааг хэрэгжүүлэх багшийн дидактик шийдэл нь хичээлийн агуулга болон хувирч, хөгжиж байдаг.

Багш хүн мэргэжлийн мэдлэг, багшлах арга зүйн ур чадвараа дээшлүүлэн хөгжүүлж байх шаардлагатай бөгөөд заавал албан ёсны, төвлөрсөн сургалтад хамрагдах замаар бус, хичээл заах явцдаа, өөрөөр хэлбэл багшлахуйн үйлдээ судалгааны үүднээс хандсан эргэцүүлэл хийж, бүтээлчээр хандсанаар хөгжих бүрэн боломжтой.

Судлагдахууны агуулгыг судалгаа хийхдээ хичээлийн зорилго, зорилтод баримжаалан мэдлэг болон ур ухааныг тодорхойлно. Өөрөөр хэлбэл цогц чадамжид суурилсан хөтөлбөрийн агуулга нь суралцагчийн бие бялдар, нас сэтгэхүй, танин мэдэхүйн хөгжлийн хэрэгцээнд тулгуурласан, тухайн шинжлэх ухааны хэл, судлах аргад суурилсан, суралцагчийн эзэмших мэдлэг чадвар нь хэрэглээ болохоор томъёологдсон байна. Зарим тохиолдолд багш нар бага, дунд боловсролын стандартад тусгагдсан мэдлэг чадварыг жагсаалт хэлбэрээр тоочиж томъёолсон байгаа нь

төслийн хүрээнд хийсэн хичээлийн судалгааны мониторингийн явцад ажиглагдаж байсан бөгөөд энэ нь хангалтгүй юм. Тухайн хичээлийн зорилгод хүрэх суралцагчдын мэдлэг бүтээх үйл ажиллагаа, тэрхүү үйл ажиллагааг хэрэгжүүлэх багшийн дидактик шийдэл нь хичээлийн агуулга болон хувирч, хөгжиж байдаг гэж үзэх хэрэгтэй. Энэ бол агуулгын тогтолцооны сонголтыг хийх үндэслэл мөн. Агуулгыг сонгоно гэдэг нь мэдэхүйн цогц чадамжийн төлөвшилд хувь нэмрээ оруулах үндсэн мэдлэгүүд (бас чадварууд)-ийг тодорхойлно гэсэн үг.



Мөн судлагдахууны агуулгын судалгаанд:

- Тухайн агуулгын түүхийг судлах
- Тухайн агуулгын шинжлэх ухааны ойлголт, ухагдахуун, хэллэг, шинж чанар зэргийг тодруулах
- Тухайн агуулгын амьдрах ухаанд хэрэглэх чухал хэсэг нь юу вэ? гэдгийг тодруулах
- Тухайн агуулгыг заах нь нийгэм, хувь хүний хэрэгцээтэй хэр уялдаж байгаа байдал
- Тухайн агуулгын ач холбогдлыг тодорхойлох
- Тухайн агуулга болон хүүхдийн хөгжлийн түвшин хоорондын уялдаа холбоог анхаарч үзэх хэрэгтэй.


Тухайн сэдвийг өмнө нь зааж байсан эсэхээс үл хамааран хичээлийн агуулгаа дахин боловсруулж, судалгаа хийн, түүнийг хэрхэн хэрэгжүүлэх арга зүйгээ шинээр төлөвлөнө. Багш хичээлийн агуулгын судалгааг хийхдээ олон төрлийн нөөц ашиглах талаар өмнө нь дурдсан билээ. Агуулгын судалгааг ямар эх сурвалжаас, ямар хэл дээрх материалыг ашиглан, хэрхэн боловсруулалт хийж өөрийн болгох вэ? гэсэн асуултуудыг өөртөө тавьж, судалгааны байр сууринаас хандах нь хичээлийн бэлтгэлийн судалгаанд чухал үүрэгтэй.

Хичээлийн агуулга нь хичээлийн хөтөлбөрт товч тусгагдсан байдаг боловч үүгээр хязгаарлаж болохгүй. Мөн бусад нэгж хичээлүүдтэй холбогдох холбоог ч нарийн тооцож агуулгаа тодорхойлно. Хичээлийн агуулгын тогтолцоог нарийн тодорхойлсноор суралцагчдын шинэ мэдлэг, чадвар эзэмшихэд шаардлагатай үйлийн баримжаа тодорч, хичээлийг үр дүнтэй зохион байгуулах боломж бүрдэх ба хичээлийн агуулгын **судалгааны ач холбогдол** үүнд оршино.

Хичээлийн бэлтгэл судалгааны аль ч хэсэг нь тухайн хичээлийн хүрээнд тавьсан зорилго, зорилтыг амжилттай хэрэгжүүлэхэд чиглэсэн төлөвлөлт хийхэд чиглэгдэнэ. Тиймээс хичээлийн зорилго, зорилтыг биелүүлж, үр дүнг нь хичээл (нэгж, ээлжит, нийт хичээлийн төгсгөлд)-ийн төгсгөлд тооцож болохоор

тодорхойлж өгөхөд багш онцгой анхаарах хэрэгтэй. Багш тухайн хичээлийн зорилго, зорилтын биелэлтийг асуулт, даалгавар, бодлого, үнэлгээний материалаар илрүүлэх боломжтой байхаар томъёолбол зохино. Хичээлийн зорилго, зорилтыг ингэж томъёолохыг хэмжигдэхүйцээр тодорхойллоо гэдэг.

**Жишээлбэл:** “Мэдээллийн процесс” гэсэн ухагдахууныг заахын тулд энэ нэр томъёоны түүхэн хөгжил, хэрэгцээ шаардлага, информатикийн шинжлэх ухаан дахь процессын тухай ойлголт, тус үг хэллэгийн амьдрал ахуй дахь хэлбэр, мэдээлэл болон процессын тухай ахуй амьдралаас олж авдаг андуу ташаа төсөөлөл, хүүхдэд мэдээллийн тухай ойлголтыг төлөвшүүлэхэд тохиолддог бэрхшээл, процессын тухай ойлголтыг хэрхэн гүнзгийрүүлэх вэ?, хүний амьдралд мэдээллийн процессын тухай ойлголтын хэрэгцээ, мэдээлэл гэсэн ухагдахууныг олгож ирсэн уламжлал, бусад ямар ухагдахуунтай уялдаа холбоотой вэ? гэх мэтээр уг асуудлыг тойруулан олон талаас нь судлан агуулгын шинжилгээг хийнэ. Энэ бол хичээлийн бэлтгэл судалгааны нэг чухал хэсэг нь юм. Энэ бүхний дараа “Мэдээллийн процесс” сэдвийг заах агуулга бэлтгэл ажлын хүрээнд тодорхой болох юм. Агуулгын судалгаанд шинжлэх ухааны агуулгыг бүүлгах буюу агуулгыг хүүхдийн нас сэтгэхүйн түвшинд тохируулан элементарчлах асуудлыг чухлаар тавих хэрэгтэй. Элементарчлал нь агуулгыг яаж хүүхдэд энгийн ойлгомжтой болгох вэ? Тухайн насны хүүхдүүд ямар үг хэллэг хэрэглэж байна вэ? Ямар нэр томъёо, үг хэллэг хэрэглэж ярих нь зүйтэй вэ? Агуулгын шинжлэх ухаанч чанарыг нь алдагдуулахгүйгээр хэрхэн хялбар энгийн болгох вэ? гэдэг асуудлыг арга зүйн үүднээс шийдэж өгөхөд чиглэнэ. Элементарчлахын тулд багш судлагдахуунаа сайн мэдэж байхаас гадна сайн арга зүйч байх ёстой. Профессор Дуит “Шинжлэх ухааны агуулга, хичээлийн агуулга хоёрыг ялгаж ойлгох хэрэгтэй” гэсэн нь элементарчлалын ач холбогдлыг тодруулсан хэрэг юм.



Зураг.2.1. Шинжлэх ухааны болон хичээлийн агуулгын ялгаатай байдал

Хичээлийн агуулгыг суралцагчийн сонирхол, нас сэтгэхүйн онцлог, үндэсний онцлог, ёс заншил, бахархал, орон нутгийн онцлог, амьдрал практиктай холбоотой жишээгээр баяжуулан тодорхойлохоос гадна бусад хичээлийн агуулга, тогтвортой хөгжил, экологи, хүний эрхийн боловсролтой холбоход анхаарах хэрэгтэй.

**Жишээ 1.** 9 дүгээр ангид судлах Мэдээлэл зүйн “Хайлтын системийн хэрэглээ” сэдэвт хичээл дээр оршин суугаа нутгийнхаа талаар, Мянганы суут хүн Чингис


хааны талаар, Монгол орны цэвэр усны нөөц, орон нутгийнхаа гол, мөрөн, рашаан ус, цэвэр усаа ариг гамтай зарцуулах тухай гэх мэдээллийг хайж олох, боловсруулалт хийх, бусдадаа мэдээллээ түгээх, бусдын санаа бодлыг тусган сайжруулалт хийх гэх мэтээр төлөвлөж болно.

**Жишээ 2.** Уулсын талаар ойлголт өгөх агуулгын хүрээнд дараах байдлаар интеграци хийж болох юм. Бид гадаргын гүдгэр хэлбэр болсон уулс хаагуур их байдаг талаар (газарзүй) агуулгаараа дамжуулан олгохоос гадна уул хэзээ яаж үүсч бий болдог (газар зүй), хэрхэн элэгдэж тал болдог (физик), уулсын өндрийг яаж тодорхойлдог (математик), уулсыг бүрдүүлэгч эрдэс чулуулгийн найрлага (хими), юунд ашигладаг (эдийн засаг) гэдгийг судалж улмаар эх орныхоо өндөр сүрлэг уулсын талаар урнаар дүрсэлсэн уранзохиол, уранзургийн хичээлээр улам баяжуулан ойлгодог.



**Зураг.2.2.** “Уулс” хичээлийн агуулгыг бусад хичээлтэй холбох нь

Судлагдахууны агуулгыг гүнзгийрүүлэх нь тухайн сурагчийн сурах, мэдэх, судлах хүсэл сонирхлыг төрүүлж, нэмж судлах, эрж хайх, мэдээлэл цуглуулах цаашид мэргэжлээ сонгон суралцахад дөхөм болдог. Тийм мэргэжилтэй болох юмсан гэсэн хүсэл тэмүүлэл нь улмаар судлагдахууны агуулгыг нэмэгдүүлэхийг шаардаж байдаг. Иймд багш нарын өмнө суралцагчдынхаа хүсэл сонирхол, ур чадварыг сайтар судалж хүүхэд нэг бүрт тохирсон аргазүйг хэрэглэх шаардлага урган гарах нь тодорхой. Газарзүйн хичээл дэх “Ашигт малтмал” сэдвийн агуулгын босоо холбоо болон гүнзгийрүүлэх боломжийг дараах байдлаар илэрхийлж харуулав.



Зураг.2.3. Хичээлийн агуулгыг гүнзгийрүүлэх боломж

Багш нар дугуйлан, хээрийн экскурс хичээлийг зохион байгуулах хэрэгтэй бөгөөд эрдэм шинжилгээний бага хурал, мэтгэлцээн, асуулт хариултын тэмцээн, уралдаан олимпиадыг зохион байгуулах нь суралцагчдын бие даан хөгжих үйлийг хөтөлж буй хэрэг билээ.


Хичээл дээр багш суралцагчийн хийх үйлийг юуны тулд, хэзээ, хэрхэн хийх зэргийг эрэмбэлэн цэгцэлж нэг тогтолцоонд оруулах бүтээлч үйл ажиллагаа бол хичээлийн төлөвлөлт юм.

Сурах бичгийг яг мөрдөх тохиолдол багшид гардаг. Багш сурах бичигт хөтлөгдөх бус түүнийг бүтээлчээр, хэрхэн ашиглахад анхаарах ёстой.

Агуулгын судалгааг багш ганцаарчлан хийх нь үр дүнтэй юу? Мэргэжлийн хамтлагаар хийх нь үр дүнтэй юу? гэдгийг ч бодолцох нь зүйтэй юм. Мөн багш мэдээллийн төрөл бүрийн нөөц (эх сурвалж)-тэй ажиллах арга барил ЯМАР байна вэ? гэдэг нь агуулгын судалгаа хийхэд ихээхэн нөлөөтэй.

#### Даалгавар:

1. Та сурган хүмүүжүүлэх дадлагыг хэддүгээр сургуульд, ямар хугацаатайгаар хийсэн бэ?
2. Тухайн сэдэвт ээлжит хичээлийн хувьд агуулгын хүрээг хэрхэн тогтоож байсан бэ?
3. Тодорхой сэдэвт ээлжит хичээлд бэлтгэхдээ агуулгын судалгааг хэрхэн хийж байсан бэ?
4. Агуулгын судалгааг илүү үр дүнтэй болгох талаар өөрийн саналаа товчхон бичнэ үү?



#### Хэрэглэгдэхүүний судалгаа

Хичээлийн бэлтгэл судалгааны бүрэлдэхүүн хэсгийн нэг нь сургалтын хэрэглэгдэхүүний судалгаа юм.

Сургалтын хэрэглэгдэхүүн нь багш сургалтын үйл ажиллагаагаа амжилттай хэрэгжүүлж, хүүхдийн мэдлэг бүтээх үйлийг оновчтой удирдах, арга зүйгээ хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлдэг. Хэрэглэгдэхүүн бэлтгэхэд дидактик боловсруулалт нэн чухал.

Тухайлбал, тухайн хэрэглэгдэхүүн агуулгын илэрхийлэл, харагдах байдал, өнгөний зохицол гэх мэт олон талаараа дидактик шаардлагад нийцэж байхаас гадна өгүүлж буй санаагаа элдэв чимэггүйгээр суралцагчдад шууд ойлгогдохоор илэрхийлсэн байх ёстой.

Тухайн хэрэглэгдэхүүн сургалтын хугацааг хэмнэж, суралцагчдын танин мэдэх хэрэгцээг хангаж байна уу? гэдэгт багш анхаарч байх нь зүйтэй юм.


Хэрэглэгдэхүүнээ сонгож, боловсруулалт хийхдээ:

- *Суралцагчдын нас, сэтгэхүйн онцлогт тохирсон байх*
- *Хэрэглэгдэхүүнд тавигдах шаардлага хангасан, хүртээмжтэй байх*
- *Хэрэглэгдэхүүнээ ашиглах аргаа боловсруулсан байх*



Багшлахуйн аргазүйн хөгжлийг түгээн дэлгэрүүлэх тогтолцоог бэхжүүлэх төслийн хүрээнд хийгдсэн сургалтын үеэр “Хүн байгаль” хичээлээр 5-р ангид “Даралт” сэдвийг заахаар хичээлийн бэлтгэл судалгааг сургалтад хамрагдсан багш нар хийсэн бөгөөд даралтын талаар суралцагчдад хэрхэн ойлгуулах туршилт сонгож, хэрэглэгдэхүүн бэлдсэн талаар дараах байдлаар дүгнэж тайлбар хийцгээснийг ажиглая.

- Тэд даралт мэдрэгч болгож гурил, шавар, порлон, баримлын шавар, ус, цас, элс, хөвөн зэрэг хэрэглэгдэхүүнийг сонгон авав.
- Харин даралт учруулагч бие болгож тэгш өнцөгт биет болох тоосго, металл ачаа, хайрцагтай элс, ундаа, модон ачаа зэргийг сонгон авч байв.
- Туршилтын үр дүнгээс харахад гурилан дээр тоосго тавихад доошоо шигдэж байсан боловч шигдсэн гүнийг хэмжих, харьцуулалт хийхэд тохиромжгүй байв.
- Мөн баримлын шаварт гурил наалдаад хэмжилтийн үр дүнд нөлөөлж байсан. Иймд модоор хийсэн биет болгож өөрчилсөн.
- Шаврыг зуурах үед хатуу, шингэн зуурснаас туршилтын үр дүн хамаарч байсан. Хэт хатуу бол сайн шигдэхгүй, шингэн бол дотор нь ороод байсан.
- Тоосгыг авах үед гаранд наалдах, шаварт хийх үед хазгай бол унах зэрэг бэрхшээлүүд гарч байв гэх зэргээр дүгнэн хэлэлцэв.



Хэрэглэгдэхүүнийг нэлээд өргөн хүрээнд авч үзсэнээр сурах, сургах орчин бүрдүүлэх боломж бий болно. Ямар ч хичээлийн нэгж сэдвийн хөтөлбөрийг төлөвлөн боловсруулахдаа материаллаг болон сэтгэл зүйн таатай орчныг бүрдүүлснээр хөтөлбөр бодит амьдралд нийцэж, хэрэгжих нөхцөл бүрдэнэ. Бид хэрэглэгдэхүүн гэхлээр сурах бичиг, самбар, шохой төдийхнөөр явцуу хүрээнд ойлгох нь бий. Хамгийн энгийнээр бодоход л тарааж өгөх материалын

хүртээмж, үзүүлэн таниулах материалын эрүүл ахуйн шаардлага хангасан байдал зэрэг асуудлыг хамруулан ойлгож болох юм. Ялангуяа орчин үеийн мэдээлэл технологийг ашиглах замаар хэрэглэгдэхүүнээ бүрдүүлэх, орчны шаардлагыг хангах, түүнчлэн сонгосон хэрэглэгдэхүүнээ хэрхэн хэрэглэж ашиглах талаар тодорхой бичсэн байх хэрэгтэй.

Судлагдахууны агуулга, арга зүй, суралцагчийн нас сэтгэхүй, мэдлэг бүтээх үйлд нийцэхүйц цахим болон хэвлэмэл хэрэглэгдэхүүн боловсруулж, хамтатган хэрэглэх нь хичээлийг амжилттай зохион байгуулах нэг үндэс болно.

Мэдээлэл харилцааны технологийг ашиглах



Мэдээлэл харилцааны технологийн зуунд суралцагчийн суралцах болон багшийн багшлах арга зүйг дэмжихүйц сургалтын материал, хэрэглэгдэхүүнийг цахим хэлбэрээр боловсруулж ашиглах шаардлага гарч байна. Вэб, блогт суурилсан цахим сургалтыг зохион байгуулснаар суралцагч хаанаас ч, хэзээ ч тухайн судлагдахууны агуулгыг

судлах, мультимедиа хэрэглэгдэхүүн ашиглан мэдлэг, чадвараа дээшлүүлэх, бие даан суралцах нөхцөл бүрдэх гэх мэт боломжтой. Сургалтыг мэдээлэл харилцааны технологигүйгээр төсөөлөхийн аргагүй болж байгаа нь залуу үеийнхэн интерактив технологи, дижитал хэрэгсэлтэй ажиллах асар их сонирхол, тэмүүлэлтэй болсонтой холбоотой. Тухайлбал, галт уулын дэлбэрэлт, газар хөдлөлт, цунамигийн аюул, түүнээс үүдэлтэй нийгэм, эдийн засагт учрах хор хөнөөлийн талаар интернэтээс (GoogleEarth, YouTube, Wikipedia гэх мэт) бодотоор нь тодорхой харж болдог. Түүнчлэн Газарзүйн мэдээллийн систем (ГМС) болон Байршил тодорхойлох төхөөрөмж (GPS) нь ч гадаргын талаар ойлгох, үнэлэхэд тусална.


Сургалтын хэрэглэгдэхүүн нь дараах шаардлагыг хангаж байх ёстой. Үүнд:

| Сургалтын хэрэглэгдэхүүнд тавигдах шаардлага                                           |                                                                                                            |
|----------------------------------------------------------------------------------------|------------------------------------------------------------------------------------------------------------|
| Хэвлэмэл хэрэглэгдэхүүн                                                                | Цахим хэрэглэгдэхүүн                                                                                       |
| Агуулга, арга зүйтэй нарийн уялдсан байх                                               |                                                                                                            |
| Суралцагчийн нас, сэтгэхүйд тохирсон байх                                              |                                                                                                            |
| Суралцагчийн сонирхлыг татдаг байх                                                     |                                                                                                            |
| Сэдвийн агуулгыг тод томруун харуулсан (судлагдахуун, агуулгад интеграцчилагдсан) байх |                                                                                                            |
| —                                                                                      | • Хичээлийн текстийг дэлгэцэнд бүтнээр нь багтаах. Энэ нь суралцагч уншиж боловсруулахад илүү сайн байдаг. |
| —                                                                                      | • Текстийн хэмжээг 5-8 мөрөөр хязгаарлах.                                                                  |
| —                                                                                      | • Текстийг хэвлэгдэх өргөний уртаар хязгаарлаж, 5-10 хүртэлх үгийг нэг мөрөнд байхаар авах.                |
| —                                                                                      | • Дэлгэцийн текстэд хоёроос илүү зүйл (параграф)-ийг холихгүй байх.                                        |

|   |                                                                                        |
|---|----------------------------------------------------------------------------------------|
| – | • Дэлгэцийн интерфэйс (Дэлгэцийн элементүүд давхардахгүй байх, өнгөний зохилдлого)     |
| – | • Хэрэглэгдэхүүн гарын товч эсвэл удирдлагын товчлуураар үргэлжилдэг байхаар хийж өгөх |

Хэрэглэгдэхүүний судалгаанд дидактик шаардлага хангасан хэрэглэгдэхүүн бүтээхээс гадна түүнийг хичээлийн явцад яаж хэрэглэх төлөвлөлт чухал байдаг. Тухайлбал, Хичээлийн ямар үе шатанд ямар зорилгоор хэрхэн ашиглах вэ? Тухайн хэрэглэгдэхүүн суралцагчид шинэ мэдлэг бүтээх, нээлт хийх явцад ямар дэмжлэг үзүүлэх вэ? зэрэг асуултад хариулт өгөх замаар дидактик шийдлийг тодорхойлох хэрэгтэй.

Хэрэглэгдэхүүн бүрийн гүйцэтгэх үүргийг тодорхойлж, хөтөлбөртөө тусган гүйцэтгэлийн байдлыг ажиглан засан сайжруулах үүрэг багшид ноогдоно.




Зураг. 2.4. Сургалтын хэрэглэгдэхүүний сонголтын хуваарилалт

Гэхдээ багшийн туршлага, ур чадвар, аргазүйн онцлогоос хамаардаг тул үүнийг хатуу баримтлах хэрэггүй юм.

Сургалтын мультимедиа танилцуулга бүтээх арга зүй, түүнийг боловсруулахад баримтлах зарим хүчин зүйлүүдийн талаар мэдээлэл зүй судлагдахууны “Асуудал шийдвэрлэх замаар мэдээллийг мэдлэг болгон хувиргах арга зүй” зөвлөмжийн 33-43 дугаар талаас үзэж болно.

Сургууль бүрт тухайн судлагдахуун (мэдээлэл зүй, математик, хими гэх мэт)-ы кабинет байдаг бөгөөд багш кабинетын ханын үзүүлэнг тухайн хичээлд хэрхэн



хэрэглэгдэхүүн байдлаар ашиглах вэ? Мэдээлэл нь тогтмол байх нь оновчтой юу? Улирлаар солигддог байхаар хийж болох уу? гэх мэт асуудлыг дэвшүүлж, хэрэгжүүлэхэд санаачилгатай ажиллах нь зүйтэй болов уу.

Ангийн самбар нь хичээлийг зохион байгуулах явцад чухал хэрэглэгдэхүүн болдог. ЕБС-д хичээлийн судалгааны

мониторинг хийж байх явцад анзаарагдсан зүйл бол багш нар самбарт хичээлийн сэдэв, огноо бичээд орхих явдал байсан.

*Ангийн самбарыг хэрхэн суралцагчдын сурахуйн үйл ажиллагаа (алдаа, оноо)-ны талбар болгох вэ? Энэ мөн л хэрэглэгдэхүүний судалгааны орхиж болохгүй хэсэг юм.*

### **Даалгавар**

1. Та ямар мэргэжлийн багш болохоор суралцаж байна вэ?
2. Сурган хүмүүжүүлэх дадлагын явцад хичээлийн онцлогоос хамаарч ямар ямар төрлийн хэрэглэгдэхүүн бэлдэж байсан бэ?
3. Хэрэглэгдэхүүн бэлтгэхдээ ямар сургалтын програм хангамж ашиглаж байна вэ? Жишээ гаргана уу?
4. Ангийн самбарын төлөвлөлт хэрхэн хийх талаар [www.hicheeliin-sudalgaa.mn](http://www.hicheeliin-sudalgaa.mn) сайтаас судлаарай.

## Семинар 2. Судлагдахууны агуулгын судалгаа хийх арга зүй

**Зорилго:** Хичээлийн бэлтгэл судалгааны нэг бүрэлдэхүүн хэсэг болох судлагдахууны агуулгын судалгааг тодорхой сэдэвт ээлжит хичээлийн хүрээнд хийх арга зүйг танин мэдэх.

**Хугацаа: 2 цаг (90 минут)**

**Хэрэглэгдэхүүн:**

- Тухайн хичээлийн тодорхой сэдэвт нэгж хичээлийн хөтөлбөр
- Тухайн нэгж хичээлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх ангийн сурах бичиг
- ТӨМ 2.1, 2.2

**Бусад хэрэглэгдэхүүн:** Самбарын цаас, фломастер, скоч, соронз, интернэт бүхий компьютер

**Удирдамж**

Хичээлийн судалгааны нэг бүрэлдэхүүн болох агуулгын судалгааг хийх арга зүйтэй танилцаж, үр дүнг танилцуулах-90 минут

1. 4 хүнтэй багт зохион байгуулагдана. 5 минут
2. Багийн гишүүд тухайн хичээлийн тодорхой сэдэвт нэгж хичээлийн хөтөлбөр судалж, агуулгын судалгаа хэрхэн хийх талаар харилцан зөвшилцөж, ойлголтоо нэгтгэнэ (**ТӨМ 2.1** ашиглах). 20 минут
3. Агуулгын судалгааг хэрхэн хийх талаар уншиж судалсан, боловсруулсан материалаа бусдадаа танилцуулахад бэлтгэнэ. Үүнд дараах үндсэн агуулгыг тусгана.
  - а. Агуулгын судалгаа хийхэд анхаарах зүйл, тайлбар
  - б. Агуулгын судалгаа хамтран хийснээр гарсан үр дүн 20 минут
4. Баг тус бүр багийн ажлаа танилцуулна. 5 x 5 минут = 25 минут
5. Танилцуулгад үндэслэн багууд харилцан асуулт тавьж хариулна. 10 минут
6. Багууд ажлын үр дүнгээ харьцуулан, “Хичээлийн бэлтгэл судалгаа – агуулгын судалгаа” гэсэн дүгнэлт гаргах 10 минут

**Даалгавар**

1. Багшлах дадлагын явцад хуримтлуулсан туршлагадаа үндэслэн, судалгаат хичээлийн видео материалтай танилцаж, (**ТӨМ 2.2**)–н асуултын дагуу тэмдэглэл хөтөлнө үү.

**ТӨМ 2.1 (.....сэдэвт хичээлийн агуулгын судалгаа хийсэн бүтээгдэхүүн)**

| Судлагдахууны агуулгын судалгаа хийх чиглэл                                                                                                                                          | ..... сэдвийн хүрээнд агуулгын судалгаа хийсэн байдал | Нэмэлт тайлбар, анхаарах зүйл |
|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------------------------------------|-------------------------------|
| ..... сэдвийн агуулга боловсролын стандартын аль айд хамаарах вэ?                                                                                                                    |                                                       |                               |
| Бусад айн агуулгатай ямар залгамж холбоотой вэ?                                                                                                                                      |                                                       |                               |
| Бусад хичээлүүдтэй ямар залгамж холбоотой вэ?                                                                                                                                        |                                                       |                               |
| Энэхүү сэдвээр өмнөх ангид болон бусад хичээлээр юу юу үзэж судалсан байдаг вэ?                                                                                                      |                                                       |                               |
| Дараагийн ангид энэ сэдвээр юу юуг гүнзгийрүүлэн судлах вэ?                                                                                                                          |                                                       |                               |
| ЕБ-ийн 12 жилийн сургуулийн сургалтын үндэсний хөтөлбөрт хэрхэн тусгагдсан бэ?                                                                                                       |                                                       |                               |
| Энэхүү сэдвийн агуулгыг ямар ямар чиглэл (уламжлал, экологи, тогтвортой хөгжлийн боловсрол гэх мэт) - ээр өргөсгөх боломжтой вэ?                                                     |                                                       |                               |
| Агуулгын судалгааг ямар ямар эх сурвалжаас хийсэн бэ?                                                                                                                                |                                                       |                               |
| Судлах зүйл ба хүүхдийн хөгжлийн түвшин:<br><ul style="list-style-type: none"> <li>Хүүхдүүддээ энэ агуулгыг яаж таниулах вэ?</li> <li>Хүүхдүүдийн сонирхлыг яаж татах вэ?</li> </ul> |                                                       |                               |

**ТӨМ 2.2 Агуулгын судалгааны арга зүйг таниулах нэгэн хувилбар**

- Та багшлах дадлагын явцад судалгаат хичээлд суусан уу?  
☐ мэдээлэл зүй ☐ математик ☐ хими ☐ хүн байгаль г.м
- Хичээл заасан багш агуулгын судалгааг хэрхэн хийсэн байна вэ?  
 Чухал гэж үзсэн 3 санаагаа бичнэ үү.  
 1.....  
 2.....  
 3.....
- Агуулгын судалгааны арга зүйг яаж хийх нь илүү үр дүнтэй байх бол?  
 .....  
 .....

### Семинар 3. Хэрэглэгдэхүүний судалгаа хийх арга зүй

**Зорилго:** Хичээлийн бэлтгэл судалгааны нэг бүрэлдэхүүн хэсэг болох хэрэглэгдэхүүний судалгааг тодорхой сэдэвт ээлжит хичээлийн хүрээнд хийх арга зүйг танин мэдэх.

**Хугацаа: 2 цаг (90 минут)**

**Хэрэглэгдэхүүн:**

- Тухайн хичээлийн тодорхой сэдэвт нэгж хичээлийн хөтөлбөр
- Тухайн нэгж хичээлд ашигласан хэрэглэгдэхүүнүүд
- ТӨМ 3.1, 3.2

**Бусад хэрэглэгдэхүүн:** Самбарын цаас, фломастер, скоч, соронз, интернэт бүхий компьютер

**Удирдамж**

Хичээлийн судалгааны нэг бүрэлдэхүүн болох хэрэглэгдэхүүний судалгааг хийх арга зүйтэй танилцаж, үр дүнг танилцуулах-90 минут

1. 4 хүнтэй багт зохион байгуулагдана. 5 минут
2. Багийн гишүүд тухайн хичээлийн тодорхой сэдэвт нэгж хичээлийн хөтөлбөр судалж, хэрэглэгдэхүүний судалгаа хэрхэн хийх талаар харилцан зөвшилцөж, ойлголтоо нэгтгэнэ (**ТӨМ 3.1** ашиглах). 20 минут
3. Хэрэглэгдэхүүний судалгааг хэрхэн хийх талаар уншиж судалсан, боловсруулсан материалаа бусдадаа танилцуулахад бэлтгэнэ. Үүнд дараах үндсэн агуулгыг тусгана.
  - с. Хэрэглэгдэхүүний судалгаа хийхэд анхаарах зүйл, тайлбар
  - d. Хэрэглэгдэхүүний судалгааг хамтран хийснээр гарсан үр дүн 20 минут
4. Баг тус бүр багийн ажлаа танилцуулна. 5 x 5 минут = 25 минут
5. Танилцуулгад үндэслэн багууд харилцан асуулт тавьж хариулна. 10 минут
6. Багууд ажлын үр дүнгээ харьцуулан, “Хичээлийн бэлтгэл судалгаа – хэрэглэгдэхүүний судалгаа” гэсэн дүгнэлт гаргах 10 минут

**Даалгавар**

1. Багшлах дадлагын явцад хуримтлуулсан туршлагадаа үндэслэн, судалгаат хичээлийн видео материалтай танилцаж, (**ТӨМ 3.2**)–н асуултын дагуу тэмдэглэл хөтөлнө үү.

**В. ТӨМ 3.1 (.....сэдэвт хичээлийн хэрэглэгдэхүүний судалгаа хийсэн бүтээгдэхүүн)**

| Хэрэглэгдэхүүний судалгаа хийх чиглэл                                                              | ..... сэдвийн хүрээнд хэрэглэгдэхүүний судалгаа хийсэн байдал | Нэмэлт тайлбар, анхаарах зүйл |
|----------------------------------------------------------------------------------------------------|---------------------------------------------------------------|-------------------------------|
| Та ямар ямар хэрэглэгдэхүүн сонгож хэрэглэхээр төлөвлөв? Тэдгээрийг бэлтгэхэд анхаарах зүйл юу вэ? |                                                               |                               |
| Хэрэглэгдэхүүн тус бүрийг хичээлийн ямар үе шатанд, хэрхэн хэрэглэхээр төлөвлөв? Яагаад?           |                                                               |                               |
| Цахим хэрэглэгдэхүүн бэлтгэх шаардлагатай юу? Ямар шаардлагыг хангасан гэж үзэж байна вэ?          |                                                               |                               |
| Самбар ашиглалтыг хэрхэн төлөвлөсөн байна вэ? Та ямар санал өгөх вэ?                               |                                                               |                               |
| Хэрэглэгдэхүүнд тавигдах дидактик зорилго гэдгийг та хэрхэн үзэж байна вэ?                         |                                                               |                               |

**ТӨМ 3.2 Хэрэглэгдэхүүний судалгааны арга зүйг таниулах нэгэн хувилбар**

**1. Багш энэ хичээлд ямар хэрэглэгдэхүүн сонгож авсан байна вэ?**

.....  
 .....

**2. Багшийн сонгож авсан хэрэглэгдэхүүн суралцагчдын мэдлэг бүтээх үйлд ямар дэмжлэг үзүүлсэн бэ? Та хамгийн чухал гэж үзсэн санаагаа бичнэ үү.**

.....  
 .....  
 .....

**3. Хэрэглэгдэхүүний судалгааны арга зүйг яаж хийх нь илүү үр дүнтэй байх бол?**

.....  
 .....

**БИЕ ДААХ АЖИЛ**

1. “Хичээлийн бэлтгэл судалгааны мөн чанар ” сэдэвт Эсээ бичих
2. “Хичээлийн бэлтгэл судалгааны талаарх миний төсөөлөл -1” сэдэвт Эсээ бичих

## Хичээлийн бэлтгэл судалгаа-2

| Хичээлийн хэлбэр, цаг | Агуулга                                                                                                                                    | Хэрэглэг дэхүүн | Бие даах ажил                                                                                                               |
|-----------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| Лекц 3 /2ц/           | <ul style="list-style-type: none"> <li>Мэдлэг эзэмшилтийн судалгаа, Хүүхдийн судалгаа</li> <li>Багшлахуйн арга барилын судалгаа</li> </ul> | ppt             | 4-7 дугаар семинар ажлын үр дүнгээ бүрэн тусгасан “Хичээлийн бэлтгэл судалгаа” хийх сайжруулсан төлөвлөлтийг эцэслэн гаргах |
| Семинар 4 /2ц/        | <ul style="list-style-type: none"> <li>Мэдлэг эзэмшилтийн судалгаа хийх арга зүй</li> </ul>                                                | ТӨМ-үүд         |                                                                                                                             |
| Семинар 5 /2ц/        | <ul style="list-style-type: none"> <li>Багшлахуйн арга барилын судалгаа</li> </ul>                                                         | ТӨМ-үүд         |                                                                                                                             |

### Лекц 3: Хичээлийн бэлтгэл судалгаа-2


#### Мэдлэг эзэмшилтийн судалгаа, Хүүхдийн судалгаа

Багш өмнөх хичээл заалтын явц дахь сурагчдын мэдлэг эзэмшилтийн үйл явцын судалгааг сайтар хийж, үр дүнг тооцон дараагийн заах хичээлийн агуулга, арга зүйн төлөвлөлтийг хийнэ.

Аливаа хичээлийг төлөвлөхдөө хичээлийн явцад сурагчдын мэдлэг эзэмшилтийн явцыг урьдчилан төсөөлж судалсныг мэдлэг эзэмшилтийн судалгаа гэнэ.

Мэдлэг эзэмшилтийн хоёр төрлийн судалгаа байдаг байна.

- Өмнө нь хийгдэж байсан судалгааг бага зэрэг засварлан хичээлээ үр дүнтэй болгоход зориулсан судалгаа
- Хичээлээ илүү үр дүнтэй болгох боломжит аргыг бодож тунгааж хийсэн судалгаа



Мөн мэдлэг эзэмшилтийн судалгаа гэдгийг хүүхдийн танин мэдэх үйл ажиллагааг судална гэж ойлгохоос бус тухайн судлагдахууныг ойлгосон, дутуу ойлгосон болон ойлгоогүй хүүхдийг тодруулж, тоон үнэлгээ өгч, анхааруулах зүйл гэж ойлгож болохгүй.

Хичээл сургалтын явцад хүүхдийн үг хэл яриа, сонирхол, байр суурь, хандлагад чухамхүү ямар өөрчлөлт гарч мэдлэг чадварт

тусах байгааг ажиглан судлах нь багш хүнд ихээхэн чухал юм.

Ж.Пиаже хүүхдийн сэтгэхүйн хөгжлийг төрснөөс эхлэн насанд хүрэх хүртэл хөгжлийн дөрвөн үе шатыг дамжина гэж тодорхойлсон байдаг ба оюутан-багш та энэхүү онолын талаарх мэдлэгээ семинарын хичээлд ашиглаарай.

Хүснэгт №1

| Үе шатууд                    | Нас                      | Зан үйлийн онцлог                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                            |
|------------------------------|--------------------------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| Хүртэх-хөдөлгөөний шат       | Төрснөөс эхлэн 1,5-2 нас | Нялх хүүхдүүд орчноо зөвхөн төрөл бүрийн үйлдлийн тусламжтайгаар танин мэддэг: Харах, хөхөх, хазах, захлах гэх мэт. Энэ үе шат нь хүүхдэд сэтгэхүй ба хэл яриа үүссэнээр дуусдаг.                                                                                                                                                                                                                                                            |
| Үйлдэл төлөвшихөөс өмнөх шат | 2-7 нас                  | Бага насны хүүхдүүд хэлд орж, орчныхоо хүмүүстэй ярих зэргээр дохиолол, тэмдгүүдийг эзэмшин, тэд тодорхой ухагдахууныг өөрийн болгоно. Гэвч ухагдахуун нь тэдний хувийн шууд туршлага, өөр дээр юмыг төвлөрүүлэн сэтгэх үзэл зэргээр хязгаарлагддаг. Хөгжлийнхөө энэ шатан дээр үр дагаврын талаар маш хязгаарлагдмал, заримдаа "үлгэрийн" юм шиг төсөөлөлтэй байдгаараа онцлог юм. Үзэгдэл юмсыг ангилахад ихээхэн төвөг, бэрхшээл учирдаг. |
| Тодорхой үйлдлийн шат        | 7-11,12 нас              | Хүүхдүүд юмыг логигоор сэтгэж эхлэх бөгөөд юмсыг хэд хэдэн шинж тэмдгээр нь ангилна. Математик ухагдахууныг тодорхой үзэгдэл юмст хамруулан хэрэглэх чадвартай болно. Юмсын шинж чанар, тогтвортой хадгалагддаг гэдгийг ойлгодог. Бага ангийн сурагчид нь “энд ба одоо” гэсэн нөхцөлд тодорхой асуудлуудыг логикийн хувьд эргэцүүлэх чадвартай болсон байдаг.                                                                                |
| Формаль үйлдлийн шат         | 12 наснаас дээш          | Өсвөр насныхан нь тодорхой ба хийсвэр асуудлыг шийдвэрлэх, задлан шинжилгээ хийх чадвартай болсон байна. Тэд бүх боломжийг бодож үзэх, өнгөрснөө дурсан санаж, ирээдүйн төлөвлөгөө зохиож чадах ба адилтгал буюу шилжүүлсэн утгад тулгуурлан эргэцүүлдэг.                                                                                                                                                                                    |

Л.С.Выготскийн хувьд нэгдүгээрт, хүүхэд хэлд орж эхлэнгүүтээ сэтгэхүйн хөгжил нь эрс өөрчлөгдөж, хоёрдугаарт, аливаа үйл ажиллагаа хэл яриатай нэгдсэнээр хүүхдийн танин мэдэх, аливааг эзэмших чадвар нь дээшилнэ хэмээн тодорхойлжээ.

Э.Эриксон нийгэм-сэтгэл зүйн хөгжлийн онолоороо нийгмийн орчин хувь хүний хөгжилд үзүүлэх нөлөөг авч үзэж, хүүхдийн хөгжлийг хэд хэдэн үе шатанд хуваасан юм. Хэдийгээр хүүхэд өөрөө ойлгож, мэдэж, сурах боловч, насанд хүрэгсэд туслагч, чиглүүлэгчийн үүрэг гүйцэтгэх болдог. Энэ үүргийн дагуу багш нар сургалтанд, үйл ажиллагаанд хэрэглэх материалыг урьдчилан бэлтгэж, тусалцаа, чиг баримжаагаараа хүүхдийн сурах сонирхлыг өдөөж, дэмжинэ.

Хүүхдийн мэдлэг эзэмшилтийн судалгааг 3 түвшинд хийдэг.

- Хичээлийн агуулгыг судлахад суурь болж өгөх мэдлэг, чадварыг хүүхдэд эзэмшсэн байгаа эсэх
- Хичээлийн агуулга нь хүүхдийн хөгжлийн төвшинд таарч байгаа эсэх

- Хичээлийн явцад хүүхдийн мэдлэг бүтээлт ямар хэлбэрээр яаж явагдаж байгаа байдал.

Мэдлэг эзэмших үйл явцын судалгааг багш хичээл заахын хажуугаар бүрэн дүүрэн хийж чадахгүй учраас мэргэжил нэгт бусад багш нартайгаа хамтран ажиллах нь зүйтэй. Мэдлэг эзэмшилтийн судалгааг нэгэн төрлийн хичээл зааж байгаа багш нар бие биеийнхээ хичээлийн явц, арга зүйн хэрэгжилт, тэр дундаа суралцагч нэг бүрийн мэдлэг эзэмшилтийг урьдчилан бэлтгэсэн шалгуурын дагуу үнэлгээ өгөх, хичээлийн дараа хамтарсан ярилцлага зохион байгуулах, хэлэлцэх, дараагийн хичээлийн бэлтгэл судалгаанд үүнийгээ ашиглах гэх мэт үйл ажиллагааны хэлбэрийг ашиглан хийх хэрэгтэй.

Хичээлийн бэлтгэл судалгааны бүрдэл хэсэг болох суралцагчийн мэдлэг эзэмших үйл явцын судалгаанд хичээлийг зохион байгуулах явцын дидактик хэсэг бүрд суралцагч (суралцагч нэг бүрийн онцлогт тохируулан төлөвлөж, чанарын өөрчлөлтийг тооцох)-ийн эзэмших мэдлэг, чадварыг тооцон төлөвлөж, түүний биелэлтэд шинжилгээ хийн, үр дүнг дараагийн хичээлийн бэлтгэл судалгаанд ашиглаж байх нь чухал юм.

Багш ээлжит хичээлийн хөтөлбөрт суралцагчдын мэдлэг эзэмших үйлийг хэрхэн тусгасан байгааг авч үзье.

#### Хичээлийн явц:

| Хичээлийн бүтэц элемент                   | Багшийн үйл ажиллагаа                                                                                                                                                                                                                                                                  | Суралцагчийн үйл ажиллагаа                                                                                                                                                                                                         |
|-------------------------------------------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| Сэргээн санах, сэдэл төрүүлэх шат /5 мин/ | Хүн хүлээн авсан мэдээллээ яах вэ?                                                                                                                                                                                                                                                     | Суралцагчдаас мэдээллийг дамжуулна, хадгална ...гэсэн <b><u>хариултыг сонсоно.</u></b>                                                                                                                                             |
| Шинэ мэдлэг олгох шат /13 мин/            | Мэдээллийг хадгалж байгаа объектийг мэдээллийн тээгч гэнэ. Мэдээллийг хадгалахын тулд хүмүүс янз бүрийн тээгчүүдийг зохиосон. Мэдээлэл нь бичвэр, график, тоон хэлбэрээр дүрслэгддэг.                                                                                                  | <b><u>Суралцагчид дэвтэртээ тэмдэглэж авах.</u></b><br>Ном, хадны бичээс, үлгэр домог, кино хальс, фото зураг, уян ба хатуу диск, flash диск гэх мэт.                                                                              |
|                                           | (12+13)*40=<br>Мэдээлэл ямар хэлбэрээр дүрслэгдсэн бэ?<br>Энэ мэдээлэл хаана оршиж байна вэ?<br>Бодлогын хариу яаж гарсан бэ?<br>Бодолтын үр дүн нь хаана хадгалагдсан бэ?<br>Бодолтын үр дүн багш сурагчдад хэрхэн тодорхой болсон бэ?<br>Үр дүнгийн мэдээллийг хэрхэн дамжуулсан бэ? | 1000<br>Тоон хэлбэрээр<br>Самбар дээр<br>Толгойдоо боловсруулалт хийж<br>Толгойд<br>Самбарт сурагч бичсэнээр<br><br>Толгойд хадгалагдсан мэдээлэл самбарт бичигдсэнээр /дамжуулалт хийгдсэнээр/ <b><u>гэх мэтээр хариулна.</u></b> |
|                                           | Орчин үед мэдээллийг хэрхэн хадгалах болсон бэ? Хүний тархи,                                                                                                                                                                                                                           | Компьютерт                                                                                                                                                                                                                         |

|                                                   |                                                                                                                                                                            |                                                                 |
|---------------------------------------------------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------------------------------------------------------------|
|                                                   | компьютер хоёрыг мэдээлэл хадгалах талд харьцуулах.                                                                                                                        | <b><u>Presentation дээр сурагч тайлбарлах.</u></b>              |
|                                                   | Слайд харуулж уншуулна. Анхааралтай ойлгож уншихыг сануулна.                                                                                                               | Уншина утгыг ойлгоно.<br><b><u>Асуултын дагуу ярилцана.</u></b> |
| <b>Бүтээлч үйл, бие даан ажиллах шат /12 мин/</b> | Хадгалах, боловсруулах, дамжуулах үйлдлүүдийг мэдээллийн процесс гэнэ. Мэдээлэл хадгалах төхөөрөмжүүд нэрлүүлэх.                                                           | <b><u>Сурагчид бичиж авна.</u></b>                              |
|                                                   | Мэдээллийг боловсруулах үйл ажиллагааг хялбарчлах автоматжуулах техник хэрэгслүүд олон байна. Үүний нэг нь компьютер юм.                                                   | Компьютерт бичвэр боловсруулах.                                 |
| <b>Үнэлгээ дүгнэлт / 8 мин/</b>                   | Бид өнөөдрийн тавьсан зорилтоо биелүүлсэн болов уу?<br>1. Мэдээллийг хаана хадгалдаг вэ?<br>2. Мэдээллийн тээгч гэж юу вэ?<br>3. Компьютерт мэдээллийг хэрхэн хадгалах вэ? | <b><u>Өөрөө өөрийг нь үнэлүүлэх.</u></b>                        |
| <b>Гэрийн даалгавар /2 мин/</b>                   | Мэдээллийг хэрхэн хэмжиж болдог талаар мэдэж ирэх. Мөн мэдээллийг хадгалах төхөөрөмжүүдийн хэмжээг гэр бүлийнхэнтэйгээ хамтарч мэдэж ирэх                                  | <b><u>Суралцагчид гэрийн даалгавар тэмдэглэж авах.</u></b>      |

Дээрх хөтөлбөрөөс хичээлийн төлөвлөлтийг гүйцэтгэх ажлын жагсаалт мэтээр хийсэн байгаа нь ажиглагдаж байна. Жишээ нь багш асууна, сануулна, нэрлүүлнэ. Сурагч сонсоно, тэмдэглэж авна гэх мэт.

Багш төлөвлөлт хийхдээ суралцагчдын чадварыг хөгжүүлэхэд чиглүүлсэн үйлийг тодорхой авч үзэх хэрэгтэй байна. Тухайлбал:

- Унших, ярих, бичих
- Тэмдэглэл, ишлэл зүүлт хийх
- Шүүмжлэх, шүүмж хүлээн авах
- Тайлбарлах, нотлох (зураг, диаграм, гол утга санаа...)
- Тайлан бичих
- Номтой ажиллах
- Мэдээлэл харилцааны технологийн орчинд ажиллах
- Судалгаа хийх (энгийн, туршилт хийх, таамаглал дэвшүүлэх...)
- Өөрийгөө илэрхийлэх
- Хамтран ажиллах гэх мэт.

Мэдлэг эзэмших үйл явцын судалгаа нь суралцагчдын тухайн үеийн мэдлэг, чадварын төвшинг хичээлийн бэлтгэл судалгаанд тооцох тухай асуудал бөгөөд багшид хичээлийн чанарыг сайжруулах дараах давуу талуудыг олгодог. Үүнд:

- Мэдлэг бүтээх үйл явцыг тооцож, урьдчилан төлөвлөх, түүнийгээ хэрэгжүүлэх
- Багш хичээлээ улам үр дүнтэй болгоход чиглэдэг

- *Баг хамтлагаараа хамтран тухайн хичээлийг заах арга зүйг судлах, сайжруулах*

Тиймээс хичээлдээ бэлтгэхдээ дараах зүйлүүдийг тооцож үзэх хэрэгтэй. Үүнд:

- *Хичээлийн агуулгыг судлахад суурь болох мэдлэг, чадварыг хүүхдүүд эзэмшсэн эсэх*
- *Хичээлийн агуулга хүүхдийн хөгжлийн төвшинд таарч байгаа эсэх*
- *Хичээлийн явцад хүүхдээр хэрхэн мэдлэг бүтээлгэхэд анхаарах*

Хүүхдэд учирч болох бэрхшээл, түүнийг даван туулах дидактик шийдлийг төлөвлөхдөө дараах зүйлүүдийг харгалзан үзнэ. Үүнд:

- *Агуулгаа тодорхойлохдоо суралцагчийн нас сэтгэхүйн онцлогт тохируулах*
- *Хүүхдийн үг хэллэг, ярианы төвшинг тооцох*
- *Сонирхол байр суурь, хандлагыг тооцох*
- *Хүүхдийн танин мэдэхүйн хөгжилд нийцэх эсэхийг тооцох*

Япон багш нар хүүхэд нэг бүрт ажиглалт тэмдэглэл хөтөлж юу чадаж мэдэж байгаа, юунд бүдэрч байгаа, хүүхдийн хөгжилд ямар өөрчлөлт гарч байгааг судалж хичээлдээ тооцдог байна. Ялангуяа сургалтын явцад хүүхдэд ямар бэрхшээл учирч энэ нь юутай холбоотой гарч байгааг таньж мэдэх нь ихээхэн чухал байдаг байна. Эндээс хүүхдийн алдааг таньж мэдэх, шалтгааныг олж тогтоох, зөв оношлох, эрт залруулах эхлэл тавигдана.

Хичээлийн бэлтгэл судалгаанд тухайн хичээлийг заах явцад суралцагчийн гаргаж болох алдааг тооцон төлөвлөнө. Суралцагчийн гаргаж болох алдаа нь тэдний амьдрал практикаас олж авсан буруу төсөөлөл (mis-conception), хүүхдийн тухайн үед гаргаж буй санаа (conception), үзэл бодол (concept), мөн багшийн гаргаж буй алдаанаас үүдэн гардаг. Тиймээс суралцагчийн гаргаж буй алдаа нь тэдний суралцах явцад гарч буй сэтгэн бодох үйл ажиллагаанд гарч байгаа бага зэргийн хазайлтаас шалтгаалан суралцагчийн чадвар илрэхгүй байгаа болохыг багш ойлгох хэрэгтэй бөгөөд алдаа гарах болсон шалтгааныг олж, аль болох түргэн залруулах хэрэгтэй. Суралцагчийн анхны төсөөлөл үнэнд үл нийцэхээр байж болох боловч түүнийг залруулан зөв болгох нь сургалтын нэгэн зорилго билээ. Суралцагчийн гаргаж байгаа алдааны шалтгааныг түүнээс хайх бус багшийн зааж буй хичээлийн чанар, заах арга зүйтэй холбон авч үзэх нь багш хөгжих нэг үндэс болно.

### **Даалгавар**

1. Дадлага хийх явцад та хэддүгээр ангид хичээл заасан бэ? Ж.Пиажегийн сэтгэхүйн хөгжлийн онолыг хэрхэн баримталж байсан бэ?
2. Таны суралцагч сурах ямар арга барилыг илүү эзэмшсэн байсан бэ?
3. Ээлжит хичээлийг зохион байгуулахдаа сурагчдын өмнө эзэмшсэн мэдлэг, чадварыг хэрхэн харгалздаг байсан бэ?
4. Суралцагчийн мэдлэг эзэмших үйл явцын судалгааг хийснээр ямар үр дүнтэй байх вэ?

## Багшлахуйн арга барилын судалгаа

### БАГШЛАХУЙН АРГА БАРИЛЫН СУДАЛГАА

- Хичээлийг хэрхэн сонирхолтой болгох вэ? Яаж сэдэл төрүүлэх вэ?
- Ямар асуулт тавих, хариу үйлдлийг хэрхэн удирдаж хөтлөх вэ?
- Ямар сорил, туршилт, дасгал бодлогыг ямар дэс дараа алхамтай хийлгэх вэ?
- Албадлагагүйгээр, олон хүүхдийг хичээлд татан оруулахын тулд яах вэ?
- Суралцагчдаас ямар хариу үйлдэл гарч болох, ямар байр суурь баримтлах вэ?

Аливаа хичээлийг төлөвлөхдөө судлагдахууны агуулгын болон мэдлэг эзэмшилтийн судалгаан дээр үндэслэн хичээл явуулах арга зүйг судалсныг багшлахуйн арга барилын судалгаа гэнэ.

Тухайн агуулгыг ямар байдлаар таниулах вэ? Хүүхдүүдийн сонирхлыг хэрхэн яаж татах вэ? Тухайн судлагдахууны үр өгөөжийг дээшлүүлэхэд ямар үйл ажиллагаа явуулах вэ? Хүүхдүүдийн алдаа

хийх магадлалтай хэсгийг яаж төлөвлөх вэ? Түүнд ямар хариу үйлдэл өгөх вэ? гэх мэт асуудлыг сайтар төлөвлөж судлах хэрэгтэй юм.

Мөн багшлахуйн арга барилын судалгаанд хичээлийг зохион байгуулах, суралцагчийн суралцах үйл ажиллагааг удирдан хөтлөх, суралцагчдаар мэдлэг бүтээлгэх гэх мэт арга, хандлагыг ойлгоно. Миний суралцагч хэн бэ? Тэд хэрхэн суралцдаг вэ? Тухайн хичээлд ямар зорилго, зорилт тавьж, түүнийг биелүүлэхийн тулд ямар хэлбэрээр зохион байгуулбал илүү оновчтой болох вэ? Хичээлийн явцад суралцагчдын анхаарлыг хэрхэн хандуулж, мэдлэг бүтээлгэх үйлийг яаж хөтлөх вэ? гэдгийг багш нарийн тооцож хичээлийн арга зүйгээ төлөвлөх хэрэгтэй. Мөн ямар туршилт, дадлага ажлыг хичээлийн аль үе шатанд хийх вэ? Ямар заавар, зөвлөмжийн дагуу хийх вэ? Ямар үр дүнд хүрэх вэ? гэх мэт зүйлсийг тодорхойлон, төлөвлөгөөнд тусгасан байх, Бага, дунд боловсролын стандартын арга зүйн хөгжлийн үндэс хэсэгт байгаа зарчмуудын санааг хөтөлбөрт тусгасан байх шаардлага тавигддаг. Тухайлбал, сурахуй, сургахуй, боломжийг тэнцүү олгох гэх мэтчилэн багш суралцагчийн хамтарсан үйл ажиллагааг оновчтой, зүй зохистой, бодитой хэрэгжихүйц байдлаар тодорхойлон, мэдлэг дамжуулах хандлагаас мэдлэг бүтээлгэх хандлага руу чиглэсэн арга зүйг боловсруулах нь чухал юм.

“Мэдлэг эзэмшилтийн судалгаа, Хүүхдийн судалгаа”-д мэдлэг эзэмшилтийн судалгааны талаар авч үзсэн байгааг эргэн харж, тухайн хичээлийн явцад суралцагч сургалтад хэрхэн хандаж болох вэ?, юу алдаж болох вэ?, үүнийг хэрхэн залруулж зөв чиглүүлэх вэ? гэх зэрэг асуудлыг хичээлийн агуулга, арга зүйн төлөвлөлтийн явцад тооцож үзсэнээр хичээлийг үр дүнтэй зохион байгуулах үндэс болно. Тухайн хичээлд суралцагч багаар ажиллах уу, ганцаарчлан ажиллах уу гэх мэт анги зохион байгуулалт багшлахуйн арга барилын судалгаанд хамааралтай.

Багш өөрийн заах арга зүйгээ тасралтгүй хөгжүүлэхийн тулд ээлжит хичээл бүрд арга зүйн судалгаагаа хийснээр, ажлын байрандаа бие даан хөгжиж, судалгааны ажил арга барилд суралцах боломж бүрдэхээс гадна сургалтын үр дүн дээшлэх давуу талтай.

Багшлахуйн арга барилын судалгаа нь хичээл зааж байгаа ангийн суралцагчдын сурлагын амжилтын тоон үзүүлэлтийг харуулах төдий зүйл биш, харин багш хичээлийг үр дүнтэй зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх арга зүйгээ бий болгож буй хэрэг юм. Дүгнээд хэлбэл, багшлахуйн арга зүйн судалгаа нь багш арга зүйгээ байнга сайжруулан хөгжүүлэх, хүүхдийн хөгжлийг дэмжихүйц сургалт зохион байгуулах чадварт суралцахад чухал нөлөө үзүүлнэ.

Ээлжит хичээлийн хөтөлбөрийн арга зүйд хөтөлбөрийг хэрэгжүүлэх сургалтын оновчтой аргуудыг сонгох, сонгосон аргуудыг хэрэглэх дидактик шийдлүүдийг хичээл тус бүрт боловсруулсан байх нь чухал юм.

Багш ээлжит хичээлийн арга зүйгээ төлөвлөхдөө:

- Тухайн хичээлийн судлагдахуун, хэрэгцээ, агуулга, хэрэглээтэй уялдуулан төлөвлөх
- Суралцагчийг идэвхжүүлэх
- Суралцагчийн суралцах үйлийг чиглүүлэх
- Суралцагчийн мэдлэг бүтээх үйлийг дэмжих
- Суралцагч тухайн хичээлээр эзэмшсэн мэдлэг, чадвараа цаашид хэрэглээ болгоход чиглүүлэх
- Суралцагч юуг? хэрхэн? суралцсанаа дүгнэх, өөртөө болон бусдадаа үнэлгээ өгөх
- Бусдадаа санал бодлоо солилцох гэх мэт үйлд хандсан арга сонгон авах нь чухал.

Аргын төлөвлөлт нь хөтөлбөр боловсруулах хамгийн чухал үйл ажиллагаа бөгөөд зарим хөтөлбөрийн энэ хэсэгт цөөн хэдэн бүтээлч аргыг дурдах төдийгөөр жагсаах нь хөтөлбөр хэрэгжихгүй байгаагийн гол шалтгаан мөн. Тодорхой сэдэвт ээлжит хичээлийн аль үе шатанд сонгож авсан аргуудыг хэрхэн хэрэглэж байгаагаа хөтөлбөртөө дэлгэрэнгүй тусгах нь чухал бөгөөд багш мэргэжил эзэмшиж буй та бүхэн энэ талаар судалгаа хийхийг орхигдуулж болохгүй.

## **Сургалтын аргуудаас**

### **Төслийн арга**

Сүүлийн үед сургалтын практикт маш хүчтэй нэвтэрч байгаа аргын нэг бол төслийн арга юм. Анх 1919 онд АНУ-ын Дальтон хотноо сурган хүмүүжүүлэгч Е.Паркхарст анги - хичээлийн системийг багштайгаа хамтран боловсруулсан төлөвлөгөөгөөр явагдах суралцагчийн ганцаарчилсан (бие даан гүйцэтгэх) ажлаар солих оролдлогыг хийсэн нь төслийн гэж нэрлэгдэж буй сургалтын аргын үндэс суурь болсон.

Төслийн арга гэдэг бол суралцагч сургалтын даалгавруудыг биелүүлэх үедээ өөрийн бүтээлч чанарыг илрүүлж, өөрийн үйл ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах, хянахад харьцангуй биеэ даасан байдлыг харуулах бололцоог түүнд олгодог, сургалтад нэг бүрчлэн хандах зарчмыг хэрэгжүүлэх боломж олгосон сургалтын иж бүрдэл арга юм. Энэ аргыг хэрэглэхэд гол чухал асуудал бол

төслийн сэдвийг сонгон авах болон төслийн үргэлжлэх хугацааг тогтоох явдал байдаг. Төслийн ерөнхий сэдвийг багш-сурагчийн өмнө дэвшигдсэн сургалтын болоод бусад зорилтуудтай уялдуулан сонгож авна. Суралцагч юмуу бүлэг сурагчдад өгөгдөх тодорхой сэдэв нь тэдэнд тушаал мэтээр тулган өгсөн биш өөрсөдтэй нь заавал зөвшин тохиролцсон байх ёстой.

Төслийг хэрэгжүүлэх цаг хугацааны тухайд бүлэг сэдвийн төгсгөлд давтлага, бататгал хичээл зохион байгуулах, эсвэл хичээлийн жилийн эцэст ерөнхий бататган давтах хичээлүүдийг төслийн хэлбэрээр зохион байгуулах нь тохиромжтой.

### **Дифференциал (ялгаатай хандах) арга**

Ахлах ангийн тухайд:

Сургалтын процессийг анги-хичээлийн системээр зохион байгуулахад суурилсан, сургалтын түгээмэл аргын нэг нь дифференциал буюу ялгаатайгаар хандах арга юм.

Ялган хуваах хуваалтыг сургуулийн түвшинд мэргэжлийн баримжаалалд тургуурлах, харин анги дотроо бол оюуны хөгжлийн түвшингээр зохион байгуулна. Информатикийн хичээлийн хувьд компьютер дээр ажиллах чадвараар нь хувааж болох юм. Ялган хувааж сургах сургалтын үндсэн үзэл баримтлал, чиг зорилго нь:

- Суралцагч бүрийг өөрийнх нь боломж бололцоо, ур чадварт нь түшиглэн сургах
- Янз бүрийн бүлгийн суралцагчдын онцлогт тохируулж нийцүүлэн сургалтыг зохион байгуулах явдал юм.

Сургалтыг зохион байгуулах технологийн хувьд ангийн сурагчдыг мэдлэг, чадварынх нь түвшингээр А, В, С – гэсэн гурван бүлэгт хуваана. Үүний хамт багш нь хүндрэлийн янз бүрийн түвшин бүхий хөтөлбөрийн ялгаварт гурван төрлийг боловсруулах ёстой. Хөтөлбөрүүд нь өөр хоорондоо маш нарийн уялдаа холбоотой байхын зэрэгцээ тус бүрдээ өөр өөрийн гэсэн заавал биелүүлэх минимум шаардлагатай байна. С – бүлэгт харгалзах хөтөлбөрийн даалгаврууд нь суурь стандартыг хангуулахад чиглэгдсэн байх бөгөөд тэдгээрийг бүх сурагч заавал биелүүлж чаддаг байх ёстой.

*Сургалтын энэ аргын хувьд түүний давуу тал нь:*

- “Алтан дундчууд” хэмээх оновчтой бус ойлголт, сайн байж яагаад ч тохирохгүй мэт хавтгайруулан үзэх явдлаас зайлсхийх боломж олгодог.
- Багш чадамж сайтай хүүхдүүдэд анхаарал тавьж, сул дорой нэгэнд нь туслах бололцоотой байдаг.
- Ангид сурлагаар хоцрогсод гэсэн ойлголт байхгүй болж, заах арга зүйн ерөнхий түвшинг бууруулах шаардлагагүй болдог.
- Оюуны чадавхи, чадвар сайтай сурагчдын улам илүү боловсролжих гэсэн хүсэл эрмэлзэл бодит биелэлээ олдог зэрэг олон зүйлийг дурьдаж болно.

**Энэ аргын хувьд сөрөг гэж үзэх асуудал нь:**

- Хүүхдийг хөгжлийн нь түвшингээр ялгаварлан хувааж буй нь хүнлэг бус
- Нийгэм, эдийн засгийн тэгш бус байдал илрэлээ олдог
- Анги хамт олны бүрдэлтэд нөлөө үзүүлж болох зэрэг болно.

Мэдээлэл зүйн хичээлийн хувьд суралцагчдын компьютер ашиглах чадвар харилцан адилгүй байгааг сайтар анхаарч, тэдний мэдлэг, чадварыг тогтоох нь чухал юм. Ингэснээр тэдний онцлогт тохирсон байдлаар хичээлийг зохион байгуулах, бие даалтын ажлыг төлөвлөх боломжтой болно.

**Багшлахуйн арга барилын судалгааг** хийхдээ тухайн ээлжит хичээлдээ ул суурьтай бэлтгэх, хичээлээ хэрхэн зохион байгуулахаа төлөвлөх, хичээлдээ дүн шинжилгээ хийж арга зүйгээ яаж дээшлүүлэх гэх мэт өргөн хүрээтэй асуудлыг суралцахуйн сэтгэл судлал, сурган хүмүүжүүлэх ухаан болон тухайн мэргэжлийн дидактикийн онолын үндэслэлд тулгуурлан, оновчтой дидактик шийдлийг гарган авах хэрэгтэй. Боловсролын стандарт, хөтөлбөрт сургалтын зорилго, агуулгыг тусгасан байдаг ч багшийн арга зүйг стандартчилж болдоггүйгээрээ онцлогтой. Иймд багш таны идэвх, санаачлага, бүтээлч сэтгэлгээ, хамтын ажиллагаа, туршлага арга зүйн хөгжлийн тулгуур болох юм шүү.

### **Даалгавар**

1. Сурган хүмүүжүүлэх дадлагын явцад та сургалтын ямар аргуудыг сонгож, хичээлд ашигласан бэ? Яагаад?
2. Сонгосон арга сурагчдыг мэдлэг бүтээх үйлд чиглүүлж чадаж байсан эсэхэд дүн шинжилгээ хийнэ үү?
3. Сурган хүмүүжүүлэх ухаан, мэргэжлийн дидактик хичээлүүдийн уялдааг хэрхэн хэрэгжүүлж байсан бэ?

## Семинар 4. Мэдлэг эзэмшилтийн судалгаа хийх арга зүй

**Зорилго:** Хичээлийн бэлтгэл судалгааны нэг бүрэлдэхүүн хэсэг болох мэдлэг эзэмшилтийн судалгааг тодорхой сэдэвт ээлжит хичээлийн хүрээнд хийх арга зүйг танин мэдэх.

**Хугацаа: 2 цаг (90 минут)**

**Хэрэглэгдэхүүн:**

- Тухайн хичээлийн тодорхой сэдэвт ээлжит хичээлийн хөтөлбөр
- Ж.Пиажегийн онол бүхий хүснэгт
- ТӨМ 4.1, 4.2

**Бусад хэрэглэгдэхүүн:** Самбарын цаас, фломастер, скоч, соронз, интернэт бүхий компьютер

**Удирдамж**

Хичээлийн судалгааны нэг бүрэлдэхүүн болох мэдлэг эзэмшилтийн судалгааг хийх арга зүйтэй танилцаж, үр дүнг танилцуулах-90 минут

1. 4 хүнтэй багт зохион байгуулагдана. 5 минут
2. Багийн гишүүд тухайн хичээлийн тодорхой сэдэвт ээлжит хичээлийн хөтөлбөр судалж, хэрэглэгдэхүүний судалгаа хэрхэн хийх талаар харилцан зөвшилцөж, ойлголтоо нэгтгэнэ (**ТӨМ 4.1; Ж.Пиажегийн онол бүхий хүснэгт** ашиглах). 20 минут
3. Мэдлэг эзэмшилтийн судалгааг хэрхэн хийх талаар уншиж судалсан, боловсруулсан материалаа бусдадаа танилцуулахад бэлтгэнэ. Үүнд дараах үндсэн агуулгыг тусгана.
  - а. Мэдлэг эзэмшилтийн судалгаа хийхэд анхаарах зүйл, тайлбар
  - б. Мэдлэг эзэмшилтийн судалгааг хамтран хийснээр гарсан үр дүн 20 минут
4. Баг тус бүр багийн ажлаа танилцуулна. 5 x 5 минут = 25 минут
5. Танилцуулгад үндэслэн багууд харилцан асуулт тавьж хариулна. 10 минут
6. Багууд ажлын үр дүнгээ харьцуулан, “Хичээлийн бэлтгэл судалгаа – мэдлэг эзэмшилтийн судалгаа” гэсэн дүгнэлт гаргах 10 минут

**Даалгавар**

1. Багшлах дадлагын явцад хуримтлуулсан туршлагадаа үндэслэн, судалгаат хичээлийн видео материалтай танилцаж, (**ТӨМ 4.2**)–н асуултын дагуу тэмдэглэл хөтөлнө үү.

**Б. ТӨМ 4.1 (.....сэдэвт хичээлийн хүрээнд сурагчид хэрхэн мэдлэг эзэмших талаар судалгаа хийсэн бүтээгдэхүүн)**

| Мэдлэг эзэмшилтийн судалгаа хийх чиглэл                                                  | ..... сэдвийн хүрээнд мэдлэг эзэмшилтийн судалгаа хийсэн байдал | Нэмэлт тайлбар, анхаарах зүйл |
|------------------------------------------------------------------------------------------|-----------------------------------------------------------------|-------------------------------|
| Таны суралцагч хэн бэ? Сурахуйн ямар арга барил илүү эзэмшсэн байна вэ?                  |                                                                 |                               |
| Энэхүү агуулгыг судлахад сурагчдын өмнөх төсөөлөл, мэдлэг, чадвар ямар байх вэ?          |                                                                 |                               |
| Суралцагч ямар үйл хийж, шинэ мэдлэгийг эзэмшихээр төлөвлөсөн бэ?                        |                                                                 |                               |
| Суралцагч ямар алдаа гаргаж болох вэ? Түүнийг хэрхэн засах талаар хөтөлбөрт тусгасан уу? |                                                                 |                               |

**ТӨМ 4.2 Мэдлэг эзэмшилтийн судалгааны арга зүйг таниулах**

1. Судалгаат хичээлийн явцад хүүхдийн мэдлэг бүтээлт ямар хэлбэрээр явагдаж байсан бэ (Мэдлэг эзэмшилтийн судалгаа – Төлөвлөсөн хичээлийн хөтөлбөр - Судалгаат хичээл)? Хамгийн онцгой гэж үзсэн санаагаа тэмдэглэнэ үү?

.....  
 .....  
 .....  
 .....

2. Мэдлэг эзэмшилтийн судалгааны арга зүйг яаж хийх нь илүү үр дүнтэй байх бол?

.....  
 .....  
 .....  
 .....

## Семинар 5. Багшлахуйн арга барилын судалгаа

**Зорилго:** Хичээлийн бэлтгэл судалгааны нэг бүрэлдэхүүн хэсэг болох багшлахуйн арга барилын судалгааг тодорхой сэдэвт ээлжит хичээлийн хүрээнд хийх арга зүйг танин мэдэх.

**Хугацаа: 2 цаг (90 минут)**

**Хэрэглэгдэхүүн:**

- Тухайн хичээлийн тодорхой сэдэвт ээлжит хичээлийн хөтөлбөр
- Сургалтын арга бүхий хүснэгт
- ТӨМ 5.1, 5.2

**Бусад хэрэглэгдэхүүн:** Самбарын цаас, фломастер, скоч, соронз,

**Удирдамж**

Хичээлийн судалгааны нэг бүрэлдэхүүн болох багшлахуйн арга барилын судалгааг хийх арга зүйтэй танилцаж, үр дүнг танилцуулах - 90 минут

1. 4 хүнтэй багт зохион байгуулагдана. 5 минут
2. Багийн гишүүд тухайн хичээлийн тодорхой сэдэвт ээлжит хичээлийн хөтөлбөр судалж, багшлахуйн арга барилын судалгаа хэрхэн хийх талаар харилцан зөвшилцөж, ойлголтоо нэгтгэнэ (**ТӨМ 5.1; Сургалтын арга бүхий хүснэгт** ашиглах). 20 минут
3. Багшлахуйн арга барилын судалгааг хэрхэн хийх талаар уншиж судалсан, боловсруулсан материалаа бусдадаа танилцуулахад бэлтгэнэ. Үүнд дараах үндсэн агуулгыг тусгана.
  - а. Багшлахуйн арга барилын судалгаа хийхэд анхаарах зүйл, тайлбар
  - б. Багшлахуйн арга барилын судалгааг хамтран хийснээр гарсан үр дүн20 минут
4. Баг тус бүр багийн ажлаа танилцуулна. 5 x 5 минут = 25 минут
5. Танилцуулгад үндэслэн багууд харилцан асуулт тавьж хариулна. 10 минут
6. Багууд ажлын үр дүнгээ харьцуулан, “Хичээлийн бэлтгэл судалгаа – багшлахуйн арга барилын судалгаа” гэсэн дүгнэлт гаргах 10 минут

**Даалгавар**

1. Багшлах дадлагын явцад хуримтлуулсан туршлагадаа үндэслэн, судалгаат хичээлийн видео материалтай танилцаж, (**ТӨМ 5.2**)–н асуултын дагуу тэмдэглэл хөтөлнө үү.

**Б. ТӨМ 5.1 (.....сэдэвт хичээлийн хүрээнд багшлах арга барилын талаар судалгаа хийсэн бүтээгдэхүүн)**

| Багшлахуйн арга барилын судалгаа хийх чиглэл                                                                           | ..... сэдвийн хүрээнд багшлахуйн арга барилын судалгаа хийсэн байдал | Нэмэлт тайлбар, анхаарах зүйл |
|------------------------------------------------------------------------------------------------------------------------|----------------------------------------------------------------------|-------------------------------|
| Боловсролын стандартад тусгагдсан арга зүйн хөгжлийн үндсийн гол санааг арга зүйн судалгаандаа хэрхэн тусгаж байна вэ? |                                                                      |                               |
| Сургалтын ямар аргыг хэрхэн сонгож авсан бэ?                                                                           |                                                                      |                               |
| Хичээлийн ямар үе шатад сургалтын аргыг хэрхэн хэрэгжүүлэх вэ?                                                         |                                                                      |                               |
| Суралцагч мэдлэг бүтээх үйлийг хэрхэн ямар арга зүйгээр чиглүүлэх вэ?                                                  |                                                                      |                               |

**ТӨМ 5.2 Багшлахуйн арга барилын судалгааны арга зүйг таниулах нэгэн хувилбар**

1. Та энэ сэдвийг заасан бол ямар арга зүйг сонгож, хэрхэн хэрэгжүүлэх вэ?

.....  
 .....  
 .....  
 .....

2. Багшлахуйн арга барилын судалгааны арга зүйг яаж хийх нь илүү үр дүнтэй байх бол?

.....  
 .....  
 .....  
 .....

**БИЕ ДААХ АЖИЛ**

1. “Хичээлийн бэлтгэл судалгааны талаарх миний төсөөлөл -2” сэдэвт эсээ бичих

## Хичээлийн бэлтгэл судалгаа-3

| Хичээлийн хэлбэр, цаг | Агуулга                                                                             | Хэрэглэг дэхүүн | Бие даах ажил |
|-----------------------|-------------------------------------------------------------------------------------|-----------------|---------------|
| Лекц 4 /2ц/           | <ul style="list-style-type: none"> <li>Үнэлгээний судалгаа</li> </ul>               | ppt             | Эсээ бичих    |
| Семинар 6, 7 /4ц/     | <ul style="list-style-type: none"> <li>Үнэлгээний судалгаа хийх арга зүй</li> </ul> | ТӨМ-үүд         |               |

### Лекц 4 Хичээлийн бэлтгэл судалгаа-3

#### Үнэлгээний судалгаа

Сургалтын үйл ажиллагааны салшгүй нэг чухал хэсэг бол үнэлгээ билээ. Үнэлгээ нь суралцагчийн суралцах үйл ажиллагаанд гарч байгаа өөрчлөлтийг илрүүлээд зогсохгүй, багшийн сургалтын ажлын нэг үзүүлэлт болно. Сургалтад үнэлгээний судалгаа нь нэг талаас суралцагчид дүн тавих зорилготой байдаг боловч нөгөө талаас багш өөрийн сургалтын ажлаа бодитойгоор илрүүлэх боломжийг багшид олгож байдаг гэдгийг энэхүү судалгаанд тооцож үзэх нь зүйтэй.

#### Үнэлгээний судалгааг хийхдээ:

- Үнэлгээ зорилго, зорилттой нийцсэн байх
- Үнэлгээний арга, хэлбэрийг тодорхойлсон байх
- Суралцагчдын танин мэдэхүйн түвшинд тохирсон даалгавар боловсруулсан байх
- Үнэлгээний даалгаврыг хэмжээсжүүлэн үнэлэх аргачлалаа боловсруулсан байхад чиглэгдэх.

Үнэлгээний материалын судалгаа нь агуулга, арга зүйн судалгаатай нягт уялдаатай хийгдэнэ. Үнэлгээний материалыг боловсруулахдаа суралцагч нэг бүрд гарч байгаа ахиц дэвшил, сурах арга барилын өөрчлөлтийг бодитойгоор илрүүлэхэд анхаарах ёстой.

Зорилго зорилтод анализ хийх замаар эзэмшвэл зохих цогц чадвар, түвшинг тодруулах судалгааг үнэлгээний судалгаа гэнэ.

Тухайн хичээлийн бүтэн жилийн, улирлын, бүлэг сэдвийн, нэгж хичээлийн зорилгыг нэг чиглэл дор нэгтгэснээр үнэлгээг хаана, хэдийд хийх нь тодорхой болно.

Зорилго нь:

- Юунд сургах вэ?
- Ерөнхий агуулга нь ямар байх вэ?
- Гүнзгий агуулга нь ямар байх вэ? Түүнээс гадна тухайн хичээлээр юуг хэрхэн яаж үнэлэх вэ?
- Сурагчдын сонирхол идэвх хандлага
- Сэтгэн бодож тунгааж буй байдал
- Илэрхийлэх, тооцоолох чадвар

- Мэдлэг, ухамсар, чадварын чухам аль хэсгийг чухалчлах вэ? гэдгийг багш судалж тогтоосон байна.

Ээлжит хичээлийг үнэлэхдээ:

- Хичээлийн явцыг үнэлэх, түүндээ тулгуурлаад сурагчийн оролцоо идэвхийг үнэлэх
- Арга зүйн төлөвлөлт нь сурагчдын идэвх сонирхолд нийцэж буй эсэх, мөн дараагийн хичээл төлөвлөхдөө юуг нь засах, эсвэл хэвээр үлдэх эсэхээ шийдэх.

Үнэлгээ нь сургалтын зорилго, зорилтын хүрээнд суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагыг тодорхойлох хэрэглэгдэхүүн, нөгөө талаас хичээлийн дидактик зорилго хэрхэн хангагдсаныг үнэлэх шалгуур болох учиртай.

Хичээлийн үнэлгээнд дараах зүйлүүдийг тооцох хэрэгтэй. Үүнд:

- Суралцагчдын сонирхол, идэвх, хандлага
- Суралцагчийг сэдэлжүүлэх, шинэ санааг хөхүүлэн дэмжих
- Сэтгэн бодох чадварын хөгжлийг илрүүлэх
- Илэрхийлэх, тооцоолох чадварыг хөгжүүлэх, илрүүлэх
- Мэдлэг эзэмшилтийн төвшинг илрүүлэх

Хичээлийн үнэлгээг хийхдээ үнэлгээний материал боловсруулан ашиглана. Энэхүү үнэлгээний материал нь суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадварыг илрүүлэхээс гадна хичээлийн зорилго зорилт хэрхэн биелснийг тодорхойлж өгдөг учраас үнэлгээний материалыг боловсруулахдаа хичээл (нэгж, ээлжит, нийт хичээл)-ийн зорилго зорилттой уялдуулан боловсруулахыг зорих хэрэгтэй.

Үнэлгээний асуултууд дараах шаардлагыг хангаж байх хэрэгтэй бөгөөд эдгээр нь үнэлгээний асуултын шалгуур болдог. Үүнд:

- Асуулт нь сургалтын материалын зорилго, зорилтод тодорхойлсон мэдлэг, чадвар, дадлын үр дүнг үнэлэхэд зориулагдсан байх
- Хариулт нь сургалтын материалын агуулгад орсон байх.
- Асуулт нь тухайн асуудлын утга учрыг бүрэн илэрхийлсэн байх
- Асуулт нь утга төгөлдөр бөгөөд хариултыг хичээлийн эхээс шууд хуулахааргүй байх
- Асуулт нь ойлгомжтой, богино, шууд утгатай байхаар томъёологдсон байх
- Асуулт нь захиран тушаасан биш, зөөлөн хэлбэртэй байх
- Хариултын хувилбарууд асуулттайгаа төлөв байдал, нэр томъёоны хувьд хамааралтай байна.
- Хариултын хувилбарууд нь ойролцоо утгатай байх
- Асуулт нь нэг утгатай тодорхойлогдсон бөгөөд түүнд харгалзах зөв хариулт заавал байх
- Асуултанд хэрэглэж байгаа үгс, зөв хариулт уруу хөтлөх буюу зөв хариултыг шууд мэдэх боломж олгохгүй байхаар илэрхийлэгдсэн байх

- Асуултад суралцагчийн хүйстэй холбоотой хандлага гаргаагүй байх
- Асуулт логикийн алдаагүй томъёологдсон байх
- Асуулт шаардлагагүй тохиолдолд давуу зэргийг илтгэх үг, илэрхийлэл агуулаагүй байх
- Хариултын хувилбаруудад “үргэлж”, “хэзээ ч” гэх үгс байхгүй байна.
- Асуулт болон хариултын хувилбаруудад электрон материалаас авсан эх байхгүй байна. Асуултын бүх хэсгүүд нь дасгал ажлын хэл дээр бичигдсэн байна.

Мөн суралцагч хариултдаа сурах бичгийн агуулгын эх дотроос авсан текст ашиглахааргүй байна.

1. Хариултын хувилбарт “дээрхээс аль нь ч биш”, “дээрх дурдсан бүгд зөв” гэх мэт хариултууд байхгүй байна.
2. Асуулт болон хариултад “үүнээс гадна”, үгүйсгэх буюу “үгүй” гэх зэрэг үг хэрэглээгүй байна.
3. Хариултуудад “А, Б хоёул зөв”, “А ч биш, Б ч биш” гэх хувилбарууд байхгүй байна.

Үнэлгээ нь суралцагчийн сурах үйлийг дэмжсэн байх зорилгыг өөртөө агуулдаг бөгөөд суралцагчийн ахицын байдлыг багш хэрхэн үнэлэх аргачлалыг ч хөтөлбөрт тусгах шаардлагатай. Чанарын үнэлгээ хийх рубрикийн аргын тухай товч авч үзье.

### Рубрик (Rubric) гэж юу вэ?

Рубрик гэж юу вэ?

- Төсөл зохиож төлөвлөх удирдамж,
- Хийж, шүүн тунгааж, үнэлж дуусгасан ажлын чухал хэсгүүдийг тодорхойлох категориудын багц үзүүлэлт юм.
- Багш суралцагчдын үнэлгээний нэгэн хэрэгсэл болохын хувьд мультимедиа төсөл, илтгэл тайлан болон бусад ангийн ажлуудыг үнэлэхэд хэрэглэгдэж болох цогц зүйл юм.

Энэ нь төсөл зохиож төлөвлөх удирдамж, багш суралцагчдын үнэлгээний хэрэгсэл бөгөөд үнэлгээний шалгуураа гаргах явдал юм.

Рубрик гэдэг нь хийж, шүүн тунгааж, үнэлж дуусгасан ажлын чухал хэсгүүдийг тодорхойлох категориудын багц үзүүлэлт юм. Категори бүр нь тухайн ажил ямар шалгууруудыг хангаад ямар түвшинд очиж

хэдэн оноо авсан байх ёстой вэ? гэсэн үзүүлэлтүүдийг багтаана.

Рубрик нь үнэлгээний нэгэн хэрэгсэл болохын хувьд мультимедиа төсөл, илтгэл тайлан болон бусад ангийн ажлуудыг үнэлэхэд хэрэглэгдэж болох цогц зүйл юм. Нэгэнт үнэлгээний шалгуур үзүүлэлт тодорхой болсон тохиолдолд багш суралцагсад тухайн төслийн зорилго болон шалгуурын талаар нийтлэг нэгэн ойлголттой болох боловч гүйцэтгэх түвшин нь өөр өөр байж болно.

Рубрикийг ашиглан үнэлгээг өөр өөр хэлбэрээр хийж болох боломжтой. Жишээ нь: Багш төсөлт ажлыг анги нийтээр, баг бүлгээр эсвэл суралцагч ганцаарчлан гүйцэтгэхээр төлөвлөж, үнэлж болох ба суралцагч рубрикийг өөрийгөө болон баг бүлгийн ажлыг үнэлэх, мөн бие биенийхээ гүйцэтгэсэн ажлыг харилцан үнэлэхэд ашиглаж болох талтай.

Мэдээллийн хэрэгслүүдийг өөр өөрийн категорит хуваах ба категори бүрт үзүүлэлтийн түвшинг өөр өөрөөр тодорхойлсноор суралцагсад тэдгээр мэдээллийн хэрэгслийг задлан шинжлэх, угсрах, бүтцийг нь судлах боломжтой. Жишээлбэл эсээ бичихдээ түүнд тавьсан зорилго зорилт, бүтэц, дэлгэрүүлсэн байдал, үг сонголт, механик (үг үсэг, дүрэм, найруулгын алдаа гэх мэт) зэрэг нь тухайн эсээний рубрик болно.

### Рубрикийг яагаад хэрэглэдэг вэ?

- Рубрик нь багш суралцагчдад чанар гэсэн ойлголтыг тодорхойлдог.
- Суралцагчид өөрсдийнхөө хийж байгаа ажилд рубрикийг байнга хэрэглэж заншвал эцсийн бүтээгдэхүүн гаргахдаа илүү хариуцлага хүлээж эхэлдэг.
- Рубрик нь багш нар суралцагчдын бие даалтын ажил гэх мэтийг үнэлэхэд зарцуулдаг цагийг багасгадаг ба суралцагчид хийсэн зүйлдээ яагаад ийм үнэлгээ, хэдэн оноо авсан бэ, юуг, яаж сайжруулах вэ гэдгийг тайлбарлахад хялбар байдаг.

Эсээг үнэлэх рубрик (хувилбар болгов)

| Үзүүлэлт                         | 3<br>Давуу                                                                                                                                                                                         | 2<br>Дутуу                                                                                                                                                                                | 1<br>Хангалтгүй                                                                                                 |
|----------------------------------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------|
| <b>Зорилгоо тодорхойлох</b>      | Зорилгоо бүрэн дүүрэн тодорхойлсон                                                                                                                                                                 | Зорилгын талаарх ойлголттой                                                                                                                                                               | Дутагдалтай                                                                                                     |
| <b>Зорилгыг дэмжих баримтууд</b> | <ul style="list-style-type: none"> <li>• Дэвшүүлсэн зорилгод хамааралтай материалыг бүрэн дүүрэн ашигласан</li> <li>• Дэвшүүлсэн зорилгодоо хүрэхэд ашиглагдах баримтууд 5 –аас багагүй</li> </ul> | <ul style="list-style-type: none"> <li>• Дэвшүүлсэн зорилгод хамааралтай материалыг дутуу ашигласан</li> <li>Дэвшүүлсэн зорилгодоо хүрэхэд ашиглагдах баримтууд 3 –аас багагүй</li> </ul> | <ul style="list-style-type: none"> <li>• Дэвшүүлсэн зорилгод хамааралтай материалыг бараг ашиглаагүй</li> </ul> |
| <b>Ашиглагдах эх сурвалж</b>     | 5-аас багагүй өөр өөр эх сурвалж ашигласан                                                                                                                                                         | 3-аас багагүй өөр өөр эх сурвалж ашигласан                                                                                                                                                | 1-ээс ихгүй эх сурвалж ашигласан                                                                                |
| <b>Механик</b>                   | Үг үсэг, дүрэм, найруулгын алдаагүй.                                                                                                                                                               | Үс үсэг, цэг таслалын алдаагүй ч дүрмийн болон найруулгын алдаатай.                                                                                                                       | Үг үсэг, цэг, таслалын алдаатай                                                                                 |
| <b>Танилцуулга</b>               | Ямар нэгэн програм ашиглах замаар үзүүлэн, танилцуулга бэлтгэж, ур чадвараа харуулсан.                                                                                                             | Ямар нэгэн програм ашиглах замаар үзүүлэн танилцуулга бэлтгэсэн ч, ур чадвараа бүрэн харуулаагүй                                                                                          | Ямар нэгэн програм ашиглан үзүүлэн танилцуулга бэлтгээгүй.                                                      |

### Даалгавар

1. Сурган хүмүүжүүлэх дадлагын явцад та үнэлгээний ямар ямар арга, хэлбэрийг хэрэгжүүлсэн бэ?
2. Үнэлгээний даалгавар боловсруулах, үнэлгээний шалгуур үзүүлэлт боловсруулах талаар өөрийн мэдлэг, чадварт дүн шинжилгээ хийнэ үү?

## Семинар 6. Үнэлгээний судалгаа хийх арга зүй

**Зорилго:** Хичээлийн бэлтгэл судалгааны нэг бүрэлдэхүүн хэсэг болох үнэлгээний судалгааг тодорхой сэдэвт ээлжит хичээлийн хүрээнд хийх арга зүйг танин мэдэх.

**Хугацаа:** 2 цаг (90 минут)

**Хэрэглэгдэхүүн:**

- Тухайн хичээлийн тодорхой сэдэвт нэгж болон ээлжит хичээлийн хөтөлбөр
- Боловсруулсан үнэлгээний материал
- ТӨМ 6.1, 7.1

**Бусад хэрэглэгдэхүүн:** Самбарын цаас, фломастер, скоч, соронз

**Удирдамж**

Хичээлийн судалгааны нэг бүрэлдэхүүн болох үнэлгээний судалгааг хийх арга зүйтэй танилцаж, үр дүнг танилцуулах - 90 минут

1. 4 хүнтэй багт зохион байгуулагдана. 5 минут
2. Багийн гишүүд тухайн хичээлийн тодорхой сэдэвт нэгж болон ээлжит хичээлийн хөтөлбөр судалж, үнэлгээний судалгаа хэрхэн хийх талаар харилцан зөвшилцөж, ойлголтоо нэгтгэнэ (**ТӨМ 6.1** ашиглах). 20 минут
3. Үнэлгээний судалгааг хэрхэн хийх талаар уншиж судалсан, боловсруулсан материалаа бусдадаа танилцуулахад бэлтгэнэ. Үүнд дараах үндсэн агуулгыг тусгана.
  - а. Үнэлгээний судалгаа хийхэд анхаарах зүйл, тайлбар
  - б. Үнэлгээний судалгааг хамтран хийснээр гарсан үр дүн 20 минут
4. Баг тус бүр багийн ажлаа танилцуулна. 5 x 5 минут = 25 минут
5. Танилцуулгад үндэслэн багууд харилцан асуулт тавьж хариулна. 10 минут
6. Багууд ажлын үр дүнгээ харьцуулан, “Хичээлийн бэлтгэл судалгаа – үнэлгээний судалгаа” гэсэн дүгнэлт гаргах 10 минут

**Даалгавар**

1. Багшлах дадлагын явцад хуримтлуулсан туршлагадаа үндэслэн, судалгаат хичээлийн видео материалтай танилцаж, (**ТӨМ 6.2**)–н асуултын дагуу тэмдэглэл хөтөлнө үү.

**ТӨМ 6.1 .....сэдэвт хичээлийн хүрээнд үнэлгээний судалгаа хийсэн бүтээгдэхүүн**

| Багшлахуйн арга барилын судалгаа хийх чиглэл                                                                                      | ..... сэдвийн хүрээнд үнэлгээний судалгаа хийсэн байдал | Нэмэлт тайлбар, анхаарах зүйл |
|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------|---------------------------------------------------------|-------------------------------|
| Боловсролын стандартад тусгагдсан үнэлгээний стандартын гол санааг үнэлгээний судалгаандаа хэрхэн тусгаж байна вэ?                |                                                         |                               |
| ... сургалтын үндэсний хөтөлбөрийн үнэлгээний аргазүйтэй хэрхэн нийцсэн бэ?                                                       |                                                         |                               |
| Үнэлгээний ямар хэлбэрийг, хэрхэн сонгож авсан байна вэ?                                                                          |                                                         |                               |
| Хичээлийн ямар ямар үе шатад үнэлгээг хэрхэн хийхээр төлөвлөсөн байна вэ?                                                         |                                                         |                               |
| Суралцагчдын ахиц, дэвшлийг үнэлэх талаар багш хэрхэн төлөвлөсөн байна вэ? Хөтөлбөрөөс энэ арга зүйг харах боломж байна уу?       |                                                         |                               |
| Хичээлийн төгсгөлд хүүхэд юу мэддэг, чаддаг, хувирган хэрэглэдэг болсон байх вэ? Хүүхэд өөрийгөө үнэлэх боломж тусгасан байна уу? |                                                         |                               |

**ТӨМ 6.2 Үнэлгээний судалгааны арга зүйг таниулах нэгэн хувилбар**

**1. Энэхүү хичээлийн төлөвлөлт хэрхэн биелсэн бэ?**

.....  
 .....

**2. Та дахин боловсруулалт хийж заах бол хичээлийн ямар арга зүйд, ямар сайжруулалт хийх вэ? Бичнэ үү?**

.....  
 .....  
 .....

**3. Үнэлгээний судалгааны арга зүйг яаж хийх нь илүү үр дүнтэй байх бол?**

.....  
 .....  
 .....

## Семинар 7. Ээлжит хичээлийн болон нэгж сэдвийн үнэлгээний судалгаа хийх арга зүй

**Зорилго:** Хичээлийн бэлтгэл судалгааны нэг бүрэлдэхүүн хэсэг болох үнэлгээний судалгааг тодорхой сэдэвт ээлжит хичээлийн хүрээнд хийх арга зүйг танин мэдэх.

**Хугацаа: 2 цаг (90 минут)**

**Хэрэглэгдэхүүн:**

- Тухайн хичээлийн тодорхой сэдэвт нэгж болон ээлжит хичээлийн хөтөлбөр
- Боловсруулсан үнэлгээний материал
- ТӨМ 7.1, 7.2

**Бусад хэрэглэгдэхүүн:** Самбарын цаас, фломастер, скоч, соронз,

**Удирдамж**

Хичээлийн судалгааны нэг бүрэлдэхүүн болох үнэлгээний судалгааг хийх арга зүйтэй танилцаж, үр дүнг танилцуулах - 90 минут

1. 4 хүнтэй багт зохион байгуулагдана. 5 минут
2. Багийн гишүүд тухайн хичээлийн тодорхой сэдэвт нэгж болон ээлжит хичээлийн хөтөлбөр судалж, үнэлгээний судалгаа хэрхэн хийх талаар харилцан зөвшилцөж, ойлголтоо нэгтгэнэ (**ТӨМ 7.1** ашиглах). 20 минут
3. Үнэлгээний судалгааг хэрхэн хийх талаар уншиж судалсан, боловсруулсан материалаа бусдадаа танилцуулахад бэлтгэнэ. Үүнд дараах үндсэн агуулгыг тусгана.
  - а. Үнэлгээний судалгаа хийхэд анхаарах зүйл, тайлбар
  - б. Үнэлгээний судалгааг хамтран хийснээр гарсан үр дүн 20 минут
4. Баг тус бүр багийн ажлаа танилцуулна. 5 x 5 минут = 25 минут
5. Танилцуулгад үндэслэн багууд харилцан асуулт тавьж хариулна. 10 минут
6. Багууд ажлын үр дүнгээ харьцуулан, “Хичээлийн бэлтгэл судалгаа – үнэлгээний судалгаа” гэсэн дүгнэлт гаргах 10 минут

**Даалгавар**

1. Багшлах дадлагын явцад хуримтлуулсан туршлагадаа үндэслэн, судалгаат хичээлийн видео материалтай танилцаж, (**ТӨМ 7.2**) –н асуултын дагуу тэмдэглэл хөтөлнө үү.

### ТӨМ 7.1 Явцын болон улирлын үнэлгээний судалгаа хийсэн бүтээгдэхүүн

| Багшлахуйн арга барилын<br>судалгаа хийх чиглэл                                                                                           | ..... сэдвийн<br>хүрээнд үнэлгээний<br>судалгаа хийсэн байдал | Нэмэлт<br>тайлбар,<br>анхаарах<br>зүйл |
|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|---------------------------------------------------------------|----------------------------------------|
| Ээлжит хичээлийн үнэлгээг<br>хэрхэн боловсруулсан байна вэ?                                                                               |                                                               |                                        |
| Нэгж сэдвийг судалсны дараа бие<br>даах ажлыг хэрхэн төлөвлөсөн<br>байна вэ?                                                              |                                                               |                                        |
| Блумийн таксономи ашиглан<br>асуулт, даалгавар боловсруулсан<br>байна уу?                                                                 |                                                               |                                        |
| ЕБ-ын 12 жилийн сургуулийн<br>сургалтын хөтөлбөрийн<br>үнэлгээний арга зүйг хэрхэн<br>хэрэгжүүлсэн байна вэ?<br>Рубрик зохиосон байна уу? |                                                               |                                        |

### ТӨМ 7.2 Үнэлгээний судалгааны арга зүйг таниулах нэгэн хувилбар

1. Энэхүү ээлжит хичээлд үнэлгээг хэрхэн төлөвлөсөн байна вэ?

.....  
.....  
.....

2. Та дахин боловсруулалт хийж заах бол үнэлгээний ямар асуулт,  
даалгавар боловсруулах вэ? Бичнэ үү?

.....  
.....  
.....

3. Ээлжит хичээлийн болон нэгж сэдвийн үнэлгээний арга зүйг яаж  
хийх нь илүү үр дүнтэй байх вэ?

.....  
.....  
.....

### БИЕ ДААХ АЖИЛ

1. “Хичээлийн бэлтгэл судалгааны мөн чанар-2 ” сэдэвт эсээ бичиж, ангидаа  
хэлэлцүүлэг хийнэ үү.

## Хөтөлбөр боловсруулахад хичээлийн бэлтгэл судалгааны үр дүнг тусгах нь

| Хичээлийн хэлбэр | Агуулга                                                                                                                                                            | Хэрэглэгдэх үүн                 | Бие даах ажил                                                                                                    |
|------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|---------------------------------|------------------------------------------------------------------------------------------------------------------|
| Лекц 5 /2ц/      | <ul style="list-style-type: none"> <li>Хичээлийн хөтөлбөрийн элементүүд</li> <li>Хичээлийн хөтөлбөр боловсруулахад бэлтгэл судалгааны үр дүнг тусгах нь</li> </ul> | ppt                             | Багаараа сонгосон сэдвийнхээ хүрээнд хичээлийн бэлтгэл судалгааг түшиглэн ээлжит хичээлийн хөтөлбөр боловсруулах |
| Семинар 8 /2ц/   | <ul style="list-style-type: none"> <li>Тухайн хичээлийн нэгэн ээлжит хичээлийн сэдэв сонгож түүнийг бэлтгэхэд чиглэсэн хичээлийн бэлтгэл судалгаа хийх</li> </ul>  | DVD хичээл Зөвлөмж, сурах бичиг |                                                                                                                  |
| Семинар 9 /2ц/   | <ul style="list-style-type: none"> <li>Хийсэн бэлтгэл судалгааныхаа үр дүнг ашиглан хичээлийн хөтөлбөр боловсруулах</li> </ul>                                     | Сурах бичиг, ХБС, шүүмж         |                                                                                                                  |

### ЛЕКЦ 5. Хичээлийн бэлтгэл судалгааны үр дүнг хөтөлбөр боловсруулахад тусгах нь


Оюутан-багш нарт дараах асуултуудыг тавьж харилцан ярилцана. Үүнд:

- Хичээлийн бэлтгэл судалгаа гэдгийг юу гэж ойлгож байна вэ?
- Ээлжит хичээлийн хөтөлбөрийн элементүүдийг нэрлэнэ үү?
- Таны бодлоор хичээлийн бэлтгэл судалгааны үр дүнг хөтөлбөрийн аль элементийг боловсруулахад ашиглаж болох вэ?

| Стандартын арга зүйн зарчмууд |                                                                                                                                                                                      | Хичээлийн бэлтгэл судалгаа      |
|-------------------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|---------------------------------|
| Судлах агуулгыг сонгох зарчим | Боловсролын агуулгын стандартад нийцүүлэх<br>Тухайн агуулгын айн зорилт, мэдлэг чадварт баримжаалан залгамж холбоог харгалзах.<br>Арга зүй, онцлогт нийцүүлэн судлах агуулгыг сонгох | Судлагдахууны агуулгын судалгаа |
| Суралцахуйн зарчим            | Суралцагч хэрхэн судлыг судлах<br>Өмнөх төсөөлөл мэдлэг чадварыг тооцох                                                                                                              | Мэдлэг эзэмшилтийн судалгаа     |
| Багшлахуйн зарчим             | Өмнөх төсөөллийн судалгаанд үндэслэн тухайн үйл ажиллагааг зохион байгуулах арга хэлбэрээ зөв сонгох                                                                                 | Арга зүйн судалгаа              |
| Технологийн зарчим            | Мэдээлэл харилцааны технологийг хэрэглэхэд бэлтгэх.                                                                                                                                  | Хэрэглэгдэхүүний судалгаа       |
| Боломжийг тэнцүү олгох зарчим | Боловсрол эзэмшихэд боломжийг тэнцүү олгох чөлөөт өрсөлдөөнд шударгаар оролцох сонголтыг хариуцлагатай хийх                                                                          |                                 |
| Үнэлгээний зарчим             | Суралцагчийн хөгжил төлөвшилийг үнэлэх суралцдын гүйцэтгэл буй танин мэдэхүйн үйлийн чанарыг үнэлэх                                                                                  | Үнэлгээний судалгаа             |

Бага дунд боловсролын стандарт киррикулимийг хөгжүүлэх үзэл баримтлал 2002 онд батлагдан 2005-2006 оноос цогц чадамжид суурилсан боловсролын стандарт сургалтад албан ёсоор үндэсний хэмжээнд мөрдөгдөх болсон. Үүнийг Монголын боловсролын хөгжлийн түүхэнд онцгойлон тэмдэглэж, хөгжлийн шинэ үеийг эхлүүлсэн үйл явдал гэж үзэж байсан. Энэхүү БСШУЯ,

ЖАЙКА-ийн хамтарсан “Суралцагчдын суралцахуйг дэмжих арга зүйн хөгжил”, “Багшлахуйн арга зүйн хөгжлийг түгээн дэлгэрүүлэх тогтолцоог бэхжүүлэх” төслүүд нь багш, судлаачдын чадавхийг нэмэгдүүлэх, сургалтын арга зүйг хөгжүүлэх зорилготойгоор үйл ажиллагаагаа явуулсан билээ. Боловсролын стандартын арга зүйн зарчмууд нь “Хичээлийн бэлтгэл судалгаа”-тай хэрхэн уялдан холбогдож байгааг энэхүү слайдаас харж болно. Эндээс үзвэл хичээлийн бэлтгэл судалгаа хэдийчинээ сайн хийгдэнэ, боловсролын стандартын арга зүйн зарчмууд төдийчинээ сайн биелэгдэх нь тодорхой.



Ээлжит хичээлийг мөсөн уултай зүйрлэвэл:

Далайн төвшингээс дээш харагдаж байгаа хэсэг бол 40 минутын хичээл (10%), далайн төвшингөөс доош харагдахгүй байгаа хэсэг бол тухайн хичээлийн бэлтгэл (90%) гэж үзье. Бидний уламжлалт ойлголт нь зөвхөн нүдэнд ил харагдах 40 минутын хичээлийг л ХИЧЭЭЛ гэж үздэг байсан. Тэгвэл одоо хичээлийн бэлтгэл судалгаа хийх, хичээлд

бэлтгэх, хичээл заах гэх мэт бүх ойлголтуудыг бүхэлд нь ХИЧЭЭЛ гэж авч үзье.

Зургаас харахад 40 минутын хичээл явуулахын тулд

1. Ямар их хүч хөдөлмөр шаардсан бэлтгэл хэрэгтэй болохыг,
2. Хичээлийн бэлтгэл судалгаа хэдий чинээ сайн байна тухайн ээлжит хичээл төдийчинээ үр дүнтэй болохыг харж болно.

#### Хичээлийн хөтөлбөрийн элементүүд

- Хичээлийн сэдэв
- Хамрах хүрээ
- Хэрэгцээ
- Зорилго, зорилтууд
- Агуулга
- Арга зүй
- Үнэлгээ
- Хэрэглэгдэхүүн

Өмнөх лекц 2-4-т Хичээлийн бэлтгэл судалгааны элементүүдийг нилээд нарийвчлан судалсан билээ. Үүнд:

1. Судлагдахууны агуулгын судалгаа
2. Мэдлэг эзэмшилтийн судалгаа
3. Арга зүйн судалгаа
4. Үнэлгээний судалгаа
5. Хэрэглэгдэхүүний судалгаа

Тэгэхлээр эдгээр судалгааг хичээлийн

хөтөлбөр боловсруулахдаа элемент бүрт хэрхэн тооцох талаар ярилцая. Жишээ нь: “Хичээлийн сэдэв”-ийг сонгохдоо, “Хамрах хүрээ”-г авч үзэхдээ, “Хэрэгцээ зорилго зорилт”-ыг тодорхойлохдоо, “Агуулга”-ыг тогтоохдоо, “Арга зүй”-г сонгохдоо, “Үнэлгээ”-г төлөвлөхдөө, “Хэрэглэгдэхүүн”-ийг сонгохдоо тус тус ямар ямар судалгааг үндэслэх вэ? гэдгийг авч үзнэ.

#### Хичээлийн сэдэв

- Сурагчдад ойлгомжтой, товч тодорхой
- Хэрэгцээ, сонирхлыг төрүүлэхүйц
- Хичээлийн агуулга болон хичээлээр шийдвэрлэх асуудлын тухай байх
- Нэр нь сэдэлжүүлэлт болохуйц

Сурагчдын өмнөх төсөөлөл, мэдлэг, чадварыг судалсан судалгаа болон агуулгыг судалсны үндсэн дээр тухайн хичээлийг асуудал шийдвэрлэх аргаар уу, эсвэл мэдлэг бүтээх аргаар заах уу, хичээлдээ чухам ямар асуулт даалгавар өгөх вэ? гэх мэтийг тооцон хичээлийн сэдвийг оновчтой, хэрэгцээ, сонирхол төрөхүйц байдлаар томъёолно. Өөрөөр хэлбэл, “Хичээлийн сэдэв”-ийг

өгөхдөө заавал хүүхдэд ойлгомжгүй, жишээ нь: Математикийн хичээлд периметр, талбай, эзлэхүүн, процент, пропорц гэх мэт тухайн шинжлэх ухааны нэр өгөхийн оронд шууд тухайн хичээлийн сэдэлжүүлэлт болохуйц, эсвэл

тухайн хичээлээр хийх үйл ажиллагааг илэрхийлсэн хүүхдэд ойлгомжтой, тэдний сонирхол татахуйц нэр өгөх нь оновчтой.

### Хэрэгцээ

- Суралцагч-хэрэглэгчийн талаас хандах
- Хэрэгцээний онол загварт тулгуурлах
- Танин мэдэхүйн хэрэгцээнээс эхлэх
- Ахуй амьдрал, ажил үйлдвэрлэлийн хэрэгцээг тодорхойлох
- Суралцах хэрэгцээнд үндэслэх
- Чанартай амьдрах арга ухаан эзэмших хэрэгцээг тусгах
- Нийгмийн эрэлт хэрэгцээ, захиалгыг харгалзах

Сургалтын хөтөлбөрт хичээлийн агуулга ерөнхийдөө тусгагдсан байдаг.

• Гэхдээ тухайн агуулгыг сонгохдоо энэ хичээлийг суралцагчид үзэх ямар хэрэгцээ байгаа юм бэ?

• Мэдлэг эзэмшилтийн судалгааг үндэслэн сурагчдын нас, сэтгэхүй, танин мэдэхүйн онцлогуудыг харгалзан хэрэгцээг тодорхойлно. Үүнд амьдрах арга ухаанд

суралцах хувь хүний болон нийгмийн хэрэгцээг тооцох хэрэгтэй.

Тухайн сэдвийг зайлшгүй хэрэгтэй гэдгийг ухамсарлуулж чадахуйц бичвэр буюу контекстийн агуулгаар сэдэлжүүлэх шаардлагатай. Хэрэгцээнээс сэдэл үүснэ, сэдлээс үйл, үйлдэл, үйл ажиллагаа хийгдэж түүгээр дамжин мэдлэг бүтээгдэнэ. Тухайн ээлжит хичээлийн агуулгыг ямар хэмжээнд авах вэ? гэдгийг бас тогтооно.

### Зорилго, зорилтууд

- Багш- нийлүүлэгчийн талаас хандах
- Зорилгоос зорилтод, зорилтоос зорилго гэсэн аль ч чиглэлээр хийж болох
- Зорилтыг танин мэдэхүйн тухайн төвшинд нийцүүлэн томъёолох
- ...-ыг мэдэх аргыг таниулах, өвлүүлэх, эзэмшүүлэх гэсэн байдлаар бичих
- Зорилтууд нь өөр хоорондоо уялдаатай, уламжилсан байх
- Зорилтын тодорхойлох үйлдлүүдийг төрөлжүүлсэн байх
- Тухайн сэдвийн агуулгыг эзэмших
- Тухайн шинжлэх ухааны хэл харилцаанд суралцах
- Учир зүйн үндэслэлтэй ойлгох
- Эзэмшсэн мэдлэг чадвараа амьдрал ахуйдаа болон асуудал шийдвэрлэхэд зохистой хэрэглэх
- Бусадтай нийгмийн хариуцлага, ёс зүйтэй хандах арга барилд суралцах
- Тухайн агуулгыг цаашид гүнзгийрүүлэн судлах бэлтгэлийг хангах

Хүүхдийн хөгжлийг дэмжих арга зүйд суурилан боловсролын стандартад нийцүүлэн хичээлийн бэлтгэл судалгааг үндэслэн ээлжит хичээлийн зорилго, зорилтоо тодорхойлно. Зорилтууд нь цогц чадамжуудыг төлөвшүүлэхэд чиглэгдсэн байдлаар төлөвлөж болно.

Энгийнээр тайлбарлавал:

- Хичээлийн зорилго нь юу юм бэ?

- Энэ зорилгод хүрэхийн тулд ямар агуулга сонгох, ямар ямар хэрэглэгдэхүүн сонгох вэ?
- Ямар арга зүйгээр явуулах вэ?
- Сурагчдыг хэрхэн яаж үнэлэх вэ? гэдгийг байнга бодож тунгаах хэрэгтэй юм.

### Хамрах хүрээ

- Сурагч нэг бүрийн танин мэдэхүйн тухайн төвшинг тодорхойлох
- Сурагчдын өмнөх төсөөлөл, мэдлэг, чадварыг оношлох

Мэдлэг эзэмшилтийн судалгаа буюу

1. Хичээлийн агуулгыг судлахад суурь болж өгөх мэдлэг чадварыг хүүхдүүд эзэмшсэн байгаа эсэхийг

2. Хичээлийн агуулга нь хүүхдийн хөгжлийн төвшинд тохирч байгаа эсэхийг судалсны үндсэн дээр хамрах хүрээг тодорхойлж бичнэ.

3. Хичээлийн явцад сурагчдын мэдлэг эзэмшилт (бүтээлт)-ийн судалгаа хийх нь нэг талдаа явцынх мэт боловч зарим тохиолдолд дараагийн хичээлийн хувьд өмнөх судалгаа болох талтай.

Судлагдахууны агуулгын судалгаагаар дараах зүйлүүдийг олж тогтоосон байна. Үүнд:

#### Агуулга

- Өмнөх төсөөллийг тодорхойлох, сэргээн сануулах
- Өмнөх төсөөллийг жишиж ерөнхийлөн нэгтгэх
- Сэдвийн агуулга, суралцагчдын өмнөх төсөөлөл туршлага, цаг хугацаа, бусад хүчин зүйлсийг тооцож үйлийн баримжааг ялгаж бэлнээр нь өгөх үү?
- Өөрсдөөр нь бүтээлгэх үү? Асуудал шийдвэрлэх байдлаар өгөх үү? гэдгээ шийдэж сонголт хийх
- Тухайн агуулга нь өмнөх ба дараагийн агуулгатай хэрхэн холбогдохыг тооцоолох
- Шинэ баримжааг зүгшрүүлэх
- Сэдвийн агуулга (судлагдахуун, ур ухаан)-ы бүтэн баримжааг бүтээх
- Агуулгын багтаамж ихтэй тулгуур дохионуудыг боловсруулах

- Тухайн агуулгын түүхийг судлах
- Тухайн агуулгын утга, тодорхойлолт, мөн чанар, теорем, мөрдлөгийг тодруулах
- Тухайн агуулгыг заах нь хувь хүний болон нийгмийн хэрэгцээ нь хэр тохирч байгааг тодруулах
- Тухайн агуулгын ач холбогдлыг тодруулах
- Тухайн агуулга болон хүүхдийн

хөгжлийн түвшин хоорондын хамаарлыг тогтоох

Судлагдахууны агуулгын судалгааг үндэслэн ээлжит хичээлийн хэрэгцээг тодорхойлсны үндсэн дээр хичээлийн зорилго, зорилтыг тодорхойлох, тухайн сэдвийн хүрээнд судлах агуулгыг судлагдахуун (мэдлэг), ур ухаан (чадвар) талаасаа юу чаддаг, мэддэг болохыг нарийвчлан тодорхойлж өгнө.

Тухайн сонгосон сэдвийн судлагдахууны агуулгыг судлахад сурагчдын мэдлэг чадвар, дадал хүрэлцээтэй эсэхийг тогтоохын тулд сурагчдын өмнөх төсөөлөл, мэдлэг чадварын төвшинг (мэдлэг эзэмшилтийн судалгаа) оношлох шаардлагатай. Ээлжит хичээлээр судлах судлагдахууны агуулга нь өмнө ба дараагийн агуулгатай ямар уялдаа холбоотойг, сурагчдын хэрэгцээ, нас, сэтгэхүйн онцлог болон өмнөх төсөөлөл, мэдлэг чадварын төвшинг харгалзан (судлагдахууны агуулгын судалгааг түшиглэн) тухайн хичээлийн зорилго, зорилт, тухайн хичээлийн агуулгыг, мөн авч үзэх асуудал, дасгал даалгаврыг сонгоно.

#### Арга зүй

- Хэрэв үйлийн баримжааг өөрсдөөр нь бүтээлгэх бол мэдээлэл боловсруулах механизмыг тайлбарлах, бүтээлч аргуудыг сануулах
- Хэрэв үйлийн баримжааг бэлнээр өгөх бол бүх зүйлийг тайлбарлах
- Мэдлэг эзэмшихүйн үе шатууд нь мэдлэг бүтээх үед I, II шат хамтдаа, харин үйлийн баримжааг ялгаж бэлнээр нь өгөх үед I, II шат тус бүрдээ ялгарна.
- Арга судлал, арга зүй, сэтгэхүйн барилыг тайлбарлах
- Биехөвөрлөх, конструктивизм тус бүрийн стратегийг хэрэгжүүлэх, багш сурагчийн үйл ажиллагааны инвариантыг тодорхойлох
- Хөгжүүлэх шатан дээр сурагчаас багш суралцах боломжийг анхаарах
- Эзэмшихүйн үе шатууд зохион байгуулах анги танхимын менежментийг (бүлгээр ажиллах, хийсэн бүтээлээ танилцуулах, ахлах ангид лекц, цагийн нөөцийг хуваарилах, төсөлт хичээл явуулах орчин бүрдүүлэх) төлөвлөх
- Аргуудыг цуглуулж, судалж, төрөлжүүлэх
- Багш бүрийн арга зүй өөр өөр байхаар уян хатан тооцох

Хичээлийн бэлтгэл судалгаанд үндэслэн хичээл явуулах арга зүйгээ тогтооно. Өөрөөр хэлбэл хэнд? юуг? яаж? таниулах вэ? гэдгийн ЯАЖ гэдгийг хэрхэн сонгож буй нь арга зүй юм. Тухайн хичээлийг явуулахаар сонгосон багшийн арга зүй нь сурагчдын нас, сэтгэхүй, танин мэдэхүйн онцлогт тохирсон, тэдний хэрэгцээ шаардлагад нийцсэн, сонирхлыг нь татахуйц, үр дүнд хүрэхүйц байх нь чухал юм.

Хичээлийн үйл ажиллагааг төлөвлөхдөө:

- Хичээлийн үе шат,
- Багшийн үйл ажиллагаа буюу асуултууд,

- Сурагчийн үйл ажиллагаа буюу хариултууд,
- Анхаарах зүйл ба дэмжлэг гэсэн баганын бүхий хүснэгтийн дагуу төлөвлөнө.

Аргазүйн судалгааг түшиглэн сурагчдын үйл ажиллагаа гэсэн баганад гарч болох хариултын хувилбаруудыг төсөөлөн бичиж төлөвлөнө. Энэ нь эхний үед зөрөөтэй төлөвлөгдөх боловч багш сурагчаа ойлгох, мэдрэх мэдрэмж хөгжихийн хэрээр оновчтой болно.

Хичээлийн төгсгөлд хийгдэх дүгнэлтийг багш өөрөө урьдчилан хэлэхгүй байх, болж өгвөл сурагчдаас асуух асуултаараа чиглүүлэн өөрсдөө гаргасан мэт сэтгэгдэл төрөхүйц байдлаар зохион байгуулах шаардлагатай. Энэ нь багшаас эв дүй, ур чадвар шаардана.

Хүүхдээс дасгал даалгаврын хариуг хэлүүлж авах нь гол биш, хэрхэн хийж гүйцэтгэх үйл, гүйцэтгэснээ бусдадаа хэрхэн тайлбарлах нь чухал. Учир нь бид өнгөрснөө эргэн санахдаа үр дүнг нь биш үр дүнд хүрэхийн төлөө ажиллаж байсан үйл ажиллагаагаа илүү их ярилцдаг. Энэ нь бидэнд үр дүнд хүрэхийн төлөө ажиллаж байх үедээ илүү их суралцдаг болохыг харуулж буй юм. Багш хүүхдийн хэлж байгаа зүйлийг сонсох, зөв ойлгох, багшийн асуулт хүүхдэд ойлгогдохуйц, энгийн амархан байх нь чухал. Ингэснээр багш сурагчийн хооронд зөв харилцаа үүснэ. (маш олон багш сурагчдаа үл сонсон өөрийнхөө төлөвлөснөөр хичээлээ явуулж дуусгадаг- энэ бол том алдаа).

#### Үнэлгээ

- Оношлуур ба даалгавар боловсруулахдаа цогц чадамжийг үнэлэхээр хийх, янз бүрийн тавилыг тодорхойлох,
- Үнэлгээний шалгуур гэдэгт тухайн даалгавраас илрүүлэх үнэлэх чадваруудыг ялгах
- Ялгагдсан чадварууд нь бүлгийн зорилтууд агуулга дахь ур ухаан, арга зүйн хэсэг дэх үйл ажиллагааны томъёолол нь үйл үгээр төгсөх ба тэдгээрийг харьцуулах замаар тухайн хэсэгт харгалзах эсэхийг нягтлана.

Зорилго зорилтод анализ хийх замаар эзэмшвэл зохих цогц чадвар түвшинг тодруулах судалгааг үнэлгээний судалгаа гэж үздэг талаар өмнө үзсэн. Үнэлгээний судалгаагаар

- Сурагчдын сонирхол, идэвхи хандлага
- Сэтгэн бодож тунгааж буй байдал
- Илэрхийлэх, тооцоолох чадвар
- Мэдлэг, ухамсар, чадварын чухам аль

хэсгийг үнэлэх вэ? гэдгээ тогтоно.

Ээлжит хичээлийн явц болон үр дүнг үнэлэхдээ:

- Түүнд тулгуурлаж хүүхдийн оролцоо идэвхийг
- Арга зүйн төлөвлөлт нь хүүхдийн хэрэгцээ, сонирхолд нийцэж буй эсэхийг судлана.

“Бид хийсэн хоолоо амталж үздэг”-ээр үнэлгээ шаардлагатай болохыг энгийнээр тайлбарласан билээ. Тухайн ээлжит хичээлээр юуг үнэлэх, үнэлгээг хэрхэн хийх талаар (үнэлгээний судалгааг түшиглэн) хичээлийн үе шатуудад зайлшгүй төлөвлөх шаардлагатай.

Үнэлгээг хичээлийн ямар үе шатуудад юуг (сонирхол, идэвхи, оролцоо, мэдлэг, чадвар, асуудал шийдвэрлэж буй байдал), яаж үнэлэх вэ? гэдгээ нарийвчлан тодорхойлно. Үнэлгээний даалгавар буюу үнэлгээ хийх асуултуудыг

төлөвлөхийн зэрэгцээ сурагчдаас гарч ирэх хариултын хувилбаруудыг ч гэсэн тооцож хичээлийн төлөвлөлтөд оруулбал зохистой. Хичээлийн явцад хүүхдийн мэдлэг бүтээлт (эзэмшилт) хэрхэн явагдаж байгааг судлах төлөвлөгөөгөө хийнэ. Багш нар мэдлэг эзэмшилтийн явцын судалгаанд үндэслэн хүүхдийн нэрийг цохож асуух, яг гар өргөхөд нь асуух, эсвэл хэнээс асуухаа урьдчилан төлөвлөсөн байна.

Сурагчид бие биенээ үнэлэх, сурагч өөрөө өөрийгөө үнэлэх, сурагч хичээлийг үнэлэх, багш хичээлээ үнэлэх боломжуудыг ямар байдлаар гаргаж өгөхийг төлөвлөнө. Мөн үнэлгээний өсөлтийг тооцохдоо тоон үзүүлэлтийг харгалзах уу, чанарын үзүүлэлтийг харгалзах уу гэдгийг ч мөн бодолцоно.

#### Хэрэглэгдэхүүн

- Хэрэглэгдэхүүн нь хүүхдийн нас бие сэтгэхүйн хөгжилд тохирсон тухайн хичээлээр асуудал шийдвэрлэхэд, мэдлэг бүтээхэд, дадлага ажил хийхэд хэрэгцээ хангахуйц байх
- Аль хэрэглэгдэхүүнийг хэдийд яаж харуулахаа нарийн төлөвлөх
- Самбар төлөвлөлтийг хийж өгөх

Хичээлийн бэлтгэл судалгааг түшиглэн сургалтын материаллаг орчин, сэтгэлзүйн орчин, үйлийн орчинг төлөвлөнө.

Сургалтын хэрэглэгдэхүүн нь хичээлээр зорьж буй зорилгыг биелүүлэхийн тулд туслах материаллаг зүйлс юм. Жишээ нь: Самбар, сурах бичиг, дэвтэр, гортиг, шугам, өнцөг хэмжигч, үзүүлэн (биет, бодит, дэлгэцэн), тарааж өгөх материал, геометрийн дүрс, геометрийн биет, өнгийн

цаас, туршилт хийх материал, дидактик тоглоомууд...

Ээлжит хичээлийн өгөөжийг сайжруулахын тулд ямар хэрэглэгдэхүүнийг хэдийд ямар байдлаар хэрхэн ашиглавал илүү үр дүнтэй вэ? гэдгийг судлах хэрэгтэй.

Тухайн насны хүүхдийн нас бие сэтгэхүйн онцлогийг маш сайн судлан, хүүхдийн хэрэгцээ шаардлагыг зөв тодорхойлж, тэдний хийж чадах, чадахгүй юмсыг сайн мэддэг байх нь чухал. Учир нь сурагчдын нас бие сэтгэхүйн онцлогт тохируулан тэдний хэрэгцээ сонирхолд нь нийцсэн сэдэлжүүлэлт болон хичээлийн хэрэглэгдэхүүнийг (хэрэглэгдэхүүний судалгааг түшиглэн) яаж сонгохоо төлөвлөнө.

Жишээ нь: Япон улсын Наримаса дунд сургуулийн 4-р ангид ПРОПОРЦ сэдвийн ээлжит хичээлд суусан товч тэмдэглэлийг сонирхуулья.

- **Ээлжит хичээлийн сэдэв:** Ундаа найруулах
- **Сэдэлжүүлэлт:** Багш хүүхдүүдтэй уух дуртай ундааны талаар ярилцсаны дараа тэдний уух дуртай ундааг найруулж үзүүлэв. (200мл өтгөрүүлсэн шүүсийг 900мл устай хольж найруулав.
- **Асуудал дэвшүүлэх:** Багш: “Хүүхэд бүрт 50мл өтгөрүүлсэн шүүс өгнө. Гэхдээ өмнө нь Багшийн найруулсантай яг адил амттайг найруулахын тулд хэдэн мл ус хэрэгтэй вэ? гэдгийг тооцоолж олно.” гэж хэллээ.

Энэ хичээлийн давуу талыг дурдвал:

1. Хичээлийн нэрийг өгөхдөө заавал хүүхдэд ойлгомжгүй шинжлэх ухааны жишээ нь: Пропорц, эзлэхүүн, периметр, процент гэх мэт нэр өгөхийн оронд шууд тухайн хичээлээр юу хийх гэж буй нь тодорхой сэдэлжүүлэлт болохуйц нэрийг өгсөн нь оновчтой

2. Тухайн хичээлийн агуулга их байх нь чухал биш, харин хүүхэд хийж байх явцдаа

суралцах, мэдлэг, чадвартай болох тэр боломжийг хайсан

3. Хүүхэд бүрт өөр өөрийн аргаар бодож тооцоолох боломжийг олгож, бодсон бодолтоо бусдадаа тайлбарлан хэлэлцүүлж буй
4. Өөрсдийн тооцоолсноо зөв эсэхийг баталж харах боломжийг олгосон
5. Тухайн хичээлд хүүхдийн хэрэгцээ сонирхлыг төрүүлэхүйц

• **Асуудал шийдвэрлэх:** Ангийн 40 хүүхэд 225 мл ус хэрэгтэй гэдгийг 7 өөр аргаар тооцоолон бодож олов.

• **Хэлэлцэх:** Багш асуудал шийдвэрлэх явцад хүүхдийн мэдлэг бүтээх явцын судалгааг хийж бүх ялгаатай бодолтуудыг самбарт бичүүлж тайлбарлуулсан хэлэлцүүлэв.

• Хичээлийн төгсгөлд дүгнэлт хийсэн

хэрэглэгдэхүүнийг сонгосноор тухайн хичээлийг үр өгөөжтэй болгож өгсөн

Хичээлийн сүүлийн 20 минутад хүүхдүүд тооцоолсны дагуу ундаа найруулж, ижил амттай эсэхийг (200 мл өтгөрүүлсэн шүүсийг 900мл устай найруулсан нь 50мл өтгөрүүлсэн шүүсэн дээр 225 мл ус хийж найруулбал ижил амттай байна гэдгийг) тогтоов.

Жишээ нь: Япон улсын Гакүгэй их сургуулийн дэргэдэх дунд сургуульд “Урвуу пропорционал хамаарал” сэдвийн ээлжит хичээлд суусан товч тэмдэглэлийг сонирхуулья.

- **Ээлжит хичээлийн сэдэв:** Амьтны нас
- **Сэдэлжүүлэлт:** Багш хүүхдүүдтэй гэртээ тэжээдэг амьтдын тухай мөн тэд ойролцоогоор хэд насалдаг талаар ярилцав.
- **Асуудал дэвшүүлэх:** Багш: “Хүүхдүүдэд амьтан бүр амьдарч байх хугацаандаа 2 000 000 удаа зүрх цохилдог” гэж судлаачид тогтоосон баримтыг хэлэв. Дараа нь Муур, нохой, яст мэлхий, тоть... гэх мэт амьтдын зүрхний 1’-д цохилох тоог өгөөд тэдгээр амьтад хэд наслахыг тооцоолж олох даалгавар өгсөн.

• Энэхүү хичээл нь бидний уламжлалт хичээлээс ялгаатай. Учир нь математикийн ихэнх багш нар Хичээлийн сэдвээ: “Урвуу пропорционал хамаарал” гэж нэрлэнэ. Хичээлийн эхэнд:

$y = \frac{K}{x}$  гэсэн томьёо нь урвуу пропорционал хамаарал болох,

k - пропорционалын коэффициент болохыг багш хэлж өгнө. Бататгал хэсэгт

пропорционалын коэффициент нь өөр өөр өгөгдсөн байх нилээд хэдэн бодлого бодуулах гэсэн дараалалтай байхаар хичээлийг төлөвлөдөг. Хамгийн хурдан олон бодлого бодсон сурагчдыг үнэлнэ. Багш түрүүлж бодсон хүүхдийн бодлогын хариуг хэлж өгч хурдан бодохыг хичээлийн турш шаардана. Өөрөөр хэлбэл удаан ойлгоцтой хүүхдэд өөрөө ойлгож өөрийнхөөрөө сэтгэх боломж олгодоггүй.

• **Асуудал шийдвэрлэх:**

- 1) амьтдын зүрхний 1 цагт цохилох тоог
- 2) амьтдын зүрхний 1 хоногт цохилох тоог
- 3) амьтдын зүрхний 1 жилд цохилох тоог тус тус олоод
- 4) 2000000-г гарсан тоонд хуваахад амьтдын нас ойролцоогоор гарна гэдгийг тооцоолон бодож олов.

• **Хэлэлцэх:** Багш асуудал шийдвэрлэх явцад хүүхдийн мэдлэг бүтээх явцын судалгааг хийж сурагчдаар бодолтыг нь тайлбарлуулав.

• Хичээлийн төгсгөлд  $y = \frac{K}{x}$  томьёог гаргаж дүгнэлт хийсэн.

• Слайд дээр товч бичигдсэн хичээлийн явцыг харахад судлагдахууны агуулгын судалгаа, арга зүйн судалгаа, үнэлгээний судалгаа маш сайн хийгдэж төлөвлөгдсөн нь мэдрэгдэж байсан.

• Хичээлийн сэдэв нь сэдэлжүүлэлт болж түүгээр дамжин асуудал дэвшигдэж байгаа нь хүүхдийн нас сэтгэхүй, танин мэдэхүйн онцлогт нийцэж сонирхлыг нь

татаж байсан.

- Тухайн асуудлыг шийдвэрлэснээр зүрхний 1 минутад цохилох тоо нь олон байвал тухайн амьтан богино насална. Зүрхний 1 минутад цохилох тоо нь цөөн байвал тухайн амьтан урт насална гэсэн урвуу хамаарал

байгааг олж тогтооно. Энэ асуудлыг шийдвэрлэхэд энэ томьёогоор бодогдож байгааг сурагчид гаргаж ирсэн.

$$y = \frac{2000000000}{x \cdot 60 \cdot 24 \cdot 365} = \frac{3805}{x}$$

Хичээлийн төгсгөлд  $y = \frac{K}{x}$  гэсэн томьёо нь урвуу пропорционал хамаарал болох,  $K$ - пропорционалын коэффициент болохыг багш хичээлийн дүгнэлт хэсэгт гаргаж өгсөн.

### Даалгавар:

1. Хичээлийн бэлтгэл судалгаа гэдгийн дор та юуг ойлгож байна вэ?
2. Ээлжит хичээлийн хөтөлбөрийн элементүүдийг нэрлэнэ үү?
3. Хөтөлбөр боловсруулахад Хичээлийн бэлтгэл судалгааны (судлагдахууны агуулгын, мэдлэг эзэмшилтийн, арга зүйн, үнэлгээний, хэрэглэгдэхүүний) үр дүнг хэрхэн ашиглаж болох вэ?

## Семинар 8. Ээлжит хичээлийн бэлтгэл судалгаа хийх

**Зорилго:** Аливаа ээлжит хичээлийн хөтөлбөр боловсруулахад чиглэсэн хичээлийн бэлтгэл судалгаа (судлагдахууны агуулгын, мэдлэг эзэмшилтийн, арга зүйн, үнэлгээний, хэрэглэгдэхүүний) хийх арга барилд суралцах

**Хугацаа: 2 цаг (90мин)**

**Хэрэглэгдэхүүн:**

- Зөвлөмж
- DVD хичээл
- LCD проектор
- Сурах бичиг
- Самбарын цаас, фломастер, скоч, соронз

**Удирдамж**

1. 3-5 гишүүнтэй багт зохион байгуулагдана. 3 мин
2. DVD хичээл үзнэ. 20 мин
3. Баг бүр тухайн хичээлийн бэлтгэл судалгааны талаар ярилцана. 5 мин
4. Багууд өөрсдийнхөө дүгнэлтийг хэлэлцэнэ. 14 мин
5. Багийн гишүүд хамтран ярилцаад ангиа, сэдвээ сонгож авна. (Анги дотроо анги, сэдэв давхцахгүйгээр байх) 3 мин
6. Багийн гишүүд тухайн сэдвийнхээ судлагдахууны агуулгын, мэдлэг эзэмшилтийн, арга зүйн, үнэлгээний, хэрэглэгдэхүүний судалгааг хамтдаа хийнэ. 20 мин
7. Багууд ажлын үр дүнгээ бусдадаа танилцуулна. 20 мин

**Даалгавар:** Багаараа хийсэн суралцагчдын өмнөх төсөөлөл, мэдлэг чадварыг судлах, тухайн судлагдахууны агуулгын болон дасгал даалгаврын сонголтын, арга зүйн, үнэлгээний, хэрэглэгдэхүүний судалгааг дээр түшиглэн ээлжит хичээлийн хөтөлбөрийг дараах загвараар боловсруулах

- Ээлжит хичээлийн сэдэв:
- Хамрах хүрээ:
- Хэрэгцээ:
- Зорилго:
- Зорилт:
- Хэрэглэгдэхүүн:
- Үйл ажиллагаа:

| Хичээлийн үе шат | Багшийн үйл ажиллагаа | Сурагчийн үйл ажиллагаа |  Дэмжлэг үзүүлэх<br> Ярилцах<br> Анхааруулах |
|------------------|-----------------------|-------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
|                  |                       |                         |                                                                                                                                                                                                                                                                                                             |
|                  |                       |                         |                                                                                                                                                                                                                                                                                                             |

## Семинар 9. Ээлжит хичээлийн хөтөлбөр боловсруулах

**Зорилго:** Хичээлийн (судлагдахууны, агуулгын, мэдлэг эзэмшилтийн, арга зүйн, үнэлгээний, хэрэглэгдэхүүний) бэлтгэл судалгаанд суурилан ээлжит хичээлийн хөтөлбөр боловсруулах

**Хугацаа: 2 цаг (90мин)**

**Хэрэглэгдэхүүн:**

- Зөвлөмж
- Сурах бичиг
- Самбарын цаас, фломастер, скоч, соронз

**Удирдамж**

1. Өмнөх багаараа ажиллана 2 мин
2. Өмнөх семинарын даалгавраа баруун гар талын баг уруугаа шилжүүлэх замаар бие биенийхээ даалгаварт шүүмж өгнө. (1-2-3-4-5-6 баг бүр бусдынхаа ажил тус бүрт 5 мин) нийт 25 мин
3. Баг бүр бусад багуудынхаа шүүмжийн дагуу дахин боловсруулалт хийнэ. 28 мин
4. Багууд ажлын үр дүнгээ бусдадаа танилцуулна. 25 мин
5. Багш хичээлийн үйл ажиллагаа, дүнг нэгтгэн дүгнэнэ. 10 мин

**Даалгавар:** Багшийн дүгнэлтийн дагуу ээлжит хичээлийн хөтөлбөрөө улам боловсронгуй болгох

### БИЕ ДААХ АЖИЛ

1. Багаараа сонгосон сэдвийнхээ хүрээнд хичээлийн бэлтгэл судалгааг түшиглэн ээлжит хичээлийн хөтөлбөр боловсруулах


## Хичээл заах, ажиглах нь

| Хичээлийн хэлбэр, цаг | Агуулга                                                                                                                                                                                                                                                                                                                                     | Хэрэглэгдэхүүн                                                                                             | Бие даах ажил                                    |
|-----------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------------------------------------------------------------------------------------------------------------|--------------------------------------------------|
| Лекц 6 /2ц/           | <ul style="list-style-type: none"> <li>Хичээлийн технологи: Хичээлийн зорилго, зорилт, агуулга, арга зүй, үнэлгээ, багшийн сурган хүмүүжүүлэх үйл, сурагчийн сурч танин мэдэх үйл</li> <li>Хичээлд ажиглалт хийх арга зүй: хичээлийн ажиглалтын техник, баримт цуглуулах арга зүй, ажиглалтын тэмдэглэл түүнд боловсруулалт хийх</li> </ul> | ppt<br>Видео бичлэг                                                                                        | “Хичээлийн судалгааг хэрхэн хийх вэ?” эсээ бичих |
| Семинар 10,11 /4 ц/   | Хичээл ажиглах, тэмдэглэл хөтлөх, судалгааны баримт цуглуулах дадлага хийх                                                                                                                                                                                                                                                                  | Ээлжит хичээлийн хөтөлбөр, Видео хичээл Лекцийн материал Ажиглалтын тэмдэглэлийн загвар хувилбар, аргачлал |                                                  |

### Лекц 6. Хичээл заах, ажиглах нь

#### 1. Хичээлийн технологийн талаар

Олон жилийн туршид сургалтын зорилго нь шинжлэх ухааны гүн гүнзгий мэдлэгтэй хүнийг бэлтгэх явдал байлаа. Тиймээс шинжлэх ухааны агуулгыг бүхэлд нь бэлнээр дамжуулдаг, багшийн яриа голлосон арга зүйг хэрэгжүүлж ирсэн. Харин хурдацтай өөрчлөгдөж буй өнөөгийн нийгэмд дасан зохицож, ажиллаж амьдрахын тулд бие даан суралцаж, өөрийгөө хөгжүүлэх, шинийг хүлээн авч, хийж бүтээх чадвартай иргэнийг төлөвшүүлэх зорилго шинээр урган гараад байна. Иймд сургалтын агуулга, арга зүй, үнэлгээ зэрэг сургалтын технологийн элементүүдийг өөрчлөх хэрэгцээ, шаардлага бий болсон.




Сургалтын технологийн шинэчлэлийг хийхэд сүүлийн 6 жилийн туршид хэрэгжүүлж ирсэн БСШУЯ, ЖАЙКА олон улсын байгууллагын хамтарсан төсөл ихээхэн үр нөлөө үзүүлсэн. Хичээлийн судалгаа зохион байгуулах нь багш нар хамтран арга зүйгээ сайжруулах, ажлын байран дээрээ мэргэжлээ дээшлүүлэх оновчтой арга хэрэгсэл юм.


Дэвшүүлсэн зорилгодоо хүрэхийн тулд хичээлийн агуулга, арга зүй,

хэрэглэгдэхүүнийг оновчтой сонгон, түүнд нөлөөлж болох хүчин зүйлүүдийг тооцоолон, сурагчийн сурч танин мэдэх, хөгжин төлөвших үйл явцыг удирдан


жолоодох үйл явцыг **сургалтын технологи** хэмээн нэрлэдэг. Тэрээр **орц→явц→гарц** хэмээх уялдаа холбоо бүхий гурван хэсгээс тогтдог.



Сургалт явуулах үндсэн хэлбэр нь хичээл юм. Орчин үеийн дидактикийг үндэслэгч Джон Дьюи-ийн боловсруулсан дидактик реконструкцийн загварт хичээл нь **зорилго (хэрэгцээ), агуулга, арга зүй хэрэглэгдэхүүн** гэсэн бүтэцтэй. Зорилго нь **яагаад** судлах хэрэгтэйг, агуулга нь **юуг** судлахыг, арга зүй нь **яаж** судлахыг, хэрэглэгдэхүүн нь **юу** ашиглахыг хэлнэ хэмэн томъёолсон байна.



**Хичээлийн зорилго** нь шинжлэх ухааны агуулгын элементарчлал буюу амин сүнс болон хүүхдийн өмнөх төсөөлөл, ойлголт, сонирхол хандлагаас урган гардаг. Жишээ нь: 5-р ангийн Хүн байгаль хичээлийн “Гэрэл ба сүүдэр” нэгж хичээлийн “Сүүдэр” ээлжит хичээлд “Сүүдрийн урт гэрэлтүүлэгчийн зай болон гэрлийн тусгалын өнцгөөс хамаарах зүйг тогтлыг илрүүлэх” гэсэн зорилготой байж болох юм.




Хичээл нь зорилго, агуулга, арга зүй, зохион байгуулалт, цаг хугацааны хувьд харьцангуй бие даасан шинжтэй боловч хичээлүүд өөр хоорондоо уялдаа холбоотой байж гэмээнэ сургалтын зорилгыг хэрэгжүүлж чадна.

Тиймээс хичээлийн судалгаа хийхээр сонгож авсан хичээл нь бусад хичээлтэй хэрхэн холбогдох, сурагчдын эзэмших мэдлэг, чадвар, төлөвшилд ямар үүрэг гүйцэтгэхийг

сайтар тунгаан бодох хэрэгтэй байдаг.

Жишээ нь: 2-р ангийн Хүн-Орчин хичээлийн “Сургуулийн орчин” нэгж хичээлийн ээлжит хичээлүүдийн агуулгын залгамж холбоог дараах байдлаар хийсэн байна.



**Хичээлийн агуулга.** Шинжлэх ухааны агуулгыг тухайн ангийн сурагчдын нас сэтгэхүйн онцлог, танин мэдэхүйн түвшинд нийцүүлэн, амьдрал, практик хэрэглээтэй холбож, дидактик боловсруулалтад оруулан элементарчилж хичээлийн агуулга болгодог. Хичээлийн агуулга нь сурагчдын эзэмших мэдлэг, чадварын тогтолцооноос бүрдэнэ. Жишээ нь: 2-р ангийн Хүн-Орчин хичээлийн “Бид сургууль дээрээ” ээлжит хичээлийн агуулгыг дараах байдлаар тодорхойлсон байна. Үүнд:


Мэдлэг:

- Сургуулийн бүтэц, зохион байгуулалт
- Хүмүүсийн ажил үүргийн онцлог

Чадвар:

- Анги танхим, өрөө тасалгааны байрлалыг зааж нэрлэх. Сургууль дотроо чөлөөтэй зорчих
- Хүмүүсийн хийдэг ажлын онцлогийг нэрлэх, тэднийг хүндлэх, бахархах
- Өөрийн хүсэл мөрөөдлөө илэрхийлэх, түүнийг хэрэгжүүлэх боломжийг олж мэдэх

**Хичээлийн зохион байгуулалт.** Тухайн хичээлийн арга зүйн онцлогтой уялдуулан хичээлийн зохион байгуулалтын хэлбэрийг сонгодог. Байгалийн ухааны хичээлд сорил туршилтын ажлыг их хийдэг тул багийн зохион байгуулалтын хэлбэрийг сонгох нь элбэг байдаг. Энэ хэлбэр нь ажиглалт, туршилтыг хамтран хийх, харилцан бие биеэс суралцах, багаар хамтран ажиллах арга барил эзэмшүүлэх, нийгэмшихүйн чадамж эзэмшүүлэх зэрэг олон сайн талтай. Гэвч сурагч бүрийн оролцоо жигд бус байх, үзэл бодлын зөрчил гарах, ажилд анхаарахгүй өөр зүйл хийх, хэн нэг нь давамгайлах, бусдыгаа сонсохгүй, үзэл бодлыг нь хүндлэхгүй байх зэрэг сөрөг зүйлүүд ажиглагддаг. Тиймээс багш эдгээр сөрөг зүйлсийг гаргуулахгүй байхад анхаарч ажиллах шаардлагатай болдог.



**Багшийн сурган хүмүүжүүлэх үйл.** Багшийн сурган, хүмүүжүүлэх үйл нь сурагчдад стандартын хэмжээний мэдлэг чадвар, сурах арга барил эзэмшүүлэх, бие хүний эрхэм чанарыг төлөвшүүлэхэд чиглэгдэж байдаг. Багш аргаа зөв сонгон хэрэглэсэн тохиолдолд сурагчид сурч, танин мэдэх үйлийг сайн хийдэг.

Багшийн сурган хүмүүжүүлэх дараах үндсэн

аргуудыг хэрэглэж болно:

1. Сурагчдад сурах сэдэл бий болгох арга. Сурагчдад сурч мэдэх юмсан гэсэн хүсэл тэмүүлэл, дур сонирхол бий болгох үйлдлүүдийг хэлнэ. Жишээ нь:
  - Багш нь зааж буй үзэгдэлтэй холбоотой ер бусын жишээ, баримтыг ярих
  - Сурагчдын өмнөх мэдлэгтэй нь зөрчилдөх жишээ баримт ярьж, асуулт асуух, эргэлзсэн нөхцөл байдалд оруулах.

- Шийдвэрлэх тодорхой асуудлыг дэвшүүлэн тавих гэх мэт.

Жишээ болон асуултууд нь сурагчдын өдөр тутмын амьдралд тохиолддог, танил байх тусам түүнийг танин мэдэх гэсэн сэдэл, хэрэгцээ амархан бий болно.

2. Сурагчдаар мэдлэг бүтээлгэх арга. Сурагчдын мэдлэг, туршлагад тулгуурлан судалж буй юмс үзэгдлийн талаар ойлголт, тодорхойлолтыг гаргуулах үйлдлүүд юм. Жишээ нь:

- Сэдвийн тулгуур ухагдахууны тодорхойлолтыг сурагчдаар гаргуулах
- Судалж буй зүйлийн талаар жишээ баримт олуулах, бодлого зохиолгох
- Судалж буй юмс үзэгдлийн тодорхой шинжид үндэслэн энгийн ангилал хийлгэх
- Судалж буй зүйлсийг амьдралдаа хэрхэн хэрэглэх дүрэм, заавар санамж гаргуулах
- Судалж буй зүйлсийн талаар үнэлгээ, дүгнэлт өгүүлэх гэх мэт.

3. Үзүүлэн таниулах арга. Сурагчдад судалж буй юмс үзэгдлийн талаар үнэн зөв төсөөлөл олгох зорилго бүхий үйлүүд юм. Жишээ нь:

- Бодит эд зүйлс
- Бодит зүйлийг орлосон зураг, схем зэрэг

4. Практик үйлийн арга. Сурах ямар нэгэн үйлийг олон удаа янз бүрийн хэлбэрээр гүйцэтгүүлэн улмаар тэдэнд тодорхой сурах арга барил, чадвар дадал төлөвшүүлэх зорилготой үйлүүд орно. Энэ арга нь сурагч мэдлэгээ хэрэглэж сурахад чухал үүрэг гүйцэтгэдэг. Энэ аргын хамгийн түгээмэл хэлбэр нь дасгал ажиллуулах арга юм. Дасгал ажиллуулахад дараах зүйлсийг анхаарна. Үүнд:

- Багш өөртөө хангалттай хэмжээний дасгалын түүвэртэй болсон байх
- Гүйцэтгэх хугацааг урьдчилан тооцоолсон байх
- Дасгал нь хөнгөнөөс хүнд рүү аажмаар шилжсэн байх
- Дасгал нь агуулга, хэлбэрийн хувьд хүүхдийн сурах чадвараас бага зэрэг илүү байх
- Бататгах энгийн дасгалыг бүтээлч дасгалуудтай хослуулан хэрэглэх
- Дасгалыг хэрхэн гүйцэтгэх заавар, тайлбар өгөх
- Дасгалыг гүйцэтгэх явцад багш сурагчийн хийж буй үйлдэл бүрийг хянаж, шаардлагатай бол нэмэлт тайлбар өгөх, залруулга хийх
- Дасгалыг бие даан хийх арга барил эзэмшүүлэх гэх мэт.

Багшийн сүрган хүмүүжүүлэх үйл ба сурагчийн сүрч танин мэдэх үйлийн холбоо

| Багшийн сүрган хүмүүжүүлэх үйлүүд | Сурагчийн сүрч танин мэдэх үйлүүд                                                                               |
|-----------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------|
| Тайлбарлан ярих                   | Сонох, ухамсарлан ойлгох, харьцуулах, тогтоох, асуух...                                                         |
| Үзүүлэн таниулах                  | Харах, задлан шинжлэх, харьцуулах, шинэ зүйл олох, бичих, зурах                                                 |
| Асуух                             | Сонох, бодох, хариулахад хэрэгтэй мэдлэгийг хайх, цуглуулсан мэдлэгээ эмхлэх, зөвлөх, тэмдэглэх, төлөвлөх, ярих |
| Харьцуулан жишүүлэх               | Юмс үзэгдлийн төсөвтэй болон ялгаатай шинжийг олох, дүгнэлт хийх                                                |

**Сурагчийн сүрч танин мэдэх үйл.**

Сурагчийн зүгээс ертөнцийн юмс үзэгдлийг танин мэдэх зорилгоор хийж буй сэтгэхүйн олон янзын үйл, үйлдлүүдийг сүрч танин мэдэх үйл гэнэ. Энэ нь эхэндээ багшийн удирдлагын доор явагддаг, түүнийг даган дуурайх шинжтэй байх боловч анги ахих

тусам аажмаар бие даасан, бүтээлч шинжтэй болж ирдэг.

Сурагчид дараах нөхцөлд амжилттай суралцдаг. Үүнд:

- “Би цаашид хэн болох вэ? Би юу мэддэг чаддаг болох вэ?” гэсэн асуултыг өөртөө тавьж, зорилготой, ухамсартай үйл ажиллагааны явцад илүү идэвхтэй
- Судалж буй зүйл нь түүний өдөр тутмын амьдрал, орчноосоо олж авсан мэдлэг туршлагад тулгуурласан, амьдралын хэрэгцээтэй холбоотой байхад илүү сонирхон
- Сурагч “муу авна”, “багш загнана” гэх мэт айдасгүй сэтгэл зүйн хувьд тайван таатай нөхцөлд илүү амжилттай
- Сурагч юуг, яаж хийх сонголт нь нээлттэй байвал илүү идэвхтэй суралцдаг.

Сурагчдын сурч танин мэдэх үйлийг зохион байгуулахад дараах зүйлсийг анхаарна. Үүнд:

1. Тухайн хичээлээр эзэмших сурагчдын сурах арга барилыг зорилт болгон дэвшүүлнэ. Жишээ нь: ..... үзэгдлийг ажиглах, харьцуулах хэмээх зорилтыг дэвшүүлэн, хичээл дээр түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулна.
2. Дээрх зорилтуудыг хэрэгжүүлж чадахуйц сэтгэхүйн тодорхой үйлдлүүдийг сурагч бүр хийж байхаар хичээлийн технологийг боловсруулна. Сурах үйлийг яаж хийж байгааг харж биш харин сурагч өөрөө ухамсартайгаар хийж үзэж байж сая сурах арга барил эзэмшдэг. Тиймээс сургалтын хэрэглэгдэхүүн, тараах материалыг оновчтой ашиглан сурагчийн сурах үйлийг олон хэлбэрээр төлөвлөн зохион байгуулах шаардлагатай болдог. Байгалийн ухааны хичээлийн хувьд тодорхой арга зүйн дагуу сорил, туршилтын ажлыг төлөвлөн хийлгэх нь сурах арга эзэмшүүлэх оновчтой арга хэрэглүүр болно.

Жишээ нь: Багш самбарт туршилтын ажиглалтын тэмдэглэлийг оюутантай хамтран хийж тэдэнд сурах арга барил эзэмшүүлж байна.



Зураг 1. Туршилт ба түүний ажиглалтын тэмдэглэл хөтлөлт

3. Багшийн өдөр тутмын сурган хүмүүжүүлэх үйл ажиллагаа нь өөрөө сурагчдад сурах аргын үлгэр жишээ болж өгдөг. Багш өөрөө сайн сурагч байж, сурах арга барилаа үргэлж сайжруулна.
4. Багш сонгон хэрэглэж буй сурган хүмүүжүүлэх үйлээрээ дамжуулан сурагчдад сурах арга барил эзэмшүүлдэг тул аргаа оновчтой сонгон хэрэглэх нь чухал байдаг.
5. Багшаас сурагчдад зориулсан аргачлал, санамж, зөвлөмж зэргийг боловсруулан ашиглах нь сурагчдад сурах арга эзэмшүүлэхэд ихээхэн үр нөлөөтэй байдаг. Багш боловсруулсан аргачлал, санамж, зөвлөмжөө томоор бичиж хананд өлгөх, олшруулан сурагчдад тарааж өгөх зэргээр ашиглана. Тэдгээр нь дараах шаардлага хангасан байна. Үүнд:
  - Гүйцэтгэх үйл ажиллагааны дарааллыг зөв гаргах
  - Үйлдлүүдийг аль болох бүрэн гаргаж өгөх
  - Сурагчдад ойлгомжтой энгийн үг хэллэгээр бичих гэх мэт.

**Хичээлийн арга зүй.** Хичээлийн арга зүй нь багшийн сурган хүмүүжүүлэх үйл, сурагчийн сурч танин мэдэх үйлийн нэгдлээс бүрдэнэ. Түүнийг хичээлийн үе шат бүрээр нарийвчлан төлөвлөдөг бөгөөд хичээл заах явцад тухайн нөхцөл байдлаас шалтгаалан арга зүйгээ бага зэрэг өөрчлөх тохиолдол гардаг. Тухайлбал: Сурагчдын ойлголтын түвшин, асуултанд хариулах байдал зэргээс шалтгаалан багш арга зүйгээ өөрчлөх шаардлага гардаг.

Хүснэгт 1. Багшийн сурган хүмүүжүүлэх үйл ба сурагчдын сурч танин мэдэх үйлүүд

| Хичээлийн үе шат   | Багшийн сургах үйл                                                                                                                                                                                                                                                                                                                                 | Сурагчийн сурч танин мэдэх үйл                                                                                                                                                                                                                                    |
|--------------------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| Хичээлийн эхэнд    | <ul style="list-style-type: none"> <li>• Сурагчдын анхаарлыг татах</li> <li>• Хичээлийн сэдэлжүүлэлтийг хийх (контекст)</li> <li>• Зорилгоо хэлэх</li> </ul>                                                                                                                                                                                       | <ul style="list-style-type: none"> <li>• Сонсох,</li> <li>• Эргэцүүлэх,</li> <li>• Асуултанд хариулах,</li> <li>• Саналаа хэлэх,</li> <li>• Жишээ хэлэх, тайлбарлах</li> </ul>                                                                                    |
| Хичээлийн дунд үед | <ul style="list-style-type: none"> <li>• Хичээлд ашиглах хэрэглэгдэхүүн, ажлын зааврыг тайлбарлах</li> <li>• Ажлын явцад хяналт тавих, тусалж дэмжих, урамшуулах, ялгаатай хандах</li> <li>• Ажлын гүйцэтгэлийг шалгах, нэмэлт тайлбар, дүгнэлт өгөх, алдаа дутагдлыг нь засч залруулах</li> <li>• Дасгал, даалгавар ажиллуулах гэх мэт</li> </ul> | <ul style="list-style-type: none"> <li>• Хичээлийн зорилгод чиглэсэн мэдлэг, чадварыг хөгжүүлэх</li> <li>• Техник, ур чадвар эзэмших</li> <li>• Эзэмшсэн мэдлэг, чадвараа хэрэглэх</li> <li>• Хууль, зүй тогтлыг турших</li> <li>• Асуудлыг шийдвэрлэх</li> </ul> |
| Хичээлийн төгсгөлд | <ul style="list-style-type: none"> <li>• Асуулт асууж ярилцах</li> <li>• Дүгнэн ярих</li> <li>• Үнэлэх</li> <li>• Дараачийн хичээлийн зорилгыг дэвшүүлэх</li> <li>• Гэрийн даалгавар өгөх</li> </ul>                                                                                                                                               | <ul style="list-style-type: none"> <li>• Сурсан зүйлээ сэргээн санах</li> <li>• Дараачийн хичээлд зорилгыг гаргаж ирэх</li> <li>• Өөрийгөө болон харилцан бие биеэ үнэлэх</li> </ul>                                                                              |

**Хичээлийн үнэлгээ.** Багш үнэлгээг дараах зорилгоор хийдэг.

- Сурагчид стандартын хэмжээний мэдлэг, чадвар, хандлага төлөвшлийг хэр зөв бүрэн эзэмшсэнийг хэмжиж тогтоох
- Сурагчдын мэдлэг, чадвар, хандлага төлөвшилд гарч буй алдаа дутагдлыг цаг тухайд нь засч залруулах, дутууг гүйцээх буюу сурлагаар хоцрогдохоос урьдчилан сэргийлэх
- Сурагч өөрийн мэдлэг, чадварыг өөрөө үнэлж, хянах чадварт сургах
- Сурагчдыг идэвхжүүлэх, тэдэнд урам зориг өгөх, өөртөө итгэлтэй болгох, амжилттай суралцахад түлхэц болох
- Багш, сурагчдын хооронд эргэх холбоо тогтоох үнэн зөв мэдээлэл өгөх гэх мэт.


Багшийн үнэлгээ нь дараах үйлдлүүдээс бүрдэнэ.

1. Хичээлийн өмнө хийх багшийн бэлтгэл үйл. Энэ үед багш үнэлгээний дасгал, даалгавар, арга, хэлбэр зэргийг сонгон төлөвлөнө. Төлөвлөлтийг хэдий чинээ сайн хийнэ үнэлгээ төдий чинээ үр дүнтэй болно.
2. Хичээлийн явцад хянаж шалгах үйл. Дасгал, даалгавар, хяналтын ажлын дэг журам, хэрхэн гүйцэтгэх зааврыг танилцуулна. Даалгаврын гүйцэтгэлийг хэрхэн хянаж үнэлэх тайлбарыг өгөх, багш өөрөө үлгэрлэн үзүүлэх гэх мэт үйлийг хийнэ.
3. Хичээлийн дараа сурагчийн мэдлэг, чадвар, дадлыг хянаж шалгах үйл. Сурагч бүрийн ажлыг анхааралтай уншиж, үнэлэх засах схемийн дагуу үнэн зөв үнэлж зохих оноог тавих, алдаа дутагдлыг засаж залруулах, анхаарах зүйлсийг дэвтэрт нь бичиж тэмдэглэх, сурагчдын гаргасан нийтлэг алдаанд дүн шинжилгээ хийх, түүнийг хэрхэн засч залруулах арга замуудыг эрэлхийлнэ.

Ээлжит хичээлд явцын үнэлгээг хэрэглэдэг. Явцын үнэлгээний олон хэлбэр байх бөгөөд тэдгээрийг оновчтой ашиглах нь хичээлийн үр дүнд сайнаар нөлөөлдөг. Дараах зурагт явцын үнэлгээний зарим аргуудаас үзүүллээ.



Зураг 2. Карт өргүүлэн сурагчдын ойлголтыг оношлох арга



Зураг 3. Сурагчдын сайн ажлыг загвар болгон үзүүлэх, ажлыг тайлбарлуулах

## 2. Хичээлд ажиглалт хийх нь



Хамгийн сайн үр  
дүнд саж хялбархан  
хүрэх арга замыг  
хамтран эрж хайх

Судалгааны багаас нэг нь хичээл зааж, бусад нь хичээл төлөвлөлтийн дагуу явагдаж буй эсэхийг ажиглаж, тэмдэглэл хөтлөн, судалгааны баримт цуглуулна. Судалгааны багийн хийсэн хичээлийн бэлтгэл судалгаа (кёзай кэнкю)-ны үр дүнг хичээлийн судалгаа (жюгё кэнкю)-аар буюу хичээл зааж, ажиглан, баримт нотолгоо цуглуулан, хэлэлцүүлэг хийх замаар тодорхойлно гэсэн үг.

Хэрэв хичээлдээ гаднаас багш нарыг урьж оролцуулах бол судалгааны багийн гишүүд өөрсдийн бэлтгэсэн хичээлийн талаар дэлгэрэнгүй танилцуулна. Энэ нь бүх хүн нэг зорилгын доор ажиглалт хийх боломжтой болгоно. Үүнд:

### 1. Заах хичээлийн хувьд:

- Хичээлийн зорилго, зорилт
- Агуулгын багтаамж, бусад агуулга болон хичээлтэй ямар уялдаа холбоотой болох тухай
- Үйл ажиллагаа бүрийн арга зүй, хүрэх үр дүн, түүнийг хэрхэн үнэлэх арга
- Хэрэглэгдэхүүний онцлог, зорилго
- Сурагчдын хувийн онцлог, хэрэгцээ

### 2. Хичээлийн судалгааны зорилгын хувьд:

- Энэ хичээлээр юуг судлуулахыг хүсч байгаа тухай
- Ямар баримт цуглуулахыг хүсч байгаа тухай
- Шаардлагатай гэж үзвэл ажиглалтын тэмдэглэлийн хуудсыг бэлтгэж, хэрэглэх аргачлалыг тайлбарлах

Хичээл ажиглах багш нар өөрөөсөө дараах асуултыг асууж биеэ бэлдэнэ. Үүнд:

### А. Хичээлийн судалгааны зорилготой холбоотой асуултууд:

1. Тухайн хичээлийг судалснаар юу мэдэхийг хүсч байна вэ?

2. Судалгааны асуултын дагуу ямар өгөгдөл цуглуулах вэ?

**Б. Хичээлийн тусгай арга зүйтэй холбоотой судалгааны асуултууд:**

1. Тухайн хичээлийн заах арга зүйн онцлогийн талаар юу мэдэхийг хүсч байна вэ?

2. Судалгааны асуултын дагуу ямар өгөгдөл цуглуулах вэ?

**В. Ерөнхий арга зүйтэй холбоотой асуултууд:**

1. Бусад хичээлд хэрэглэж болох ямар ерөнхий арга зүйг харахыг хүсч байна вэ?

2. Судалгааны асуултын дагуу ямар өгөгдөл цуглуулах вэ?

### **Хичээлийн судалгааны баримт цуглуулах нь**

#### **Хичээлийн судалгааны баримт цуглуулах арга зүй**

- 1.Хичээл заахын өмнө
- 2.Хичээлийн заах явцад
- 3.Хичээл заасны дараа

Хичээлийн судалгааны баримт цуглуулах, дүн шинжилгээ хийх ажлыг дараах 3 түвшинд гүйцэтгэдэг. Үүнд:

1. Хичээл заахын өмнө судалгааны асуултуудыг боловсруулна.

1.1 Тухайн хөтөлбөрөөр суралцагчдыг хэрхэн хөгжүүлэхээр төлөвлөсөн бэ?

- a) Сурагчид ямар амжилтанд хүрэх
- b) Сурагчид ямар ажил гүйцэтгэх

c) Юуг ажиглах

d) Сурагчид хөгжсөн талаарх ерөнхий тоймыг хэрхэн илрүүлэх

e) Эзэмшвэл зохих стандартын мэдлэг, чадварын түвшин, мужлал

1.2 Тухайн хөтөлбөрөөр хичээлийн зорилгыг хэрхэн биелүүлэхээр төлөвлөсөн бэ?

a) Ямар амжилтанд хүрэх

b) Сурагчид ямар ажил гүйцэтгэх

c) Юуг ажиглах

d) Багш, сурагчдын туршлага

2. Хичээл заах явцад судалгааны баримтууд цуглуулна.

- Хичээлийн зорилго биелэгдсэнийг илрүүлэх баримт
- Тухайн хичээлийн онцлогтой холбоотой судалгааны баримт
- Тухайн хичээлд хандах сурагчдын хариу үйлдэл
- Багшийн асуулттай холбоотой баримт
- Хэлэлцүүлэгт ажиглалт судалгааны үр дүнг хэлэлцүүлсэн баримт

3. Хичээл заасны дараа цугларсан баримтуудад дүн шинжилгээ хийнэ.

- Тухайн баримтын өгөгдөлд анализ хийж, тайлбарлах
- Тайлбарын дагуу хичээлийн төлөвлөлтийг нягтлах
- Тухайн баримтын өгөгдөлд хийсэн тайлбарын дагуу дараачийн хичээлийн төлөвлөлтийг сайжруулах
- Тухайн өгөгдлийг хичээлийн судалгааны дараачийн циклд ашиглах

- Дараачийн хичээлтэй холбоотой судалгааны ерөнхий болон тусгай асуултуудыг бүтээх

#### А. Хичээлийн зорилготой холбоотой баримт цуглуулах

##### Судалгааны асуулт:

- Энэ хичээлийн зорилго юу вэ?
- Энэ хичээлийг зааснаар сурагчид юуг ойлгож, мэдэж, хийж чаддаг болох вэ?
- Бид хэрхэн түүнийг илрүүлэх вэ?

##### Цуглуулах баримтын өгөгдөл:

- Сурагчид хичээлийн тухайн зорилгыг ойлгосон гэдгийг хэрхэн мэдэх вэ? Тэд юу хийж, юу хэлсэн бэ? Тэдний ойлголтыг аль багийнхан харуулж чадсан бэ?
- Сурагчид зорилгодоо хүрч, мэдлэг эзэмшсэнийг нотлох ямар баримт байна вэ? Тэд юу хийж, юу гэж хэлж байна вэ?
- Сурагчид эзэмшсэн мэдлэг, чадвараа ашиглаж чадаж буйг харуулах ямар баримт байна вэ? Тэдний ажлаас юуг харж болох вэ? Тэд нөхдийгөө хэрхэн сонсож байна вэ? Өөр өөр бүлгийн сурагчид үүнийг хэрхэн хийж байна вэ?

##### **Хичээлийн зорилготой холбоотой баримтын жишээ:**

Зорилго: Өгөгдсөн процесст олон оронтой тооны хүчин зүйлсийг хэрэглэж чадах

Асуултууд:

- Хэдэн сурагч зааврын дагуу дагуу хийж гүйцэтгэсэн бэ?
- Бусад сурагчид аль хэсгийг ашигласан бэ?
- Ямар сурагч практикт хэрэглэх талаар зөв хариулт өгч чадсан бэ?
- Ямар сурагч үйл явцын гол санааг зөв хариулсан бэ?
- Ямар санаан дээр эргэлзсэн бэ?
- Ямар сурагч олон оронтой тооны хүчин зүйлийг өөр зүйлд ашиглаж чадсан бэ?

##### **Жишээ А:**

Зорилго: Өгөгдсөн процесст олон оронтой тооны хүчин зүйлсийг хэрэглэх

Асуултууд:

- Хэдэн сурагч зааврын дагуу хийж гүйцэтгэсэн бэ?
- Бусад сурагчид аль хэсгийг ашигласан бэ?
- Ямар сурагч практикт хэрэглэх талаар зөв хариулт өгч чадсан бэ?
- Ямар сурагч үйл явцын гол санааг зөв хариулсан бэ? Ямар санаан дээр эргэлзсэн бэ?
- Ямар сурагч олон оронтой тооны хүчин зүйлийг өөр зүйлд ашиглаж чадсан бэ?

#### Б. Хичээлийн тусгай арга зүйтэй холбоотой судалгааны баримт цуглуулах

##### Судалгааны асуулт:

- Бид юу хийхээр шийдсэн бэ? Яагаад?
- Бидний шинээр туршиж буй зүйл тухайн хичээлийн үр дүнг сайжруулахад хэрхэн нөлөөлөх вэ?
- Энэ нь сурагчдыг сурах арга барилд сургаж байна гэж үзэх ямар баталгаа байна вэ?

##### Цуглуулах баримтын өгөгдөл:

1. Хэдэн сурагч (аль баг) даалгаврыг гүйцэтгэхдээ бидний боловсруулсан шинэ аргачлалыг:
  - Сонирхсон
  - Ойлгосон
  - Зааврын дагуу ажилласан

- *Суралцахуйн үйл ажиллагаандаа ашигласан*
  - *Дүгнэлт хийсэн*
  - *Шинэ аргачлалд суралцсан гэдгээ харуулж чадсан*
  - *Сурах арга барилд суралцсан*
  - *Өөр сэдвийг судлахад хэрэглэсэн*
  - *Сэтгэхүйн нэг түвшнээс нөгөөд шилжиж чадсан*
  - *Тухайн хичээлийн агуулгын үндсэн мэдлэгийг хэр зэрэг илэрхийлсэн бэ?*
2. Хэрхэн үүнийг мэдэх вэ? Тэд юу хэлж, юу хийж байна вэ?

**Хичээлийн тусгай хүчин зүйлтэй холбоотой судалгааны баримтын жишээ:**

Зорилго: Муруй болон шугаман хамаарлын ялгааг ойлгуулах  
Асуултууд:

- Хэдэн сурагч (аль баг) өмнөх хичээл дээр үзсэн түлхүүр санааг эргэн санаж, өгөгдсөн карт дээр бичиж чадаж байна вэ?
- Оюуны шуургын үед хэдэн сурагч (аль баг) дэлхийн популяцийн өсөлтийн талаар өөр хоорондоо санал бодлоо хуваалцсан бэ?
- Хэдэн сурагч (аль баг) популяцийн өсөлтийн график муруй байдаг гэж үзсэн бэ? Хэд нь шугаман байдаг гэж үзсэн бэ?
- Аль сурагч бусдадаа график муруй гэдгийг үнэмшүүлж чадсан бэ?
- Хэдэн сурагч (аль баг) хичээлийн зорилгыг оновчтой дүгнэж чадсан бэ?

**Жишээ Б:**

Зорилго: Муруй болон шугаман хамаарлын ялгааг ойлгуулах

Асуултууд:

- Хэдэн сурагч (аль баг) өмнөх хичээл дээр үзсэн түлхүүр санааг эргэн санаж, өгөгдсөн карт дээр бичиж чадаж байна вэ?
- Оюуны шуургын үед хэдэн сурагч (аль баг) дэлхийн популяцийн өсөлтийн талаар өөр хоорондоо санал бодлоо хуваалцсан бэ?

- Хэдэн сурагч (аль баг) популяцийн өсөлтийн график муруй байдаг гэж үзсэн бэ? Хэд нь шугаман байдаг гэж үзсэн бэ?
- Аль сурагч бусдадаа график муруй гэдгийг үнэмшүүлж чадсан бэ?
- Хэдэн сурагч (аль баг) хичээлийн зорилгыг оновчтой дүгнэж чадсан бэ?

**В. Хичээлийг ерөнхийд нь ажиглахтай холбоотой судалгааны баримт цуглуулах**

- Хичээлийг ажиглаж байх үед таны толгойд орж ирсэн асуултууд
- Ангид болсон шүүмжлэх зүйлс
- Сурагчдын тавьсан асуултын төрөл
- Багшийн тавьсан асуултын төрөл
- Өндөр түвшинд сэтгэж байгаагийн баталгаа
- Чадвар эзэмшсэний баталгаа
- Төөрөгдөж буйн баталгаа
- Гараа өргөж буй сурагчдын эзлэх хувь
- “Аа хаа”, нүдэндээ гэрэл цацруулж буй агшин зэрэг биеийн хэл
- Бодол санаа нь өөрчлөгдсөний баталгаа
- Ангийнхандаа зааж, сургасан сурагчдын тоо

**Хичээлийг ерөнхийд нь ажиглаж, цуглуулсан баримтын жишээ**

Суралцахуйн талаар:

- Агаарын халалтын талаарх сурагчдын төсөөлөл туршилтын дараа хэрхэн өөрчлөгдсөн бэ?
- Сурагчид энгийн тоолох аргаас илүү нарийн нийлмэл арга руу хэрхэн шилжиж байсан бэ?
- Жүжгийн дүрд тоглуулснаар сайн бичихэд нь нөлөөлж чадсан үү?
- Талбайн талаар мэдсэн зүйлээ тэмдэглэлээрээ илэрхийлж чадсан үү?

Идэвхтэй байдал:

- Гараа өргөсөн сурагчдын хувь
- “Аа хаа” болон, нүдэндээ гэрэл цацруулж буй агшин зэрэг биеийн хэл
- Сурагчид хэдэн удаа засвар оруулах, бүтээх санал гаргасан бэ?
- Сурагчид бие биедээ нөхөрсөг байж чадсан үү?
- Нэг сурагч хэдэн удаа харилцсан бэ?

Сурагчдын хичээлд хандаж хандлага:

- Хичээлийг аль хэсэгт дуртай, аль хэсэгт дургүй байна вэ?
- Хичээлийг зааснаар дараачийн хичээл дээр хэрхэн өөрчлөгдсөн бэ?
- Таны өдөр тутмын хичээлтэй харьцуулахад маргалдаа байна вэ?

- Тохиролцоонд хүрсний баталгаа
- Хичээлийн дараалал, түүнээс хазайсан байдал

**Жишээ В1:**

Суралцахуйн талаар:

- Агаарын халалтын талаарх сурагчдын төсөөлөл туршилтын дараа хэрхэн өөрчлөгдсөн бэ?
- Сурагчид энгийн тоолох аргаас илүү нарийн нийлмэл арга руу хэрхэн шилжиж

байсан бэ?

- Жүжгийн дүрд тоглуулснаар сайн бичихэд нь нөлөөлж чадсан уу?
- Талбайн талаар мэдсэн зүйлээ тэмдэглэлээрээ илэрхийлж чадсан уу?

Идэвхитэй байдал:

- Гараа өргөсөн сурагчдын хувь
- “Аа хаа” болон, нүдэндээ гэрэл цацруулж буй агшин зэрэг биеийн хэл
- Сурагчид хэдэн удаа засвар оруулах, бүтээх санал гаргасан бэ?
- Сурагчид бие биедээ нөхөрсөг байж чадсан уу?
- Нэг сурагч хэдэн удаа хариулсан бэ?


Сурагчдын хичээлд хандах хандлага:

- Хичээлийн аль хэсэгт дуртай, аль хэсэгт дургүй байна вэ?
- Хичээлийг зааснаар дараачийн хичээл дээр хэрхэн өөрчлөгдсөн бэ?
- Таны өдөр тутмын хичээлтэй харьцуулахад ямар ялгаа байна вэ?

### Жишээ В2:

- Суралцагчийн тухайн суралцах арга барил хичээлийн тодорхой хэсэгт хэрхэн нөлөөлж байна вэ? Ямар аргаар энэ амжилтад хүрсэн бэ? Яагаад? Энэ талаар сурагчид юу хийсэн бэ?
- $X \rightarrow Y \rightarrow Z$  шилжих үед сурагчид юу хийсэн бэ?
- Хичээлийн явцад сурагчид ямар асуулт (үгээр, чадах ядахаараа, Блумын таксономын ангиллын дагуу) асууж байсан бэ?
- Сурагчдын дундаас хэн ямар төрлийн асуулт асууж байсан бэ? Хэн асуулт асуухгүй байсан бэ? Асуулт асуугаагүй сурагчид мэдлэг, чадвар эзэмшсэн гэдгийг хэрхэн яаж илрүүлэх вэ?
- Сурагчид өөр хоорондоо болон ангийнхантайгаа юу гэж ярьсан бэ? Тэдгээрийг Блумын таксономоор ангилвал? Эдгээр нь ямар танин мэдэхүйн түвшинд байна вэ?
- Сурагчид чадвартай болсон гэх ямар баталгаа байна вэ?
- Аль нэг зүйлийг сайн ойлгосон эсвэл эргэлзэж байна гэх ямар баталгаа байна вэ? Хэдэн сурагч сурсан, хэд нь чадаагүй вэ? Тухайн багийн талаар таны тэмдэглэлд юу гэж бичсэн байна вэ?
- Сурагчид нэг сэдвээс нөгөөд шилжиж чадаж байгааг та юугаар батлах вэ?
- Сурагчид бие биедээ тусалж байгааг та юугаар батлах вэ?
- Багш хичээлийн аль хэсэгт төлөвлөснөөсөө хазайсан бэ? Энэ хазайлтын үед юу болсон бэ? Тухайн багш үүнийг хэрхэн өөрчилсөн бэ? Энэхүү өөрчлөлт сурагчдад хэрхэн нөлөөлсөн бэ?

Хичээлийн ажиглалтын тэмдэглэлийг янз бүрээр хөтөлж болно. Гэхдээ аль болох хялбар, энгийн байвал зүйтэй. Зарим нэг ажиглалтын тэмдэглэлийн хувилбарыг танилцуулья.



### Ажиглалтын хуудас 1

**Зорилго:** Сурагч, баг хамт олны оролцоог ажиглах

**Тайлбар:** Та аль нэг баг болон сурагчийг сонгон тэдний идэвх, оролцоог өөрт ойлгомжтой байдлаар тэмдэглээрэй.

### Ажиглалтын хуудас 2

|                                       |                                     |                 |
|---------------------------------------|-------------------------------------|-----------------|
| Ажиглалт хийсэн<br>Он сар, өдөр       | Хичээлийн нэр<br>Хичээл заасан багш | Сэдэв           |
| Сурагчийн мэдлэг бүтээх үйл ажиллагаа |                                     | Багшийн дэмжлэг |
|                                       |                                     |                 |

### Ажиглалтын хуудас 3

|                                 |                                     |                  |
|---------------------------------|-------------------------------------|------------------|
| Ажиглалт хийсэн<br>Он сар, өдөр | Хичээлийн нэр<br>Хичээл заасан багш | Сэдэв            |
| Сайн болсон зүйл                | Сайжруулах зүйл                     | Сайжруулах санал |
|                                 |                                     |                  |

### Ажиглалтын хуудас 4

|                                                                                                                                                                                       |                                                                                                                              |
|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| <p><i>Хичээлээс олж авсан санаанууд</i><br/> <i>Хичээлд ажиглалт хийх явцдаа өөрт төрсөн анхны сэтгэгдлийг тэмдэглэнэ.</i></p>                                                        |                                                                                                                              |
| <p>Санал шүүмжлэл<br/> <i>Танд ямар зүйл шүүмжлэлтэй санагдсан бэ?</i><br/> <i>Та яагаад эсрэг байр суурьтай байна вэ?</i><br/> <i>Таны өгсөн шүүмжлэлийн гол санаа нь юу вэ?</i></p> | <p>Эргэлзээтэй санагдлаа<br/> <i>Танд ямар зүйл нь эргэлзээтэй санагдсан бэ?</i><br/> <i>Таны бодлоор яавал дээр вэ?</i></p> |
|                                                                                                                                                                                       |                                                                                                                              |

Судалгааны багийн гишүүд хичээлд ажиглалт хийсний дараа ажиглалтын тэмдэглэл, хичээлийн судалгааны талаар цуглуулсан баримтаа цэгцлэх шаардлагатай байдаг. Ингэхдээ дараах зүйлсийн талаар эргэцүүлэн бодно.

### Хичээлийн зорилго, зорилтууд

- Сурагчид юуны тухай хичээл болохыг ойлгосон уу? Яаж түүнийг мэдэх вэ?
- Хичээлийг тохирсон түвшинд төлөвлөсөн үү?
- Сурагчдад ямар зүйл хүндрэлтэй байсан бэ?
- Хичээлийн амжилтын үзүүлэлт шалгуурыг сурагчид мэдэж байсан уу?
- Сурагчид юу сурав? Сурсан зүйлс нь тэдэнд тустай байж чадсан уу?
- Хичээлийн үеэр сурагчид юу давтсан бэ? Давтлага тэдэнд тустай байсан уу?

### Үйл ажиллагаа ба материал хэрэгсэл

- Хичээл дээр ашигласан материал болон гүйцэтгэсэн ажлууд нь сурагчдын сонирхлыг татаж чадсан уу?
- Ашиглах материалууд нь хэрэглэгдсэн үү?

### Сурагчид

- Бүх сурагч даалгаврыг гүйцэтгэж чадсан уу? Яагаад?
- Хичээлийн аль хэсэг хүүхдүүдэд хамгийн сонирхолтой эсвэл хамгийн сонирхолгүй байсан бэ? Яагаад?

### Анги зохион байгуулалт

- Төлөвлөсөн үйл ажиллагааны цагийн төлөвлөлт оновчтой байсан уу?
- Ангиар, бүлгээр, хосоор болон дангаараа хийсэн ажлууд нь оновчтой болж чадсан уу?
- Ангиар, бүлгээр, хосоор болон дангаараа ямар ажлууд хийсэн бэ? Тэд оновчтой байсан уу?
- Хийх ажлын зааварчилгаа тодорхой байж чадсан уу?
- Сурагчид бүгд оролцож чадсан уу?
- Сурагчдад тодорхой ахиц гарсан гэдэг нь ажиглагдсан уу?

### Ерөнхий

- Хэрэв би энэ хичээлийг заавал юуг нь өөрчлөх вэ?

Хичээлийн ажиглалтын тэмдэглэлд үндэслэн хичээлд үнэлгээ хийхдээ дараах загваруудыг ашиглаж болно. Үүнд:

### **SWOT (Давуу болон сул тал, боломж ба эрсдэл) шинжилгээний арга**

Аливаа зүйлийн давуу, сул тал, ашигтай зүйлс болон учирч болзошгүй аюул заналыг олох нь хичээлийг үнэлэх нэг арга юм.

**Жишээ 1:** Хүн-Орчин, 2-р анги, “Голын ус яагаад бохирдов?” хичээл дээр хийсэн голын усыг шүүх туршилтын ажил

|           |                                                                                         |
|-----------|-----------------------------------------------------------------------------------------|
| Давуу тал | Сурагчид маш идэвхтэй, сонирхолтой оролцсон. Хийсэн ажлаа өөрөө үнэлэхэд хялбар байсан. |
|-----------|-----------------------------------------------------------------------------------------|

|         |                                                                                                                                                 |
|---------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| Сул тал | Олон сурагч шүүлтүүрийн цаасыг зөв нугалж чадахгүй байв. Харин багш тийм байна гэж бодоогүй.                                                    |
| Боломж  | Дадлагын үеэр сурагчид туршилтыг өөрсдөө хийж үзэхийг хичээж байсан. Тиймээс ийм туршилтын ажлуудыг илүү их хийж байх нь зүйтэй.                |
| Аюул    | Сурагчид энгийн туршилтыг хийж чадахгүй байгаа нь дараа дараачийн ажилд саад болох магадлалтай тул ийм зүйлүүдийг дахин дахин хийлгэх хэрэгтэй. |

|                                                          |                                                                                                                                                                                                                    |
|----------------------------------------------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| Ямар зүйл амжилттай болов?                               | <i>Сурагчид хичээлд сайн оролцсон. Тайлбар амжилттай болсон</i>                                                                                                                                                    |
| Яагаад амжилттай болсон бэ?                              | <i>Сурагчид уралдах дуртай учраас хооронд нь тоглоомонд их идэвхтэй оролцсон.</i>                                                                                                                                  |
| Ямар зүйл амжилтгүй болов?                               | <i>Дасгалын хуудас сурагчдад дэндүү хүнд байсан.</i>                                                                                                                                                               |
| Яагаад?                                                  | <i>Сурагчид, ялангуяа 5-р бүлгийн сурагчид зааврыг анхааралтай сонсоогүй.</i>                                                                                                                                      |
| Энэ сэдвийг дахин заахад юуг нь өөрчлөх шаардлагатай вэ? | <i>Сурагчдад хийх ажлыг нь сайн ойлгуулахын тулд ажлын хуудсыг өгөхөөсөө өмнө тодруулах олон асуулт асууж хариулт авах ёстой байсан. Мөн зааврыг хүүхдүүдээр өөрсдөөр нь дахин хэлүүлсэн бол дээр байх байсан.</i> |

### Хичээлийн талаар өөрийн санаа бодлыг багцлах

|                          |                        |
|--------------------------|------------------------|
| Сонирхолтой санагдсан    | Аятайхан болжээ        |
| Маш сайн болжээ          | Эргэлзээтэй санагдсан  |
| Жаахан ойлгомжгүй байлаа | Би тэгж бодохгүй байна |
| Бусад:                   |                        |

## Жишээ 2

Ажиглагчид хичээлийг ажиглан, судалгааны асуултын дагуу баримтын өгөгдөл цуглуулсны дараа түүнээс гурвыг нь сонгон авч эргэцүүлэл бичнэ. Дараа нь эргэцүүлэл болгоны юуг нь гайхсан, ямар зүйлтэй нь санал нийлсэн, ямар зүйлд эргэлзэж байсан тухайгаа эргэн санаж, сайтар тунгаасны эцэст зургаан баллаар үнэлж, тайлбар бичнэ.

Эргэцүүлэл 1: \_\_\_\_\_

|      |   |            |   |        |   |
|------|---|------------|---|--------|---|
| 6    | 5 | 4          | 3 | 2      | 1 |
| сайн |   | дунд зэрэг |   | сулхан |   |

Тайлбар: .....

.....

.....

.....

Хэрэв хичээлийн судалгаанд олон хүн оролцсон бол хэлэлцүүлэг эхлэхийн өмнө багаар ажиллаж саналаа нэгтгэнэ. Ингэснээр асуудлын голыг олж харах, давхардсан санаануудыг нэгтгэх, асуудалд үндэслэлтэй хандах, хугацаа хожих зэрэг олон талын ач холбогдолтой байдаг. Үүний тулд:

1. Багийн ажлын нэгдсэн хүснэгтийг ашиглан, багийн гишүүд саналаа нэгтгэнэ.
2. Багийн ажлын нэгдсэн тэмдэглэлийн чухал үг хэллэг хэсэгт байгаа түлхүүр үгнүүдийг багцлан тухайн хичээлээр ямар зүйлд анхаарах шаардлагатай байгааг тодорхойлно.
3. Тэдгээр түлхүүр санааг зургаан баллын үнэлгээгээр үнэлж тайлбарыг хийнэ.
4. Багаас нэг гишүүн багийн ажлыг танилцуулж хэлэлцүүлнэ.

### Хүснэгт 3. Хэлэлцүүлэгт бэлтгэх багийн ажлын нэгдсэн тэмдэглэл

| Өгүүлбэр<br><i>Багийн гишүүн бүр өөрийн тэмдэглэлээс чухал гэж үзсэн өгүүлбэрийг сонгон авна.</i> | Үг хэллэг<br><i>Өгүүлбэрээс чухал үг хэллэгийг сонгон авна.</i> | Үг<br><i>Чухал үгийг сонгон авна.</i> |
|---------------------------------------------------------------------------------------------------|-----------------------------------------------------------------|---------------------------------------|
|                                                                                                   |                                                                 |                                       |

**Даалгавар:**

5. Сурган хүмүүжүүлэх ажлын дадлага хийх явцдаа хичээлд сууж ажиглалт хэрхэн хийснээ эргэн санаарай.
  - А. Хэдэн багш, хэдэн оюутны хичээлд сууж ажигласан бэ?
  - Б. Та ажиглалтын тэмдэглэл хөтөлдөг байсан уу?
  - В. Хэрэв ажиглалтын тэмдэглэл хөтөлдөг байсан бол тэр танд хэр тустай байсан бэ?
  - Г. Та юу ажиглаж мэдсэн бэ?
  - Д. Ажиглаж мэдсэн зүйлсээ нийтээрээ хэлэлцдэг байсан уу?
  - Е. Хэрэв тийм бол ямар үр дүн ажиглагдсан бэ?
6. Хичээлийн технологи, багшийн сургах үйл, сурагчийн сурч танин мэдэх үйлийн талаар бичсэн хэсгийг уншсанаа эргэн санана уу?
  - А. Хичээлийн технологи гэж юу вэ?
  - Б. Хичээлийн технологийн шинэчлэлийг яагаад хийх хэрэгтэй вэ?
  - В. Хичээлийн агуулга гэж юуг хэлэх вэ? Жишээ бичнэ үү?
  - Г. Хичээлийн арга зүй гэж юу вэ? Жишээгээр тайлбарлана уу?
  - Д. Хичээлийн эхэнд багш ямар аргыг хэрэглэдэг вэ? Жишээ хэлнэ үү
  - Е. Хичээл дээр явцын үнэлгээ хийх нь ямар ач холбогдолтой вэ?
7. Хичээлд ажиглалт хийх аргачлалын хэсгийг уншсанаа эргээд санаарай.
  - А. Хичээлийн судалгааг ямар зорилгоор хийдэг вэ?
  - Б. Хичээлд уригдан ирсэн гадны оролцогчдод хичээлийн өмнө яагаад заавал мэдээлэл өгөх шаардлагатай вэ?
  - В. Хичээлийн судалгааны баримтыг хэрхэн цуглуулах вэ?
  - Г. Хичээлд ажиглалт хийж байсан өмнөх туршлагадаа тулгуурлан ямар баримтыг ажигласнаа тайлбарлана уу?
  - Д. Танд хичээлд ажиглалт хийх ямар шинэ санаа төрсөн бэ?

## Семинар 10, 11. Хичээлд ажиглалт хийх

**Зорилго:** Хичээлд ажиглалт хийх, ажиглалтын тэмдэглэл хөтлөх, судалгааны баримт цуглуулах арга зүйд суралцах

**Хугацаа:** 4 цаг (180 минут)

**Хэрэглэгдэхүүн:**

- Лекц №6. Хичээл заах, ажиглах
- Лекц №6. Хуудас 86-88 загвар хүснэгтүүд
- Ээлжит хичээлийн төлөвлөлт
- Видео хичээл

**Бусад хэрэглэгдэхүүн:** Самбарын цаас, фломастер, скоч, соронз

**Удирдамж:**

1. 4-6 хүнтэй багаар зохион байгуулна. 5 минут
2. Ажиглалтад бэлтгэх (нийт 75 минут)
  - 2.1 Багийн гишүүн бүр заах хичээлийн хөтөлбөртэй танилцан хичээлийн судалгааны зорилго болон тухайн хичээлийн арга зүйн төлөвлөлтийн онцлогийг судлах 20 минут
  - 2.2 Юу ойлгож мэдсэнээ бусдадаа танилцуулж ярилцах 20 минут
  - 2.3 Багаараа хамтран ажиглалтын хуудас бэлдэх, юуг хэрхэн яаж ажиглахаа тогтох 15 минут
  - 2.4 Багууд ажлаа танилцуулж, харилцан санал солилцох 20 минут
3. Хичээл ажиглах (нийт 45 минут)
  - 3.1 Багийн гишүүн бүр видео хичээлийг ажиглан тэмдэглэл хөтлөх ба шаардлагатай тохиолдолд зураг авч баримтжуулна.
4. Ажиглалтын тэмдэглэлд үндэслэн судалгааны баримт цуглуулах (нийт 65 минут)
  - 4.1 Багийн гишүүн бүр өөрийн ажиглалтын тэмдэглэлээс хамгийн чухал гэсэн санаануудыг хураангуйлж бичнэ. 20 минут
  - 4.2 Чухал гэж үзсэн зарим санаагаа багийнхандаа танилцуулж, багийн ажлын нэгдсэн хүснэгтэд бичнэ. Багийн гишүүд санал нийлээгүй тохиолдолд мэтгэлцэхгүй 20 минут
  - 4.3 Бүлгийн хэлэлцүүлэг. Багийн нэгдсэн тэмдэглэлээс суралцан, ямар чухал санаанууд байгааг тодруулна. 25 минут

**Даалгавар:**

1. Өөрийн цуглуулсан баримтаас чухал гэж үзсэн 3 баримтыг сонгон авч эргэцүүлэл хийгээрэй.

### БИЕ ДААХ АЖИЛ

1. “Хичээлийн ажиглалтыг хэрхэн хийх вэ?” сэдвээр эсээ бичээрэй.

## Судалгаат хичээлийн хэлэлцүүлэг

| Хичээлийн хэлбэр, цаг | Агуулга                                                                                                                                                                                                                                              | Хэрэглэгдэхүүн                                                                                                                            | Бие даах ажил                                                       |
|-----------------------|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|---------------------------------------------------------------------|
| Лекц- 7<br>/2 ц/      | <ul style="list-style-type: none"> <li>Судалгаат хичээлийн хэлэлцүүлгийг зохион байгуулах, хэлэлцүүлгийн орчин</li> <li>Хэлэлцүүлгийг хөтлөн удирдах, чиглүүлэг</li> <li>Хэлэлцүүлэг-идэвхтэй оролцоо</li> <li>Судалгаат хичээлийн хуудас</li> </ul> | ppt<br>Фото хичээл<br>судалгаат хичээлийн А1, А2, В1, В2, Г, Д хуудас (“Хичээлд мониторинг хийх зөвлөмж”, 46, 48, 53, 56, 59, 61 дэх тал) | Судалгаат хичээлийн хэлэлцүүлэг хийдэг туршлагатай биечлэн танилцах |
| Семинар 12<br>/2 ц/   | <ul style="list-style-type: none"> <li>Хэлэлцүүлэг хийж буй бодит жишээн дээр анализ хийж орчныг хэрхэн бүрдүүлж, хэрхэн хөтлөх дээр дүгнэлт гаргах</li> </ul>                                                                                       | видео бичлэг, эх бичвэр                                                                                                                   |                                                                     |
| Семинар 13<br>/2 ц/   | <ul style="list-style-type: none"> <li>Судалгаат хичээлийн хуудсыг бөглөсөн жишээтэй танилцах</li> <li>Хэлэлцүүлэгт бодитойгоор оролцох</li> </ul>                                                                                                   | видео бичлэг, судалгаат хичээлийн бөглөсөн хуудас (А, В, Г, Д хуудас)                                                                     |                                                                     |

### Судалгаат хичээлийн хэлэлцүүлэг



#### Энэхүү бүдүүвчийг ашиглах зорилго

-Өмнө үзсэн лекцүүдийг нь, өөрөөр хэлбэл үйлийн алхам-1, 2 (хичээлийн бэлтгэл үе, хичээлээ туршин заах, ажиглах үе)-ийг сэргээн сануулах

-Хичээлийн судалгааны 3 дахь үйлийн алхам болох хичээлийн хэлэлцүүлгийн зорилготой танилцуулах

- Үйлийн алхам-1, 2, 3-ыг бүхэллэг байдлаар уялдаа холбоонд нь ойлгуулах

#### -Шинэ сэдэв рүүгээ орох зорилгоор асуудал дэвшүүлнэ.


#### Өгөгдөл:

1. Та хичээлд ажиглагчаар оролцох боломжтой боллоо.

2. Ангийн А, Б, В, Г гэсэн хэсгүүд сул чөлөөтэй байлаа.

- Энэ тохиолдолд хаана зогсож

ажиглалт хийвэл үр дүнтэй байх бол? ЯАГААД?





### Хэлэлцүүлэгт:

- **ХЭН?** (хөтлөгч, багш нар, менежер, зөвлөх багш г.м. оролцогчид)
- **ЮУГ?** (хичээлийн явцын алдаа оноог)
- **ХААНА?** (сэтгэлзүйн таатай орчинд)
- **ЯАЖ?** (эрэг хандлага, авах гээхийн ухаанаар)

ярих вэ? зэрэг нь ямар чухал болох, түүнийг монгол хөрсөнд хэрхэн буулгаж хэрэгжүүлэх талаар тодорхой жишээгээр тайлбарлана.

- Хэлэлцүүлэг нь хичээлийн үйл явцыг ажиглахтай шууд холбоотой ч гэсэн, хэлэлцүүлэг хэр үр дүнтэй болох нь юуны түрүүнд оролцогчид тухайн судалгаат хичээлийн бэлтгэл судалгаа болон хөтөлбөртэй хэр танилцсанаас шууд хамаарна.

- Японд бүх багш нараа заавал суулгадаг. Сургуулиуд нь 1 ээлжтэй байдаг учир үүнийг


хичээлийн хуваариар зохицуулах бүрэн боломжтой. Ингэснээр багш нарын аргазүй нь ижил түвшинд зэрэг хөгжинө гэж үздэг.

- Бусад орны туршлагаас харвал хичээлийн хөтөлбөрөө дор хаяж 3 хоногийн өмнө оролцогчдод тарааж өгдөг байна. Хичээлийн явцад анзаарсан зүйлээ хөтөлбөр дээрээ дор бүр нь тэмдэглэж түүнийгээ хэлэлцүүлгийн явцад ашиглахаас гадна өөрийн хичээлдээ бүтээлчээр ашигладаг. Иймээс ч хичээлийн судалгаа нь нийт оролцогчид бүтээлчээр хэлэлцэж, илүү сайн аргазүйг боловсруулж хэрэгжүүлэх үйл ажиллагаа юм. Тиймээс оролцогчид бол үр дүнг хүртэгч бас хувь нэмэр оруулагчид болно.

- Нөгөөтэйгүүр хэлэлцүүлэгт бэлтгэл судалгаа (Судлагдахууны агуулгын судалгаа, мэдлэг эзэмших явцын судалгаа, багшлахуйн арга барилын судалгаа, үнэлгээний судалгаа, хэрэглэгдэхүүний судалгаа)-ны талаар маш дэлгэрэнгүй танилцуулах шаардлагатай (лекц № 3-ээ эргэж санаарай.). Үүнийг судалгаат хичээлд бэлтгэсэн мэргэжлийн баг-хамтлагийн багш нар танилцуулах нь зохимжтой байдаг.

- Хэлэлцүүлэгт ярих зүйлдээ зориулж бэлтгэл судалгаа болон ажиглалтын явцад материал цуглуулж, богино хугацаанд боловсруулалт хийн, өөрийн гэсэн гаргалгаа (шийдэл, хувилбар)-г санал болгон үзэл бодлоо илэрхийлж, бусдыгаа сонсон туршлага солилцон, хөтөлбөрөө засч сайжруулна. (БШУЯ, ЖАЙКА-ийн хамтарсан “Монгол улсын хүүхдийн хөгжлийг дэмжих багшлах арга зүйн

шинэчлэл” төслийн хүрээнд гарсан “Хими” суурь боловсрол, VCD-ий хэлэлцүүлгийн хэсгээс үзнэ үү.)




- Ямар төрлийн судалгаат хичээлийн хэлэлцүүлэг хийх гэж байгаагаас хамаарч хичээлийн судалгааны аль үйлийн алхам (Слайд 1-ээ хараарай.)-д түлхүү анхаарч ярихаа бэлтгэнэ. Тухайлбал, сургалтын үед ахмад багшийн заах загвар хичээлд үйлийн алхам-2, 3 буюу хичээл заах ажиглах, хэлэлцэхэд гол анхаарлаа хандуулна гэсэн үг.

Олон оронд хичээлийн судалгаа нь:

- ✓ Багш нар ажлын байран дээрээ мэргэжлээ дээшлүүлэх
- ✓ Бусдаасаа суралцах
- ✓ Өөрийн арга туршлагаа бусадтай хуваалцах
- ✓ Жинхэнэ үлгэр жишээ болохуйц “сайн хичээл”-тэй танилцах
- ✓ Багаараа хамтран шинэ аргазүй боловсруулж, туршин заах
- ✓ Нийтийн хүртээл болгох боломжийг олгодог байна.

Үүнд хичээлийн хэлэлцүүлэг нэлээд чухал байрыг эзлэх ба хичээлээ заагаад, яриад л өнгөрөх биш эргэн харж засч сайжруулах бүтээлч, тасаралтгүй үйл ажиллагаа болгож өгдөг. (лекц № 6 “бүдүүвч-1”-ээсээ харна уу.)

## Юуг ярих вэ?



Хичээлийг бүхий л талаас ерөнхийд нь ажигласан хичээлийн хэлэлцүүлгийн хувьд:

- **Эхлэл удиртгал** (сэдэл төрүүлж сонирхол татсан байдал, хичээлийн зорилго зорилтыг дэвшүүлсэн байдал г.м.),

- **Агуулга** (Агуулгын оновчтой байдал, агуулгын гадаад ба дотоод интеграц, тухайн судлагдахууны шинжлэх ухааны мэдлэгийг амьдрал практиктай холбосон байдал

өөрөөр хэлбэл, мэдлэг болон ур ухааныг хэрхэн оновчтой холбосон байдал г.м.),

- **Аргазүй** (сургалтын аргаа сонгосон байдал, асуултаа томъёолсон байдал, сурагчдын мэдлэг бүтээх үйл явцыг хэрхэн дэмжиж буй байдал, тухайн ангийн

сурагчдын хөгжлийн насыг оновчтой харгалзсан эсэх, тэдэнд ойлгомжтой энгийн, оновчтой, сурагчдыг сурах аргад сургаж буй байдал),

- **Хэрэглэгдэхүүн** (сургалтын хэрэглэгдэхүүнийг сонгосон байдал - мэдлэг бүтээх үйл явцыг дэмжиж буй эсэх, агуулгад нийцсэн эсэх, техник хэрэгсэл оновчтой ашигласан эсэх, самбарыг оновчтой ашигласан эсэх - хүүхдийн бодол санааг тусгаж буй эсэх),

- **Хугацаа** (сурагчдад санаа бодлоо амаар болон бичгээр илэрхийлэх хугацааг хангалттай өгсөн эсэх, цаг хуваарилалт оновчтой, уян хатан байгаа эсэх - дидактик алхмуудтай нийцэж байгаа эсэх, цагтаа багтсан эсэх),

- **Үнэлгээ дүгнэлт** (хичээлийн дүгнэлтээ оновчтой хүртээмжтэй сонгосон эсэх)-ийн талаар тус тус хэлэлцэж ярилцана.

Харин тодорхой зорилгоор 2-3 зүйлийг ажигласан хичээлийн хэлэлцүүлгийн ХҮВЬД:

- Заагч багшийн зүгээс санал болгосон тодорхой товлосон зүйл (жишээ нь)-ийг нарийвчлан ажиглаад, ахиц ололттой тал дээр нь түшиглэн цаашид хэрхэн засч сайжруулах гарцыг хамтдаа эрэлхийлнэ. (Лекц № 6-тай холбогдоно)


#### “Алдааны шинжилгээ”

- Сурагчдын алдааг судлах зорилготой.
- Японд “tsumazuki” /санаандгүй ямар нэг юманд бүдрэх, тээглэх гэсэн утгатай/ гэж нэрлэдэг.
- Сургалтын явцад хүүхдийн санамсаргүй гаргадаг хөнгөн алдааг биш, харин хүүхдийн ухамсарт зөв юм шиг ойлгогдсон буруу төсөөллийг судална гэсэн үг.

- Хэлэлцүүлэгт оролцож буй хүмүүс хүүхдийн алдааг хичээлээ дутуу ойлгосон байна гэж дүгнээд орхих биш тэр алдааны цаана байгаа шалтгааныг олохыг хичээж түүнд анализ хийж энэ алдааг яаж засаж болох талаар бодож тунгаах хэрэгтэй.

- Энэ тухайд, дэлхийд боловсролоор тэргүүлэгч зарим оронд сурагчдын алдааг судлах зорилготой “Алдааны шинжилгээ”-г хэрэглэдэг. Японд энэ судалгааг “tsumazuki” (санаандгүй ямар нэг юманд бүдрэх, тээглэх гэсэн утгатай) гэж нэрлэдэг ч сургалтын явцад хүүхдийн санамсаргүй гаргадаг хөнгөн алдааг биш, харин хүүхдийн ухамсарт зөв юм шиг ойлгогдсон буруу төсөөллийг судлах гэсэн утгатай. (“Монгол улсын хүүхдийн хөгжлийг дэмжих багшлах арга зүйн шинэчлэл” төслөөр гарсан VCD болон зөвлөмжүүдээс дэлгэрүүлж судлаарай)

#### Хэлэлцүүлгийн орчин, зохион байгуулалт



- Японд хэлэлцүүлгээ цуглааны өрөөнд хийдэг. Энэ нь манайд төдийлөн хэрэгжүүлэх боломжгүй ч хичээл анги танхимыг сайн зохицуулсан тохиолдолд хичээл заасан ангидаа (орчинд нь) хийх тохиромжтой байдаг нь туршилтын явцад ажиглагдсан.

- Хичээлийг зөвхөн шүүмжлэх бус бүтээлч санал, шийдэл гаргах нөхцөлийг бий болгох

орчныг бүрдүүлнэ. Тухайлбал, “...-Та яаж заах вэ? гэдэг асуудал дэвшүүлээд ирэхээр зэмлэх биш зөвлөн туслах, харилцан туршлага солилцох эерэг хандлагатай болсон...” тухай тайландаа тэмдэглэсэн байдаг. (СХД-ийн 67-р сургуулийн тайлангаас)

- Хэлэлцүүлэг хийх үед хөтлөгч багш заагч багшийн хажууд суух нь ямар нэг асуудал тулгамдахад бусдад саад болохгүйгээр түүнтэй ярилцах боломж олгох сайн талтай.

- Хэлэлцүүлгийн өмнө А1, А2 (төсөлт ажил), В1, В2 (төсөлт ажил), Г хуудас
- Хэлэлцүүлгийн явцад-Д хуудас

Ярих дараалал

- Заагч багш
- Ажиглагч багш нар
- Удирдлага \менежер, захирал\
- Зөвлөх багш

-Хэлэлцүүлэг эхлэхээс өмнө (барагцаалбал 10 минут) заагч багш “хичээл заасан багш өөрийн хичээлд үнэлгээ өгөх хуудас-А”-г, ажиглагч багш “ажиглагч хичээлд үнэлгээ өгөх хуудас-В”-г тус тус бөглөсөн байна.

- Хичээлийн явцын тэмдэглэл хөтлөх “Г” хуудас, хичээлийн хэлэлцүүлгийн тэмдэглэл хөтлөх “Д” хуудаст тэмдэглэсэн тэмдэглэлд үндэслэн тухайн хичээлийг үнэлж буй

үнэлгээний шалгуур болох багц, түүний үзүүлэлтүүдийг оноожуулна.

- Хичээлд үнэлгээ дүгнэлт өгөхдөө хичээлийн судалгаа хийж буй хамрах хүрээ болоод эргэх холбоотой мэдээлэл авах хэрэгцээ шаардлага, судалгааны зорилтдоо баримжаалан ямар түвшинд хэрхэн үнэлгээ өгөх вэ? гэдэг нь нээлттэй байна.


- Гэхдээ үр дүнг богино хугацаанд, нүдэнд харагдаж байгаа төдийхнөөр үнэлэхгүй байхыг хичээх хэрэгтэй.

- Хичээлийн зорилго зорилтоо сайн тодорхойлсон тохиолдолд зорилтоо биелүүлсэн эсэхийг нь гол шугамаа болгож ярина. Өөрөөр хэлбэл хэтэрхий хальж ярихгүй байх сайн талтай.

- ✓ Заагч багш эхлээд хичээлийнхээ зорилго зорилт, алдаа оноогоо ярина.
- ✓ Дараа нь ажиглагч багш нар (багийн багш нар, бусад багш, менежер) санал зөвлөгөөгөө хэлнэ.
- ✓ Хөтлөгч тухайн хичээлийн зорилго, зорилтын талаар тодорхой мэдээлэлтэй байж, хэлэлцүүлгийг үр ашигтай зохион байгуулахын тулд асуудал дэвшүүлж өрнүүлнэ.
- ✓ Багаар сууж хийсэн хөтөлбөрийг туршсаны дараа ийм алдааг хараагүй юм байна гэх мэтээр багаараа хариуцлага хүлээж чаддаг болсон нь багш нарт гарч байгаа сайн тал байлаа. (СХД-ийн 67-р сургуулийн тайлангаас)
- ✓ Эцэст нь зөвлөх багш дүгнэж ярина.

- ✓ Хэлэлцүүлгийн дараа баг болж ажилласан багш нар тусдаа уулзаж дахин хэлэлцээд, хичээлээ хэрхэн сайжруулахаа нухацтай ярилцана.

- Хичээлийн судалгаанд үнэлгээ өгөх нь гол биш.



- Бусад оронд хичээл ажиглалтын явцад 1 багш хичээлийн явцыг дэлгэрэнгүй тэмдэглэж, хэлэлцүүлэгт оролцогчдод олшруулж өгдөг байна. Энэ тохиолдолд оролцогчид түүн дээрээ шууд тэмдэглэж болно.

- Харин манайд нөхцөл байдлыг тооцож үзвэл, хичээлийн явцыг урт цаасан дээр (Факсын цаас илүү тохиромжтой байдаг.)

фломастераар, томоор харагдахуйц бичээд хэлэлцүүлэг хийх өрөөний хананд байрлуулах нь олон талын (хичээлийн аль хэсэгт ямар санал хэлэхээ баримжаалах, цаас, цаг хэмнэх, санал давхардуулалгүй ярих г.м.) ач холбогдолтой. Мөн хичээлийн явцад тухайн нөхцөл байдлаас шалтгаалаад хичээлийн хөтөлбөрөөс гадуур үйл ажиллагаа явагддаг тал байдаг. Үүнийг алдалгүй тэмдэглэж аваад хэлэлцүүлэгт ашиглах зэрэг ач холбогдолтой.

-Хэлэлцүүлэгт биечлэн оролцож амжихгүй (тухайн цагт хичээлтэй) багш нар хичээлийн яг аль хэсгийг сайжруулах талаар өөрийн санал, шийдэл, гарцаа цаасан дээр бичээд, яг тухайн хэсэгт нь наана.



Жишээ:

Хичээлийн явцыг урт цаасан дээр томоор харагдахуйц бичээд хэлэлцүүлэг хийх өрөөний хананд байрлуулсан байдал

(СХД-ийн 67-р сургууль, төсөлт ажлын хэлэлцүүлэг)

## Даалгавар

1. Өнөөдрийн лекцээ нэгтгэн дүгнэж багцлаад, ухагдахууны сүлжээ зохио.
2. Судалгаат хичээлийн хэлэлцүүлгийн үр дүнг “Хичээлийн хөгжил” гэсэн ойлголттой хэрхэн уялдуулах талаар саналаа нэгтгэ.

## Семинар 12. Хэлэлцүүлгийн орчин, хэлэлцүүлгийг удирдах

**Зорилго:** Хэлэлцүүлгийг ямар орчинд, хэрхэн зохион байгуулах арга зүйтэй танилцах

**Хугацаа:** 2 цаг (90 минут)

### Хэрэглэгдэхүүн:

- “Эргэдэг сэнс” хичээлийн хэлэлцүүлэг, видео бичлэг (Япон)
- “Ус уусмал” (суурь боловсрол) Сорил тооцоогоор мэдлэг бүтээлгэх аргазүй VCD, БСШУЯ Жайкагийн хамтарсан төсөл, 2009 он

**Бусад хэрэглэгдэхүүн:** Самбарын цаас, фломастер

### Удирдамж:

1. Сонирхлын бүлгээр баг бүрдүүлнэ. 5 минут
2. Багш, бичлэгээс хэлэлцүүлгийн орчин, зохион байгуулалтыг голлон анхаарахыг сануулж, тэмдэглэл хөтлөх зааварчилгаа өгнө 10 минут
3. “Эргэдэг сэнс” (Япон) хичээлийн хэлэлцүүлгийн видео бичлэг үзнэ. 10 минут
4. Багууд бичлэгээс хэлэлцүүлгийн орчин, зохион байгуулалтын талаар олж харсан зүйлүүдээ багцлах буюу утгын зураглал хийх аргаар тэмдэглэнэ. 10 минут
5. “Ус уусмал” хичээлийн хэлэлцүүлгийг үзүүлнэ. 10 минут
6. Бичлэгээс ажиглагч багш нар ямар дараалал, хандлагаар ярьж байгаад дүгнэлт хийж баримтын өгөгдөл цуглуулж, тэмдэглэл хөтөлнө. 10 минут
7. Багуудын дүгнэлтийг сонсож ярилцана. 60 минут
8. Багаараа ярилцан, ярих зүйлээ нэгтгээд, бусад багийнхандаа танилцуулна.
9. Энэ үед багш бичлэгийн шаардлагатай хэсгүүдийг давтан үзүүлнэ. Өөрөөр хэлбэл оюутнуудын олж хараагүй өнгөрсөн чухал хэсгүүдийг үзүүлнэ.
10. Бусад багийн тавьсан асуултад хариулж харилцан ярилцаж, санал солилцоно.

### Даалгавар.

1. Семинарын хичээлээр үзсэн хоёр хэлэлцүүлгийн видео бичлэгээс хичээлийн хэлэлцүүлэг явагдсан орчны ялгаатай болон төсөөтэй зүйлсийг ялгаж тодорхойлох

## Семинар 13. Хэлэлцүүлэгт оролцож судалгаат хичээлийн хуудас бөглөх

**Зорилго:** Хичээлийн хэлэлцүүлэгт бодотоор оролцож, судалгаат хичээлийн хуудсыг хэрхэн бөглөхтэй танилцах

**Хугацаа:** 2 цаг (90минут)

**Хэрэглэгдэхүүн:**

- “Зохион бичлэгийн бэлтгэл” Б.Нарантуяа, Ө.Хадаа видео бичлэг (жич: Багш өөрийн мэргэжлээр хийгдсэн видео ашиглаж семинарын хичээлээ зохион байгуулна)
- Ажиглагч хичээлд үнэлгээ өгөх хуудас В1

**Бусад хэрэглэгдэхүүн:** Самбарын цаас, факсын цаас, фломастер

**Удирдамж:**

1. Багш, хичээлийг бүхэлд нь ажиглаж тэмдэглэл хөтлөх талаар зааварчилгаа өгнө. 10 минут
2. Хэлэлцүүлгийн зохион байгуулалтаа тогтоно. 5 минут
  - Хичээлийн тухайн явцыг урт цаасан дээр бичих “багш”-аа сонгоно.
  - Багш хуваагдана.
  - Хичээлийн хэлэлцүүлгийг хэнээр хөтлүүлэхээ сонгоно.
3. “Зохион бичлэгийн бэлтгэл” видео үзүүлнэ (Семинар 11-ээ эргэн санаж, хичээлийг жинхэнэ багшийн байр сууринаас ажиглаж, тэмдэглэл хөтөлнө). 20 минут
4. Багууд гишүүдийнхээ тэмдэглэлээс баримтын өгөгдөл цуглуулах, хичээлийн талаар санаа бодлоо багцлах хүснэгт, хэлэлцүүлэгт бэлтгэх багийн ажлын нэгдсэн тэмдэглэл хийх хувилбаруудаас чөлөөтэй сонгон ашиглаж саналаа нэгтгэнэ. 10 минут
5. Багаараа нэгтгэсэн дүгнэлтээ үндэслэн В1 хуудсаа бөглөнө. (Ажиглагч хичээлд үнэлгээ өгөх хуудсыг баг тус бүрт нэгийг тарааж өгнө, Хэрхэн бөглөх талаар зааварчилгаа өгнө) 10 минут
6. Хэлэлцүүлгээ зохион байгуулна. 25 минут
  - Хэлэлцүүлэг эхлэхийн өмнө хичээлийн явцыг бичсэн урт цаасаа хананд байрлуулсан байна.
  - Хичээлийн аль хэсэгт юу ярихаа хананд байрлуулсан явцын тэмдэглэлээ харж төлөвлөнө
  - Оролцогчид хэлэлцүүлэг дээр ярихдаа лекцээр үзсэн оновчтой дарааллын дагуу ярина.
  - Бичлэгийн шаардлагатай хэсгүүдийг давтан үзүүлнэ.
  - Багш зөвлөх багшийн байр сууринаас оролцоно.
  - Хэлэлцүүлгээр яригдаж буй гол санааг багш самбарын цаасан дээр дараах байдлаар зэрэг бичиж явна.

| Олж харсан алдаа | Гарах арга зам (гарц, гаргалгаа, шийдэл) |
|------------------|------------------------------------------|
|                  |                                          |

7. Хэлэлцүүлгээс хамгийн чухал асуудлыг тодорхойлох 10 минут
  - Хичээлийн хэлэлцүүлэгт хамгийн чухал гэсэн зүйлээ үзэг шилжүүлэн бичих аргаар том цаасан дээр дамжуулан бичнэ.
  - Эдгээрээс хамгийн чухал гэсэн 3 зүйлийн өмнөх дугаарыг дугуйлж, түүнээсээ 2-ыг, 2-оосоо чухлын чухал 1-ийг сонгож ЯАГААД сонгосноо дүгнэн ярилцана.

## Даалгавар:

2. Хэлэлцүүлгээс суралцсан зүйлсийн жагсаалт гаргах

### ТӨМ 13.1. Ажиглагч хичээлд үнэлгээ өгөх хуудас

| Үнэлгээний шалгуур үзүүлэлт |    |                                                                                                                                                                           | Үнэлгээ |   |   |   |   | Үнэлгээний бодит шалтгаан |
|-----------------------------|----|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|---------|---|---|---|---|---------------------------|
| <b>Эхлэл Удиртгал</b>       | 1  | Сэдэл төрүүлж сонирхол татсан байдал                                                                                                                                      | 5       | 4 | 3 | 2 | 1 |                           |
|                             | 2  | Хичээлийн зорилтыг дэвшүүлсэн байдал                                                                                                                                      | 5       | 4 | 3 | 2 | 1 |                           |
| <b>Агуулга</b>              | 3  | Хичээл болон сэдэв хоорондын залгамж холбоог хангасан байдал                                                                                                              | 5       | 4 | 3 | 2 | 1 |                           |
|                             | 4  | Амьдралтай холбосон байдал (түүх, соёл)                                                                                                                                   | 5       | 4 | 3 | 2 | 1 |                           |
|                             | 5  | Агуулгын оновчтой байдал (энгийн, нас сэтгэхүйн онцлогт тохирсон эсэх)                                                                                                    | 5       | 4 | 3 | 2 | 1 |                           |
| <b>Арга зүй</b>             | 6  | Сургалтын аргыг сонгосон байдал                                                                                                                                           | 5       | 4 | 3 | 2 | 1 |                           |
|                             | 7  | Багшийн асуултаа томъёолсон байдал (мэдлэг бүтээх үйл ажиллагааг дэмжиж байгаа эсэх, сурагчдад ойлгомжтой, оновчтой, энгийн)                                              | 5       | 4 | 3 | 2 | 1 |                           |
|                             | 8  | Суралцагчдыг сурах аргад сургаж байгаа байдал                                                                                                                             | 5       | 4 | 3 | 2 | 1 |                           |
| <b>Хэрэглэгч дэхүүн</b>     | 9  | Сургалтын хэрэглэгдэхүүнийг сонгосон байдал (мэдлэг бүтээхэд дэмжлэг болж байгаа эсэх, агуулгад нийцсэн эсэх, суралцагчдад ойлгомжтой, хүртээмжтэй эсэх)                  | 5       | 4 | 3 | 2 | 1 |                           |
|                             | 10 | Сургалтын хэрэглэгдэхүүний шаардлага хангасан байдал (өнгө, хэмжээ, харагдах байдал, аюулгүй ажиллагааг хангасан эсэх)                                                    | 5       | 4 | 3 | 2 | 1 |                           |
|                             | 11 | Самбарыг хичээлийн агуулга, сурагчдын мэдлэг бүтээх үйл ажиллагааг холбохуйцаар хөтөлсөн байдал (хүүхдийн бодол санааг тусгаж байгаа эсэх)                                | 5       | 4 | 3 | 2 | 1 |                           |
|                             | 12 | Суралцагчид хичээлийн тэмдэглэлийг хөтөлж байгаа байдал                                                                                                                   | 5       | 4 | 3 | 2 | 1 |                           |
| <b>Хугацаа</b>              | 13 | Цаг хуваарилалт (дидактик алхмуудтай нийцэж байгаа эсэх, цагтаа багтсан эсэх)                                                                                             | 5       | 4 | 3 | 2 | 1 |                           |
|                             | 14 | Сурагчдад бодох хугацаа хангалттай өгч байгаа эсэх, хариулт ирэх хугацааг тохируулж байгаа байдал                                                                         | 5       | 4 | 3 | 2 | 1 |                           |
| <b>Харилцаа</b>             | 15 | Багш, сурагчийн суралцах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж буй байдал (нийт сурагчдад хүртээмжтэй эсэх, сурагчийн санал бодол, хариулт сонголтонд хүндэтгэлтэй хандсан эсэх) | 5       | 4 | 3 | 2 | 1 |                           |
|                             | 16 | Сурагчийн буруу ойлгосон тохиолдолд багшийн зүгээс учир шалтгааныг анзаарч байгаа байдал                                                                                  | 5       | 4 | 3 | 2 | 1 |                           |
|                             | 17 | Суралцагчдын бие даан болон хамтран ажиллаж байгаа байгаа байдал                                                                                                          | 5       | 4 | 3 | 2 | 1 |                           |
| <b>Үнэлгээ дүгнэлт</b>      | 18 | Үнэлгээний хэлбэрийг оновчтой сонгосон байдал (бодитой хүртээмжтэй)                                                                                                       | 5       | 4 | 3 | 2 | 1 |                           |
|                             | 19 | Хичээлийн дүгнэлтийг оновчтой сонгосон байдал (бодитой, хүртээмжтэй)                                                                                                      | 5       | 4 | 3 | 2 | 1 |                           |
|                             | 20 | Суралцагчдын сэтгэл хангалуун байдал                                                                                                                                      | 5       | 4 | 3 | 2 | 1 |                           |

## БИЕ ДААХ АЖИЛ

1. Түшиц, загвар сургуулиудын судалгаат хичээлийн хэлэлцүүлэг хийдэг туршлагатай биечлэн танилцаж мэдээлэл цуглуулан, боловсруулалт хийж бусдадаа хүртээл болгох

## Хичээлийн судалгааны үр дүнг хичээлийн арга зүйг сайжруулан хөгжүүлэхэд хэрэглэх нь

| Хичээлийн хэлбэр, цаг | Агуулга                                                                                                                                                                                                                               | Хэрэглэг дэхүүн                 | Бие даах ажил       |
|-----------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|---------------------------------|---------------------|
| Лекц 8 /2 ц/          | <ul style="list-style-type: none"> <li>Хичээлийн хөтөлбөрийг сайжруулах</li> <li>Агуулга сайжруулахад хэрэглэх</li> <li>Арга зүй, дидактик шийдлийг сайжруулахад хэрэглэх</li> <li>Хэрэглэгдэхүүнийг сайжруулахад хэрэглэх</li> </ul> | ppt                             | Өөрийн үнэлгээ хийх |
| Семинар 14, 15 /4 ц/  | <ul style="list-style-type: none"> <li>Ажиглалтын тэмдэглэл, хэлэлцүүлгийн дүнг үндэслэн судалгаат хичээлийн хөтөлбөрийг сайжруулах үндэслэлийг тодорхойлох, хөтөлбөрийг сайжруулах</li> </ul>                                        | Өмнөх семинарын бүтээгдэхүүнүүд |                     |
| Семинар 16 /2 ц/      | <ul style="list-style-type: none"> <li>Хичээлийн судалгааны үндсэн алхам, хичээлийн судалгаа ба судалгаат хичээл, хичээлийн бэлтгэл судалгаа</li> </ul>                                                                               |                                 |                     |

### Лекц 8: Хичээлийн судалгааны үр дүнг хичээлийн арга зүйг сайжруулан хөгжүүлэхэд хэрэглэх нь<sup>2</sup> /2 цаг/

Хичээлийн судалгааны үр дүнг арга зүйн хөгжилд хэрэглэх асуудлыг үндсэн хэд хэдэн түвшинд, хэрэглэгчээс (сургуулийн удирдлага, хамтлаг, хувь багш, судлаач), хугацаанаас хамааруулан олон талаас нь авч үзэж болох юм. Тухайлбал,

1. Хэлэлцүүлгийн үр дүнгээр хичээлийн хөтөлбөр сайжруулах;
2. Хичээлийн судалгаагаар багшлах арга зүйг хөгжүүлэх, хүнд сэдвийг заах дидактик шийдлийг боловсруулах;
3. Хичээлийн судалгаагаар сургуулийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэх гэсэн гурван түвшинд авч үзэж болно. Энэ хичээлийн хувьд эхний түвшин буюу Хэлэлцүүлгийн үр дүнгээр хичээлийн хөтөлбөр сайжруулах талаар авч үзье.




Хичээлийн хөтөлбөрийг сайжруулахад баримтлах ёстой үндсэн зарчим дараалал нь ажиглалтын үед цуглуулсан баримт өгөгдөлд хийсэн анализ, тодорхойлсон шалтгаанд үндэслэсэн, үнэхээр хичээлийн төлөвлөлтийг сайжруулахад зайлшгүй саналыг дэвшүүлэхэд оршино. Нэг талаас, нэгэнт багш бүрийн арга зүй харилцан адилгүй тул бүх багш ганцхан арга зүйг хэрэгжүүлэх

<sup>2</sup> Тухайн мэргэжлийн хичээлээр ЕБС дээр хичээлийн судалгаа хийсэн, хэлэлцүүлгийн үр дүнг үндэслэн хичээлийн хөтөлбөрийг сайжруулсан, түүнчлэн сайжруулах болсон үндэслэл шалтгаанаа тодорхой бичиж тэмдэглэсэн бодит жишээ урьдчилан бэлтгэсэн байхыг багшаас шаардах болно.

боломжгүй. Нөгөө талаас, тухайн хичээлийн зорилго, сурагчдын онцлог, багшийн арга зүйн онцлог зэргийг тооцохгүйгээр зөвхөн “өөрийн” арга барилдаа тулгуурласан, хэт ерөнхий сайжруулах санал нь хичээлийн судалгааны үндсэн зорилгод нийцэхгүй.

Лекц 6, Семинар 10, 11-ээр хичээлийг ажиглах, ажиглалтын явцад баримт өгөгдлийг хэрхэн яаж бүрдүүлэх талаар авч үзээд, дараагийн Лекц 7, Семинар 12, 13-аар хэлэлцүүлэг хийх арга барилд суралцсан. Хэлэлцүүлэгт оролцож буй багш нар өөр өөрийн санал шүүмжлэлийг чөлөөтэй илэрхийлж, хичээлийг сайжруулах олон хувилбартай саналыг дэвшүүлдэг. Хэлэлцүүлгийн үр дүнг үндэслэн хичээлийн хөтөлбөрийг сайжруулахад бүх хичээлд тохирсон тодорхой аргачлал байдаггүй, байх ч боломжгүй юм. Гэвч хэлэлцүүлгийн үр дүнг үндэслэн хичээлийн хөтөлбөрийг сайжруулахдаа ажиглагдсан сул тал, тухайн сул тал гарах болсон шалтгаанд үндэслэсэн байх зарчмыг баримтлах нь зүйтэй юм.



Нөгөө талаас, ажиглалт хэлэлцүүлгийн үед цугларсан баримт өгөгдөл хийсэн шинжилгээний дүнд тухайн асуудлын шалтгааныг илүү бодитой тодорхойлж улмаар сайжруулах арга замыг боловсруулж чадна.

Агуулга, арга зүй, хэрэглэгдэхүүнийг сайжруулах гэдгийг нэг мөр зааглан авч үзэх боломжгүй бөгөөд харилцан маш нарийн уялдаатай байдаг учраас хэдийгээр тус тусад нь авч үзэн тайлбарлаж байгаа хэдий ч хичээлийн хөтөлбөрийг бодотоор сайжруулахад хамтдаа хийгддэг үйл юм.

Хэлэлцүүлгийн үр дүнг тусган хичээлийн хөтөлбөрийг сайжруулсан байдлыг төслийн 1-р шатанд Химийн мэргэжлийн багаас боловсруулсан “Контекстэд суурилан мэдлэг бүтээлгэх арга зүй” зөвлөмж III-аас авсан жишээгээр тайлбарлая. Бусад зөвлөмжүүдэд энэ мэт жишээ хангалттай байгаа болно.

#### **а. Агуулгыг сайжруулах**

| Агуулгыг сайжруулах                        |                                       |                                         |                   |
|--------------------------------------------|---------------------------------------|-----------------------------------------|-------------------|
|                                            | Ажиглалтаар цуглуулсан баримт өгөгдөл | Баримт өгөгдөлд хийсэн шинжилгээний дүн | Сайжруулах боломж |
| Агуулгын багтаамж                          |                                       |                                         |                   |
| Өмнөх ба дараах холбоо                     |                                       |                                         |                   |
| Сурагчийн хөгжлийн түвшинд тохирсон байдал |                                       |                                         |                   |

Агуулгыг сайжруулахдаа агуулгын багтаамж, өмнөх ба дараах хичээлийн залгамж холбоо, сурагчийн хөгжлийн түвшинд тохирсон эсэх тухай зэрэг асуудлыг авч үзье. Тухайн хичээлээр судалсан судлагдахууны агуулгын багтаамж ихдэх, багадах, тохирох гэсэн гурван төрлийн баримтыг ажиглалтаар илрүүлэх боломжтой ч манай практикт

ихэнхдээ “агуулгын багтаамж ихэдсэн” байх нь түгээмэл байдаг. Агуулгын багтаамж ихэдсэний шалтгаан нь харилцан адилгүй бөгөөд тийм, тийм шалтгаан байдаг гээд хатуу томъёолох боломжгүй гэдэг нь мэдээж юм. Гэвч зарим нэг нийтлэг байдаг шалтгааныг нэрлэе. Жишээ нь, үнэхээр агуулгын багтаамжийг хэтрүүлэн төлөвлөсөн байж болно. Эсвэл зайлшгүй чухал ач холбогдолгүй хэрнээ хугацаа их шаардсан үйл ажиллагаа төлөвлөгдсөн байж болно. Мөн элементарчлал зэрэг дидактик боловсруулалт дутуу хийгдсэнээс шинжлэх ухааны хувьд хүнд агуулгатай шаардлагагүй зүйл тусгагдсан байж болно. Дараах хүснэгтээс зарим нэг бодит жишээг харж болно.

**“Контекстэд суурилан мэдлэг бүтээлгэх арга зүй” зөвлөмж III-ийн 1.2.7-р хүснэгтээс (Агуулгыг сайжруулсан хэсгээс)**

| Ямар сул талыг яаж сайжруулсан бэ?                                                                                                                                                                                                                                                                                       | Яагаад ийнхүү сайжруулах болсон бэ?                                                                                                                                                                                                             |
|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| <b>Сэдэлжүүлэх хэсэгт</b>                                                                                                                                                                                                                                                                                                |                                                                                                                                                                                                                                                 |
| Гал унтраагуурын төрөл, ангид байгаа гал унтраагуурын талаарх сурагчдын өмнөх төсөөллийг судлах хэсгийг багш өөрөө зохицуулахаар ерөнхий болголоо                                                                                                                                                                        | Тухайн орон нутгийн сурагчдын туршлага, өмнөх мэдлэг харилцан адилгүй бөгөөд үүнийг багш нь хамгаас сайн мэдэж байгаа                                                                                                                           |
| <b>Мэдлэг бүтээх</b>                                                                                                                                                                                                                                                                                                     |                                                                                                                                                                                                                                                 |
| Сурагчдыг багт хуваах үйлдлийг төлөвлөлтөд оруулсан                                                                                                                                                                                                                                                                      | Сурагчдыг багт хуваах олон аргууд байдаг. Багт хуваахад тодорхой цаг, арга хэрэгтэй                                                                                                                                                             |
| <ul style="list-style-type: none"> <li>❖ Гал унтраагуурын бүтцийг сурагчдын өөрсдийнх нь бэлтгэсэн хялбар гал унтраагууртай харьцуулална.</li> <li>❖ Багш өөрийн танилцуулсан болон сурагчдын хийсэн хялбар гал унтраагуурын бүтцийг зуруулна гэсэн үйлдлүүдийг гэрийн даалгаварт оруулж өгсөн</li> </ul>                | Энэ хоёр үйл ажиллагаа хичээлийн энэ хэсэгт ач холбогдол багатай, цаг их орсон үйл тул сурагчдад ярих, бичих бусад үйл ажиллагаанд зарцуулах цаг бага гарч байсан                                                                               |
| <ul style="list-style-type: none"> <li>• Жинхэнэ болон хялбар гал унтраагуурыг хэрэглэхэд гал яагаад унтарч байгаа шалтгаан, ажиллах зарчмыг багшид нэмэлтээр зөвлөж орууллаа.</li> <li>• Гарын доорхи материал ашиглан <b>ТӨМ 1.1-д</b> үзүүлсэн бүтэц бүхий гал унтраагуур хийж болохыг багшид зөвлөж өгсөн</li> </ul> | <ul style="list-style-type: none"> <li>• Гол хими сэтгэлгээ хэрэглэх хэсэг нь юу вэ? гэдэг нь тодорхойгүй төлөвлөгдсөн</li> <li>• Ангид хийж буй хялбар гал унтраагуурын ажиллах зарчим нь жинхэнэ гал унтраагуураас ялгаатай байгаа</li> </ul> |
| Химийн урвалын тэгшитгэлтэй ажиллах мэдээлэл 1,2-ийг бэлнээр өгч багш сурагчид ярилцахаар төлөвлөлтийг өөрчилсөн.                                                                                                                                                                                                        | <ul style="list-style-type: none"> <li>• Гал унтраах үед явагдах химийн урвалын тэгшитгэлийг бичүүлэх хэсэгт сурагчдын сэтгэн бодох боломж, цаг хомс</li> <li>• Нимбэгний хүчлийн томъёо нийлмэл тул</li> </ul>                                 |
| <b>Бататгал</b>                                                                                                                                                                                                                                                                                                          |                                                                                                                                                                                                                                                 |
| <ul style="list-style-type: none"> <li>• Гал унтраагуурын бүтэц, ажиллах зарчмыг сурагчдын өөрсдийнх нь бэлтгэсэн хялбар гал унтраагуурынхтай харьцуулж ярилцана.</li> <li>• Хийсэн гал унтраагуурын давуу ба сул талыг ярилцахаар төлөвлөлт хийсэн</li> </ul>                                                           | <ul style="list-style-type: none"> <li>• Хичээлээр олсон мэдлэгээ бүгдийг нэгтгэн авч үзэх тал дээр бага анхаарсан байсан</li> <li>• Сурагчид өөрсдийн хийсэн гал унтраагуураа үнэлэх талыг орхигдуулсан гэж үзсэн</li> </ul>                   |
| <b>Гэрийн даалгавар</b>                                                                                                                                                                                                                                                                                                  |                                                                                                                                                                                                                                                 |
| Жинхэнэ ба хялбар гал унтраагуурын ажиллах зарчмын ялгааг илүү мэдүүлэх, дараагийн хичээлийн бэлтгэл болгож 2 асуулт даалгавар оруулсан                                                                                                                                                                                  | <ul style="list-style-type: none"> <li>• Үнэлгээгээр 2 гал унтраагуурын ажиллах зарчмын ялгаа ойлгомжгүй болох нь олонтоо илэрч байсан</li> <li>• Хичээл хоорондын залгамж холбоо төлөвлөлтөөс харагдахгүй байсан</li> </ul>                    |

Хичээлийн агуулга сурагчдын хөгжлийн түвшинд тохирсон байх эсэх нь олон талтай асуудал юм. Мэдээж энд сурган хүмүүжүүлэх ухааны үүднээс хэдэн настай хүүхэд ямар сэтгэхүйн үйл ажиллагааны онцлогтой байдгийг тооцох асуудал багтана. Мөн түүнчлэн тухайн хичээлийн үед хэрэглэсэн хэрэглэгдэхүүн, сургалтын арга “цоо шинэ” байх зэрэг нь заримдаа сонгосон

агуулгыг сурагчид хүлээн авах үйл ажиллагаанд нөлөөлдөг. Тиймээс судалгаат хичээл явуулсан ангийн сурагчдад тохируулан сайжруулсан агуулга дараагийн анги бүлэгт бүрэн дүүрэн нийцнэ гэдэг баталгаа байхгүй гэсэн үг. Хичээлийн судалгааг хангалттай хэмжээгээр хийгээд тодорхой туршлага хуримтлуулсан багш өөрийн сурагчдад “хийсэн” мэдлэг эзэмшилтийн явцын болон алдааны судалгааны дүнтэй хичээлийн ажиглалт, хэлэлцүүлгийн үр дүнг хавсран хэрэглэх нь агуулгыг сайжруулахад чухал юм.

Агуулгыг сайжруулна гэдэг нь хэлэлцүүлгийн үр дүнд үндэслэн өмнө хийгдсэн судлагдахууны агуулгын судалгааны үр дүнг дахин сайжруулна гэсэн үг.

#### **б. Арга зүй, дидактик шийдлийг сайжруулах**

| <b>Арга зүй, дидактик шийдлийг сайжруулах</b> |                                       |                                         |                   |
|-----------------------------------------------|---------------------------------------|-----------------------------------------|-------------------|
|                                               | Ажиглалтаар цуглуулсан баримт өгөгдөл | Баримт өгөгдөлд хийсэн шинжилгээний дүн | Сайжруулах боломж |
| Асуултын томъёолол                            |                                       |                                         |                   |
| Сурагчдын гүйцэтгэх үйл ажиллагаа             |                                       |                                         |                   |
| Идэвхтэй сургалтын арга                       |                                       |                                         |                   |

Багшийн тавьж буй асуулт маш зөв томъёологдсон байх нь дидактик шийдэлд чухал үүрэгтэй. Асуултыг хасах уу, өөрчлөн найруулах уу, аль эсвэл асуултын тавилаа өөрчлөх үү гэх мэтээр асуултын томъёололтой холбоотой сайжруулах олон арга замууд байж болно. Зарим тохиолдолд сурагчдаас ирж болох зөв болон алдаатай хариултын боломжит хувилбарыг нэмж тооцох шаардлага гардаг. Хамтран

төлөвлөсөн хичээлийн төлөвлөлтөд заримдаа аль нэг гишүүний боловсруулж оруулсан асуултыг хичээл зааж байгаа багш өөрийнхөөрөө, өөр өнцгөөр ойлгож асуух нь ч байдаг. Тиймээс тухайн асуултаар сурагчдаас ямар хариулт авахыг зорьсон, эсвэл юуны төлөө энэ асуултыг асууж байгаагаа багш зөв илэрхийлж чадсан эсэхээс яаж сайжруулах вэ? гэдэг шийдэл хамаарна. Дараах хүснэгтээс асуултыг сайжруулсан зарим нэг жишээг харж болно.

#### **“Контекстэд суурилан мэдлэг бүтээлгэх арга зүй” зөвлөмж III-ийн 1.2.7-р хүснэгтээс (Асуултыг сайжруулсан хэсэг)**

| Ямар сул талыг яаж сайжруулсан бэ?                                                                                                                                                                                                                                                           | Яагаад ийнхүү сайжруулах болсон бэ?                                                                                                                                                                                                                                                                       |
|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| <b>Сэдэлжүүлэх хэсэгт</b>                                                                                                                                                                                                                                                                    |                                                                                                                                                                                                                                                                                                           |
| Энэ юу вэ?<br>Ямар зориулалттай вэ? гэсэн асуултыг хассан.                                                                                                                                                                                                                                   | Энэ насны сурагчдын танин мэдэхүйн түвшинд хөнгөдсөн гэж үзлээ.                                                                                                                                                                                                                                           |
| <b>Мэдлэг бүтээх</b>                                                                                                                                                                                                                                                                         |                                                                                                                                                                                                                                                                                                           |
| Анги дахь гал унтраагуураар гал унтраах үед ямар бодис голлон оролцож байна вэ? гэдэг асуултад сурагчдын хариулах хувилбарыг гүйцээж оруулсан. Үүнд:<br><i>Нүүрсхүчлийн хий, хөөс үүсгэгч бодис, ус, нүүрсхүчлийн хий ба хөөс үүсгэгч бодис</i>                                              | <ul style="list-style-type: none"> <li>Энэ асуултад сурагчдын хариулах хариултын хувилбар болон аль нь яг оновчтой хариулт вэ? гэдэг нь химийн багш нарт төвөгтэй бөгөөд ойлгомжгүй байсан</li> <li>Нүүрсхүчлийн хий ба хөөс үүсгэгч бодис гэсэн зөв хариултыг төлөвлөлтөд тодруулаагүй байсан</li> </ul> |
| Хялбар гал унтраагуураар гал унтраахад ямар бодис голлон оролцож байна вэ? гэсэн асуулт, түүний хариулт,<br><i>(Нүүрсхүчлийн хий ба ус оролцож байгаа)</i><br>Хялбар гал унтраагуур хэрхэн ажиллаж байна вэ? гэсэн асуулт, түүний хариултыг тодруулж төлөвлөсөн. <i>(Даралтын нөлөөгөөр)</i> | Хялбар гал унтраагуурын бүтэц, ажиллах зарчим, гал унтраахад оролцож буй бодисын ялгаа байгаа эсэх нь бүдэг, ойлгомжгүй байсан                                                                                                                                                                            |

Багшийн өгсөн аргачлал, ТӨМ-ын бүтэц, зургийн харагдах байдал зэрэг нь сурагчдын гүйцэтгэх үйл ажиллагаанд ихээр нөлөөлдөг. Сурагчдын үйл ажиллагаанд бодит дэмжлэг болохын тулд арга зүй, дидактик шийдэлд хийх сайжруулалт нь нэлээд өргөн хүрээг хамардаг. Дараах хүснэгтээс сурагчдын гүйцэтгэх үйл ажиллагааг хэрхэн сайжруулсан жишээг харж болно.

**“Контекстэд суурилан мэдлэг бүтээлгэх арга зүй” зөвлөмж III-ийн 1.2.7-р хүснэгтээс (Сурагчдын гүйцэтгэх үйл ажиллагааг сайжруулсан хэсэг)**

| Ямар сул талыг яаж сайжруулсан бэ?                                                                                                                                                                                                                                                                                                                      | Яагаад ийнхүү сайжруулах болсон бэ?                                                                                                                                                                                                                             |
|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| <b>Мэдлэг бүтээх</b>                                                                                                                                                                                                                                                                                                                                    |                                                                                                                                                                                                                                                                 |
| Сурагчдыг багт хуваах үйлдлийг төлөвлөлтөд оруулсан.                                                                                                                                                                                                                                                                                                    | Сурагчдыг багт хуваах олон аргууд байдаг. Багт хуваахад тодохой цаг, арга хэрэгтэй.                                                                                                                                                                             |
| <u>Зурган мэдээлэлтэй ажиллах хэсэгт:</u><br>А. Зурган мэдээлэлтэй ажиллах үйл ажиллагааг судлагдахууных нь агуулгаар 2 ангилж өгсөн. Бүтцийн хэсэг ТӨМ 1.1а, ажиллах зарчмын хэсэг ТӨМ 1.1б<br>Б. Зургийн а) хэсгийг ажиглуулж, гал унтраагуурын үндсэн хэсгийг нэрлүүлнэ.<br>Зургийн б) хэсгийг ажиглуулж, галын хорын ажиллах зарчмыг тайлбарлуулна. | <ul style="list-style-type: none"> <li>Бүтэц болон ажиллах зарчмын мэдээлэл нэг ТӨМ-д холилдон орсон тул сурагчид зорилгоо ухаарах, ялган салгахад бэрхшээлтэй болсон байна.</li> <li>Тухайн зурган мэдээлэл дээр яаж ажиллах нь тодорхой биш байна.</li> </ul> |
| Гал унтраагуурын бүтэц, ажиллах зарчмыг бодит үйл ажиллагаагаар мэдэх, галын хорыг ашиглаж чаддаг болохын тулд хялбар гал унтраагуурыг хийцгээе гэж хичээлийн зорилгыг тодруулсан.                                                                                                                                                                      | Яагаад гал унтраагуур хийх болсон нь тодорхой биш байсан.                                                                                                                                                                                                       |
| Сурагчид гал унтраагуур хийх явцын багшийн үйл ажиллагааг тодруулан төлөвлөсөн                                                                                                                                                                                                                                                                          | Багш ямар үе шатад сурагчдад туслах, шалгах нь чухал болох нь ойлгомжгүй байсан.                                                                                                                                                                                |
| Химийн урвалын тэгшитгэлтэй ажиллах мэдээлэл 1,2-ийг бэлнээр өгч багш сурагчид ярилцахаар төлөвлөлтийг өөрчилсөн.                                                                                                                                                                                                                                       | <ul style="list-style-type: none"> <li>Гал унтраах үед явагдах химийн урвалын тэгшитгэлийг бичүүлэх хэсэгт сурагчдын сэтгэн бодох боломж, цаг хомс</li> <li>Нимбэгний хүчлийн томъёо нийлмэл тул</li> </ul>                                                     |
| <b>Бататгал</b>                                                                                                                                                                                                                                                                                                                                         |                                                                                                                                                                                                                                                                 |
| <ul style="list-style-type: none"> <li>Гал унтраагуурын бүтэц, ажиллах зарчмыг сурагчдын өөрсдийнх нь бэлтгэсэн хялбар гал унтраагуурынхтай харьцуулж ярилцана.</li> <li>Хийсэн гал унтраагуурын давуу ба сул талыг ярилцахаар төлөвлөлт хийсэн.</li> </ul>                                                                                             | <ul style="list-style-type: none"> <li>Хичээлээр олсон мэдлэгээ бүгдийг нэгтгэн авч үзэх тал дээр бага анхаарсан байсан.</li> <li>Сурагчид өөрсдийн хийсэн гал унтраагуураа үнэлэх талыг орхигдуулсан гэж үзсэн.</li> </ul>                                     |

Арга зүй, дидактик шийдлийг сайжруулна гэдэг нь хэлэлцүүлгийн үр дүнд үндэслэн өмнө хийгдсэн багшлах арга барилын судалгааны үр дүнг дахин сайжруулна гэсэн үг.

**в. Хэрэглэгдэхүүнийг сайжруулах**

| Хэрэглэгдэхүүнийг сайжруулах      |                                       |                                         |                   |
|-----------------------------------|---------------------------------------|-----------------------------------------|-------------------|
|                                   | Ажиглалтаар цуглуулсан баримт өгөгдөл | Баримт өгөгдөлд хийсэн шинжилгээний дүн | Сайжруулах боломж |
| Хэрэглэгдэхүүний агуулга, тохироц |                                       |                                         |                   |
| Суралцахуйг дэмжих байдал         |                                       |                                         |                   |
| Шаардлага хангасан байдал         |                                       |                                         |                   |

Хэрэглэгдэхүүний зарим төрөл, тухайлбал үзүүлэн, зургийн харагдах байдал, өнгөний зохицол зэргийг сайжруулах шаардлагатай байгааг ажиглалтаар илрүүлэх харьцангуй хялбар байдаг. Гэхдээ түүнийг сайжруулахад зарим хичээлийн хувьд мэргэжлийн, аргын, технологийн, аюулгүй ажиллагааны гээд олон зүйлийг тооцож үзэх хэрэгтэй болдог. Жишээлбэл, химийн үзүүлэх туршлагад үзэгдэх байдлыг нэмэгдүүлэхийн тулд урвал

явуулах шил савыг томруулах боломжгүй байдаг. Мөн биологийн үзэгдэл явц урт хугацаанд ажиглалт хийхийг шаардах тохиолдол байдаг. ТӨМ-ийн боловсруулалт нь тухайн хичээлийн арга зүй дидактик шийдэлтэй нягт

холбоотой байдаг учраас сурагчийн ажиллах хэсгийн зай хэмжээг тохируулах, зураг, бүдүүвчийн харагдах байдлыг сайжруулах зэргээс гадна ихэнх тохиолдолд арга зүйн шинжтэй өөрчлөлт хийгддэг. Дараах хүснэгтэд хэрэглэгдэхүүний сайжруулалтын зарим жишээг ялгаж үзүүлэв.

**“Контекстэд суурилан мэдлэг бүтээлгэх арга зүй” зөвлөмж III-ийн 1.2.7-р хүснэгтээс (Хэрэглэгдэхүүнийг сайжруулсан хэсэг)**

| Ямар сул талыг яаж сайжруулсан бэ?                                                                                                                                                                                                                                                                                                                                            | Яагаад ийнхүү сайжруулах болсон бэ?                                                                                                                                                                                                                                                                                                                                                    |
|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| <b>Мэдлэг бүтээх</b>                                                                                                                                                                                                                                                                                                                                                          |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                        |
| <u>Зурган мэдээлэлтэй ажиллах хэсэгт:</u><br>А. Зурган мэдээлэлтэй ажиллах үйл ажиллагааг судлагдахууных нь агуулгаар 2 ангилж өгсөн. Бүтцийн хэсэг ТӨМ 1.1а, ажиллах зарчмын хэсэг ТӨМ 1.1б<br>Б. Зургийн а) хэсгийг ажиглуулж, гал унтраагуурын үндсэн хэсгийг нэрлүүлнэ.<br>Зургийн б) хэсгийг ажиглуулж, галын хорын ажиллах зарчмыг тайлбарлуулна.                       | <ul style="list-style-type: none"> <li>Бүтэц болон ажиллах зарчмын мэдээлэл нэг ТӨМ-д холилдон орсон тул сурагчид зорилгоо ухаарах, ялган салгахад бэрхшээлтэй болсон байна.</li> <li>Тухайн зурган мэдээлэл дээр яаж ажиллах нь тодорхой биш байна.</li> </ul>                                                                                                                        |
| Гал унтраагуурыг бэлтгэх болон, ажиллах зарчмыг тайлбарлуулах хэсгийн мэдээллийг төлөвлөлт хэсгээс авч ТӨМ болгож оруулсан<br>Анги дахь гал унтраагуураар гал унтраах үед ямар бодис голлон оролцож байна вэ? гэдэг асуултад сурагчдын хариулах хувилбарыг гүйцээж оруулсан. Үүнд:<br><i>Нүүрсхүчлийн хий, хөөс үүсгэгч бодис, ус, нүүрсхүчлийн хий ба хөөс үүсгэгч бодис</i> | <ul style="list-style-type: none"> <li>Мэдээлэлтэй хэрхэн ажиллах зарчим нь багшид ойлгомжгүй төлөвлөгдсөн</li> <li>Энэ асуултад сурагчдын хариулах хариултын хувилбар болон аль нь яг оновчтой хариулт вэ? гэдэг нь химийн багш нарт төвөгтэй бөгөөд ойлгомжгүй байсан</li> <li>Нүүрсхүчлийн хий ба хөөс үүсгэгч бодис гэсэн зөв хариултыг төлөвлөлтөд тодруулаагүй байсан</li> </ul> |
| Химийн урвалын тэгшитгэлтэй ажиллах мэдээлэл 1,2-ийг бэлнээр өгч багш сурагчид ярилцахаар төлөвлөлтийг өөрчилсөн.                                                                                                                                                                                                                                                             | <ul style="list-style-type: none"> <li>Гал унтраах үед явагдах химийн урвалын тэгшитгэлийг бичүүлэх хэсэгт сурагчдын сэтгэн бодох боломж, цаг хомс</li> <li>Нимбэгний хүчлийн томьёо нийлмэл тул</li> </ul>                                                                                                                                                                            |
| <b>Бататгал</b>                                                                                                                                                                                                                                                                                                                                                               |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                        |
| <ul style="list-style-type: none"> <li>Гал унтраагуурын бүтэц, ажиллах зарчмыг сурагчдын өөрсдийнх нь бэлтгэсэн хялбар гал унтраагуурынхтай харьцуулж ярилцана.</li> <li>Хийсэн гал унтраагуурын давуу ба сул талыг ярилцахаар төлөвлөлт хийсэн</li> </ul>                                                                                                                    | <ul style="list-style-type: none"> <li>Хичээлээр олсон мэдлэгээ бүгдийг нэгтгэн авч үзэх тал дээр бага анхаарсан байсан</li> <li>Сурагчид өөрсдийн хийсэн гал унтраагуураа үнэлэх талыг орхигдуулсан гэж үзсэн</li> </ul>                                                                                                                                                              |

Хэрэглэгдэхүүнийг сайжруулна гэдэг нь хэлэлцүүлгийн үр дүнд үндэслэн өмнө хийгдсэн хэрэглэгдэхүүний судалгааны үр дүнг дахин сайжруулна гэсэн үг.

Агуулга, арга зүй, дидактик шийдэл, хэрэглэгдэхүүнийг сайжруулах нь харилцан маш нарийн уялдаатай, хамтдаа хийгддэг үйл болохыг цөөн зарим жишээгээр авч үзье.

**Жишээ 1.**

2011 онд төслийн хүрээнд зохион байгуулагдсан үндэсний сургалт семинарт Химийн багш нар “Атомын бүтэц” сэдвээр 8-р ангид судалгаат хичээл зохион байгуулсан юм. Багш нар өмнөх туршлагаас Хими-I сурах бичигт өгөгдсөн атомын бүтцийн зургаас “электрон давхраа” ба “электрон бүрхүүл”-ийн ялгааг олж харахад сурагчдад бэрхшээлтэй байдгийг хамтран хэлэлцээд өөрчлөлт хийсэн боловч судалгаат хичээлийн үед сурагчид “электрон давхраа” ба “электрон бүрхүүл”-ийн ялгааг олж илрүүлэхэд энэхүү зураг дэмжлэг болж чадахгүй байгаа нь тогтоогдсон учраас хэлэлцүүлгийн үр дүнд үндэслэн

“электрон давхраа” тус бүрийг зурагт тусгайлан ялгаж нэрлэсэн байдлаар сайжруулалт хийсэн болно.

| Сурах бичиг дээрх зураг                                                                                                                                            | Хэрэглэгдэхүүний судалгаагаар сайжруулсан байдал | Судалгаат хичээлийн хэлэлцүүлгийн үр дүнд сайжруулсан байдал |
|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--------------------------------------------------|--------------------------------------------------------------|
|                                                                                                                                                                    | <p>Зураг 2</p>                                   | <p>Зураг 2</p>                                               |
| <p><b>электрон бүрхүүл</b> нь тодорхой зүй тогтол бүхий электрон давхраануудаас тогтоно. <b>электрон давхрааг</b> атомын цөмд ойр талаас нь эхлэн дугаарладаг.</p> |                                                  |                                                              |

Үүнийгээ дагаад багшийн тавих асуулт ч сайжирсан байна.

## Жишээ 2.

2012 онд төслийн хүрээнд зохион байгуулагдсан үндэсний сургалт семинарт Химийн багш нарын зохион байгуулсан “Шүлтийн металлын химийн идэвхийг харьцуулан судлах” гэсэн 9-р ангийн химийн хичээлийн төлөвлөлтөд ТӨМ-д эхлээд бэлэн өгөгдсөн урвалын тэгшитгэлийг сурагчид нөхөн гүйцээгээд, дараа нь үзүүлэх туршлага болон видео туршлага үзэж хийсэн ажиглалтдаа үндэслэн сурагчид шүлтийн металлын химийн идэвхийн өөрчлөлтийн зүй тогтлыг илрүүлэхээр төлөвлөсөн байсан. Судалгаат хичээлийн ажиглалтаар үзүүлэх сорилоос өмнө явагдах урвалын тэгшитгэлийг өгснөөс болоод сурагчид шууд “устөрөгчөө ялгаруулсан” гэх мэтээр ажиглалт бус “зөв байх гэсэн бодлоо” бичих байдал ажиглагдсан (**Эхний төлөвлөлтөөр заасан хичээлийн ТӨМ, сурагчийн гүйцэтгэлийн жишээ**-УБ хотын Ирээдүй цогцолбор сургууль дээр заагдсан). Тиймээс хичээлийн төлөвлөлтөд арга зүй дидактик шийдлийн өөрчлөлт хийж түүнийгээ ТӨМ-д тусгасан. Ингэхдээ эхлээд үзүүлэх сорил, видео бичлэгийг үзэж явагдаж байгаа урвалын эрчмийг ажиглах, өөрийн ажиглах зүйлээ тэмдэглэх, улмаар химийн идэвхийг харьцуулах үйл ажиллагаа хийх ба улмаар фенолфталеинаар туршиж үзэх зэргээр урвалын бүтээгдэхүүн бодис юу байсныг илрүүлж, үүн дээрээ үндэслэн урвалын тэгшитгэл бичиж тэнцүүлэхээр өөрчилсөн байна (**Дараагийн төлөвлөлтөөр заасан хичээлийн ТӨМ, сурагчийн гүйцэтгэлийн жишээ**-Дорнод аймгийн 5-р сургууль дээр заагдсан). Энд дидактик шийдлийн хувьд зарчмын томоохон өөрчлөлт хийгдсэн тул хичээлийн төлөвлөлтөд багшийн асуулт, сурагчдаас ирэх боломжит хариултад нэлээд өөр болсон байна. Харин хоёр дахь төлөвлөлтөөр заагдсан хичээлийн хэлэлцүүлгийн дүнд хичээлийн төлөвлөлтөд дидактикийн эрс сайжруулалт хийгдэх шаардлагагүй, гагцхүү зарим нэг асуулт зэргийг илүү нарийвчлан төлөвлөсөн юм. Иймээс хоёр хичээлийн төлөвлөлтийг хавсаргав.

| ТӨМ-1  |                          |                     |                                                                                                                                 |                                        |                                                                                                                                                                                                                                                  |                                    |
|--------|--------------------------|---------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----------------------------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------------------------------------|
| Дугаар | Химийн элементийн тэмдэг | Атомын радиус $A^0$ | Электроны хуваарилалтыг гүйцээж бичнэ үү?                                                                                       | Урвалын тэгшитгэлийг гүйцээж бичнэ үү? | Урвал явагдахад ажигласан зүйлээ бичнэ үү?<br>(1-хамгийн бага, 6-хамгийн их эрчимтэй гэж үзнэ) →                                                                                                                                                 | Урвалын эрчийг эрэмбэлнэ үү? (1-6) |
| 1      | 2                        | 3                   | 4                                                                                                                               | 5                                      | 6                                                                                                                                                                                                                                                | 7                                  |
| 3      | Li                       | 1.55                | $+3 \left) \begin{array}{c} ) \\ ) \\ ) \end{array} \right. \\ 2 \quad 1$                                                       | $2Li + 2H_2O = 2LiOH + H_2$            | Үзүүлэх туршилт: Маш дүр дутал явахад дутал үсэрхэгээр дамжиж шүлт үүснэ. Дутал бүчлэх болох нь шүлт үүснэ.<br>Видео туршилт: Дутал үсэрхэг урвал оруулахад дутал үсэрхэг хөдлөх үүснэ. Металлоид ажиглагдсан.                                   | 1                                  |
| 11     | Na                       | 1.89                | $+11 \left) \begin{array}{c} ) \\ ) \\ ) \\ ) \end{array} \right. \\ 2 \quad 8 \quad 1$                                         | $2Na + 2H_2O = 2NaOH + H_2$            | Үзүүлэх туршилт: Маш дутал хөдлөх нь дутал үсэрхэгээр дамжиж шүлт үүснэ. Маш дутал хөдлөх нь дутал үсэрхэгээр дамжиж шүлт үүснэ.<br>Видео туршилт: Маш дутал үсэрхэг урвал оруулахад дутал үсэрхэг хөдлөх нь дутал үсэрхэгээр дамжиж шүлт үүснэ. | 2                                  |
| 19     | K                        | 2.27                | $+19 \left) \begin{array}{c} ) \\ ) \\ ) \\ ) \\ ) \end{array} \right. \\ 2 \quad 8 \quad 8 \quad 1$                            | $2K + 2H_2O = 2KOH + H_2$              | Таамаглал: Маш дутал хөдлөх нь дутал үсэрхэгээр дамжиж шүлт үүснэ.<br>Видео туршилт: Маш дутал үсэрхэг урвал оруулахад дутал үсэрхэг хөдлөх нь дутал үсэрхэгээр дамжиж шүлт үүснэ.                                                               | 3                                  |
| 37     | Rb                       | 2.48                | $+37 \left) \begin{array}{c} ) \\ ) \\ ) \\ ) \\ ) \end{array} \right. \\ 2 \quad 8 \quad 18 \quad 8 \quad 1$                   | $2Rb + 2H_2O = 2RbOH + H_2$            | Таамаглал: Маш дутал хөдлөх нь дутал үсэрхэгээр дамжиж шүлт үүснэ.<br>Видео туршилт: Маш дутал үсэрхэг урвал оруулахад дутал үсэрхэг хөдлөх нь дутал үсэрхэгээр дамжиж шүлт үүснэ.                                                               | 4                                  |
| 55     | Cs                       | 2.68                | $+55 \left) \begin{array}{c} ) \\ ) \\ ) \\ ) \\ ) \end{array} \right. \\ 2 \quad 8 \quad 18 \quad 18 \quad 8 \quad 1$          | $2Cs + 2H_2O = 2CsOH + H_2$            | Таамаглал: Маш дутал хөдлөх нь дутал үсэрхэгээр дамжиж шүлт үүснэ.<br>Видео туршилт: Маш дутал үсэрхэг урвал оруулахад дутал үсэрхэг хөдлөх нь дутал үсэрхэгээр дамжиж шүлт үүснэ.                                                               | 5                                  |
| 87     | Fr                       | 2.80                | $+87 \left) \begin{array}{c} ) \\ ) \\ ) \\ ) \\ ) \end{array} \right. \\ 2 \quad 8 \quad 18 \quad 32 \quad 18 \quad 8 \quad 1$ | $2Fr + 2H_2O = 2FrOH + H_2$            | Таамаглал: Маш дутал хөдлөх нь дутал үсэрхэгээр дамжиж шүлт үүснэ.<br>Видео туршилт: Маш дутал үсэрхэг урвал оруулахад дутал үсэрхэг хөдлөх нь дутал үсэрхэгээр дамжиж шүлт үүснэ.                                                               | 6                                  |

## Эхний төлөвлөлтөөр заасан хичээлийн ТӨМ, сурагчийн гүйцэтгэлийн жишээ

ТӨМ.

Таамаглал 1.

Cs Rb K Na Li

Яагаад ингэж байрлуулсан бэ?

Маш дутал хөдлөх нь дутал үсэрхэгээр дамжиж шүлт үүснэ. Маш дутал хөдлөх нь дутал үсэрхэгээр дамжиж шүлт үүснэ. Маш дутал хөдлөх нь дутал үсэрхэгээр дамжиж шүлт үүснэ. Маш дутал хөдлөх нь дутал үсэрхэгээр дамжиж шүлт үүснэ.

| Дугаар | Химийн элементийн тэмдэг | Сорил туршлагаар ажигласан зүйлсийг бичнэ                         | Шүлтийн металл устай харилцааг ойлгох урвалын тэгшитгэл |
|--------|--------------------------|-------------------------------------------------------------------|---------------------------------------------------------|
| 1      | 2                        | 3                                                                 | 4                                                       |
| 3      | Li                       | дүү шүлт бага, идэвх нь удаан, шүлт үүснэ                         | $2H_2O + 2Li = 2LiOH + H_2 \uparrow$                    |
| 11     | Na                       | дүү нь бага зүт ихсэж, идэвх нь маш бага зүт ихсэж, шүлт үүснэ    | $2H_2O + 2Na = 2NaOH + H_2 \uparrow$                    |
| 19     | K                        | дүүнь ихсэж, бага дүү, шүлт тийт цацарсан шүлт үүснэ, хий ямарсан | $2H_2O + 2K = 2KOH + H_2 \uparrow$                      |
| 37     | Rb                       | дүү болоод идэвх нь бүр ихсэж дүү дүрхт хий их гарсан, шүлт үүснэ | $2H_2O + 2Rb = 2RbOH + H_2 \uparrow$                    |
| 55     | Cs                       | дүү нь хамгийн идэвх ихсэж, маш шүлт хий гарсан, шүлт үүснэ       | $2H_2O + 2Cs = 2CsOH + H_2 \uparrow$                    |

Шүлтийн металлын химийн идэвхийн жагсаалт (видео туршлага үзсний дараа)

Li Na K Rb Cs

## Дараагийн төлөвлөлтөөр заасан хичээлийн ТӨМ, сурагчийн гүйцэтгэлийн жишээ

## Даалгавар

- Хэлэлцүүлгийн үр дүнг хичээлийн арга зүйг сайжруулан хөгжүүлэхэд хэрэглэх нь лекцийн үед хөтөлсөн зэрэгцүүлсэн тэмдэглэлээс 3 жишээг дэлгэрүүлэн бичгээр тайлбарлах

## Жишээ 2-ийн хавсралт хөтөлбөр 1.

Бүлэгсэдэв: Бодисын шинж чанар Нэгж хичээлийн сэдэв: Шүлтийн металл

Сар өдөр: 2012.11.05

Багш: .....

Анги: 9г

Сурагчдын тоо: 35

Хугацаа: 40 мин

Ээлжит хичээлийн сэдэв: Шүлтийн металлын хими шинж чанарын өөрчлөлтийн зүй тогтол

Ээлжит хичээлийн зорилго: Шүлтийн металлын хими шинж чанарыг өөрчлөлтийг атомын бүтцээс хэрхэн хамаарах зүй тогтлыг судлах

Ээлжит хичээлийн зорилт:

- Шүлтийн металлууд устай харилцан үйлчлэх урвалыг судлах
- Шүлтийн металлуудын үүсгэх дан бодисуудын химийн идэвхийг харьцуулах
- Химийн идэвхийн өөрчлөлтийг атомын бүтэцтэй холбон тайлбарлах

Хэрэглэгдэхүүн: Видео үзүүлэн, металл лити ба натри, ус, үелэх систем, проектор, компьютер, ТӨМ 1, талсжуулагч 2 ширхэг, хямсаа, хутга, фильтрийн цаас, кодоскопи

| Хичээлийн үе шат          | Багшийн үйл ажиллагаа<br>Асуулт боломжит хувилбар                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                           | Сурагчийн үйл ажиллагаа<br>Хариулт боломжит хувилбар                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                | Нэмэлт тайлбар                |
|---------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------------|
| Өмнөх мэдлэг<br><br>7 мин | <p>1. ТӨМ ийн 4,5 дугаар баганын даалгаварыг нөхөж бичнэ үү Хугацаа 4 мин</p> <p>Дүгнэлт асуултууд 3 мин</p> <p>Г.А. Шүлтийн металлын атомын электронт давхрааны бүтцэд ямар зүй тогтол ажиглагдаж байна вэ? Яагаад?</p> <p>Ч.А:Электрон давхрааны бүтцэд ижил ба ялгаатай зүйл юу байнавэ?</p> <p>Ч.А:Цөмийн цэнэг ихсэхэд атомын радиус хэрхэн өөрчлөгдөж байна вэ?</p> <p>Ч.А:Элементүүдийн давхрааны тоо нь цөмийн цэнэг ихсэхэд хэрхэн өөрчлөгдөж байна вэ?</p> <p>Г.А:Эдгээр урвалд байгаа ижил төсөөтэй зүйл нь юу вэ?</p> <p>Ч.А Ямар элементийн атомын тоо тэнцүү, харин аль элементийн атомын тоо хэдээр дутуу байна вэ?</p> <p>Ч.А К, О, Н агуулсан нэгдэл ямар томьёотой байх боломжтой вэ?</p> | <p>Даалгаварыг гүйцэтгэнэ</p> <p>Боломжит хариултууд</p> <p>1. Ижил- гадаад давхрааны электроны тоо- нэгбүлгийн элемент учраас</p> <p>- Өөр – Электрон давхрааны тоо цөмийн цэнэг ихсэхэд давхрааны тоо нэмэгдэж байна.</p> <p>- Цөмийн цэнэг ихсэхэд атомын радиус ихсэж байна</p> <p>Шүлтийн металлууд устай харилцан үйлчлэх үед шүлт үүсээд устөрөгч ялгаруулна<br/>Шүлтийн металлууд устай харилцан үйлчлээд металлын гидроксид үүсээд устөрөгч ялгаруулна</p> | - Хоёр даалгавар бүхий ТӨМ 1. |

|                                                       |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                   |                                                                                                                                                                                                                                                           |                   |
|-------------------------------------------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------|
| Шинэ мэдлэг                                           | Лити ба натри устай харилцан үйлчлэх урвалыг үзүүлэх туршлагаар кодоскопон дээр талсжуулагч аяганд хийж явуулаад сурагчдаар ажиглуулж ажиглалтын үр дүнг ТӨМ ийн 6 дугаар баганын үзүүлэх туршилт гэсэн мөрөнд бичнэ үү:                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                          | <ul style="list-style-type: none"> <li>- Ижил байна</li> <li>- Өөр өөр байна...</li> </ul> Таамаглал: <ul style="list-style-type: none"> <li>- Идэвх нь ижил байна. Нэг бүлгийн элементүүд учир.</li> <li>- Үе нь өөр учир идэвх нь өөр байна.</li> </ul> | Үзүүлэх туршилт   |
| Туршилт 4 мин<br>Таамаглал ба ажиглалт бичүүлэх 8 мин | Г.А Шүлтийн бусад металлууд устай урвалд орох эрчим нь ямар байх вэ?<br><br>Таамаглалыг ТӨМ ийн 6 дугаар баганын таамаглал гэсэн мөрөнд бичнэ үү                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                  |                                                                                                                                                                                                                                                           |                   |
| Видео бичлэг 3 мин<br>Үзүүлэх туршилт дүгнэлт 12 мин  | Ч.А: Лити ба натрийн аль нь эрчимтэй урвалд орсон бэ?<br><br>Видео бичлэгээр шүлтийн металлууд устай харилцан үйлчлэх урвалыг үзүүлж ажиглуулна.<br><br>ТӨМ ийн 6 дугаар баганын видео туршилт гэсэн мөрөнд бичнэ үү.<br>ТӨМ ийн дугаар баганыг бөглөнө үү<br><br>Г.А:Шүлтийн металлуудын устай харилцан үйлчлэх урвалын эрчим нь бүлгийн дагуу литигээс франци хүртэл хэрхэн өөрчлөгдөж байна вэ?<br><br>Ч.А Бүлгийн дагуу литигээс франци хүртэл элементүүдийн цөмийн цэнэг хэрхэн өөрчлөгддөг вэ?<br><br>Г.А Шүлтийн металлын химийн идэвх нь атомын радиусын өөрчлөлттэй хэрхэн холбогдож байна вэ?<br><br>Ч.А Бүлгийн дагуу литигээс франци хүртэл атомын радиус хэрхэн өөрчлөгдөж байна вэ? | Бичлэг үзэж дүгнэлт гаргах<br><br>ТӨМ ийг ажиллаж урвалын эрчимээр нь илэрхийлнэ<br><br>ТӨМ ажиллаж атомын радиус ихсэхэд урвалын эрчим ихсэж байна гэсэн дүгнэлт хийнэ                                                                                   | Видео бичлэг үзнэ |
| 5 мин                                                 | Нэгтгэн дүгнэлт хийнэ                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                             |                                                                                                                                                                                                                                                           |                   |
| Гэрийн даалгавар 1 мин                                | ТӨМ ийн 3 ба 7 р баганын өгөгдлийг ашиглан график байгуулах<br>Х.А Шүлтийн металлуудын хүхэртэй харилцан үйлчлэх                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                  | -                                                                                                                                                                                                                                                         |                   |

|  |                                                                                                                                              |  |  |
|--|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--|--|
|  | урвалын эрчимийн өсөх дарааллаар холбогдох урвалын тэгшитгэлүүдийг бичиж тэнцүүлж ирнэ үү? Дарааллыг гаргасан учир шалтгааныг тайлбарлана уу |  |  |
|--|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--|--|

## Жишээ 2-ийн хавсралт хөтөлбөр 2.

Анги: 9 б, г

Огноо : \_2012.11.09

**Сэдэв:** Шүлтийн металлын химийн идэвхийг харьцуулан судлах**Зорилго:** Шүлтийн металлын химийн идэвхийг харьцуулан судлах, зүй тогтлыг илрүүлэх**Зорилт:**

- Шүлтийн металлын устай харилцан үйлчлэх урвалыг судлах
- Сорил туршлагаар шүлтийн металлын химийн идэвхийг харьцуулах

**Хэрэглэгдэхүүн:** Видео үзүүлэн, металл лити ба натри, ус, үелэх систем, проектор, компьютер, ТӨМ 1, талсжуулагч 2 ширхэг, хямсаа, хутга, фильтрийн цаас, кодоскоп

**Арга зүй:**

|                  |                                                                                                                                                                                                                                                                                                                                                               |            |    |                   |        |                                                                                                                                                                                                                                                                                                                                                         |                                                                                                                                                  |               |
|------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------------|----|-------------------|--------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|---------------|
| Хич. элемент     | Багшийн үйл ажиллагаа<br>Асуулт боломжит хувилбар                                                                                                                                                                                                                                                                                                             |            |    |                   |        | Сурагчийн үйл ажиллагаа<br>Хариулт боломжит хувилбар                                                                                                                                                                                                                                                                                                    | Нэмэлт тайлбар                                                                                                                                   |               |
| Сэргээн санах 5` | Өмнөх хичээл дээр юу үзсэн бэ?<br>Багуудаас сурагчдыг сонгон хүснэгт нөхүүлэх                                                                                                                                                                                                                                                                                 |            |    |                   |        | Шүлтийн металлын атомын бүтэц<br>үелэх системд эзлэх байр<br>Атомын шинж чанар<br>Хүснэгтийг дэвтэртээ нөхөж ажиллах.                                                                                                                                                                                                                                   | Багийн нэг гишүүн самбарт гарч бөглөх.                                                                                                           |               |
|                  | Химийн тэмдэг                                                                                                                                                                                                                                                                                                                                                 | Дэс дугаар | Үе | Валентын электрон | Валент |                                                                                                                                                                                                                                                                                                                                                         |                                                                                                                                                  | Исэлдлийн хэм |
|                  |                                                                                                                                                                                                                                                                                                                                                               |            |    |                   |        |                                                                                                                                                                                                                                                                                                                                                         |                                                                                                                                                  |               |
|                  |                                                                                                                                                                                                                                                                                                                                                               |            |    |                   |        |                                                                                                                                                                                                                                                                                                                                                         |                                                                                                                                                  |               |
| Сэдэлжүүлэлт 5`  | Эдгээр металлуудын химийн идэвх ямар дарааллаар өөрчлөгдөх вэ?<br>Яагаад?<br><br>Эдгээр металлуудаас аль нь хамгийн идэвх бага вэ?<br>Хамгийн идэвх багатай нь хамгийн эхэнд байрлуулна.<br>Эдгээр металлуудаас аль нь хамгийн идэвхтэй вэ?<br>Хамгийн их идэвхтэйг хамгийн ард байрлуулна.<br><br>Химийн идэвхийн өсөх дарааллаар хэрчим дээр байрлуулна уу. |            |    |                   |        | Сурагчид идэвхи нь ихсэх дарааллаар байрлуулна.<br><br>Самбарт<br><div><div><div></div><div></div><div></div><div></div><div></div><div></div></div><div>NaLiCsKRbFr</div></div> <div><div><div></div><div></div><div></div><div></div><div></div><div></div></div><div>LiNaKRbCsFr</div></div> <p>- Идэвх нь янз бүр байна. Нэг бүлгийн элементүүд</p> | Галогентэй жишиж бүлгийн дагуу дээрээс доошоо химийн идэвх буурна гэсэн хариултыг өгвөл багш яаж чиглүүлэх вэ?<br>ТӨМ1-ийг сурагчдад дэлгэрэнгүй |               |

|                  |    |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                 |                                                                                                                                                                                                                                                                                                                                            |                                                                                                    |
|------------------|----|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----------------------------------------------------------------------------------------------------|
|                  |    | Самбарт хичээлийн сэдвийг бичих.<br>ТӨМ-ийн <b>Таамаглал 1</b> -д жагсаалтаа тэмдэглэсэн 2-3 сурагчийн идэвхийн дараалалтай танилцаж бусад сурагчдын саналыг хураах.                                                                                                                                                                                                                                                                                                            | учир.<br>- Үе нь өөр учир идэвх нь өөр байна.<br>- Галоген бүлгийн дагуу химийн идэвх ихэсдэгтэй адил байх<br>- Дэс дугаар ихсэх тусам идэвхи буурна.<br>- Дэс дугаар ихсэх тусам идэвхи өснө.                                                                                                                                             | тайлбарлах.                                                                                        |
| Мэдлэг бүтээлгэх | 12 | Үзүүлэх туршлага 1:<br>Натри болон зэсийг сурагчдад зүсэж үзүүлэх<br>Үзүүлэх сорилын ерөнхий дарааллыг тайлбарлана.<br>Металл натрийг усанд уусгахад явагдах процессыг ажиглаарай. Хий гарч байгаа байдал болон урвалд орох хурд, дуу чимээ гэх мэт<br>Зэс, хөнгөн цагааныг ингэж хадгалдаг уу?<br>Яагаад керосин дотор хадгалдгийн учрыг энэ хичээлийн төгсгөлд үзнэ.<br>Натри устай харилцан үйлчлэхэд юу ажиглагдав?<br>Химийн урвалын үед гардаг өөрчлөлтүүдийг нэрлэнэ үү? | Сурагчид натри болон зэсийн физик шинж чанарыг харьцуула тэмдэглэх.<br>Натрийг устай хэрхэн, яаж харилцан үйлчилж буйг ажиглана. Ажиглалтаа ТӨМ-ийн ажиглалт хэсэгт бүтэн өгүүлбэрээр бичнэ.<br>- Утаа гарах. Энэ нь хий юм<br>- Натри усанд уусаж байна<br>Натри усан дээр шажигнан дуугарч уусч байна.<br>Натри усанд буцалж уусч байна. | Буцлах гэдэг алдаа гарвал яаж засах вэ?<br>Яагаад                                                  |
|                  |    | Химийн урвал явагдсан учраас урвалын бүдүүвчийг хэрхэн илэрхийлэх вэ?<br>Хийн бөмбөлөг гарч байгаа учраас хий ялгарсан гэдгийг үндэслэн урвалын нэг бүтээгдэхүүн нь хий байна гэж үзье.<br>Урвалаас өөр бүтээгдэхүүн үүссэн эсэхийг яаж мэдэх вэ?<br>Фенолфталеин дусааж үзье. Уусмалд ямар бодис агуулагдаж байна вэ?<br>Тэгвэл ямар урвалын тэгшитгэл бичиж болох вэ?                                                                                                         | Ус + натри = хий + ?<br><br>Фф-д ягаан өнгө үзүүлж байгаа учраас урвалын дүнд шүлт үүссэн.<br>NaOH үүссэн<br>$2\text{Na} + 2\text{H}_2\text{O} = 2\text{NaOH} + \text{H}_2$                                                                                                                                                                | Металл натри болон литийг ижил хэмжээтэй зүсэж бэлтгэсэн байх хэрэгтэй.                            |
|                  |    | Лити, натри хоёрын аль нь устай урвалд орохдоо илүү идэвхтэй байх вэ? гэдгийг туршиж үзье.<br>Үзүүлэх туршлага 2:<br>Үзүүлэх сорилын ерөнхий дарааллыг тайлбарлана.<br>Лити болон натрийн усанд уусахад ажигласан зүйлийнхээ тэмдэглэлийг хөтлөөрэй.<br>Лити устай харилцан үйлчлэхэд ямар урвал явагдсан бэ?                                                                                                                                                                   | Лити илүү идэвхтэй байх болов уу.<br>Натри илүү идэвхтэй байх болов уу.<br><br>$2\text{Li} + 2\text{H}_2\text{O} = 2\text{LiOH} + \text{H}_2$                                                                                                                                                                                              | Металл натри болон литийг усанд зэрэг хийж урвалыг ажиглуулах мөн урвал явуулах шил саваа хаяглах. |
|                  |    | Лити ба натрийн аль нь эрчимтэй урвалд орсон бэ? Яагаад ингэж үзэх болов?                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                       | Лити болон натри усан дээр илүү хурдтай хөдөлж байна.                                                                                                                                                                                                                                                                                      |                                                                                                    |
|                  | 10 | Видео туршлага 1:<br>Шүлтийн металлуудын устай харилцан үйлчлэх урвалыг харуулсан видео бичлэгийг үзүүлнэ.                                                                                                                                                                                                                                                                                                                                                                      | Металл тус бүрийг хэсэгчлэн ажиглан тэмдэглэлийг хөтөлнө.<br>-                                                                                                                                                                                                                                                                             | өөрийн таамаглалын дагуу ажиглалтаа                                                                |

|                     |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                            |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                   |                                                                                    |
|---------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------------------------------------------------------------------------------------|
|                     | <p>Ажиглалтаа тэмдэглэнэ үү.<br/>Дахин үзэх шаардлагатай эсэхийг сурагчдаас асууна. Зөвхөн нэг удаа давтан үзэх боломжтойг анхааруулна.</p>                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                   | ажлын хуудсанд бөглөнө.                                                            |
|                     | <p>Лити, натри, кали, рубиди, цези, франци устай харилцан үйлчлэхэд юу ажиглагдсан бэ?</p> <ul style="list-style-type: none"> <li>○ Литийг устай харилцан үйлчлүүлэхэд юу ажиглагдсан бэ?</li> <li>○ Натрийг устай харилцан үйлчлүүлэхэд юу ажиглагдсан бэ?</li> <li>○ Калийг устай харилцан үйлчлүүлэхэд юу ажиглагдсан бэ?</li> <li>○ Рубидийг устай харилцан үйлчлүүлэхэд юу ажиглагдсан бэ?</li> <li>○ Цезийг устай харилцан үйлчлүүлэхэд юу ажиглагдсан бэ?</li> </ul> <p>Ажиглалтын дүнг үндэслэн шүлтийн металлын химийн идэвхийн өсөх дарааллаар байрлуулаарай.</p> <ul style="list-style-type: none"> <li>○ Анхны дэвшүүлсэн таамаглал батлагдсан уу?</li> <li>○ Францийг устай харилцан үйлчлүүлвэл юу ажиглагдах вэ?</li> </ul> | <p>Лити болон натри уусахад хий ялгарч байсан. Шатаасан зомгол ойртуулахад ялгарч байгаа устөрөгч хий шатаж байна.<br/>Натри нь литиэс арай хурдан урвалд орж байна.</p> <p>Кали уусахад шууд авалцаж шатаж байна.<br/>Кали шатаж ууссан /буруу/<br/>Рубиди уусахад шууд авалцан эрчимтэй шатаж байна.<br/>Цези маш эрчимтэй урвалд орж шил сав хагартал тэсэрсэн.<br/>Цези тэсэрч ууссан /буруу/<br/>- Франци устай урвалд орохдоо цезигээс илүү их эрчимтэй урвалд ордог.<br/>Батлагдсан /Бүлгийн дагуу дээрээс доошлоход идэвх өснө гэж таамагласан сурагчид/<br/>Батлагдсангүй, эсрэгээрээ байсан /Бүлгийн дагуу дээрээс доошлоход идэвх буурна гэж таамагласан сурагчид/</p> | Шатаж байгааг хүүхэд юу гэж тайлбарлах бол?                                        |
|                     | <p>Шүлтийн металлын устай харилцан үйлчлэх урвалуудын тэгшитгэлийг бичиж тэнцүүлээрэй.<br/>Шүлтийн металлын хадгалалтыг тайлбарлах</p>                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                     | Хадгалалтыг тэмдэглэж авах                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                        | Хүүхдийн гаргасан алдааг анзаарч зааруулна.                                        |
| Бататгах 6'         | <p>Шүлтийн металлын агаарын хүчилтөрөгчтэй исэлдэх урвалын эрчим ямар дарааллаар өсөх вэ?<br/>Видео туршлага 2:<br/>Шүлтийн металлуудын агаарын хүчилтөрөгчтэй харилцан үйлчлэх урвалыг харуулсан видео бичлэгийг үзүүлнэ.<br/>Багш хичээлийг нэгтгэн дүгнэж сурагчдыг урамшуулах</p>                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                      | $4\text{Li} + \text{O}_2 = 2\text{Li}_2\text{O}$ $4\text{Na} + \text{O}_2 = 2\text{Na}_2\text{O}$ $4\text{K} + \text{O}_2 = 2\text{K}_2\text{O}$                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                  | Металлын гялалзлагыг сануулах, оксидын бүрхүүл үүсэхэд металлын гялалзлага арилна. |
| Гэрийн даалгавар 2' | <p>0.7 гр лити, цезигийн устай харилцан үйлчлэхэд аль нь илүү хий ялгарах уу? Таамаглалаа тооцоогоор батла.</p>                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                            | $4\text{Rb} + \text{O}_2 = 2\text{Rb}_2\text{O}$ $4\text{Cs} + \text{O}_2 = 2\text{Cs}_2\text{O}$ $4\text{Fr} + \text{O}_2 = 2\text{Fr}_2\text{O}$                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                | Хичээл цагтаа багтаж хугацаа гарвал урвалын тэгшитгэлийг ангид бичүүлнэ.           |

## **Семинар 14, 15. Судалгаат хичээлийн хөтөлбөрийг сайжруулах**

**Зорилго:** Судалгаат хичээлийн ажиглалт, хэлэлцүүлгийн үр дүнд үндэслэн Хичээлийн хөтөлбөрийг сайжруулах арга зүйд суралцах

**Хугацаа: 4 цаг (180 минут)**

**Хэрэглэгдэхүүн:**

- Хэлэлцүүлэг хийсэн судалгаат хичээлийн төлөвлөлт, хэрэглэгдсэн хэрэглэгдэхүүн бодотоор
- Ажиглалтын тэмдэглэл хийсэн хуудсууд
- Хэлэлцүүлгийн тэмдэглэл, протокол
- Боломжтой бол судалгаат хичээлийн видео бичлэг
- Хичээлийн хөтөлбөрийг сайжруулахад шаардлагатай бусад лавлах материал, ном сурах бичиг

**Бусад хэрэглэгдэхүүн:** Самбарын цаас, фломастер, скоч, соронз

**Удирдамж**

1. 4-6 хүнтэй багт зохион байгуулагдана. 5 минут
2. Агуулгыг сайжруулах нийт 45 минут
  - е. Багийн гишүүн бүр хичээлийн ажиглалтын тэмдэглэл, хэлэлцүүлгийн тэмдэглэлд үндэслэн бие даан боловсруулсан хичээлийн хөтөлбөрийг агуулгын хувьд сайжруулах саналаа танилцуулна. 10 минут
  - ф. Багийн гишүүд хамтран хичээлийн хөтөлбөрийг агуулгын хувьд сайжруулах саналаа нэгтгэн боловсруулж бусдад танилцуулахад бэлтгэнэ. 15 минут
  - г. Баг тус бүр ажлаа танилцуулна. Бусад багийн ажлыг анхааралтай сонсож эрс зөрөөтэй саналыг хамтран хэлэлцэж тогтоно. 4 x 5 минут = 20 минут
3. Хэрэглэгдэхүүнийг сайжруулах нийт 45 минут
  - h. Багийн гишүүн бүр хичээлийн ажиглалтын тэмдэглэл, хэлэлцүүлгийн тэмдэглэлд үндэслэн бие даан боловсруулсан хичээлийн хөтөлбөр дэх хэрэглэгдэхүүнийг сайжруулах саналаа танилцуулна. 10 минут
  - i. Багийн гишүүд хамтран хичээлийн хөтөлбөр дэх хэрэглэгдэхүүнийг сайжруулах саналаа нэгтгэн боловсруулж бусдад танилцуулахад бэлтгэнэ. 15 минут
  - j. Баг тус бүр ажлаа танилцуулна. Бусад багийн ажлыг анхааралтай сонсож эрс зөрөөтэй саналыг хамтран хэлэлцэж тогтоно. 4 x 5 минут = 20 минут
4. Заах арга зүй, дидактик шийдлийг сайжруулах нийт 75 минут

- k. Багийн гишүүн бүр хичээлийн ажиглалтын тэмдэглэл, хэлэлцүүлгийн тэмдэглэлд үндэслэн бие даан боловсруулсан хичээлийн хөтөлбөрийн заах арга барил, дидактик шийдэл, асуултын томъёолол болон сурагчийн өгч болох хариултын хувилбаруудыг сайжруулах саналаа танилцуулна. 25 минут
  - l. Багийн гишүүд хамтран хичээлийн хөтөлбөрийн заах арга барил, дидактик шийдэл, асуултын томъёолол болон сурагчийн өгч болох хариултын хувилбаруудыг сайжруулах саналаа нэгтгэн боловсруулж бусдад танилцуулахад бэлтгэнэ. 25 минут
  - m. Баг тус бүр ажлаа танилцуулна. Бусад багийн ажлыг анхааралтай сонсож, эрс зөрөөтэй саналыг хамтран хэлэлцэж тогтоно. 4 x 6 минут = 24 минут
5. Хэлэлцүүлгийн үр дүнг үндэслэн хичээлийн хөтөлбөрийг сайжруулах талаар сурсан зүйлээ нэгтгэн дүгнэх 10 минут

### **Даалгавар**

1. Семинарын ажлын үр дүнгээ бүрэн тусгасан “Хичээлийн сайжруулсан төлөвлөлт”-ийг эцэслэн гаргах

## **Семинар 16. Хичээлийн судалгааны талаар сурсан зүйлээ нэгтгэн дүгнэх**

**Зорилго:** Хичээлийн судалгааны талаар дүгнэн ярилцах

**Хугацаа:** 2 цаг (90 минут)

**Хэрэглэгдэхүүн:**

- Лекцийн тэмдэглэл, бие даах ажлаар хийсэн бүтээлүүд
- Семинарын хичээлийн тэмдэглэл, бие даах ажлаар хийсэн бүтээлүүд

**Бусад хэрэглэгдэхүүн:** Самбарын цаас, пламастер, скоч, соронз

**Удирдамж**

1. 4-6 хүнтэй багт зохион байгуулагдана. 5 минут
2. Багийн гишүүд ТӨМ 16.1-ийн дагуу Хичээлийн бэлтгэл судалгаа, Хичээлийн судалгааны хүрээнд эзэмшсэн түлхүүр ойлголтоо тодорхойлж, хамтран хэлэлцсэний үндсэн дээр ойлголтуудад товч тайлбар бэлтгэнэ. 30 минут
3. Баг тус бүр багийн ажлаа танилцуулна. 5 x 5 минут = 25 минут
4. Танилцуулгад үндэслэн багууд харилцан асуулт тавьж хариулна. 15 минут
5. Багш багуудын бүтээгдэхүүн болон асуулт хариултыг нэгтгэн дүгнэж “Хичээлийн бэлтгэл судалгаа ба хичээлийн судалгааны түлхүүр ойлголтууд”-ад шаардлагатай нэмэлт тайлбарыг хийж дүгнэнэ. 15 минут

**Даалгавар.**

1. Семинарын ажлын үр дүнгээ бүрэн тусгасан “Хичээлийн бэлтгэл судалгаа ба хичээлийн судалгааны түлхүүр ойлголтууд”-ыг эцэслэн гаргах

### ТӨМ 16.1. Хичээлийн бэлтгэл судалгаа ба хичээлийн судалгааны түлхүүр ойлголтууд

| Агуулга                         |               | Түлхүүр ойлголт                                                                          | Товч тайлбар                                                                             |
|---------------------------------|---------------|------------------------------------------------------------------------------------------|------------------------------------------------------------------------------------------|
| Хичээлийн бэлтгэл судалгаа (КК) |               | <ul style="list-style-type: none"> <li>•</li> <li>•</li> <li>•</li> <li>• ...</li> </ul> | <ul style="list-style-type: none"> <li>•</li> <li>•</li> <li>•</li> <li>• ...</li> </ul> |
| Хичээлийн судалгаа (ЖК)         | Төлөвлөх      | <ul style="list-style-type: none"> <li>•</li> <li>•</li> <li>•</li> <li>• ...</li> </ul> | <ul style="list-style-type: none"> <li>•</li> <li>•</li> <li>•</li> <li>• ...</li> </ul> |
|                                 | Заах, ажиглах | <ul style="list-style-type: none"> <li>•</li> <li>•</li> <li>•</li> <li>• ...</li> </ul> | <ul style="list-style-type: none"> <li>•</li> <li>•</li> <li>•</li> <li>• ...</li> </ul> |
|                                 | Хэлэлцүүлэг   | <ul style="list-style-type: none"> <li>•</li> <li>•</li> <li>•</li> <li>• ...</li> </ul> | <ul style="list-style-type: none"> <li>•</li> <li>•</li> <li>•</li> <li>• ...</li> </ul> |

## БИЕ ДААХ АЖИЛ

1. “Хичээлийн судалгаа ба Одоо миний төсөөлөл” бичих
2. “Хичээлийн судалгаа ба эхэн үеийн миний төсөөлөл”, “Хичээлийн судалгаа ба Одоо миний төсөөлөл”-ийг харьцуулан ахиц дэвшилдээ өөрийн үнэлгээ өгөх
  - “Хичээлийн судалгаа ба одоо миний төсөөлөл” нь “... миний ойлголт”, “... миний эзэмшсэн мэдлэг, чадвар” гэсэн үндсэн хоёр хэсэгтэй (*загвар нь 1-р бие даалттай ижил байна*). “Хичээлийн судалгаа” хичээлийг судалсан, хийж гүйцэтгэсэн ажил, гаргасан бүтээлдээ үндэслэн одоогийн төсөөллөө гараар бичиж (өөртөө 1 хувь хуулбар авч үлдэнэ) багшид Семинар 16-аас өмнө хураалгана.
  - “Хичээлийн судалгаа ба Одоо миний төсөөлөл”-өө бичиж багшид хураалгаснаар 1-р бие даах ажлаар бичиж хураалгасан “Хичээлийн судалгаа ба эхэн үеийн миний төсөөлөл”-өө багшаас авна.
  - Семинар 16 орсны дараа “Хичээлийн судалгаа ба эхэн үеийн миний төсөөлөл”, “Хичээлийн судалгаа ба Одоо миний төсөөлөл”-ийг харьцуулан өөрийн ахиц дэвшилд өөрийн үнэлгээ өгөх

### Өөрийн үнэлгээ

“Хичээлийн судалгаа” - Миний ойлголт ингэж өөрчлөгджээ:

.....

.....

.....

.....

.....

“Хичээлийн судалгаа” – Эзэмшсэн мэдлэг, чадвараа ингэж үнэлж байна:

.....

.....

.....

.....

.....

Би ЕБС-д багшийн ажлын байран дээрээ очоод “Хичээлийн судалгаа”-нд оролцоход бэлэн үү?:

.....

.....

.....

.....

.....

### Нэр томьёоны хураангуй

| 1  | Нэр томьёо                           | Key words                                  | Тайлбар                                                                                                                                                                                                                                                    |
|----|--------------------------------------|--------------------------------------------|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| 1  | Суралцагчийн хөгжил                  | Learner development                        | Суралцагчийн таних, бүтээх үйлийн арга барил, хандлагад гарч буй өөрчлөлт                                                                                                                                                                                  |
| 2  | Суралцагчийн хөгжлийн үнэлгээ        | Learner development evaluation             | Суралцагчийн үйлийн гүйцэтгэлийн түвшин ба чанараар тэдний хөгжлийг үнэлэх үнэлгээ                                                                                                                                                                         |
| 3  | Эзэмшихүй                            | Acquire                                    | Үг тэмдэг, ухагдахуун хэрэглэж харьцах суралцагчийн үйл ажиллагаа нь гадаад, хамтын, материаллаг, дэлгэрэнгүй хэлбэрээс тодорхой үе шатуудыг дамжин дотоод, хувийн, сэтгэцийн, хураангуй хэлбэрт хувирах үйл явц                                           |
| 4  | Суралцахуй                           | Learning                                   | Эзэмшихүйн зүй тогтлын дагуу суралцагчийн эрдэм мэдлэг туурвин бүтээж хөгжих танин мэдэхүйн үйл                                                                                                                                                            |
| 5  | Багшлахуй                            | Teaching                                   | Суралцахуйг дэмжих, удирдах менежментийн үйл                                                                                                                                                                                                               |
| 6  | Суралцахуйн хөгжлийг дэмжих арга зүй | Learning support teaching methodology      | Суралцагчаар эрдэм мэдлэг бүтээлгэх багшлах үйлийн цогц шийдэл (дидактик шийдэл) ба түүнийг бүрэн хэрэгжүүлэх үйлийн, материаллаг, сэтгэл зүйн орчин нөхцөл                                                                                                |
| 7  | Боловсролын стандарт                 | Education standards                        | Нийгмийн хөгжил болон хувь хүний боловсролжих эрэлт хэрэгцээг хангах наад захын норматив шаардлага                                                                                                                                                         |
| 8  | Киррикулим                           | Curriculum                                 | Боловсролын стандартын хэрэгжилт, түүнийг хөгжлийг хангах нийлүүлэлтийн менежментийн үйл явц                                                                                                                                                               |
| 9  | Суралцахуйн 4 зорилт                 | Four pillars of learning (Learning to ...) | Мэдэх, бүтээх, бие даан амьдрах, нийгэмшин иргэнших 4 төрлийн үйлэнд суралцах зорилт                                                                                                                                                                       |
| 10 | Цогц чадамж                          | Competence                                 | Хүний хөгжлийн түвшинг багцаар илэрхийлэх мэдлэг, чадварын цогц                                                                                                                                                                                            |
| 11 | Суралцахуйн судалгаа                 | Learning study                             | Эзэмшихүйн зүй тогтлын дагуу суралцагчийн эрдэм мэдлэг туурвин бүтээж хөгжих танин мэдэхүйн үйлийн судалгаа                                                                                                                                                |
| 12 | Хичээл                               | Lesson                                     | Суралцагчдад тодорхой зорилгыг хэрэгжүүлэхээр сонгосон агуулгыг төлөвлөсөн хугацаанд эзэмшүүлэх үйл ажиллагааны зохион байгуулалтын хэлбэр                                                                                                                 |
| 13 | Агуулгын нэгж                        | Content unit                               | Цогц чадамжид баримжаалан сонгосон агуулгаас тодорхой дидактик зорилтыг хэрэгжүүлэхээр эзэмшихүйн зүй тогтолд нийцүүлэн ялгасан бүтэц                                                                                                                      |
| 14 | Нэгж хичээл                          | Unit Lesson                                | Агуулгын нэгжийг эзэмших, эзэмшүүлэх үйл ажиллагааны зохион байгуулалтын хэлбэр                                                                                                                                                                            |
| 15 | Хичээлийн нэгж                       | Unit of lessons                            | 40-45 минут (төрөөс тогтоосон тодорхой хугацаа)-нд ногдох нэгж хичээлийн хэсэг                                                                                                                                                                             |
| 16 | Хичээлийн анализ                     | Lesson analysis                            | Хичээлийн хүрээнд явагдах суралцахуй ба багшлахуйн үйлийн шүтэлцээ ба түүний менежментийн задлан шинжилгээ                                                                                                                                                 |
| 17 | Сургалтын арга зүйн судалгааны төв   | Research center of training methods        | Суралцахуй ба багшлахуйн хөгжлийг дэмжих арга зүйг судлах, турших, хэрэгжүүлэх, хөгжүүлэх төв                                                                                                                                                              |
| 18 | Хичээл - шинжилгээ                   | Monitoring                                 | Мониторинг буюу хяналт, шинжилгээ, үнэлгээ нь үйл явцыг бүхэлд нь буюу түүний үе шатууд, төлөв байдлыг тодорхой индикатор, үзүүлэлт хэрэглэн аль болох тасралтгүй мөрдөн ажиглаж, дэлгэрэнгүй мэдээ баримт цуглуулан задлан шинжилгээ хийж, сайжруулах үйл |
| 19 | Хичээлийн хяналт - шинжилгээ         | Lesson monitoring                          | Багшийн багшлахуй болон сурагчдын суралцахуйн хөгжилд дэмжлэг болох зорилгын дор нэгдэн, зохион байгуулалтад орсон бүлэг хүмүүс хамтран сургуулийн сургалтын үйл ажиллагаанд урьдчилан                                                                     |

|    |                                           |                          |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                      |
|----|-------------------------------------------|--------------------------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
|    |                                           |                          | боловсруулсан хичээлийн мониторингийн хуудсуудыг ашиглан судалгаа хийх замаар багшлахуй ба суралцахуйд гарч буй өөрчлөлтийг хянан ажиглалт хийж, мэдээ баримт цуглуулан, түүндээ дүн шинжилгээ хийж, гарсан өөрчлөлт, анхны дэвшүүлсэн зорилго зорилтын биелэлт болон үр дүнгийн талаар үнэлгээ дүгнэлт өгөн зөвлөмж гаргах, хэрэглэх үйл явц                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                        |
| 20 | Хичээлийн судалгаа (Jugyo Kenkyu)         | Lesson study             | Хичээлийн хүрээнд явагдах суралцахуй ба багшлахуйн үйлийн шүтэлцээ ба түүний менежментийн судалгаа                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                   |
| 21 | Хичээлийн судалгаа бэлтгэл (Kyoza Kenkyu) | Study teaching materials | Хичээлд бэлтгэх төлөвлөлтийн хүрээнд тасралтгүй хийгдэх тодорхой үе шат бүхий киррикулим (цогц) судалгаа;<br>- Хичээлийн бүтэн жилийн, улирлын, бүлэг сэдвийн, нэгж хичээлийн зорилго, зорилтыг нэгтгэж эрэмбэлэн төлөвлөдгөөрөө тодорхой үе шат бүхий<br>- Киррикулимийн үндсэн бүрэлдэхүүн хэсэг болох агуулга (тухайн судлагдахууны тогтолцооны болон суралцагчийн мэдлэг эзэмшилтийн), арга зүй, хэрэглэгдэхүүн, үнэлгээг хамардагаараа цогц,<br>- Тухайн хичээлийн бэлтгэлд өмнөх хичээлийн явц, үр дүнгээ бүтээлчээр хэрэглэдэг, өнөөдрийн хичээлээс дараагийн хичээлийнхээ бэлтгэлд хэрэглэх санааг олж авч байдгаараа тасралтгүй шинжийг өөртөө агуулсан байдаг.                                                                                                                                                                                                                                                                                                                                             |
| 22 | Алдааны шинжилгээ (Tsumazuki)             | Stumbling                | Дидактик шийдэл, арга зүйгээ сайжруулахын тулд сурагчийн алдаанд хийх задлан шинжилгээ “Цумазүки” гэдэг нь Япон хэлэнд хүн санамсаргүйгээр ямар нэгэн юманд бүдрэх, тээглэх үед хэрэглэгддэг, монголын “Бөх хүн бүдүүн өвсөнд” гэдэгтэй утга, агуулга ойролцоо үг хэллэг юм. Боловсролд “цумазүки” гэдэг үг нь хүүхдийн суралцах үеийн сэтгэн бодох үйл ажиллагаанд гарч байгаа бага зэргийн хазайлтын улмаас хүүхдийн чадвар илэрч чадахгүй байгааг олж харах гэсэн утгыг илэрхийлнэ.<br>Алдааны задлан шинжилгээнд “concept”, “conception”, “mis-conception” гэсэн нэр томъёо чухал байдаг. Concept-зөв үзэл, зөв бодол, зөв санаа гэсэн утгатай. Conception-хүүхдийн гаргаж ирэх санаа (энэ нь зөв ч байж болно)-г илэрхийлнэ.<br>Mis-conception-амьдралаас олж авсан шинжлэх ухааны хувьд буруу төсөөллийг илэрхийлдэг. Багшийн алдаанаас шалтгаалж сурагч алдлаа гэж дүгнэсэн багшийн арга зүй үргэлж сайжрах боломжтой байдаг бол “Алдаа бол хүүхдийн л алдаа” гэж үздэг багш хэзээ ч хөгжих боломжгүй байдаг. |

Тайлбар гаргасан: Н.Нэргүй (БСШУЯ), У.Дорьд (МУИС), Н.Оюунцэцэг (МУИС)